



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 4



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 4

Улаанбаатар, 2022

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 4

СУДЛААЧИД:

1. А.Түвшинтөгс, Д.Ганхүрэл, Э.Золзаяа, Н.Лхамцэрэн
2. Б.Ариунзаяа, Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн
3. Л.Банзрагч
4. М.Ванчигмаа

Дугаар хариуцсан редактор С.Билгүүн

© Нээлттэй Нийгэм Форум, 2022.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9840-2-1

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 4



1

СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ
НЭХЭМЖЛЭЛТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ
ШҮҮХИЙН ПРАКТИК, ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

9

2

ЭДИЙН БУС ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ
ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ОНОЛЫН АСУУДАЛ БА
МОНГОЛ УЛСЫН ШҮҮХЭЭР ЭДИЙН БУС ХОХИРЛЫГ
НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БҮЙ БАЙДАЛ

93

3

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН
ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ

219

4

ЭДИЙН БУС ГЭМ ХОРЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ

247

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум 2021 оноос шүүхийн шийдвэрийн судалгааны чанарыг дээшлүүлэх зорилгоор Редакцын зөвлөлтэй хамтран ажиллаж, нийт гурван удаагийн цувралаар шүүхийн шийдвэрийн есөн тайланг нийтийн хүртээл болгоод байна. Редактор С.Билгүүний эрхлэн гаргаж буй энэ удаагийн дугаарт эдийн бус хохирлын талаар судалсан дөрвөн судалгааг танилцуулж байна. Нийгмийн амьдрал хувьсан өөрчлөгдөхийн хэрээр иргэдийн эрхийн зөрчил, түүнтэй холбоотой үүсэх сэтгэл санааны хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх арга хэлбэр хувьсан өөрчлөгдөж, хууль тогтоомжийн зохицуулалт нарийвчлагдах, шүүгчдийн зүгээс мэдлэг, ур чадвараа ахиулах шаардлага зүй ёсоор гарч байгааг эдгээр судалгаанаас харж болно. Судлаачид сэтгэл санааны хохирол хэрхэн үүсдэг, ямар нөхцөл байдал түүнд нөлөөлж болох талаар өнөөгийн практик, бусад улсад жишиг болсон ч манай улсын хувьд цөөн тохиолдох, цаашдаа тодорхой эрх зүйн зохицуулалт шаардах онцлог тохиолдлуудын хүрээнд эдийн бус хохирлыг судалсан нь бодлого боловсруулагчдын хувьд сонирхол татна гэж найдаж байна. Мөн Улсын Дээд шүүхээс эдийн бус хохиролтой холбогдуулан гаргасан тодорхой хоёр шийдвэрт тус тус дүн шинжилгээ хийсэн бэсрэг тайлангаас Улсын Дээд шүүх шийдвэр гаргахдаа баримталсан үндэслэлтэй танилцах боломжтой.

Нээлттэй Нийгэм Форум хохирол барагдуулах үндэсний тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд анхааран ажиллаж байгаа бөгөөд энэхүү судалгааны эмхэтгэл нь уг хүчин чармайлтын нэг хэсэг болохыг энд дурдах нь зүйтэй.

Судалгаа хийж гүйцэтгэсэн бүх судлаач, тайланг сайжруулахад хувь нэмэр оруулсан шүүмжлэгч, редакторуудад талархал илэрхийлье. Шүүхийн шийдвэрийн судалгааг эргэлтэд оруулахад хувь нэмэр оруулж байгаа уншигч Та бүхэнд талархал илэрхийлэхийн ялдамд цувралын талаарх санал шүүмжээ үргэлжлүүлэн хуваалцаж, бидний ажилд дэмжлэг үзүүлэхийг хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд гэм хор учруулснаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг багцлан энэхүү цувралаар Та бүхэнд толилуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах, бусдын хууль бусаар учруулсан гэм хорыг арилгуулах иргэний эрхийг баталгаажуулсан боловч эдийн бус гэм хор, ялангуяа сэтгэл санааны хохирлыг үнэлэх, арилгуулах асуудал өнөө хэр нь ярвигтай, практикт маргаан дагуулсан хэвээр байна.

Энэхүү цувралд багтсан судалгаагаар бусдын хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан эдийн бус гэм хор, түүний дотор сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой маргааныг эрүү, иргэний хэргийн шүүхээс хянан шийдвэрлэж буй практикийг өргөн хүрээнд, олон талаас нь шинжлэн судалсны зэрэгцээ тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг тухайлан сонгож дүн шинжилгээ хийсэн болно.

Энэхүү дүн шинжилгээг хийсэн судлаачдын зүгээс шүүхийн практикийн болон харьцуулсан судалгааны үр дүнд тулгуурлан эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхтэй холбоотой

хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тодорхой санал дэвшүүллээ. Эдгээр санал зөвлөмж нь цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эдийн бус хохирлыг үнэлж, нөхөн төлүүлэх, практикт зөв жишиг тогтоох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаарх иргэний эрхийн баталгааг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

Уг цувралд багтсан судалгаануудыг хийж гүйцэтгэсэн судлаачид болон дүн шинжилгээний чанарыг сайжруулах талаар санал, шүүмжээ харамгүй өгч хамтран ажилласан МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Т.Мэндсайхан, мөн сургуулийн ахлах багш, хууль зүйн ухааны доктор Б.Буянхишиг, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Оюунтуяа, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх Редакцын зөвлөлийн гишүүн, хуульч, судлаач Г.Оюунболд нарт талархсанаа илэрхийлье.

Редакцын зөвлөлийн гишүүн
С.Билгүүн

1

СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ НЭХЭМЖЛЭЛТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИК, ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



АДЪЯАСҮРЭНГИЙН ТҮВШИНТӨГС

Өмгөөллийн “Номун түншлэл” ХХК-ийн партнер, өмгөөлөгч.

2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр суралцаж төгссөн. Капитрон банк, Жунсон констракшн зэрэг ХХК-д хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд “Эрх зүй”, “Хууль дээдлэх ёс”, “Шүүх эрх мэдэл”, “Хүний эрх” зэрэг хууль зүйн мэргэжлийн сэтгүүлүүдэд 10 гаруй өгүүлэл, судалгааны ажил нийтлүүлсэн.



ДАМБЫН ГАНХҮРЭЛ

2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Япон Улсын Нагояагийн их сургуулийн эрх зүйн хөтөлбөрийг зэрэг дүүргэсэн.

Японы Чүо их сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Одоо МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимд багшилж байгаа бөгөөд үүргийн, өмчийн, гэрээний болон гэм хорын эрх зүйгээр мэргэшин, тогтмол судалгаа хийж байна.

Судалгааны
багийн ахлагч:

А.Түвшинтөгс (LL.B)

Судлаачид:

Д.Ганхүрэл (LL.M)

Э.Золзаяа (LL.B)

Н.Лхамцэрэн (LL.M)



ЭНХБОЛДЫН ЗОЛЗАЯА

Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН-ийн өмгөөлөгч.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгсөж, Удирдлагын академид Нийтийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Одоогоор өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН-д хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж байна. 2021 онд албан ёсоор орчуулагч болсон ба хууль зүйн орчуулгын ажил гүйцэтгэдэг.



НЯМСҮРЭНГИЙН ЛХАМЦЭРЭН

2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Япон Улсын Нагоягийн их сургуулийн эрх зүйн хөтөлбөрийг зэрэг дүүргэсэн.

2020 онд Нагоягийн их сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Одоо МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимд багшилдаг. Орлогын албан татварын эрх зүй, татварын процессын эрх зүйгээр мэргэшин тогтмол судалгаа хийж байна.

ГАРЧИГ

УДИРТГАЛ 15

НЭГ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫН ТУХАЙ

ОЙЛГОЛТ 18

1.1. Эдийн бус гэм хор ба сэтгэл санааны хохирол 18

1.2. Сэтгэл санааны хямрал (дистресс) ба
сэтгэл санааны хохирол 21

1.3. Бүлгийн дүгнэлт 27

ХОЁР. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА 28

2.1. Үндсэн хууль: Сэтгэл санааны хохирлоо
нөхөн төлүүлэх эрх 28

2.2. Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрх,
холбогдох хуулийн зохицуулалтууд 30

2.2.1. Иргэний хууль 30

2.2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх
тухай хууль 33

2.2.3. Гэр бүлийн тухай хууль 36

2.3. Сэтгэл санааны хохирлыг үнэлэн тогтоох тухай
эрх зүйн зохицуулалт 37

2.4. Бүлгийн дүгнэлт 40

ГУРАВ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ПРАКТИК СУДАЛГАА:	
ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	42
3.1. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр	43
3.1.1. Дахин сэргээх боломжгүй эрүүл мэндийн хохирол учирсантай холбоотой сэтгэл санааны хохирол	43
3.1.2. Сэжигтнээр шалгагдан цагдан хоригдож, шүүхээс хорих ял сонссоны эцэст цагаатгагдсан иргэний сэтгэл санааны хохирол	46
3.1.3. Хууль бусаар цагдан хоригдсонтой холбоотой сэтгэл санааны хохирол	49
3.1.4. Урт хугацааны турш таслан сэргийлэх арга хэмжээ авхуулсан, сэжигтнээр татагдсантай холбоотой сэтгэл санааны хохирол	53
3.1.5. Хөнгөн гэмтэл учирсантай холбоотой сэтгэл санааны хохирол	57
3.2. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр	60
3.2.1. Амь насанд гэм хор учруулсантай холбоотой сэтгэл санааны хохирол	60
3.3. Бүлгийн дүгнэлт	64
ДӨРӨВ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	
4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	68
4.2. Япон Улс	73
4.3. Бүлгийн дүгнэлт	79

ТАВ. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ	82
ЗУРГАА. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТТЭЙ УЯЛДУУЛАН ГАРГАСАН САНАЛ	86
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	88

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ИХ	Иргэний хууль
МУ	Монгол Улс
УДШ	Улсын Дээд шүүх
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс

УДИРТГАЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2019 оны гуравдугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлангаас үзэхэд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг арилгах (нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан)-тай холбоотой маргаан иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй нийт маргааны гурван хувийг эзэлжээ. Өөрөөр хэлбэл, эдийн бус гэм хорыг арилгахтай холбоотой маргаан иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй бусад маргаантай харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлж байна.

Бидний судалж буй сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой маргаан нь бусдын буруутай, хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас үүсдэг. Ялангуяа бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас сэтгэл санааны хохирол дагалдан гарах нь элбэг тохиолддог ажээ. Харин бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас бусад байдлаар учирсан эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэж байгаа эсэхтэй холбоотой судалгаа, мэдээлэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргадаг шүүн таслах ажиллагааны аль ч оны тайланд тусгагдаагүй байна. Энэ нь Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хор гэж зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдлыг тооцохоор хязгаарлагдмал хүрээнд зохицуулсантай холбоотой гэж үзэж байна.

Түүнчлэн сэтгэл санааны хохирлыг судлах явцад манай улсад эдийн бус гэм хор, тэр дундаа бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой хохирлын талаарх судалгаа тодорхой хэмжээнд хийгдсэн байх боловч эдийн ба эдийн бус эрх, ашиг сонирхолд хохирол учруулсны улмаас үүсэж байгаа сэтгэл санааны хохирлын асуудлыг тодорхой судлагдахуун болгож судлаагүй иржээ. Гэтэл сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь хуулиар хамгаалагдсан буюу Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрх мөн. Харин Иргэний хуульд сэтгэл санааны хохирол, түүнийг хэрхэн үнэлэх тухай зохицуулаагүй тул сэтгэл санааны хохирлыг судлагдахуун болгож судлах, хууль зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий болж байна.

Энэхүү судалгааны тайлан нь нийт зургаан бүлэгтэй. Нэгдүгээр бүлэгт сэтгэл санааны хохирлын тухай ойлголт буюу эдийн бус гэм хор ба сэтгэл санааны хохирлын харилцан хамаарал, сэтгэл санааны хохирлын үндсэн элемент болох сэтгэл санааны дистрессийн тухай; хоёрдугаар бүлэгт сэтгэл санааны хохирлыг Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн зохицуулж, хамгаалж байгаа талаар; гуравдугаар бүлэгт сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ; дөрөвдүгээр бүлэгт сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой бусад улсын зохицуулалтын харьцуулсан судалгааг багтаасан бол тавдугаар бүлэгт дээрх бүлэг тус бүрийн гол санаа, үндсэн үзэл баримтлалыг нэгтгэн дүгнэж, уг дүгнэлтдээ үндэслэсэн судалгааны санал дэвшүүлэв.

Уг судалгаагаар гэм хорын эрх зүйд тулгамдаж буй асуудлын нэг болох сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой асуудлыг олж илрүүлснээр Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад харгалзан үзэх нэг эх

сурвалж болох ач холбогдолтой юм. Судалгааны цар хүрээний хувьд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирснаас бусад байдлаар үүсэж буй сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой үүсэж буй хууль зүйн асуудлыг судлахыг зорилоо.

1

НЭГ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

1.1. ЭДИЙН БУС ГЭМ ХОР БА СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

Эдийн бус гэм хор болон сэтгэл санааны хохирлын харилцан хамаарал, эдгээр ойлголтын ялгааг юуны түрүүнд тайлбарлах нь зүйтэй. Үүрэг үүсэх үндэслэлийг гэрээний ба гэрээний бус гэж ангилдаг. Гэрээний бус үүрэг нь хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа, зөрчлийн улмаас үүсэх үүргийн харилцаа гэж хуваагдах бөгөөд гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь зөрчлийн улмаас үүсэх үүрэгт хамаардаг. Амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг эдийн бус гэм хорын хохирол гэж үздэг бол материаллаг шинжтэй буюу эд хөрөнгийн бодит үнэ, алдагдал, олох ёстой байсан орлого нь эд хөрөнгөд учирсан гэм хорд тооцогддог байна.¹

Гэм хор болон хохирол зэрэг нь ялгаатай ойлголтууд юм. Тухайлбал, Иргэний хууль тогтоомжид эдийн бус хохирол хэмээх ойлголтын тухай томъёолоогүй харин эдийн бус гэм хор гэж томъёолсон байдаг. Гэм хор нь хохиролтой харьцуулахад зөрчлийн эрх зүйн хувьд илүү өргөн хүрээг хамарсан ойлголт

¹ Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV, УБ., 2016, 54 дэх тал.

юм. Учир нь гэм хор нь өөртөө хохирол, хор уршиг гэсэн ойлголтыг багтаадаг. Иргэний хуульд хохирлын талаар тодорхойлон тусгасан боловч хор уршиг хэмээх ойлголт, нэр томъёог тусгаагүй. Харин Монгол Улсын Эрүүгийн хуульд хохирол, хор уршиг гэсэн хоёр ойлголтыг ялгаатай байдлаар томъёолсон байдаг.² Эрүүгийн хуульд гэмт хэргийн улмаас шууд учирсан үр дагаврыг хохирол; гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршиг гэж тодорхойлсон.

Судлаачдын зүгээс сэтгэл санааны гэм хор бус харин сэтгэл санааны хохирол гэж томъёолох нь үндэслэлтэй гэж үзсэн. Учир нь Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд Эдийн бус гэм хор гэж малгай зохицуулалт тусгасан боловч тус зүйлийн заалт буюу агуулгад зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн эрхийн зөрчлийг сэргээн эдлүүлэхээр тусгасан юм. Харин сэтгэл санааны хохирол нь хүний эрх, ашиг сонирхол зөрчигдсөний улмаас үүсэн бий болдог тул ийнхүү сэтгэл санааны гэм хор бус, сэтгэл санааны хохирол гэж энэхүү судалгаанд томъёолж хэрэглэснийг дурдах нь зүйтэй. Гэхдээ энэхүү судалгаагаар иргэний эрх зүйн харилцаанд үүсэж буй сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой үүсэж буй асуудлыг илүү хөндөхийг зорьсон тул тулгамдсан асуудлыг авч үзье.

Эдийн бус гэм хор гэдэгт материаллаг бус бүх хохирлыг хэлнэ. Энд тухайлбал, бие эрхтний болон сэтгэцийн хохирол, цаашлаад амьдралын баяр баясгалан байхгүй болох, зайлшгүй хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна.³ Эдийн бус гэм хор хэмээх нэр томъёо нь манай улсын эрх зүйн тогтолцоонд аль хэдийнээ хэрэглэгдэж,

² Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйл.

³ Ё.Кают, Э.Шпанглер нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, УБ., 2010, 458 дахь тал.

хуульд тусгагдсан боловч үндсэн агуулга, зарчмын хувьд бүрэн тодорхойлогдож шүүхийн практикт хэрэглэгдэхгүй байгааг дурдах нь зүйтэй.⁴ Учир нь Иргэний хуульд болон бусад хуульд эдийн бус гэм хор хэмээх ойлголтыг тодорхойлоогүй. Монгол Улсын Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-д эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй гэж заасан боловч эдийн бус гэм хор гэдэгт юу ойлгох талаар хуульд тусгайлсан заалт үгүй байна.⁵ Харин ХБНГУ, Япон, Франц зэрэг улсын Иргэний хуулийг судалж байхад эдийн бус гэм хорын ойлголтыг хуулиар тодорхойлоогүй байх боловч хамгаалагдах эрх, ашиг сонирхлоор нь эдийн бус гэм хорын хүрээ хязгаарыг тодорхойлсон нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан **эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ**” гэж зааснаас харахад бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг эдийн бус гэм хорын хүрээнд хамааруулсан. Дээрх нэр томъёог хэт явцуу тодорхойлсны улмаас эдийн бус гэм хорд хамаарах сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх боломж хязгаарлагдах зэрэг үндсэн эрхийн зөрчил бий болсоор байна.

⁴ УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 592, УДШ-ийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Дугаар 169, УДШ-ийн 2019 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн Дугаар 692 тогтоолуудыг тус тус судлан дүн шинжилгээ хийхэд эдийн бус гэм хор хэмээх ойлголтод зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамааруулан ойлгож байгаа бөгөөд харин бусдын буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас бие махбод, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирснаас бий болох сэтгэл санааны хохирлыг Иргэний хуульд тусгайлан заагаагүй гэж үзэж, эдийн бус гэм хорд багтаан ойлгохгүй байна.

⁵ Э.Золзаяа, Монгол Улсын болон гадаад улсын иргэний эрх зүй дэх сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлын эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа, “Эрх зүй” сэтгүүл, 2014, №1 (27), 45 дахь тал.

Эдийн бус гэм хор хэмээх ойлголтод сэтгэл санааны хохирол багтах ба сэтгэл санааны хохирол гэдгийг юу гэж ойлгохыг хуульд тусгайлан зохицуулаагүй. Сэтгэл санааны хохирлыг тодорхойлохын өмнө сэтгэл санааны хямрал хэмээх ойлголтыг тодорхойлох шаардлагатай. Сэтгэл санааны хямрал буюу дистресс⁶ гэдэг нь бусдын хууль бус үйлдлийн үр дүнд үүсэх сэтгэл санааны, оюуны зовлон, шаналлыг хэлэх бөгөөд үүнд уй гашуу, сэтгэл гонсойх, уур уцаар төрөх, бахархал үгүй болох, ичих, олон нийтийн доромжлолд өртөх, цөхрөл зэрэг хамаарах⁷ ба дээрх хямрал нь сэтгэл санааны хохирол болно.

Эдийн бус гэм хор хэмээх нэр томъёог явцуу утгаар хуульд зааснаас өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо мөнгөн хэлбэрээр бусдаар гаргуулах боломжгүй байна. Учир нь (i) эдийн хохирлоос гадна эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлоо бусдаар нөхөн төлүүлэх талаар Иргэний хууль болон бусад⁸ хуульд тусгаагүй; (ii) сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулахын тулд уг хохирлыг мөнгөн хэлбэрээр гаргуулах талаар хуульд тусгайлан заасан байх⁹ ёстой юм.

1.2. СЭТГЭЛ САНААНЫ ХЯМРАЛ (ДИСТРЕСС) БА СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

Сэтгэл санааны хохирлыг тайлбарлахын өмнө сэтгэл мэдрэлийн эмгэг, өвчлөлийг бид судлах шаардлага үүсэж байна. Сэтгэц

⁶ Англиар “Emotional distress, mental harm, mental distress, mental suffering, mental anguish” гэх зэргээр томъёолсон байна.

⁷ Black’s law dictionary (7th ed. 1999), 542 дахь тал.

⁸ Судлаачийн зүгээс бусад хууль гэдэгт Иргэний хуулиас бусад салбар эрх зүйн хууль тогтоомжийг дурдсан болно. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэтгэл санааны хохирлоо мөнгөн хэлбэрээр гаргуулах тухай тодорхой заасан байдаг.

⁹ Ц.Одмаа, Нийтийн эрх зүйн бүлийн зарим улс дахь эдийн бус гэм хорыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2009, №1, 55 дахь тал.

мэдрэлийн өвчнийг дагнан судалдаг судлаачид хүний бие болон оюун санаа, мэдрэл нь хоорондоо харилцан үйлчлэл бүхий нөлөө үзүүлдэг гэдгийг судлан хөгжүүлж эхэлсэн.¹⁰ Энэ үүднээс сэтгэл санааны хямрал нь үүсэн бий болохдоо бусдын учруулсан эдийн болон эдийн бус хохирлоос үүдэлтэй байдаг гэж үзэж болно. Ийм учраас сэтгэл санааны хохирлыг үргэлжилсэн шинжтэй байдлаар илэрдэг гэж үздэг. Эрүүл мэнд гэж хүн зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, сэтгэц, оюун санаа, нийгмийн сайн сайхан байдлын цогц бүрдлийг хэлнэ.¹¹ Эндээс харахад эрүүл мэндийг биеийн болон нийгмийн, сэтгэцийн эрүүл мэнд гэж гурван бүрэлдэхүүнд хуваан авч үзэж байна. Сэтгэцийн эрүүл мэнд гэсэн ойлголтыг ихэнх хүмүүс сэтгэцийн өвчин эмгэгтэй холбон андуу ташаа ойлгодог. Гэтэл сэтгэцийн эрүүл мэнд гэдэг нь маш өргөн хүрээний ойлголт юм. Тухайн хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, оюун санаа, бие хүний хувьд ямар нэг эмгэггүй байхыг хэлдэг.¹² Гэтэл бусдын учруулсан эдийн болон эдийн бус хохирлын улмаас сэтгэл санааны хямралтай байгаа хүнийг эрүүл хүн гэж үзэх үү эсхүл түр зуурын стресс гэж үзэх үү гэдгийг бид анзаарах шаардлага үүснэ. Аль ч тохиолдолд хүн эрүүл бус байна гэж үзнэ. Учир нь сэтгэл санааны хямрал өөрөө стрессийн нэг хэлбэр юм.

Гэнэтийн, санамсаргүй, урьдчилан төлөвлөөгүй аливаа тааламжгүй явдлаас болж сэтгэл санаа, бие махбод доройтон хямрахыг стресс гэнэ.^{13,14} Хувь хүнд нөлөөлөх байдлаар нь

¹⁰ Betsy J. Grey, The Future of Emotional Harm, 83 Fordham L. Rev. 2605 (2015), 2624 дэх тал.

¹¹ Швейцарын хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Стрессийг үүсгэх шалтгаан ба оношилгоо, тусламж: Мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ., 2010, 11 дэх тал.

¹² Мөн тэнд, 11 дэх тал.

¹³ Мөн тэнд, 15 дахь тал.

¹⁴ Finja Marten, The Mediating Effect of Eustress and Distress on the Relation between the Mindset Towards Stress and Health, 4 дэх тал.

стрессийг эустресс, дистресс гэж ангилдаг.¹⁵ Эустресст баярлах, инээх, сэтгэл ханах, сэтгэл догдлох, хөөрч баярлах, хайрлах зэрэг эерэг сэтгэл хөдлөл үүсгэдэг стресс ордог бол дистресст гомдох, уурлах, бухимдах, уйтгарлах, айх, ичих гэх мэт сөрөг сэтгэл хөдлөл үүсгэдэг стресс багтдаг байна.¹⁶

Хүний гадаад юмс үзэгдэлд ямар байр суурьтай байгаа, сэтгэл мэдрэмжийн дотоод хандлагаа илэрхийлэн гаргах хэлбэр бол сэтгэлийн хөдөлгөөн юм. **Сэтгэцийн байдал бол орчны юмсад үнэлэлт дүгнэлт өгөх, баримжаалах үүрэгтэй.**¹⁷ Сэтгэлийн хөдөлгөөн энэ үүргээ гүйцэтгэхдээ эерэг болон сөрөг олон янзаар илэрхийлнэ.¹⁸ Сэтгэл санааны хямралд өртсөн этгээдэд сэтгэлийн хөдөлгөөн сөрөг хэлбэрээр илрэх ба гашуудах, нойргүйдэх, сэтгэлээр унах, сэтгэлийн шаналал, зовлонтой байх, цөхрөх, айх, ичих, уурлах, сэтгэлийн түгшүүртэй болох, санаж, мартаx зэрэг хэв шинжээр илэрнэ. Иймд дээрх судалгаа, дүгнэлтүүдээс үзэхэд сэтгэл санааны хохирол нь бие махбодод хохирол учрахтай адил сэтгэцийн гэмтэл үүсгэдэг бөгөөд бие махбодын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэж дүгнэж болохоор байна.

¹⁵ Amir Mohammad Shahsavarani, Esfandiar Azad Marz Abadi, Maryam Hakimi Kalkhoran, Stress: Facts and Theories through Literature Review, International Journal of Medical Reviews, Volume 2, Issue 2, Spring 2015, 233 дахь тал.

¹⁶ Мөн тэнд, 16 дахь тал.

¹⁷ Б.Батсайхан, М.Дэлгэржав, Ерөнхий сэтгэл судлал (Анхны хэвлэл) УБ., 2013, 212 дахь тал.

¹⁸ Мөн тэнд.



Зураг 1-ээс үзэхэд стрессийн хэлбэр болох дистресс нь хүний эрүүл мэндэд хэвийн бус үйл ажиллагаа бий болгодог бөгөөд ингэснээр эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, стрессийн муу хэв шинжүүд илэрдэг байна. Сэтгэл санааны хямрал дистресс бол өргөн утгаараа сэтгэлийн тавгүй байдал, сэтгэл гутралын хэв шинжүүдийн үр дүнд үүсэн бий болж буй сэтгэлийн зовлон шаналал¹⁹ гэдгийг дээрх зургаас харж болно.

Дээрх үзэл баримтлалтай холбогдуулан “...хувь хүний оюун санаа, сэтгэл амар тайван байх ашиг сонирхлыг хуулиар зохицуулж хамгаалахыг хүлээн зөвшөөрөх нь зохистой”.²⁰

¹⁹ Aline Drapeau, Alain Marchand and Dominic Beaulieu-Prévost, *Epidemiology of Psychological Distress*, 2012, 5 дахь тал.

²⁰ M.Lee Huffaker, *Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama*, 2003, 1003 дахь тал. Francis X. Clinch and Jodie L. Johnson, *Compensation of Emotional Distress in Montana: Distinctions between Bystanders and Direct Victims*, 47 Mont. L. Rev. (1986), 1 дэх тал.

Шүүхийн хувьд хэд хэдэн шинж, урьдчилсан нөхцөл хангаж байгаа тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой гэж үзсэн: (i) санаатай болон болгоомжгүй гэм буруутай байх; (ii) үйлдэл нь жигшим, зэвүүцмээр, хэнд ч мэдэгдэхүйц сэтгэл санааны хохирол учруулах үйлдлээр илэрсэн байх; (iii) дээрх үйлдэл нь нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирол учрах шалтгаан болсон байх явдал юм²¹. Сэтгэл санааны хохирол учирсан эсэхийг тогтоох нэг үндэслэл нь хохирол учрахад гол шалтгаан болсон үйлдэл болон үр дагаврын хоорондын шалтгаант холбоо байдаг. Энэ талаар Блэйкийн толь бичигт “Хэдийгээр сэтгэл санааны хямрал үүссэнийг нэхэмжлэгч нотлох ёстой хэдий ч хариуцагчийн зэвүүцмээр, хэн ч харсан сэтгэл санааны хохирол учруулахуйц хүнд, ноцтой үйлдэл нь өөрөө сэтгэл санааны хохирол бий болсон эсэхийг нотлоход ихээхэн ач холбогдолтой байдаг”²² гэж дурджээ. Үүнээс үзэхэд сэтгэл санааны хямрал хохирогчид учирсан эсэхийг тогтооход нэлээд хүндрэлтэй байхаас гадна сэтгэл санааны хохирлыг сэтгэл зүйч, эмчийн тусламжтайгаар тогтоох нь ихээхэн үр дүнтэй юм. “Сэтгэл санааны хямрал буюу дистресс”²³ гэдэг нь бусдын хууль бус үйлдлийн үр дүнд үүсэх сэтгэл санааны, оюуны зовлон, шаналлыг хэлэх бөгөөд үүнд уй гашуу, сэтгэл гонсойх, уур уцаар, бахархал үгүй болох, ичих, олон нийтийн доромжлолд өртөх, цөхрөл зэрэг хамаарах²⁴ ба дээрх хямрал нь сэтгэл санааны хохирол болно.

Манай улсын 2002 оны хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хор, сэтгэл санаанд учирсан үр дагавар, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

²¹ M.Lee Huffaker, Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama, 2003, 1004 дэх тал.

²² Black's law dictionary (7th ed. 1999), 542 дахь тал.

²³ Англиар “Emotional distress, mental harm, mental distress, mental suffering, mental anguish” гэх зэргээр томъёолсон байна.

²⁴ Black's law dictionary (7th ed. 1999), 542 дахь тал.

тухай хуульд сэтгэл санааны үр дагавар, сэтгэл санаанд учирсан хор уршиг, сэтгэл санааны хохирол, Гэр бүлийн тухай хуульд сэтгэл санааны хохирол гэсэн нэр томъёог тус тус хэрэглэсэн байдаг. Манай улсын хувьд сэтгэл санааны хохирол гэсэн нэр томъёог хэрэглэхдээ зөвхөн Иргэний хуульд зааснаар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбогдуулан ойлгох хандлага их гардаг. Гэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэр бүлийн тухай хуулийн холбогдох заалтуудаар²⁵ сэтгэл санааны хохирлыг илүү өргөн хүрээнд тодорхойлсон буюу гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хувьд хохирох, хууль бус ажиллагааны улмаас сэтгэл санаанд хор уршиг бий болох, гэрлэгчдийн хооронд үүсэх сэтгэл санааны хохирол учрах зэрэг нөхцөлүүдийг тусгасан нь ихээхэн ач холбогдолтой юм.

Ийнхүү хуульд тусгаснаар сэтгэл санааны хохирлыг сэтгэл санааны хямрал хэмээх ойлголтоор тайлбарлах боломжтой болж байгаа юм. Гэр бүлийн зүй бус харилцааны улмаас сэтгэл санааны хохирол учрах нөхцөлд гэрлэгсэд сэтгэл санаагаар унах, дарамтад орох, айх, ичих, нойр хүрэхгүй байх, уур уцаартай болох, амьдралын баяр баясал үгүй болох, цөхрөх зэрэг байдлаар илэрдэг. Харин хууль бусаар мөрдөн шалгах ажиллагааны улмаас хохирогчийн эрүүл мэнд муудах, амь нас эрсдэх, сэтгэлээр унах, гонсойх, айх, ичих, амьдралын баяр баясалгүй болох, өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ алдах, уур уцаартай болох, олон нийтийн доромжлол хүртэх, зовлон, шаналлыг хүртэх зэрэг сөрөг стресс үүсэж байдаг. Энэ нь бидний тодорхойлж байгаагаар сэтгэл санааны хохирол болон илэрч байгаа юм.

²⁵ Холбогдох зохицуулалтуудыг энэхүү судалгааны 2 дугаар бүлгийн 2.2 дахь хэсгээс харна уу.

1.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Эдийн бус гэм хор нь сэтгэл санааны хохирол хэмээх ойлголтыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Эдийн бус гэм хорд хамаарах сэтгэл санааны хохирлыг хууль болон эрх зүйн бусад актаар тодорхойлж өгөөгүй бөгөөд өнөөдрийг хүртэл практикт сэтгэл санааны хохирол гэж юу болох, хэрхэн үүсдэг талаар тайлбарлаж байгаагүй. Судалгааны энэ хэсэгт сэтгэл санааны хямрал буюу дистресс хэмээх ойлголтыг судлан мэдсэний үндсэн дээр сэтгэл санааны хохирлыг тодорхойлох боломжтой гэж үзэв. Сэтгэл санааны хямрал буюу дистресс гэдэг нь бусдын хууль бус үйлдлийн үр дүнд үүсэх сэтгэл санааны, оюуны зовлон, шаналлыг хэлэх бөгөөд үүнд уй гашуу, сэтгэл гонсойх, уур уцаар, бахархал үгүй болох, ичих, олон нийтийн доромжлолд өртөх, цөхрөл зэрэг хамаарах ба дээрх хямрал нь сэтгэл санааны хохирол болно. Сэтгэл санааны хохирол нь үндсэндээ дам байдлаар үүсэн бий болдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл, бусдын санаатай үйлдлийн улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдаж сэтгэл санааны гүн хямралд орж сэтгэл санааны хохирол учирсан, бусдын нэр төр, алдар хүндийг гутаасны улмаас тухайн хүнд сэтгэл санааны хохирол учирсан, бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас сэтгэл санааны хохирол учирсан зэрэг үндсэн хохирлоос улбаалан дам байдлаар сэтгэл санааны хохирол учирдаг байна.

Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хорын хүрээг тодорхойлохдоо зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, дүрсийн эрхээр хязгаарласан нь бусад байдлаар учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн гаргуулах боломжгүй болоход хүргэсэн байна.

ХОЁР. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

2.1. ҮНДСЭН ХУУЛЬ: СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛОО НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй” гэж заасан. Иргэний хэргийн шүүхэд “гомдол гаргаж хохирлоо нөхөн төлүүлэх” эрх нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах гол баталгаа болж байдаг билээ.²⁶

Хохирол гэдэгт аливаа этгээдийн үнэт зүйлс нь түүний хүсэл зоригийн эсрэг утсан, дордсон, муудсан явдлыг ойлгож болно.²⁷ Уг хохирлыг эдийн буюу материаллаг, эдийн бус буюу материаллаг бус хохирол гэж ангилан авч үздэг ба эдийн бус хохиролд сэтгэл санааны хохирол хамаарах юм. Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хангах нь Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах үзэл баримтлал, иргэний эрх зүйн хохирол арилгахаас өмнөх байдалд эрхийг

²⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 2018-09-21, Дугаар 11.

²⁷ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011, 110 дахь тал.

сэргээх²⁸ үндсэн зарчимд тус тус нийцнэ. Хүний эрх, эрх чөлөө нь хууль зүйн олон эх сурвалжтай учир хүний салшгүй болон бусад эрх, эрх чөлөөг Үндсэн хуульд жагсааж бичээгүй, харин тэр бүхний үндсийг нь бэхжүүлсэн онцлогтой.²⁹

Энэ үүднээс Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “МУ-ын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл ...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...эрхтэй” гэсэн зохицуулалтыг бусад органик хуультай уялдуулан системчлэн тайлбарлах замаар Үндсэн хуулийн суурь үзэл санааг ойлгох нь зүйтэй. Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн үзэл баримтлалыг ИХ-ийн 228-230, 497, 511 дүгээр зүйл, заалтад тодорхой тусгасан. Эдгээр зохицуулалт нь гэм хорын эрх зүйн үндсэн зорилго болох хохирлыг бүрэн нөхөн төлүүлэхэд оршино.

Хохирол олгоход чиглэсэн эрх зүйн зохицуулалтууд нь юуны түрүүнд эрхийг өмнөх байдалд нь нөхөн сэргээх, тэнцвэржүүлэхэд чиглэнэ. Хохирлыг нөхөн сэргээх боломжгүй бол хохирогчийн сэтгэлийг хангах замаар хохирлыг мөнгөөр барагдуулж болно. Учир нь хүнд учирсан сэтгэл санааны хохирлыг бага ч болов мөнгөн төлбөрөөр орлуулах нь аливаа зөрчил гаргасан этгээд бүхий л хохирлыг хариуцах үндсэн зарчимд нийцнэ.³⁰

Дээрхээс гадна хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх явдал нь өмнөх зөрчигдсөн эрхийн үргэлжлэл болж өгдөг. Аль ч хохирол арилгахтай холбоотой шаардах эрх холбогдох этгээдийн субьектив эрх, эрх зүйн үнэт зүйлсийг зөрчсөнөөр л үүснэ. Тиймээс аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас

²⁸ Б.Улаанбаатар, Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2006, 910-911 дэх тал.

²⁹ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага, УБ., 2017, 194 дэх тал.

³⁰ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011, 112 дахь тал.

тодорхой гэрээний үүрэг эсвэл хамгаалагдсан эрх, үнэт зүйлд халдсан байх явдал бол хохирол шаардах эрх үүсэх анхдагч нөхцөл юм. Энэхүү шаардах эрх нь эрхийг өмнөх байдалд нь сэргээхэд чиглэх тул эрх зүйн үүднээсээ хохирол арилгаж буй явдал өөрөө тухайн эрхийн үргэлжлэл болох чиг үүрэгтэй.³¹ Энэхүү үзэл баримтлалыг Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж зохицуулсан.

2.2. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛОО НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ, ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТУУД

2.2.1. Иргэний хууль

Монгол Улсын Иргэний хуулийг боловсруулж байх үед ХБНГУ-ын Иргэний хуулийн нэгэн адил тодорхой нөхцөл өгөгдсөн, биелсэн тохиолдолд л аливаа этгээдэд учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилж болохоор зохицуулагдсан.³² Ингэснээрээ зарим улсад элбэг тохиолдох, хууль бус үйлдлийн улмаас гэм буруутайгаар хохирол учруулсан л бол гэм хорыг арилгадаг нийтлэг нэг хэмжээнд багтаан зохицуулах хэлбэрээс татгалзсан.³³ Иргэний хуулийн зохицуулалтыг системчлэлийн үүднээс харахад Иргэний хуулийн ерөнхий анги буюу 228-230 дугаар зүйлд заасан зохицуулалтаар хохирол арилгах арга хэлбэрийг тодорхой зохицуулж өгсөн бол Иргэний хуулийн тусгай анги буюу

³¹ Б.Буянхишиг, Үүргийн эрх зүй (Ерөнхий анги), УБ., 2013, 236 дахь тал.

³² Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011, 472 дахь тал.

³³ Мөн тэнд.

497-514 дүгээр зүйлд гэм хорын тусгай төрлүүдийг зааж өгсөн байна.³⁴

Аливаа зөрчлийн улмаас хохирол амссан этгээдэд үүссэн алдагдал, нэмэлт зардал буюу хохирлыг тухайн зөрчлийг гаргасан хүнээр нөхөн төлүүлэх үндэслэлийг гэм хорын эрх зүйгээр зохицуулдаг.³⁵ Энэхүү эрх зүйн зохицуулалт юуны түрүүнд хохирол арилгахад чиглэсэн буюу нөхөн төлбөрийн зорилготой гэж үздэг. Харин эдгээр зохицуулалт нь хохирол арилгахад чиглэсэн буюу нөхөн төлбөрийн зорилгодоо хүрч чадахгүй тохиолдолд хохирол учирсан этгээдийн эрх зүйн байдал дордох аюултай байх юм.

Сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулахад хууль хэрэглээний хувьд Иргэний хуулийн тусгай ангид заасан 497 дугаар зүйлийн 497.1, 511 дүгээр зүйлийн 511.1 дэх зохицуулалтыг хэрэглэх бөгөөд хохирлыг барагдуулахдаа Иргэний хуулийн 228-230 дахь зохицуулалтыг хэрэглэх юм. Өөрөөр хэлбэл, тусгайгаас ерөнхий гэсэн “хаалт”-ын аргачлалын дагуу Иргэний хуулийг хэрэглэдэг. Гэтэл Иргэний хуулийн тусгай анги болох Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн гаргуулж байхаар хүрээ хязгаар тогтоосон.³⁶ Дээрхээс бусад эдийн бус эрхэд халдсан тохиолдолд сэтгэл санааны хохирол гаргуулах боломжгүй байгаа юм. Учир нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Зөвхөн хуульд тусгайлан заасан

³⁴ Тусгай ангид заасан гэм хорын тусгай төрөлд ажил олгогчийн хариуцлага, тээврийн хэрэгсэл ашигласнаас үүдэх хариуцлага, барилга, байгууламжийн өмчлөгч, эзэмшигчийн хариуцлага, амьтны учруулсан гэм хорыг өмчлөгч, эзэмшигч хариуцах, аюултай ажиллагаанаас үүдэх хариуцлага, үйлдвэрлэгчийн болон ажил үйлчилгээ санал болгогчийн хариуцлага зэрэг багтана.

³⁵ Ж.Оюунтунгалаг, Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019, №1 (71), 9 дэх тал.

³⁶ Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК), Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ, УБ., 2013, 2 дахь тал.

тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн гаргуулна” гэж зааснаар хязгаарласан юм. Иргэний хуульд зааснаар үүсэх шаардах эрхийн тухайд гэрээний харилцааг үндэслэл болголтгүй хуульд заасан хэргийн бүрэлдэхүүн хангагдсан нөхцөлд хэрэгжих шинжтэй байдаг.³⁷

Монгол Улсын хувьд эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг Иргэний хуулиар зохицуулж байна. Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Иргэний эрх зүйн харилцаа дараах үндэслэлээр үүснэ”, 8.1.5-д “Гэм хор учруулах”, 9 дүгээр зүйлийн 9.4-т “Иргэний эрхийг дараах аргаар хамгаална”, 9.4.5-д “Эдийн бус гэм хорыг арилгуулах”, 228 дугаар зүйлийн 228.1-д “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно”, 230 дугаар зүйлийн 230.1-д “Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй”, 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө”, 497 дүгээр зүйлийн 497.1-д “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”, 511 дүгээр зүйлийн 511.1-д “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ”, 511.2-т “Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан

³⁷ Гүнтэр Кристиан Шварц, Манфрэд Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй (3 дахь хэвлэл), УБ., 2017, 3 дахь тал.

хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно” гэж тус тус зохицуулсан.

Иргэний хуулийн үзэл баримтлалаас судлан үзэхэд эдийн бус гэм хорыг тодорхой заагаагүйгээс гадна эдийн бус гэм хор хэмээх ойлголтод зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг багтаасан байна. Түүнчлэн эдийн бус гэм хорын заалтад бусдын бие махбод, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсны улмаас бий болох сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр хэрхэн барагдуулах тухай зохицуулаагүй.

2.2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй”, 45.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана” гэж тус тус зохицуулсан. Дээрх зохицуулалтаас үзэхэд Иргэний хуульд бусдын бие махбод, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсны улмаас бий болох сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах талаар тусгаагүй ч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын улмаас сэтгэл санаанд хохирол бий болсон бол

мөнгөн хэлбэрээр нэхэмжлэх боломжийг хуульд тодорхой заасан. Гэхдээ иргэний хэргийн шүүх дээрх зохицуулалтыг хэрэглэж, сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахгүй байх практик сүүлийн үед тогтож байна. Учир нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан зохицуулалтын дагуу сэтгэл санааны хохирлыг гаргуулахаар Иргэний хуульд тусгайлан заагаагүй гэж тайлбарлаж байгаатай холбоотой юм.

Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ” гэж заасны дагуу Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль хэрэглэхдээ төсөөтэй байдлаар хууль тогтоомжийг тайлбарлан хэрэглэх боломжтой. Гэтэл шүүх эдийн бус гэм хор болон сэтгэл санааны хор уршгийг арилгах заалтыг хэрэглэхдээ Иргэний хуульд тухайлан зохицуулалт байхгүй нөхцөлд шаардлагыг хангах боломжгүй гэж шийдвэрлэж байгаа нь хуулийг хэрэглэхээс татгалзсантай нэгэн адил юм.

Иргэний хуульд гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх тухай заасан бөгөөд уг тусгайлсан заалт нь нарийвчилсан хууль болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан байна. Энэ хоёр зохицуулалтыг системчлэлийн аргаар тайлбарлах боломжтой.

Эрүүгийн эрх зүйд хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглодог ч иргэний эрх зүйд хуулийг төсөөтэй хэрэглэхийг хүлээн зөвшөөрдөг. Энэ талаас нь харахад Иргэний хуулийн 230.2 дахь зохицуулалтын хүрээг нэмэгдүүлэх үүднээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1, 45.4 дэх зохицуулалтыг төсөөтэй байдлаар хэрэглэх бүрэн боломжтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Иргэний хуулийн 497.1 дэх хэсгийн зохицуулалтын хүрээ:

Иргэний хуулийн Тавин хоёрдугаар бүлэгт “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг”-ийг зохицуулсан бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд зөрчлийн улмаас үүсэх объект буюу эрхийг тоочиж тусгасан гэж болно. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-т “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж заасан. Дээрх зохицуулалтад эдийн бус гэм хорын хүрээг зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээр хязгаарлаж тусгасан тул шүүхийн практикт дээрх эрхийг хуульд зөвхөн тусгасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр олгоно гэсэн үндэслэлээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээс бусад эдийн бус гэм хорд хамаарах үндэслэлийг үгүйсгэсээр ирсэн.

Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолд³⁸ “Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйгээр учруулсан гэм хорыг ойлгоно”, түүнчлэн “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “...эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан ба “...хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовуурь шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй” гэж тайлбарласан байдаг ба

³⁸ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай, Дугаар 15.

шүүх өнөөдрийг хүртэл дээрх хууль хэрэглээний зөвлөмжийн дагуу хууль хэрэглэж ирсэн. Дээрх тайлбар, хууль хэрэглээний зөвлөмжөөс үзэхэд эдийн бус гэм хорыг Иргэний хуулийн 497.1 дэх зохицуулалтаар хязгаарлан ойлгож байгаа нь ажиглагдаж байгаа болно.

Харин “Бусдын эрх” хэмээх ойлголтод бусад хуулиар тогтоосон эдийн бус гэм хорыг арилгах боломжийг багтаасан эсэх нь тодорхойгүй тул шүүх тус заалтыг тайлбарлан хэрэглэх хэрэгцээ шаардлага үүсэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, шүүх системчлэн тайлбарлах аргыг ашиглан Эрүүгийн хуулийн 45.1, 45.4 дэх заалтын дагуу хууль бусаар цагдан хоригдсон этгээдийн сэтгэл санааны гэм хорыг арилгах шийдвэр гаргах бүрэн боломжтой юм.

Учир нь дээрх заалтын “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд” гэснийг үгчлэн тайлбарлавал тусгайлан гэх ойлголт нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх тухай заасан байхыг илэрхийлж байгаа бөгөөд бусад хууль гэдэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан сэтгэл санааны үр дагаврыг мөнгөөр арилгах тухай заалт хамаарах юм.

2.2.3. Гэр бүлийн тухай хууль

Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчийн эрх, ашиг сонирхол хохирсон нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн тал өөрт учирсан материалын болон сэтгэл санааны хохирлыг буруутай этгээдээс Иргэний хуульд заасны дагуу гаргуулах эрхтэй” гэж зохицуулжээ. Гэр бүлийн тухай хуульд сэтгэл санааны хохирлоо шаардах боломж олгосон ч мөнгөн хэлбэрээр барагдуулах талаар тусгаагүй юм. Мөн сэтгэл санааны хохирлоо шаардах урьдчилсан нөхцөл нь гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчийн эрх, ашиг сонирхол хохирсон

нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон байх ёстой. Хуулийн нөхцөлөөс үзэхэд сэтгэл санааны хохирлоо шаардах үндэслэл нь дээрх урьдчилсан нөхцөл байх юм.

2.3. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ҮНЭЛЭН ТОГТООХ ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан “Хохирол нөхөн төлүүлэх эрх”-ийг хангах, зөрчил, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх асуудал юм.³⁹ Иргэний эрх зүйд талууд өөрт учирсан хохиролтой холбоотой нотлох баримт гаргаж өгөх, нотлох үүрэг хүлээдэг. Иргэний хуульд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлыг арилгах хэмжээг мэдээ тараасан, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоохоор хуульчилсан.⁴⁰ Дээрх зохицуулалтаар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлын үнэлгээг тооцох аргачлалыг хуулиар тогтоосон гэж үзэж болно. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгаа эсэхийг нотлох үүрэг хүлээдэг бөгөөд хууль тогтоогч нотлох үүргийг мэдээ тараасан этгээдэд хуваарилсан.

Гэхдээ Иргэний хуулиар дээрх тохиолдлоос бусад нөхцөлд сэтгэл санааны хохирлыг хэрхэн үнэлэх талаар тодорхой зохицуулагдаагүй. Сэтгэл санааны хохирлыг үнэлэн тогтоох зохицуулалт байхгүйгээс сэтгэл санааны хохирлыг нөхөн

³⁹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2007, 417 дахь тал.

⁴⁰ 2002 оны Иргэний хуулийн 511 дүгээр зүйл.

гаргуулах эрх хэрэгжихгүй байх асуудал үүсэж байгаа бөгөөд шүүхийн практикт нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлийнхээ шаардлагыг хэрхэн нотолж байгаагаас хамаарч сэтгэл санааны хохирлыг гаргуулах эсэх асуудлыг шийдвэрлэж ирсэн.

Иргэний хуулийн 228-230 дугаар зүйлд гэм хорыг арилгах хэмжээг тодорхойлох талаар зохицуулжээ. Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-т “Гэм хорын хэмжээг тодорхойлохдоо хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал, гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээг харгалзан үзнэ” гэж зохицуулсан. Дээрх зохицуулалтаас харахад эдийн бус гэм хорыг үнэлэх тухай тодорхой зохицуулалт тусгаагүй боловч шүүгчид гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээ, хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж хохирлын хэмжээг тогтоох боломжийг хуульд заасан. Гэвч ИХ-ийн 229 дүгээр зүйлийн 229.2 дахь хэсгийн зохицуулалт нь шүүхийн практикт сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудалд жишиг болох хэмжээнд хэрэглэгдэж байгаагүй юм. Учир нь манай улсад сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой шаардах эрх олгосон зохицуулалтыг хязгаарлагдмал хүрээнд тусгасны улмаас бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас бусад нөхцөлд сэтгэл санааны хохирол шаардах эрхийг хэрэгжүүлэх эрх хязгаарлагдсан байна. Харин практикт зарим тохиолдолд сэтгэл санааны хохирлыг тодорхой хүрээнд нотолсон, сэтгэл санааны хохирол учруулахуйц илт зэвүүцмээр, жигшим үйлдэл гарсан нь тодорхой баримтаар тогтоогдсон бол талууд хэлцлийн үндсэн дээр харилцан тохиролцож гэрээгээр тохиролцсон хэмжээгээр сэтгэл санааны хохирлыг гаргуулж байна.

Тухайлбал, Хариуцагч Т тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчиж гэмт хэрэг үйлдсэний улмаас нэхэмжлэгч Б-гийн охин П-гийн амь насыг хохироосон болох нь Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн

анхан шатны шүүхийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 1087 дугаартай шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон, хохирогчийн төлөөлөгчөөр түүний эх Б тогтоогдсон. Хохирогчийн төлөөлөгч, хариуцагч нарын хооронд 2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр “Хохирол төлөх хэлцэл” байгуулжээ. Тус хэлцэлд сэтгэл санааны хохирол болох 25,000,000 төгрөгийг таван жилийн хугацаанд төлөхөөр харилцан тохиролцсон байдаг. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатын шүүх тус хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 230 дугаар зүйлд зааснаар хуульд тусгайлан заасан нөхцөлд хохирол барагдуулах эрх зүйн үндэслэлтэй гэж үзэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Харин Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан үзээд талуудын тохиролцоо байх тул тус хэлцлийг үндэслэн хариуцагчаас 25,000,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгох нь Иргэний хуулийн 497.1, 230.1 дэх хэсэгт заасантай нийцнэ гэж үзээд анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж, нэхэмжлэгчийн гаргасан гомдлыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” 15 дугаар тогтоолын 6.2.4-т “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовуурь шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй” гэж дурджээ. Дээрх тогтоолд дурдсаны дагуу эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт тодорхой байхгүй тул сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх боломжгүй нөхцөл үүсэж байна.

2.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсын хувьд хууль тогтоомжийг судлан үзэхэд бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсны улмаас үүсэх сэтгэл санааны хохирлыг шаардах хууль зүйн боломж хязгаарлагдмал байна. Учир нь Иргэний хуульд эдийн бус гэм хор хэмээх ойлголтод бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамааруулан үзэж буй бөгөөд хэрэв сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нэхэмжлэх бол тус зохицуулалт нь зөвхөн хуульд заасан байхыг шаардаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, шаардах эрх олгож буй зохицуулалт Иргэний хуульд тусгагдсан байх ёстой гэсэн үг.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нэхэмжлэх боломжийг тодорхой тусгасан боловч тус зохицуулалтыг шүүх бүр ялгамжтай байдлаар хэрэглэж байгаа нь иргэдийн эрх, ашиг сонирхлыг ихээхэн зөрчиж байна. Иргэний хуулийн 228-230 дугаар зүйлд сэтгэл санааны хохирлыг үнэлэх боломж, хэрэгжүүлэх эрхийг шүүгчийн мэдэлд үлдээсэн харагдаж байна. Үнэлэхдээ гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээ, хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж хохирлын хэмжээг тогтоох ёстой. Гэвч Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2 дахь хэсгийн зохицуулалт нь практикт сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудалд жишиг болох хэмжээнд хэрэглэгдэж байгаагүй юм. Учир нь манай улсад сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой шаардах эрх олгосон зохицуулалтыг хязгаарлагдмал хүрээнд тусгаснаас үүдэн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас бусад нөхцөлд сэтгэл санааны хохирлыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эрх хязгаарлагдсан байсан. Иймээс хохирлыг үнэлэх зохицуулалт ч энэ хугацаанд шүүхийн практикт тогтох түвшинд хэрэглэгдэж байгаагүй юм.

Харин практикт зарим тохиолдолд сэтгэл санааны хохирлыг тодорхой хүрээнд нотолсон, сэтгэл санааны хохирол учруулахуйц илт зэвүүцмээр, жигшим үйлдэл гарсан нь тодорхой баримтаар тогтоогдсон хэргүүдэд талууд хэлцлийн үндсэн дээр харилцан тохиролцож, гэрээгээр тохиролцсон хэмжээгээр сэтгэл санааны хохирлыг гаргуулж байна.

1

ГУРАВ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ПРАКТИК СУДАЛГАА: ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудал нь олон төрлийн маргаанд эдийн бус хохирол байдлаар илрэх боломжтой тул сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан хэргүүдийг бүхэлд нь илэрхийлэх статистик тоон мэдээлэл одоогоор хомс байна. Түүнчлэн эрүүгийн хэргийн хувьд ч гэмт хэргийн улмаас учирсан хохирол байдлаар энэ төрлийн хохирлын нөхөн төлбөрийг шаардах нь цөөнгүй байдаг. Энэ утгаараа сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэрийг эмхэтгэх, түүвэрлэхэд багагүй бэрхшээл тулгарсан. Судлаачдын багийн зүгээс шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой 20 гаруй хэргээс он цагийн хувьд сүүлд шийдвэрлэгдсэн, мөн агуулга давхцуулахгүй байдлаар зургаан хэргийн шүүхийн шийдвэрийг энэхүү судалгаандаа төлөөлүүлэн орууллаа. Ингэхдээ хууль хэрэглээний ялгаатай байдал бий болсон байж болзошгүй гэсэн таамаглалыг тодруулах үүднээс тухайн хэргийг шийдвэрлэж буй шүүхийн хэргийн харьяаллаар нь эрүү, иргэний хэргийн шүүх гэдэг байдлаар ангилан авч үзсэн болно.

3.1. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР

3.1.1. Дахин сэргээх боломжгүй эрүүл мэндийн хохирол учирсантай холбоотой сэтгэл санааны хохирол

Шүүхийн шийдвэр: УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 592 дугаартай тогтоол

Хэргийн үйл баримт: Иргэн С нь нурууны үений суултын улмаас олон жил шаналж байгаа бөгөөд “А” эмнэлэгт тогтмол эмчлүүлдэг байжээ. Тухайн эмнэлэгт гэрээгээр ХБНГУ-аас нуруу, мэдрэлийн мэргэшсэн эмч нар ирж мэс засал хийх гэж байгааг сонсоод иргэн С эмнэлгийн эмч нараас мэс засал хийлгэх шаардлагатай эсэхийг асуусан байна. Эмнэлгийн зүгээс ХБНГУ эмч нар салбартаа мэргэшсэн тул мэс засал хийлгэхийг С-д санал болгожээ.

Ийнхүү С нь нуруундаа мэс ажилбар хийлгэсэн боловч хагалгааны үед эмч нар нурууны мэдрэлээс хол зайтай байрладаг зүүн ташаан дахь артерын судсыг хөндөж тасалсан ноцтой алдаа гаргажээ. Тасарсан судсаар их хэмжээний цус алдаж байсан тул С-ийн амь насыг аврахын тул гуянд нь хиймэл судас залгасан байна. Гэтэл уг судас нь жирэмсэн болсон хүний биеийн байдалд зохицон өөрчлөлт ордог судас байсан. Иймээс уг хиймэл судсыг тавиулсны дараа С цаашид ураг тээх боломжгүй болсон байна. Үүнээс гадна С нь тухайн үедээ 8-9 долоо хоногтой жирэмсэн байсан ба эмч нарын зөвлөгөөний хурлаар амь насанд нь эрсдэлтэй байсан учир ургийг хөндөх нь зүйтэй гэж үзэж, улмаар ургаа авхуулсан байна.

Иргэн С нь “А” эмнэлгээс сэтгэл санааны хохиролд 50,000,000, эд хөрөнгийн хохиролд 31,098,432, нийт 81,098,432 төгрөг шаардан нэхэмжлэл гаргажээ.

Шийдвэрийн агуулга: Анхан шатны шүүхээс С-ийн эд хөрөнгийн хохиролд 18,452,502, харин сэтгэл санааны хохиролд 10,000,000, нийт 28,452,502 төгрөгийг “А” эмнэлгээс гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Харин УДШ-ээс анхан болон давж заалдах шүүх хууль хэрэглээний алдаа гаргасан байна гэж үзэн өөрчлөлт оруулжээ. Уг өөрчлөлтөөр анхан болон давж заалдах шатны шүүхээс сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг олгосныг хангахгүй орхисон байна. Гэхдээ нэхэмжлэгчийн эд хөрөнгөд учирсан зарим хохирлыг үнэлээгүй байна гэж үзэн, эд хөрөнгөд учирсан хохиролд 10,000,000 төгрөг олгуулахаар ханган шийдвэрлэжээ.

Шийдвэрийн үндэслэл (Сэтгэл санааны хохирлын тухайд): “Нэхэмжлэлийн шаардлагын нэг болох сэтгэл, санааны хохирол буюу нэхэмжлэгчид хариуцагчийн үйлдлийн улмаас сэтгэл санааны хохирол учирсан гэж үзэх үндэслэлтэй бөгөөд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-д зааснаар хохирогч эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй боловч мөн зүйлийн 230.2-т “гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан. Мөн хуулийн эдийн бус гэм хорыг арилгах тухай 511 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлыг арилгах асуудал зохицуулагдаагүй тул нэхэмжлэлийн шаардлагын энэ хэсгийг хангах үндэслэлгүй юм. Иймээс сэтгэл, санааны хохиролд 10,000,000 төгрөг гаргасан шүүхийн шийдвэрийн үндэслэл хуульд нийцээгүй хэдий ч уг 10,000,000 төгрөгийн хэмжээнд нэхэмжлэлийн шаардлагын нөгөө нэг хэсэг болох нэхэмжлэгчийн эд хөрөнгөд учирсан гэм хорын шаардлагаас хэрэгсэхгүй болгосон хэсгээс дүйцүүлэн хангах нь зүйтэй”.

Дүн шинжилгээ: Нэхэмжлэгч С-ийн зөрчигдсөн эрх нь сэргээх боломжгүй буюу эрх зөрчигдөхөөс өмнөх байдалд оруулах боломж байхгүй учраас түүний хохирлыг анхан болон давж заалдах шатны шүүхээс Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д зааснаар мөнгөөр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Ингэхдээ Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2 дахь хэсгийг төсөөтэй хэрэглэн сэтгэл санааны хохиролд 50,000,000 төгрөг нэхэмжилснээс 10,000,000 төгрөгийг хангах нь үндэслэлтэй гэж үзжээ. Гагцхүү сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг тооцоолсон аргачлалыг шийдвэртээ тусгаагүй байна.

Харин УДШ-ийн шийдвэрийн байр суурь болон шийдвэрийг салгаж авч үзвэл тус шүүхээс нэхэмжлэгч С-д сэтгэл санааны хохирол учирсан нь үндэслэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Гагцхүү Иргэний хуулийн 230.2 дахь заалтад хуульд тусгайлан заасан байх ёстой гэсэн нөхцөл заасан нь нэр төр, алдар хүндэд гэм хор учирснаас бусад байдлаар сэтгэл санаагаараа хохирсон этгээд хохирсон нь үндэслэлтэй боловч нөхөн төлбөр авах боломжгүй гэж шийдвэрлэжээ. Үүнээс үзвэл УДШ-ээс сэтгэл санааны хохирлыг тооцоолох аргачлал болон түүнийг нотлох асуудлыг бус, зөвхөн хуулийн заалт байхгүй нь сэтгэл санааны хохирол амссан этгээд нөхөн төлбөр авч чадахгүй байх шалтгаан гэж үзсэн болох нь харагдаж байна. Тиймдээ ч хууль хэрэглээний хувьд сэтгэл санааны хохиролтой холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзсан ч тус үнийн дүнгээр эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг нэмэгдүүлж тооцсон байна.

Сэтгэл санааны хохиролтой холбоотой УДШ-ийн байр суурийг дээрх байдлаар дүгнэх нь шүүмжлэл дагуулахыг үгүйсгэхгүй. Гагцхүү үүнтэй төстэй буюу сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй ч сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хангасан хэсэгтэй

дүйцэхүйц нэхэмжлэлийн үнийн дүнг эд хөрөнгийн хохирлын нөхөн төлбөрийн хувиар хангаж шийдвэрлэсэн шийдвэр байгаа юм. Тус шийдвэрийг энэхүү шийдвэрийн араас зориуд танилцуулъя.

3.1.2. Сэжигтнээр шалгагдан цагдан хоригдож, шүүхээс хорих ял сонссоны эцэст цагаатгагдсан иргэний сэтгэл санааны хохирол

Шүүхийн шийдвэр: УДШ-ийн 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 001/ХТ2019/00036 дугаартай тогтоол.

Хэргийн үйл баримт: Иргэн Б-д 2013 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Эрүүгийн хуулийн 153.1-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдөр яллах дүгнэлт прокуророос гаргажээ. Улмаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн ... дугаар шийтгэх тогтоолоор гурван жил хорих ял шийтгэжээ. Б анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргасан ба давж заалдах шатны шүүх 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ... дугаар магадлалаар түүнийг цагаатгажээ. Харин түүний дараа хяналтын шатны шүүх хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан байна.

Нэмэлт мөрдөн байцаалт хийсэн боловч прокурорын газрын 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн ... дугаар тогтоолоор Б-гийн шалгагдаж буй үйлдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Б нь ийнхүү гурван жил сэжигтнээр шалгагдан, анхан шатны шүүхээс гурван жилийн хорих ял сонсож, мөн сэжигтнээр шалгагдах хугацаандаа 30 хоног цагдан хоригдсон болон бусад байдлаар амссан эд хөрөнгийн хохиролд 207,062,483, сэтгэл санааны хохиролд 20,000,000 төгрөгийг Монгол Улсын Засгийн газраас шаардан иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Шийдвэрийн агуулга: Анхан шатны шүүх Монгол Улсын Засгийн газраас Б-д 30 хоног цагдан хоригдсон хугацааны хөдөлмөрийн орлого 192,000, бусад эд хөрөнгийн хохиролд 6,378,600, сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг тус тус, нийт 16,570,600 төгрөг гаргуулж, нэхэмжлэлийн үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Тус шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн байна.

Харин хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, сэтгэл санааны хохиролд хангасан 10,000,000 төгрөг гаргуулах нь үндэслэлгүй гэж хасан, харин өмгөөллийн хөлс болох 9,500,000 төгрөгийг ханган шийдвэрлэх нь үндэслэлтэй гэж үзэн нийт 16,070,600 төгрөгийг хохирогч Б-д олгохоор шийдвэрлэжээ.

Шийдвэрийн үндэслэл (Сэтгэл санааны хохирлын тухайд):

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-т “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй...” гэж заасан нь сэтгэл санааны хохиролд шаардсан 20,000,000 төгрөгийг гаргуулах үндэслэл болохгүй. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь иргэний эрх зүйн маргааныг иргэний шүүх хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг болно.”

Дүн шинжилгээ: Анхан болон давж заалдах шатны шүүх Б-гийн сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг олгох нь зүйтэй гэж шийдвэрлэжээ. Харин Дээд шүүхээс Б-г сэтгэл санааны хувьд хохирсон эсэх дээр тайлбар хийгээгүй ч анхан болон давж заалдах шатны шүүхээс Б-д сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр олгон шийдвэрлэсэн нь хуулийг буруу хэрэглэсэн гэж үзжээ. Гэхдээ дээрх үндэслэлээс үзвэл

УДШ-ийн шийдвэрт тусгасан үндэслэл нь ихээхэн учир дутагдалтай. Учир нь УДШ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-т “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй...” гэснийг Иргэний хуулийн 230.2-т заасан “хуульд тусгайлан заасан” гэдэгт хамаарахгүй гэж үзсэн ба ингэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь иргэний хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг гэж тайлбарлажээ.

Дээрх үндэслэл нь бүрэн дүүрэн ойлгомжтой биш байгаа боловч УДШ-ээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-т заасныг бие даасан шаардах эрх олгосон зохицуулалт биш гэж үзсэн байх магадлал өндөр. Тэгж үзвэл УДШ-ийн тайлбарыг дараах байдлаар сийрүүлж болно. Мөн хуулийн 45.4-т “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй” гэж заасан нь хохирогчийн зөвхөн нэхэмжлэл гаргах эрхийг заасан болохоос сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх тухай шаардах эрхийг зохицуулаагүй гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, хохирол шаардах эрхтэй холбоотой зохицуулалт Иргэний хуульд байх ёстой бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд иргэний харилцаанд оролцогчийн шаардах эрхийг бус, шүүхэд нэхэмжлэл гаргахтай холбоотой процессын харилцааг зохицуулсан гэж тайлбарласан байна.

Үүнээс үзвэл УДШ-ээс сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дэх хэсгийг хэт явцуу байдлаар тайлбарласан нь уг заалт батлагдах болсон зорилго хийгээд үзэл баримтлалд нийцээгүй гэж дүгнэгдэхээр байна.

Гэвч УДШ-ээс доод шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулсан боловч Б-гийн нэхэмжлэлд хангагдсан үнийн дүнд бараг өөрчлөлт оруулаагүй. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр болох 10,000,000 төгрөгийг хангахаас татгалзсан ч эд хөрөнгийн хохиролд 9,500,000 төгрөг ханган шийдвэрлэсэн нь нэхэмжлэлийн хангагдсан нийт үнийн дүн анхан болон давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн үнийн дүнд их хэмжээний өөрчлөлт оруулаагүйг харуулж байна. Энэ нь тун сонирхол татахуйц байгаа бөгөөд үүний өмнө дүн шинжилгээ хийгдсэн УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 592 дугаартай тогтоолд үүнтэй төстэй өөрчлөлт орсон байна. Уг хэрэгт УДШ нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрт холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзсан ч ойролцоо үнийн дүнгээр эд хөрөнгийн хохирлын нөхөн төлбөрийг хангаж шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, доод шатны шүүхийн шийдвэрээр хангагдсан нэхэмжлэлийн шаардлага нь бараг өөрчлөгдөөгүй гэсэн үг юм.

3.1.3. Хууль бусаар цагдан хоригдсонтой холбоотой сэтгэл санааны хохирол

Шүүхийн шийдвэр: УДШ-ийн 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 169 дүгээр тогтоол.

Хэргийн үйл баримт: Нэхэмжлэгч И, Э нарт Орхон аймгийн цагдаагийн газраас 2009 оны 10 дугаар сарын 28-нд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн ба 2009 оны 11 дүгээр сарын 16, 17-нд таслан сэргийлэх арга хэмжээ авч мөн өдрөө Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.3-т зааснаар сэжигтнээр татжээ. Улмаар 2010 оны 2 дугаар сарын 24-нд Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4 буюу онц хүнд гэмт хэрэгт яллагдагчаар татаж ял сонгосон байна.

И, Э нарыг яллагдагчаар татсан шийдвэр 2014 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Орхон аймаг дахь сум дундын шүүхээс цагаатгах тогтоол гартал хүчинтэй байсан ба уг хэрэгтэй холбоотой 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн УДШ-ийн шийдвэр гарснаар И, Э нар гэмт хэрэг үйлдээгүй болох нь тогтоогджээ.

Ийнхүү И, Э нар гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдсан, таслан сэргийлэх, цагдан хорих арга хэмжээ авхуулсан, ял сонссон зэрэг төрийн байгууллага, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Нэхэмжлэлдээ эд хөрөнгөд учирсан хохирол 8,995,300 төгрөг, сэтгэл санаанд учирсан хохирол 18,507,000 төгрөг гэж тодорхойлсон байна.

Шийдвэрийн агуулга: Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4, мөн хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, нэхэмжлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг нэхэмжилснийг хангаж, нийт 24,988,500 төгрөгийг төрөөс гаргуулан нэхэмжлэгчдэд олгох нь зүйтэй гэж шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Хариуцагч уг шийдвэрийг эс зөвшөөрч УДШ-д гомдол гаргажээ.

УДШ анхан болон давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн хэрэглэвэл зохих зүйл, заалтыг хэрэглээгүй, зарим зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн, улмаар нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа эрх зүйн хувьд алдаатай дүгнэлт хийсэн гэж үзэн магадлалд

дараах өөрчлөлт оруулжээ. УДШ-ээс нэхэмжлэгчдэд сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгохоос татгалзсан боловч сэтгэл санааны хохиролд нэхэмжилсэн зарим шаардлага нь эд хөрөнгийн хохирлын шинжтэй гэж үзэн нэхэмжлэлээс 11,812,800 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, үлдэх 15,689,500 төгрөгийг Засгийн газрын сангаас гаргуулахаар шийдвэрлэжээ.

Шийдвэрийн үндэслэл (Сэтгэл санааны хохирлын тухайд): “Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан зохицуулалтыг тухайн маргаанд төсөөтэй хэрэглэсэн нь алдаатай болжээ. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх боловч мөн зүйлийн 4.3-т зааснаар тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. Сэтгэл санаанд учирсан гэм хор болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас учирсан гэм хор нь эдийн бус гэх төрөлд хамаарах боловч агуулга, хэлбэрийн хувьд ялгаатай тул эдгээр харилцаанд эрх зүйн нэг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзнэ”.

Дүн шинжилгээ: УДШ-эс нэхэмжлэгч Э, И нарын сэтгэл санааны хохирлыг ханган шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шийдвэрийг үнэлэхдээ хууль буруу хэрэглэсэн гэж үзжээ. Ингэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 болон 45.4 дүгээр зүйл нь Иргэний хуулийн 230.2-т заасан “хуульд тусгайлан заасан” гэдэгтэй нийцэхгүй гэж үзжээ. Учир нь Дээд шүүх “хуульд тусгайлан заасан” гэдгийг “Иргэний хуульд тусгайлан заасан” гэж ойлгоно гэж тайлбарласан байна.

“Хуульд” гэдгийг “Иргэний хуульд” гэж ойлгоно гэсэн УДШ-ийн тайлбар нь хууль тогтоогчийн байр суурьтай зөрчилдөнө. Учир нь хуулийн зүйл заалтад тухайн хуулиа заах тохиолдолд “энэ хууль” гэх нэршлийг ашигладаг. Тухайлбал, Иргэний хуульд “энэ хууль” гэсэн холбоо үг 15 удаа давтагдсан байна. Харин “хууль” гэж 401 удаа давтагдан орсон байна. Ингэхдээ “хууль” гэдэг нь “энэ хууль” гэдгээс ялгаатай агуулга илэрхийлсэн байна. Тухайлбал, Иргэний хуулийн 369 дүгээр зүйлийн 369.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн ерөнхий үндэслэлийг хэрэглэнэ” гэсэн байна. Өөрөөр хэлбэл, нэг өгүүлбэрт “хуульд өөрөөр заагаагүй бол” болон “энэ хуулийн” гэсэн байдлаар хамтдаа хуульчлагджээ. Энэ тохиолдолд эхний “хуульд” гэсэн нь зөвхөн Иргэний хууль бус, хүчин төгөлдөр бусад хуулийг зааж байгаа нь ойлгомжтой юм. Жишээ нь, Хөдөлмөрийн хууль үүнд хамаарах нь гарцаагүй. Үүнээс үзвэл Иргэний хуулийн 230.2-т заасан “хуульд ...” гэсэн нь зөвхөн Иргэний хуулийг хэлж байна гэж тайлбарлах нь өрөөсгөл болно.

Нөгөө талаар Иргэний хууль бол хувийн эрх зүйн ерөнхий хууль юм. Тэр утгаараа нэмэлт, өөрчлөлт оруулахад бусад салбарын хуулиас илүү ярвигтай байх ба үүнээс хамааран зарим зүйлийг салбар хуулиудад нарийвчлан зохицуулах үүднээс ерөнхий байдлаар хуульчлах аргыг хууль тогтоогчид өргөн ашигладаг. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчид 2002 онд Монгол Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шаардах эрхийг өргөн хүрээгээр зохицуулах нь эрх зүйн шинэтгэл ид явагдаж байсан тухайн үед хэт эртдэх магадлалтай учир түүнээс улбаатай ойлгомжгүй байдлаас зайлсхийх үүднээс “хуульд тусгайлан заасан” гэх хязгаарлалт тогтоон бага багаар хүрээг нь тэлье гэсэн зорилготой байсан болов уу. Ийнхүү бусад салбар хуульд зохицуулах замаар хүрээг нь тэлж буй явдал нь 2017 онд батлагдсан Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлд тусгалаа олсноор илэрч байгаа юм. Хэрэв хууль тогтоогчийн байр суурь дээр тайлбарласнаас зөрүүтэй бол ийнхүү сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг Иргэний хуулиас өөр хуульд оруулан хуульчлах ямар ч шаардлага байхгүй, мөн тийнхүү хуульчлах үр нөлөө гэх зүйл үгүй болно.

Гэхдээ УДШ нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохиролд нэхэмжилсэн шаардлагын зарим хэсгийг эд хөрөнгийн хохирлын шаардлага гэж үзэхээр байна гээд эдийн хохирлын нөхөн төлбөр байдлаар ханган шийдвэрлэсэн. Тус шаардлага нь цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй байх үеийн хохирлын нөхөн төлбөр юм.

Хууль бусаар цагдан хоригдсон этгээдэд тухайн хугацаанд хоригдоогүй бол олох ёстой байсан орлого гэдэг байдлаар дор хаяж хөдөлмөрийн хөлстэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр олгодог. Олох ёстой байсан орлогыг цагдан хорих арга хэмжээтэй ижил шинжтэй гэрийн хорио, зорчих эрх хязгаарласнаар ажилдаа явах боломжгүй болсон тохиолдолд нөхөн төлбөрийг эдийн хохирлыг арилгах зорилгоор олгож болох ч энэ хэрэгт уг нөхцөл байдал байсан талаар дурдаагүй, тогтоогдоогүй байхад УДШ эд хөрөнгийн шинжтэй гэж үзсэн үндэслэл нь тодорхой бус байна. Гагцхүү ийнхүү шийдвэрлэснээрээ хохирогч буюу нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирлын шаардлага бүхэлдээ хангагдахгүй байх нөхцөл байдалд оруулаагүй буюу хохирогчид ашигтай тайлбар гэж дүгнэж болохоор байна.

3.1.4. Урт хугацааны турш таслан сэргийлэх арга хэмжээ авхуулсан, сэжигтнээр татагдсантай холбоотой сэтгэл санааны хохирол

Шүүхийн шийдвэр: УДШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 001/ХТ2018/01759 дүгээр тогтоол.

Хэргийн үйл баримт: 1995 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Дорнод аймгийн ...сумын уурын зуухнаас Б-гийн цогцос шатсан байдалтай олджээ. Тус хэрэгт холбогдуулан Дорнод аймгийн цагдаагийн газраас иргэн О (нэхэмжлэгч)-д эрүүгийн хэрэг үүсгэн сэжигтнээр тооцож 1995 онд, мөн 2000 онд нийт 134 хоног цагдан хорьжээ. Дээрх хэрэгт 2010 оноос иргэн Г-г сэжигтнээр тогтоон шалгаж эхэлсэн ба Г-г шалгах явцад О-г гэрчээр байцааж мэдүүлэг авч байсан байх боловч түүнийг өмнө нь уг хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татсан тухай тогтоол шийдвэрүүдийг хүчингүй болгожгүйгээр хэргийг шүүхэд шилжүүлжээ.

2015 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Г-г бусдыг санаатай алсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ. Түүний дараа 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Дорнод аймгийн Прокурорын газраас О-д холбогдуулан үүсгэсэн эрүүгийн хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.

О нь ийнхүү хууль бусаар нийт 138 хоног цагдан хоригдсоны улмаас авбал зохих цалин хөлс буюу эдийн хохиролд 960,000 төгрөгийг, түүнчлэн 21 жил сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан, тус хэргээс болж ажилгүй болсон, нутгийнхан нь гэмт хэрэгтэн мэтээр харилцдаг байсан, цаашлаад тус хэргээс улбаалан 2006 онд тэтгэвэрт гартлаа ажилгүй, цалингүй байсан гэж сэтгэл санааны хохиролд 500,000,000 төгрөгийг төрөөс шаардан иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Шийдвэрийн агуулга: Анхан шатны шүүхээс Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2, 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4, Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д тус

тус заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын нөөцийн сангаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохиролд 73,218 төгрөг, эдийн бус хохиролд 50,000,000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч О-д олгохоор шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2, 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас 960,000 төгрөгийг нэхэмжлэгч О-д олгож, харин сэтгэл санааны хохирлын шаардлагыг хангахаас татгалзсан байна. О уг магадлалд сэтгэл санааны хохиролд 50,000,000 төгрөг нэмж гаргуулахаар өөрчлөлт оруулж өгнө үү хэмээн УДШ-д гомдол гаргажээ.

УДШ-ээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Өөрөөр хэлбэл, О сэтгэл санааны хохиролд 50,000,000 төгрөг, эдийн хохиролд 73,218 төгрөгийг төрийн сангаас гаргуулж авах эрхтэй болсон байна.

Шийдвэрийн үндэслэл (Сэтгэл санааны хохирлын тухайд): “Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрхийг нэхэмжлэгчид олгосон байхад зөвхөн Иргэний хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй гэсэн үндэслэл зааж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан “...иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим”-д нийцэхгүй. Иймээс нэхэмжлэгч О нь 134 хоног цагдан хоригдсон, 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож

байх тул Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг гаргуулах нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т нийцнэ”.

Дүн шинжилгээ: Уг шийдвэр нь сэжигтнээр тооцогдон цагдан хоригдож, таслан сэргийлэх арга хэмжээ авхуулсан бөгөөд хожим гэм буруугүй болох нь тогтоогдсон этгээд төрөөс сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нэхэмжлэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрснөөрөө онцлогтой.

Ингэхдээ УДШ-ээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 болон 45.4 дүгээр зүйлийг сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх эрхэд хамааруулан заасан ба Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан “хуульд тусгайлан заасан тохиолдол” мөн гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, үүнтэй төстэй өмнөх шүүхийн шийдвэрүүдээс өөрчлөгдсөн тайлбар нь 230.2-т заасан “хуульд тусгайлан” гэдэг нь зөвхөн Иргэний хуулиар хязгаарлагдахгүй гэсэн агуулгыг уг шийдвэрт илэрхийлсэн байна. Ингэснээр өөр бусад эдийн бус хохирлыг тусгай хуульд заах байдлаар сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг өргөжүүлэх боломжтой болж байна. Энэ тайлбар нь хохирогчийн эрх талаас дэвшилд тооцогдох нь гарцаагүй биз ээ.

Гэвч нөгөө талаас нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирлын үнэлгээ 50,000,000 төгрөг гэж үзэхдээ юуг үндэслэл болгосон бэ гэдэг нь тодорхой бус юм. Хууль хэрэглээний хувьд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2-т заасан “...хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох” гэснийг төсөөтэй хэрэглэсэн байна. Угаасаа сэтгэл санаанд учирсан хохирлыг эд хөрөнгийн хохирол шиг яв цав тодорхойлох боломжгүй учраас ихэнх оронд шүүхийн жишгийг

ашигладаг. Өөрөөр хэлбэл, өмнө нь үүнтэй ижил хэрэг дээр ийм хэмжээний нөхөн төлбөр олгосон байна гэдэг байдлаар эсхүл өөр бусад сэтгэл санааны хохирол ханган шийдвэрлэсэн хэргүүдийг харьцуулж, энэ хэрэг болон нөгөө хэргийн хохирогчид нөлөөлөх байдлын талаар дүгнэлт хийх явдал юм. Тухайлбал, хөнгөн гэмтлийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр нь хүн амины хэргийн хохирогчийн ойр дотнын хүнд учруулсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрөөс бага байх буюу нийгмийн ёс суртахууны үнэлэмж шүүгчийн дотоод итгэл үнэмшилд нөлөөлнө. Ташрамд дурдахад, 2017 онд гарсан бага насны хүүхдийн амь насыг бусниулсан хэрэгт (Энэ бүлгийн 3.2.1) УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас талийгаачийн эхэд 50,000,000 сая төгрөгийн сэтгэл санааны нөхөн төлбөр олгуулахаар шийдвэрлэсэн байна. Дүн шинжилгээ хийсэн энэ хэрэгт ч шүүхээс 50,000,000 төгрөгийн сэтгэл санааны нөхөн төлбөр олгуулахаар шийдвэрлэсэн. Эдгээр хоёр хэргийн хувьд “severe” буюу харгис хэрцгий, жигшим хэрэг хэмээн нийгмийн ёс суртахууны зүгээс үнэлж болох юм гэсэн нийтлэг шинж ажиглагдаж байна.

3.1.5. Хөнгөн гэмтэл учирсантай холбоотой сэтгэл санааны хохирол

Шүүхийн шийдвэр: УДШ-ийн 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 692 дугаартай тогтоол.

Хэргийн үйл баримт: 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр иргэн М авто машин жолоодож явахдаа туслах замын гарцаар гарч байсан иргэн Б-г мөргөж эрүүл мэндэд нь хөнгөн гэмтэл учруулжээ. Б-гийн биед зүүн мөрний шөрмөсний сэмрэлт, зүүн мөр, түнхний үеийн зөөлөн эдийн няцрал, цус хуралт учирсан нь тогтоогдсон ба эмчилгээний төлбөрт 776,500, рашаан сувиллын зардалд 667,200, олох байсан орлогод 4,800,000, сэтгэл

санааны хохиролд 2,000,000 төгрөг тус тус, нийт 8,243,700 төгрөг нэхэмжилжээ.

Шийдвэрийн агуулга: Анхан шатны шүүхээс Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 511 дүгээр зүйлийн 511.2 дахь хэсэгт заасныг баримтлан М-ээс эд хөрөнгийн хохиролд 776,500, сэтгэл санааны хохиролд 1,000,000 төгрөг тус тус, нийт 1,776,000 төгрөг гаргуулан Б-д олгож шийдвэрлэжээ.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нэхэмжлэгч Б-д эмчилгээний зардалд 776,500 төгрөг гаргуулан олгож, нэхэмжлэлийн үлдэх шаардлагыг хангахаас татгалзжээ. УДШ давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

Шийдвэрийн үндэслэл (Сэтгэл санааны хохирлын тухайд): “Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулж, хэрэгт авагдсан баримтад тулгуурлан нэхэмжлэлээс эмчилгээний зардал 776,500 төгрөгийн шаардлагыг хангасан нь зөв боловч хариуцагчаас сэтгэл санааны хохиролд 1,000,000 төгрөг гаргуулахдаа хуулийг буруу тайлбарлан хэрэглэжээ.

Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх талаар Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан, давж заалдах шатны шүүх шийдвэрт өөрчлөлт оруулахдаа хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн, магадлал хууль ёсны байх шаардлагыг хангажээ”.

Дүн шинжилгээ: Тус хэргийн хувьд хохирогч зам тээврийн ослын улмаас хөнгөн гэмтсэн бөгөөд үүнтэй холбогдуулан сэтгэл санааны хохирол нэхэмжилснийг анхан шатны шүүх зарим хэсгийг нь хангасан ч дээд шатны шүүхүүд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан “хуульд тусгайлан заасан”

тохиолдолд л эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлнэ гэсэнтэй нийцээгүй гэж үзэн сэтгэл санааны хохиролтой холбоотой шаардлагыг бүхэлд нь хангахаас татгалзсан байна.

Уг үндэслэлийг буруутгах боломжгүй юм. Учир нь Иргэний хуульд тусгайлан заасан нь “нэр төр, алдар хүндэд учруулсан гэм хор”, бусад хуульд тусгайлан заасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан гэм хор”, түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасан тохиолдол юм. Өөрөөр хэлбэл, бусдын эрүүл мэндэд учруулсан хохирлоос үүдэх сэтгэл санааны хохирлын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй. Гэвч бусдын амь насыг бусниулсан хэргээс үүсэх сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой тусгайлан заасан зохицуулалт мөн байхгүй ч хуулийг тайлбарлах замаар 2017 онд УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн юм (Энэ бүлгийн 3.2.1). Өөрөөр хэлбэл, хууль зүйн үүднээс авч үзвэл хөнгөн гэмтэл учруулсан хэрэгт ч, амь нас бусниулсан хэргийн хувьд ч сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх талаар хуульд тусгайлан зохицуулаагүй.

Үүнээс “Шүүх яагаад амь нас бусниулсан хэрэгт сэтгэл санааны хохирлыг хүлээн зөвшөөрч байна вэ?” гэсэн асуулт урган гарах ба үүний хариултыг судлаачийн судалсан хүрээнд хууль тогтоомжоос хайгаад олсонгүй. Харин сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх шаардлагыг ханган шийдвэрлэсэн тохиолдлуудад байгаа нийтлэг шинжээс авч үзвэл, объектив байдлаар сэтгэл санааны хохирол бий болох боломжтой хэргүүд дээр нэхэмжлэлийн шаардлагыг хангажээ. Өөрөөр хэлбэл, тухайн хэргүүд нь “severe” буюу хэн ч уг хэргийг хэрцгий, жигшим гэж үзэхээр шинж агуулсан байна.

Сэтгэл санааны хохирол нь өөрөө бүрэн нотлох, хэмжих боломжгүй, хэт субъектив шинжтэй байдгаас үүдэн шүүхээс түүнийг харьцангуй тодорхой байдлаар шийдвэрлэхийн тулд нийгмийн ёс суртахууны үнэлэмжийг шийдвэр гаргахдаа авч үзсэн байх талтай гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, объектив буюу нийгэмд тухайн хэргийг харгис, хэрцгий, зэвүүцэм, нөгөө талаас хохирогчид сэтгэл санааны хохирол учрах нь заавал нотолгоогоор батлах шаардлагагүй гэсэн үнэлэмжийг удиртгал болгосон байх талтай юм.

3.2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР

3.2.1. Амь насанд гэм хор учруулсантай холбоотой сэтгэл санааны хохирол

Шүүхийн шийдвэр: УДШ-ийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаартай тогтоол.

Хэргийн үйл баримт: А1 (хохирогчийн төрсөн эцэг), А2 (хохирогчийн хойд эх) нар бүлэглэн 2014 оны 10 дугаар сарын 2-ноос 2015 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд Х (3 нас 11 сартай, охин)-д арцыг арвайн будаатай хольж хүчээр идүүлэх, суран бүсний арлаар зодох зэргээр байнга зодож тарчлаадаг байсан ба 2015 оны 2 дугаар сарын 15-ны өдөр өмдөндөө баалаа, үгэнд орсонгүй гэж Х-г биеэ хамгаалж чадахгүйг мэдсээр байж, онц харгис хэрцгий аргаар зодож санаатайгаар амь насыг нь бусниулжээ.

Түүнчлэн А2 нь 2014 оны 10 дугаар сарын 2-ноос 2015 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд өөрийн дагавар охин Х-г бөөгийн үйл хийж байна гэх нэрийдлээр модон могойгоор байнга зодож, эхийнх нь бузрыг арилгаж байна хэмээн бэлэг эрхтнийг нь базах, чимхэх, усанд оруулсны дараа

онгорхой цонхон доор зогсоох, үгэнд ороогүй гэж нүд рүү нь будаг арилгагч шингэн цацах, алгадах зэргээр байнга зодож тарчлаасан байжээ.

Тус эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад хохирогч болох талийгаачийн төрсөн эх шүүгдэгчдээс оршуулгын зардалд 4,646,839 төгрөг нэхэмжилжээ. Өөр ямар нэг хохирлын нөхөн төлбөр нэхэмжлээгүй байна.

Шийдвэрийн агуулга: Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс А1, А2 нарыг санаатайгаар хүн алах гэмт хэргийг хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж онц харгис хэрцгий аргаар бүлэглэн үйлдсэн, бусдыг байнга зодох буюу тарчлаах гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн гэм буруутай гэж үзэн А2-ыг 23 жил, А1-ийг 20 жил хорих ял эдлүүлэх, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсгийг үндэслэн А2-оос 2,324,420 төгрөг, А1-ээс 2,324,420 төгрөгийг тус тус гаргуулан, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С (хохирогчийн төрсөн эх)-д олгуулахаар шийдвэрлэжээ. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээжээ.

Дээд шүүхээс А2-т 18 жил, А1-д 13 жил хорих ял оногдуулах, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч А1, А2 нараас хувь тэнцүүлэн 50,000,000 (тавин сая) төгрөг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С-д олгохоор шийдвэрлэжээ.

Шийдвэрийн үндэслэл (Сэтгэл санааны хохирлын тухайд): “Энэ гэмт хэргийн улмаас 3 нас 11 сартай Х амь насаа алдсан бөгөөд түүний төрсөн эх С-д учирсан сэтгэл санааны болон гэм хорын хохирлын нөхөн төлбөрийг шүүгдэгчдээс гаргуулах нь зүйтэй. Хохирол гаргах аргачлалгүй, тооцох техник байхгүй гэсэн шалтгаанаар уг хохирлыг гаргуулахаас татгалзаж шийдвэрлэх нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг

хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасантай нийцэхгүй гэж үзэв.

Хохирлын хэмжээг тогтоохдоо амь нас хохирсны улмаас учирсан сэтгэл санааны болон бусад хохирлын нөхөн төлбөрт гаргуулан олгож шийдвэрлэж байсан шүүхийн шийдвэрүүд, 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршгийн хэмжээг тодорхойлохдоо 50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 50,000,000 төгрөгийг их хэмжээний хохирлын доод хэмжээ болгон хуульчилсан зэрэг жишиг болох нөхцөл байдлуудыг харгалзан үзэж шүүгдэгч А1, А2 нараас хувь тэнцүүлэн 50,000,000 төгрөг гаргуулан хохирогчийн хууль ёсны төлөөлөгч С-д олгуулахаар шийдвэрлэсэн болно”.

Дүн шинжилгээ: Сэтгэл санааны хохиролтой холбоотой гарсан шийдвэрүүд дундаас энэхүү шийдвэр туйлын ач холбогдолтой. Учир нь өдийг хүртэл шүүхээс сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотойгоор эрх зүйн зохицуулалт дутмаг, тооцоолох аргачлал байхгүй зэрэг шалтгааныг дурддаг байсан боловч уг шийдвэр нь дурдсан шалтгааныг давж гарчээ. Тодруулбал, өмнө нь байсан практикийг эвдэж шинэ жишиг тогтоосон гэж үнэлэхүйц юм. Ач холбогдлын хувьд маргаангүй ч гагцхүү хууль хэрэглээний хувьд шүүмжлэлтэй хэд хэдэн зүйл ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхийг хүлээн зөвшөөрсөн ч “Хэний сэтгэл санааны хохирол вэ?” гэдэгт тайлбар өгөөгүй байна. Шийдвэрийн үндэслэх хэсэгт “Энэ гэмт хэргийн улмаас 3 нас 11 сартай Х амь насаа алдсан бөгөөд түүний төрсөн эх С-д учирсан сэтгэл санааны болон гэм хорын хохирлын нөхөн төлбөрийг шүүгдэгч нараас гаргуулах нь зүйтэй” гэснээс үзвэл 50,000,000 төгрөг нь С-ийн сэтгэл санааны нөхөн төлбөр гэж ойлгогдоно. Гэтэл шийдвэрийн тогтоох

хэсэгт Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсгийг үндэслэсэн байх боловч тус зохицуулалт хохирогч нас барсан тохиолдолд тухайн учруулсан хохирлыг түүний өв залгамжлагч шаардах эрх олгосон зохицуулалт юм. Үүнээс үзвэл талийгаачид учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг түүний өв залгамжлагч болох төрсөн эхэд нь олгосон гэж ойлгогдохоор байна. Өөрөөр хэлбэл, уг шийдвэрийн үндэслэх хэсэг болон тогтоох хэсэг логикийн зөрчилдөөнтэй байна.

Хоёрдугаарт, УДШ-ээс сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрт 50 сая төгрөгийг хангаж шийдвэрлэх нь үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн ч хэд хэдэн алдаа гаргажээ. Нэн тэргүүнийх нь, 50 сая төгрөгт анхан шатны шүүх дээр хохирогчийн нэхэмжилсэн оршуулгын зардал багтсан бөгөөд оршуулгын зардал нь эдийн хохирол учир сэтгэл санааны хохирлыг 50,000,000 төгрөг гэсэн нь үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, 50,000,000 төгрөгөөс оршуулгын зардал хассан дүн нь сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр болно. Хэрэв тийм бол УДШ-ээс сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг тооцоолохдоо үндэслэл болгосон тухайн гэмт хэргийн харьяалагдах ангиллын хохирлын хамгийн доод шалгуурт хүрэхээ больж байна.

Удаах нь шүүх хохирлыг нэхэмжлэлийн хүрээнд шийдвэрлээгүй. Хэдийгээр тус шийдвэрийг УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар гаргасан боловч хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцаа нь иргэний эрх зүйн гэм хорын харилцаа юм. Иймд тухайн харилцааг шийдвэрлэхдээ иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд удирдлага болгодог зарчмыг мөрдөх нь үндэслэлтэй. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх үндсэн зарчмуудын нэг бол диспозитив зарчим ба тус зарчим нь хэргийн зохигч, талуудын сайн дурын үндсэн дээр буюу тэдгээрийн нэхэмжлэл, шаардлагын хүрээнд шүүх хэргийг шийдвэрлэх тухай агуулгатай.

Өөрөөр хэлбэл, хохирогчийн төрсөн эх С шүүхэд сэтгэл санааны хохирол гэж 50,000,000 төгрөг эсхүл түүнээс илүү үнийн дүнтэй нэхэмжлэл гаргасан байх нь ийнхүү шийдэх урьдач нөхцөл болно. Анхан шатны шүүхийн шийдвэрээс үзвэл хохирогчийн хууль ёсны төлөөлөгч талийгаачийн оршуулгын зардалд 4,646,839 төгрөг шүүгдэгчдээс нэхэмжилсэн ба анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн байна. Харин сэтгэл санааны хохирол гэж 50,000,000 төгрөг эсхүл түүнээс илүү үнийн дүн бүхий нэхэмжлэл гаргаагүй байхад шүүхээс дур мэдэн хохирогчид нөхөн төлбөрийг гэм хор учруулагчдаас гаргахаар шийдвэрлэжээ.

Хэдийгээр энэхүү шүүхийн шийдвэрт дээр дурдсан шүүмжлэл дагуулахуйц зүйлс тусгагдсан байх боловч шүүхийн байр суурь хүний амь насыг бусниулсан хэрэгт сэтгэл санааны хохирол тусгайлсан зохицуулалт байхгүй ч хууль тайлбарлах замаар хүлээн зөвшөөрч, түүгээр ч үл барам нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолохдоо тухайн гэмт хэргийн харьяалагдах төрлийн материаллаг шинжээр дүйцүүлнэ гэж үзсэн нь тодорхой юм. Гагцхүү энэ хуулийн тайлбар, нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолсон үндэслэл дараа дараагийн шийдвэрт жишиг хэлбэрээр ашиглагдах эсэхийг анхааралтай ажиглах шаардлагатай юм.

3.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Дээд шүүхээр 2017 оны 10 дугаар сараас 2019 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд шийдвэрлэгдсэн сэтгэл санааны хохиролтой холбоотой, судалгааны ач холбогдол өндөртэй шүүхийн цөөн тооны шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Дээрх шийдвэрүүдийг шийдвэрлэж буй шүүхээс нь хамаарч иргэний хэргийн шүүх болон эрүүгийн хэргийн

шүүх гэсэн хэлбэрээр ангилсан. Үүнээс УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас “Хохирлыг гаргах аргачлалгүй, тооцох техник байхгүй гэсэн шалтгаанаар уг хохирлыг гаргуулахаас татгалзаж шийдвэрлэх нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасантай нийцэхгүй” гэж үзэн хууль тайлбарлах аргаар сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгон шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь тодоор тэмдэглүүштэй.

Харин уг судалгаанд авагдсан УДШ-ийн Иргэний хэргийн танхимаас гарсан шийдвэрүүд дунд ганц л шийдвэрт сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр олгохыг хүлээн зөвшөөрчээ. Энэ нь 2018 оны 12 дугаар сард шийдвэрлэгдсэн хэрэг бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 болон 45.4 дүгээр зүйлд хохирогч сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхтэйг дурдаад Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэн сэтгэл санааны хохиролд нөхөн төлбөр олгожээ. Гэтэл энэ хэрэгтэй төстэй хууль бусаар цагдан хоригдож, таслан сэргийлэх арга хэмжээ авхуулсан этгээдийн сэтгэл санааны хохирлыг 2019 оны 1 дүгээр сард шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтууд нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хохирогчид олгоогүй гэж тайлбарлан нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзжээ.

Нэг шүүхийн 2018 оны 12 дугаар сард гаргасан шийдвэрт байх хуулийн тайлбар 2019 оны 1 дүгээр сард эрс өөрчлөгдсөн шалтгаан уг шүүхийн шийдвэрт тусгагдаагүй ч тухайн хэргийн хүнд, хөнгөн байдал нь хууль хэрэглээнд нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байгаа юм. Учир нь сэтгэл санааны хохирол хангагдсан хэргийн хувьд төрийн албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас хохирогч 21 жилийн турш эд хөрөнгийн болоод сэтгэл зүйн хувьд хүнд гарз амссан. Энэ нь судлаачийн

зүгээс “severe” буюу харгис хэрцгий, жигшим хэрэгт шүүх сэтгэл санааны хохирлыг хүлээн зөвшөөрч байна гэсэн дүгнэлт өгөх үндэслэл болж байна.

Эрүүгийн хэргийн танхимаас шийдвэрлэсэн хэргийн хувьд ч 3 нас 11 сартай охинд учруулсан гэм хор нь мөн “severe” шинжийг агуулж байгааг харж болно. Түүнчлэн эдгээр хэрэгт хохирогчид 50,000,000 төгрөгийн нөхөн төлбөр олгон шийдвэрлэснээрээ төстэй бөгөөд тус үнэлгээг дараа дараагийн хэргүүдэд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр тооцоолоход жишиг байдлаар ашиглах боломжтой нь харагдаж байна.

Хэдийгээр Иргэний хэргийн танхим сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг Иргэний хуульд тусгайлан заасан байх ёстой гэж тайлбарлан, үүнтэй холбоотой нэхэмжлэлийг хангахаас татгалзаж байгаа боловч тус шаардлагатай ижил үнийн дүнгээр эд хөрөнгийн хохиролд ногдуулсан нөхөн төлбөрийг нэмэгдүүлэн хохирогчид олгохоор шийдвэрлэж байгаа нь дээрх дүн шинжилгээгээр ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, шүүх сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх нь хууль зүйн хувьд одоогоор боломжгүй гэж шийдвэрлэж байгаа ч эрх нь зөрчигдсөн этгээдүүдийн эрх ашигт нийцэх байдлаар нотлох баримтыг үнэлэх асуудалд уян хатан хандаж байгаа юм.

Эдгээрээс үзвэл манай улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хүлээн зөвшөөрөх хандлага, цаашлаад тооцоолох жишиг тогтох суурь нөхцөл бүрдсэн гэж хэлж болохоор байна. Гагцхүү сэтгэл санааны хохиролтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг нэгдмэл, тодорхой болгох хуулийн нэмэлт, өөрчлөлт шаардлагатай байгааг дээрх шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээ харуулж байна.

ДӨРӨВ. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харьцуулсан судалгаанд ХБНГУ, Япон Улсыг сонгон авч судалсан болно. Энэ хоёр улсыг сонгон авч судлах үндэслэл нь манай улсын хувьд эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудын бүлд хамаардаг бөгөөд энэ үүднээс Япон Улс⁴¹ болон ХБНГУ-ыг судлах нэг шалтгаан болсон. Нөгөө талаар манай улс анх Иргэний хуулийн үзэл баримтлалыг боловсруулахдаа ХБНГУ-ын эдийн бус гэм хорын зохицуулалтыг жишиг болгон боловсруулсан байдаг тул цаашид Герман улсын эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлын зохицуулалтыг нарийвчлан судлах нь зүйтэй гэж судлаачдын зүгээс үзсэн. Учир нь ХБНГУ-ын хувьд 1900 онд боловсруулсан Иргэний кодексдоо 2002 оноос эхлэн хэд хэдэн томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд үүний багагүй хэсэг нь эдийн бус гэм хорын зохицуулалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт байдаг. Иймээс ХБНГУ-ын 2002 оноос эхлэн оруулсан гэм хорын эрх зүйн

⁴¹ Хэдийгээр Япон Улс нь эрх зүйн бүлийн хувьд эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсад бус, холимог төрлийн эрх зүйн тогтолцоо бүхий улсад хамаардаг гэж олонх судлаач үздэг боловч иргэний эрх зүй дэх гэм хорын эрх зүйн хувьд Франц буюу эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсын үзэл баримтлалыг хүлээн авч, нутагшуулсан гэж үздэг. Түүнчлэн Япон Улсын Иргэний хуулийн зөрчлийн эрх зүйн бүлгийг боловсруулах явцад ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтууд ихээхэн нөлөөлсөн гэж ч үздэг. Энэ үүднээс судлаачдын зүгээс тус улсыг эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орны тоонд хамааруулан харьцуулан судлах нэг шалтгаан гэж судалгааны ажилд дурдсан болно.

нэмэлт, өөрчлөлт бүхий зохицуулалтуудын үзэл баримтлал, нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан, нөхцөлийг ул суурьтайгаар судлахыг зорилоо. Японы гэм хорын эрх зүйн зохицуулалт нь манай улсын Иргэний хуульд тусгагдсан гэм хорын эрх зүйн зохицуулалттай төстэй байхаас гадна сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг Иргэний хэргийн процессын хуулиараа зохицуулдаг бөгөөд сэтгэл санааны хохирлыг шүүгч хэрхэн нотлох баримтын хүрээнд үнэлж байгааг харьцуулан судлах боломжтой учир Япон Улсыг харьцуулсан судалгааны хүрээнд сонгон авлаа. Манай улсын хувьд сэтгэл санааны хохирлыг хэрхэн үнэлэх тухай эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь Япон Улсын эрх зүйн зохицуулалттай төстэй гэж үзэж болохоор байна. Иймээс Япон Улсын хувьд эдийн бус гэм хорыг хэрхэн үнэлж, тогтоож байгааг харьцуулан судлах шалтгааныг нөхцөлдүүлж байгаа гэж үзэж болно.

4.1. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Германы иргэний эрх зүй дэх үүргийн ангид 1900 онд кодификаци хийсэн ба үүнээс хойш 2002 онд томоохон өөрчлөлт хийж эхэлсэн. Энэхүү реформын томоохон хэсэг нь Иргэний хууль дахь гэм хорын эрх зүй ба хохирлын зохицуулалт байв. Гэм хорын эрх зүйн реформын зорилго, шалтгаан нь ХВНГУ-ын Иргэний кодексыг 1900 оны 1 дүгээр сард баталснаас хойш тус хуулийн гэм хорын зохицуулалтуудад өөрчлөлт ороогүй байсантай холбоотой юм.⁴² Энэхүү реформын томоохон өөрчлөлтийн нэг нь эдийн бус гэм хорыг нөхөн гаргуулах зохицуулалтыг өргөжүүлэн тусгах асуудал байсан. Өмнөх Иргэний кодекст зөвхөн хуульд заасан тохиолдолд

⁴² Ulrich Magnus (2013) The Reform of German Tort Law, Universidad de Hamburgo, 5 дахь тал. <https://core.ac.uk/download/pdf/39073135.pdf>

хохирлыг нөхөн гаргуулах боломжтой байхаар зохицуулж байсан (ХБНГУ-ын хуучин Иргэний кодексын 253 дугаар зүйл) бөгөөд энэхүү зохицуулалтаар тодорхой тохиолдолд л хохирлыг нөхөн гаргуулсаар ирсэн. Хуучин Иргэний кодексын 847 дугаар зүйлд бие махбодод гэмтэл учруулсны улмаас сэтгэл санаа зовж шаналсны нөхөн төлбөрийг гаргуулах талаар зохицуулж ирсэн. Гэхдээ хууль хэрэглээний хувьд хэрэв хохирогч гэм хор учруулагчийн хууль бус үйлдлийг нотолж чадахгүй тохиолдолд гэм хор учруулагчаар нөхөн төлбөр төлүүлэхгүй байх эрх зүйн үр дагавар үүсэж байсан. 1900 онд Иргэний кодексын гэм хорын зохицуулалтыг дээрх байдлаар зохицуулах учир шалтгаан нь зовж, шаналсны хохирлыг үнэлэхэд төвөгтэй байдал үүсэхээс гадна нөхөн олговрыг *өргөн хүрээнд олгосон нөхцөлд хохирогч этгээд буруугаар ашиглах боломжтой* гэж хууль тогтоогч үзсэн байдаг.⁴³

ХБНГУ-ын шүүхийн практикт Иргэний хуулийн 253, 847 дугаар зүйлийн үгийн шууд утгыг илүү өргөн цар хүрээтэй авч үзэж, эрхэд халдсан нь онцгой хүндрэлтэй байсан бөгөөд өөр арга хэлбэрээр арилгах боломжгүй тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлж болдог. Үүнийг “өвдөж шаналсны төлбөр” гэж нэрлэдэг.⁴⁴ ХБНГУ-ын эрх зүйн номлол болон шүүхийн практикт дээрх нэр томъёо хэрэглэгддэг боловч хуульд уг томъёолол тусгагдаагүй байна. “Шаналал” гэдэг нэр томъёог ХБНГУ-ын хууль зүйн зарим сурах бичигт “мэдрэмжид учирсан гэм хор” гэдгээр мөн хэрэглэдэг.⁴⁵ Мөнгөн төлбөрийг зөвшөөрч байгаа нь хувь хүний эрхийн хууль зүйн хамгаалалтыг улам бэхжүүлэхийн зэрэгцээ нэр төр,

⁴³ Мөн тэнд.

⁴⁴ Гүнтэр Кристиан Шварц, Манфрэд Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, 3 дахь хэвлэл, УБ., 2017, 44 дэх тал.

⁴⁵ Э.Золзаяа. Монгол Улсын болон гадаад улсын иргэний эрх зүй дэх сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлын эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. “Эрх зүй” сэтгүүл. 2014, №1 (27). 46 дахь тал.

алдар хүндэд гэм хор учруулсан этгээд зохих шийтгэлгүй үлдэх ёсгүй гэсэн санааг давхар агуулдаг. 2002 онд хохирлыг нөхөн төлөх эрх зүйг шинэчилснээс хойш дан ганц зөрчлийн эрх зүйн шаардах эрхээр хязгаарлахаа больж хохирол нөхөн төлүүлэхийг шаардах эрхийн хууль зүйн үндэслэлээс шалтгаалахаар болсон.⁴⁶

Иймд ХБНГУ-д Иргэний кодексын 847 дугаар зүйлээр эдийн бус хохирлын харилцааг зохицуулж байсан боловч тус зүйлийг хүчингүй болгож, оронд нь Иргэний кодексын 253 дугаар зүйлийн 2 дахь зохицуулалтаар илүү өргөн хүрээнд зохицуулах болсон байна.⁴⁷ ХБНГУ-ын Иргэний кодексын 249-254 дахь зохицуулалтууд нь зөрчигдсөн эрхийг сэргээх болон нөхөн төлөх үзэл санаан дээр үндэслэгдсэн.⁴⁸ *Бодит хохирлоос шалтгаалж бий болсон эдийн бус болон зовж, шаналсны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх зохицуулалтыг ХБНГУ-ын Иргэний кодекс тусгахад нэлээд маргаантай байсан.*⁴⁹ *Учир нь дээрх байдлаар зохицуулах нь Англи-Америкийн эрх зүйд хэрэглэгддэг “Punitive damage”-тэй төстэй бөгөөд “Punitive damage” нь шийтгэл юм. Шийтгэл нь эрүүгийн эрх зүйн үзэл санаа тул иргэний эрх зүйн үзэл санаанд үл хамаарна гэж эсэргүүцэж байсан байна.*⁵⁰ Улмаар

⁴⁶ Гүнтэр Кристиан Шварц, Манфред Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, 3 дахь хэвлэл, УБ., 2017, 168 дахь тал.

⁴⁷ Ulrich Magnus, The Reform of German Tort Law, Universidad de Hamburgo (2013), 5 дахь тал.
<https://core.ac.uk/download/pdf/39073135.pdf>

⁴⁸ Madeleine Tolani, U.S. Punitive damages before German courts: A comparative analysis with respect to the ordre public, Annual Survey of International & Comparative Law, Vol. 17, Iss. 1, Article 9 (2011), 193 дахь тал.

⁴⁹ Volker Behr, Punitive Damages in America and German Law - Tendencies towards Approximation of Apparently Irreconcilable Concepts, Chi.-Kent. L. Rev. (2003), 106 дахь тал.
<http://scholarship.kentlaw.iit.edu/cklawreview/vol78/iss1/6>

⁵⁰ Volker Behr, Punitive Damages in America and German Law - Tendencies towards Approximation of Apparently Irreconcilable Concepts, Chi.-Kent. L. Rev. (2003), 106 дахь тал,

ХБНГУ-ын хувьд бодит хохирлоос шалтгаалж бий болсон эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх үзэл санаа нь хувийн эрх зүй дэх шийтгэл болно гэдгийг ойлгож, Иргэний кодекст нэмж зохицуулжээ.⁵¹

ХБНГУ-ын Иргэний кодексын §253.1-д “Зөвхөн хуульд заасан тохиолдолд эдийн бус хохирлын нөхөн төлбөрт мөнгөн торгууль ногдуулж болно”⁵², мөн кодексын §253.2-т “Амь бие, эрцүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэгт учирсан эдийн бус хохирлыг эдийн хохирлоос гадуур мөнгөөр үнэлэн төлүүлж болно” гэж зохицуулсан.⁵³ Энэ зохицуулалтыг шүцхээс хэрэгжүүлэхдээ тэгш байдлыг буй болгох зорилгоор эдийн бус хохирлыг хэрхэн үнэлэх тухай нийтлэг жишиг гаргаж, хуулиа тайлбарладаг.⁵⁴

Манай улсын Иргэний хуулийг батлах цед 230.2 дахь хэсгийн зохицуулалт нь англо-саксоны эрх зүйн “Punitive damage” буюу “хохирлыг гэм буруутай үйлдлийн шийтгэл болгож, өндрөөр тогтоон олгох практик”⁵⁵-ийг хуульдаа тусгахгүй, харин эх газрын эрх зүйн бодит хохирлыг хэмжиж олгох гэсэн үзэл санааг дэмжиж байсантай холбоотой. Гэхдээ

<http://scholarship.kentlaw.iit.edu/cklawreview/vol78/iss1/6>

⁵¹ Мөн тэнд, 106 дахь тал.

⁵² ХБНГУ-ын Иргэний кодексын 253 дугаар зүйлийн 253(1) Money may be demanded in compensation for any damage that is not pecuniary loss only in the cases stipulated by law.

⁵³ ХБНГУ-ын Иргэний кодексын 253 дугаар зүйлийн 253(2) If damages are to be paid for an injury to body, health, freedom or sexual self-determination, reasonable compensation in money may also be demanded for any damage that is not pecuniary loss.

⁵⁴ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2013, 521 дэх тал.

⁵⁵ “Punitive damage” буюу шийтгэл хэлбэрээр ногдуулах нөхөн төлбөр нь АНУ-д XIX зуунаас хойш Иргэний эрх зүйн нэг хэсэг болон хөгжсөөр байна. Анхандаа “Punitive damage” нь эрүүгийн эрх зүйд хамаарч байсан ба нэмэгдэл шийтгэлийн хувиар хэрэглэгдэж байсан. “Punitive damage”-ийн үндсэн зорилго нь бусдын санаатай болон илт болгоомжгүй үйлдлийн улмаас бий болсон бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлж, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог бөгөөд “нийгмийн болон хувь хүний ашиг сонирхлын онол” дээр суурилдаг байна. Англо-саксоны эрх зүйд “punitive damage” олгох асуудлыг хязгаарлаж эхэлсэн хандлагатай байгаа ба АНУ-ын зарим муж “punitive damage”-ийн дээд хэмжээг тогтоож өгсөн байдаг байна.

сүүлийн үед ХБНГУ-ын Иргэний кодексын §253-т эдийн хохирлоос тусдаа амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэг эрх зөрчигдсөнөөс үүссэн сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлж болох тухай заалт тусгагдсан, мөн англо-саксоны эрх зүйд “*punitive damage*” олгох асуудлыг хязгаарлаж эхэлсэн хандлага нь манай улсын Иргэний хуулийн 230 дугаар зүйлийг дээрх хоёр эрх зүйн бүлийн эдийн бус хохирол арилгах аргыг хослуулах замаар өөрчлөн найруулах нийгмийн шаардлага буй болсныг илтгэж байна.⁵⁶ Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийг батлах цаг үед ойлгож байсан зарим ойлголт, үзэл баримтлал өөрчлөгдөж байгааг бид анзаарах хэрэгтэй.

Монгол Улсын хувьд сэтгэл санааны хохирлын тухай ойлголт шинэ зүйл биш боловч практик хэрэглээ, сэтгэл санааны хохирлыг үнэлэх ажиллагаа нь шинэ зүйл юм. ХБНГУ-ын хувьд сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг шүүхийн практик хэрэглээний явцад жишиг байдлаар тогтоосон байдаг. Гэхдээ сэтгэл санааны хохирлыг үнэлэхдээ шүүх шууд үзэмжээр шийдэж байгаа гэсэн үг биш. Харин манай улсын Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2 дахь хэсгийн зохицуулалттай адил гэм хорын эрх зүйн үндсэн элементүүдийн хүрээнд сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг шийдэж байна. Манай улсын хувьд сэтгэл санааны хохирлыг үнэлэхэд хамаарах зохицуулалт Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-т тусгагдсан. Гэхдээ зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд шаардлагатай шаардах эрхийн зохицуулалт хязгаарлагдмал хүрээнд тусгагдсан талаар өмнөх бүлгүүдэд дурдсан. Хэрэв сэтгэл санааны хохирлыг шаардах эрхийн зохицуулалт нь өргөн хүрээнд зохицуулагдаж чадсан нөхцөлд

⁵⁶ Б.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь, бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011, 40-42 дахь тал.

хохирлын хэмжээг үнэлэх арга техник шүүхийн практикаар тогтоно гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Мөн ХБНГУ-ын хувьд гэм хорын эрх зүйн хамгаалалтын ерөнхий зохицуулалт болон сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах тусгай зохицуулалтыг хуульдаа тусгах байдлаар хууль хэрэглээний асуудлыг шийдэх гэж оролдсон. Сэтгэл санааны хохирлыг эдийн хохирол учирснаас үл хамааран гаргуулахаар тусгахдаа тодорхой хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хязгаарлаж тусгасан. Учир нь бүхий л нөхцөлд сэтгэл санааны хохирлыг шаардах боломжгүй юм. Ингэхдээ бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэг гэж тоочих зарчмын дагуу шаардах эрхийн хүрээг хязгаарласныг анхаарах шаардлагатай байна.

4.2. ЯПОН УЛС

Япон Улсын хувьд Иргэний хуулийнхаа гэм хорын эрх зүйн зохицуулалтыг анх боловсруулах явцдаа Франц, Латин Америкийн улсуудын Иргэний хуулиудыг судалж байжээ. Мөн ХБНГУ-ын гэм хорын эрх зүйн зохицуулалтууд ч нөлөөлсөн байдаг. Иргэний хуулийг боловсруулахдаа Япон Улсын судлаач, эрдэмтэд эдийн бус алдагдлын (*non-economic losses*) хувьд гэм хорын төрлийг хөгжүүлэхээс илүү хохирлыг үнэлж, тооцооллын эрх зүйн зохицуулалтад анхаарсан байдаг.⁵⁷

Япон Улсад сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх шаардах эрхийн үндэслэлийг тус улсын Иргэний хуулийн 710, 711 дүгээр зүйлд тус тус зохицуулжээ. Түүнчлэн эдийн бус хохирлын хэмжээг тогтоохтой холбоотой зохицуулалтыг Япон

⁵⁷ Ruben Enrique Rodriguez Samudio, Non-economic losses under Japanese law from a comparative law perspective, Hokkaido University, Doctoral thesis, 2017, 1 дэх тал.

Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйлд заасан байна.

Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг шаардах эрх

Дээр дурдсанчлан хохирогчийн сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг Япон Улсын Иргэний хуулийн гэм хорын хэсэгт зохицуулжээ. Ингэхдээ тус хуулийн 709 дүгээр зүйлд гэм хороос учирсан хохирол шаардах ерөнхий зохицуулалтыг хуульчилсан ба тус заалт нь манай улсын Иргэний хуулийн 497 дугаар зүйлтэй дүйцнэ. Харин тус заалтын дараагийн заалт буюу 710 дугаар зүйлд эд хөрөнгийн бус хохирлын нөхөн төлбөр шаардах эрх, 711 дүгээр зүйлд хохирогчийн гэр бүл, ойр дотнын хүмүүсийн хохирол шаардах эрхийг тус тус тусгажээ.

Япон Улсын Иргэний хуулийн 709 дүгээр зүйл. Гэм хороос үүдэх хохирлыг нөхөн төлүүлэх нь⁵⁸

Санаатай юм уу болгоомжгүйн улмаас бусдын эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан этгээд нь учруулсан хохирлоо нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

Япон Улсын Иргэний хуулийн 710 дугаар зүйл. Эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх нь⁵⁹

Бусдын бие махбод, эрх чөлөө болон алдар хүндэд гэм хор учруулсан тохиолдол болон бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан аль ч тохиолдолд 709 дүгээр зүйлд заасны дагуу хохирлыг хариуцах үүрэгтэй этгээд нь эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

⁵⁸ (不法行為による損害賠償)

第七百九条 故意又は過失によって他人の権利又は法律上保護される利益を侵害した者は、これによって生じた損害を賠償する責任を負う。

⁵⁹ (財産以外の損害の賠償)

第七百十条 他人の身体、自由若しくは名誉を侵害した場合又は他人の財産権を侵害した場合のいずれであるかを問わず、前条の規定により損害賠償の責任を負う者は、財産以外の損害に対しても、その賠償をしなければならない。

Япон Улсын Иргэний хуулийн 711 дүгээр зүйл. Гэр бүл, дотнын хүний хохирлыг нөхөн төлүүлэх нь⁶⁰

Бусдын амь насыг бусниулсан тохиолдолд хохирогчийн эцэг эх, хань ижил болон хүүхдэд эд хөрөнгийн хохирол учраагүй байсан ч бусад хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Дээрх 710, 711 дүгээр зүйлд зааснаас үзвэл хохирогчид учруулсан хохиролтой холбоотойгоор түүний гэр бүл, ойр дотнын хүмүүс ч эд хөрөнгийн бус хохирол нөхөн төлүүлэх боломжтой. Гэхдээ мөн хуулийн 711 дүгээр зүйлийн урьдчилсан нөхцөлд “бусдын амь насыг бусниулсан тохиолдол” гэж байгаа боловч зарим тохиолдолд шүүхийн жишгээр өргөжүүлэн ойлгох явдал байгааг ч анхаарах нь зүйтэй. Тухайлбал, өсвөр насны охин бусдын учруулсан гэм хороос үүдэн нүүрэндээ засаршгүй гэмтэл авсан байна. Түүнээс улбаалан хохирогчийн эх охиныхоо нүүрний гэмтэлд ихэд шаналан сэтгэл зүйн хувьд гүн депресст орсон ба үүнийг нь харгалзан шүүхээс охины эхэд ч сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр олгож шийдвэрлэсэн байдаг.⁶¹

Харин хохирогч гэм хор учирсан даруйд нас барсан тохиолдолд талийгаачид учирсан хохирол түүний гэр бүл ойр дотнын хүнд шилжих эсэх дээр онолын хувьд ихээхэн маргаан өрнөж иржээ. Учир нь хохирогч нас барсан тохиолдолд нэхэмжлэгч нь хохирогчийн гэр бүл, ойр дотнын хүн байх бөгөөд шүүхээс сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэхдээ хохирлын хэмжээг нэхэмжлэгчид учирсан хохирлоор хязгаарлах уу эсхүл хохирогч (талийгаач)-д учирсан эдийн

⁶⁰ (近親者に対する損害の賠償)

第七百十一条 他人の生命を侵害した者は、被害者の父母、配偶者及び子に対しては、その財産権が侵害されなかった場合においても、損害の賠償をしなければならない。

⁶¹ 最判昭和33年8月5日民集12・12・1901 (Япон Улсын Дээд шүүхийн тогтоол, 1958 оны 8 сарын 5-ны өдөр).

бус хохирлыг багтааж ойлгох уу гэдэг дээр онолын хувьд маргаантай байсаар байна.

Хэрэв талийгаачийн хохирол өвлөгдсөн гэж үзвэл сэтгэл санааны хохирлыг таамаглах замаар нэхэмжлэгчид харьцангуй амар байдлаар шийдвэрлэгдэнэ. Энэ тохиолдолд 710 дугаар зүйлд заасны дагуу талийгаачид учирсан сэтгэл санааны хохирол, түүний өвлөгчид шилжсэн гэж үзсэн хэрэг юм. Үүнийг “Өвийн онол (相續説)” гэж тайлбарладаг. Тус онолоор хохирогч нас барсны улмаас уг эрх нь ойр дотнын хүмүүст нь өвлөгдөж, талийгаачийн эрх өвлөгчид эдийн бус хохирол нэхэмжлэх эрх үүсдэг гэж тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, талийгаачийн эрх залгамжлагчийн нэхэмжилж буй сэтгэл санааны хохирол нь анхнаасаа эрх залгамжлагчийн өөрийнх нь хохирол биш бөгөөд талийгаачийн хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх эрхийг өвлөж авсан этгээд хэрэгжүүлж буй хэлбэр юм.⁶²

Гэхдээ талийгаач өөрийн сэтгэл санаанд учирсан хохирлыг нэхэмжлэгчид өвлүүлэхийг хүсэхгүй байсан бол хэрхэх вэ гэдэг асуудал бий. Гэм хор учирснаас нас барах хүртэлх хугацаанд хүсэл зоригоо илэрхийлэх боломж талийгаачид олдоогүй нөхцөл байдалд өвлүүлэхийг хүсээгүй хүн нь түүний өмнөөс хохирол нэхэмжлэх магадлалтай тул ийм тохиолдолд 710 дугаар зүйл бус харин 711 дүгээр зүйлийг хэрэглэнэ гэж тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, шүүхээс талийгаачийн дотнын хүн буюу нэхэмжлэгч өөрөө тухайн гэм хорын улмаас сэтгэл санаагаараа хохирсон эсэх дээр үнэлэлт, дүгнэлт өгөн нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэхийг шийдвэрлэнэ. Үүнийг “Бие даасан хохирлын онол (固有被害説)” гэж тайлбарладаг байна.⁶³

Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг тооцоолох нь

Эдийн бус хохирлын шинж чанараас хамаараад түүний

⁶² 前田陽一 (2017) 「債権各論Ⅱ〔不法行為法〕〔第3版〕」弘文堂、p. 119.

⁶³ Мөн тэнд, 120 дахь тал.

хэмжээг тооцоолох, нотлох асуудал хуульчдын дунд ихээхэн ярвигтайд тооцогддог. Ялангуяа иргэний эрх зүйн хэрэг, маргааны хувьд маргалдагч талууд үндэслэлээ нотлох үүрэгтэй байдаг нь сэтгэл санааны хохирол шиг яв цав нотлох боломжгүй асуудал дээр тусгайлсан зохицуулалт хэрэгтэй гэж үзэх нь бий. Япон Улсын хувьд ч энэ нөхцөл байдалтай уялдуулан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолохдоо Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэдэг байна.

Япон Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйл. Хохирлын хэмжээг тогтоох нь⁶⁴

Хохирол үүссэн байдлыг тогтооход хохирлын шинж чанараас шалтгаалан түүний хэмжээг нотлоход илт хүндрэлтэй бол шүүх талуудын мэтгэлцээний бүрэн агуулга болон нотлох баримтын үнэлгээний үр дүнд үндэслэн, тохирох хохирлын хэмжээг тогтоох эрхтэй.

Уг заалт нь нэгэнт хөдөлбөргүй нотлох бололцоо байхгүй хохирлын шинж чанараас улбаалан хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх эрсдэлээс хамгаалах зорилготой. Тодруулбал, сэтгэл санааны хохирлын үнэлгээг тооцоолох аргачлалгүй эсхүл нэхэмжлэгч нь нэхэмжлэлийнхээ шаардлагад заасан хэмжээгээр эдийн бус хохирол амссан гэдгийг нотолж чадахгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хангахаас татгалзаж шийдвэрлэх нь логик үндэслэл муутай юм. Учир нь энэ төрлийн хохирлыг нотлох аргачлал хуульд ч тодорхой бус байгаа бөгөөд хэрхэн нотлохыг шүүгч өөрөө ч бүрэн дүүрэн тайлбарлах боломжгүй юм.

⁶⁴ (損害額の認定)

第二百四十八条 損害が生じたことが認められる場合において、損害の性質上その額を立証することが極めて困難であるときは、裁判所は、口頭弁論の全趣旨及び証拠調べの結果に基づき、相当な損害額を認定することができる

Иймд хууль тогтоогч дээрх заалтаар шүүгчид сонгох эрх олгосон байна. Ингэхдээ шүүгч нь шүүх хуралдааны үед явагдсан мэтгэлцээн болон бусад нотлох баримтыг харгалзан өөрийн дотоод итгэл үнэмшилдээ тулгуурлан хохирлын нөхөн төлбөрийг тогтоох боломжтой. Мэдээж, өнгөц харвал ийм сонгох эрх шүүгчид өгсөн нь үзэмжээрээ шийдвэрлэх боломж олгосон мэт харагдахыг үгүйсгэхгүй ч энэ асуудлыг Японы эрх зүйн тогтолцоо нь өөрөө шийдвэрлэж өгчээ. Тодруулбал, дээрх хуулийн 248 дугаар зүйлтэй адил төстэй байдлаар шүүгчид сонгох эрх олгосон зохицуулалтын хууль хэрэглээнд “шүүхийн прецедент”-ийн үр нөлөө тод ажиглагддаг. Тус улсад хэдий албан бус боловч дээд шатны шүүхийн шийдвэрээр тогтоогдсон жишиг нь доод шатны шүүхийн шийдвэрт тодорхой нөлөө үзүүлдэг. Тиймдээ ч эдийн бус хохирол болох сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг ханган шийдвэрлэсэн дээд шатны шүүхийн шийдвэрүүд нь тэдгээртэй ижил төстэй хэрэгт хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг шүүхээс хэр зэрэг хэмжээгээр нөхөн төлүүлэх нь зохистой вэ гэдгийг шийдвэрлэхэд харгалзан үзэх гол эх сурвалж болно.

Гэхдээ зөвхөн дээд шатны шүүхийн жишиг тогтоосон шийдвэр сэтгэл санааны хохирлын хэмжээг тодорхойлно гэвэл өрөөсгөл болно. Судлаачдын үзэж буйгаар шүүхээс хохирогчид хохирлын нөхөн төлбөр гарган шийдвэрлэхэд нийт хангагдаж буй нэхэмжлэлийн шаардлагын дүн нь харьцангуй бага болсон гэж шүүгч дотоод итгэл үнэмшлээрээ дүгнэсэн тохиолдолд тохирох үнийн дүнгээр сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хангаж шийдвэрлэдэг гэж үзэх хандлага бий.⁶⁵ Өөрөөр хэлбэл, хохирогчийн нотлогдсон эд хөрөнгийн хохирлын нөхөн төлбөр нь тухайн хохирогчийн хохирсон эрх, ашиг сонирхлыг сэргээхэд хангалтгүй гэж шүүхээс үзсэн

⁶⁵ 升田純 (2018、民事法研究会) 『判例にみる慰謝料算定の実務』 p. 11.

тохиолдолд шүүх нэмэлт байдлаар сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хангаж шийдвэрлэдэг гэсэн үг юм.

Дээрх агуулгаар Япон Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө гэм хор учруулагчийн үйлдэлд шийтгэл байдлаар буюу *punitive damage* (懲罰的損害賠償)-ийн онолыг хүлээн зөвшөөрдөггүй. Харин хохирогчийн эрх, ашиг сонирхлыг тэргүүнд тавьж, хохирлын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх, нөхөх байдлаар хүлээн зөвшөөрөх хандлага давамгайлж байна.⁶⁶

4.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

ХБНГУ болон Япон Улсын гэм хорын эрх зүй дэх сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг судлан үзлээ. Дотоодын хууль тогтоомжийн зохицуулалттай харьцуулан авч үзвэл ХБНГУ болон Япон Улс нь зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой сэтгэл санааны хохирлыг гэхээс илүүтэй бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдлыг зөрчсөнтэй холбоотой сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах боломжийг Иргэний хуулиараа олгосон байна. Ингэснээрээ эдийн хохирлоос гадна сэтгэл санааны хохирлоо шаардах боломжийг өргөтгөсөн бөгөөд гэм хорын эрх зүйн бүхий л хохирлыг барагдуулах, эрхийг бүрэн сэргээх зарчимд нийцэж байгаа юм.

ХБНГУ-ын хувьд Иргэний хуульдаа сэтгэл санааны хохирлыг шаардах зохицуулалтыг тусгахдаа зөвхөн хуульд тухайлан заасан нөхцөлд шаардах боломжтой байдлаар

⁶⁶ 升田純 (2018、民法研究会) 『判例にみる慰謝料算定の実務』 p. 8.

оруулсан нь манай улсын Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгтэй адил төстэй гэж үзэж болохоор байна. Харин манай улсын Иргэний хуулийн 511 дүгээр зүйлээр тухайлан хамгаалагдсан эрхээс өргөн хүрээнд сэтгэл санааны хохирлыг гаргуулах боломж олгосон нь ихээхэн ач холбогдолтой байна. Япон Улсын хувьд мөн адил бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, алдар хүндийг гутааснаас үүдэн бий болж буй сэтгэл санааны хохирлыг гаргуулах боломжийг Иргэний хуулиар тухайлан олгож байгаа бөгөөд манай улсын Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан зохицуулалттай адил зохицуулалтыг тусгайлан тодотгох байдлаар сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахаар зохицуулсан байна. Энэ дагуу манай улсын хувьд ч Иргэний хуулийнхаа 511 дүгээр зүйлд заасан хүрээг өргөтгөн тусгаж, сэтгэл санааны хохирол гаргуулах асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг ХБНГУ болон Япон Улсын хувьд гэм хорын эрх зүйн үндсэн элемент болон хэргийн нөхцөл байдал, нотлох баримтыг үндэслэн шүүх хуулийг тайлбарлах замаар мөнгөн хэлбэрээр гаргуулж байна. Харин манай улсын Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-т гэм хорыг арилгах хэмжээг хэрхэн тусгах талаар зохицуулсан боловч тус зохицуулалт нь практикт төдий л хэвшиж хэрэглэгдээгүй байна. Энэ нь манай улсын Иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг гаргуулах шаардах эрхийг хэт хязгаарлан тусгасан учир сэтгэл санааны хохирлыг шаардах эрхгүй гэж шүүх дүгнэж ирсэнтэй холбоотой юм.

Япон Улсын Иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг дам хохирол гэж үзвэл шууд бус хохирогч этгээд нь дам хохирлоо шаардах эрхтэй гэж өргөн хүрээнд зохицуулсан. Харин манай улсын Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1-д хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний

өв залгамжлагч шаардах эрхтэй гэж зохицуулсан бөгөөд тус зохицуулалтаас үзвэл өв залгамжлагч шаардах эрхтэй байхаар байна. Учир нь дам хохирол нь шууд бус хохирогчийн шаардах боломжтой хохирол бөгөөд заавал өв залгамжлагч бус тухайн гэм хор учирсны улмаас шууд бус хохирогч өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо шаардах эрхтэй байдаг. Тухайлбал, ганц хүүгээ алдсан ээжид сэтгэл санааны хохирол учирсан гэж үзвэл гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирлоо шаардах боломжтой. Гэтэл манай улсын хувьд тус эрхийг хязгаарлаж зөвхөн өв залгамжлагч этгээд шаардах эрх олж авах байдлаар зохицуулжээ.

ТАВ. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Сэтгэл санааны хохирол гаргуулах шаардах эрхийн хүрээг нэмэгдүүлснээр өөрт учирсан хохирлыг гаргуулах тухай Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн баталгааг хангахаас гадна гэм хорын эрх зүйн хохирлыг бүрэн хэмжээгээр арилгах, эрхийг нөхөн сэргээх зарчимд нийцэх юм. Иймд эдийн хохирол учирснаас үл хамааран сэтгэл санааны хохирлоо шаардах эрх нээлттэй байх ёстой. Манай улсын хувьд сэтгэл санааны хохирол шаардах боломжийг Иргэний хуулиар хязгаарласан бөгөөд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой сэтгэл санааны хохирлыг шүүх гаргуулж байна. Үүнээс бусад тохиолдолд үүсэж болох сэтгэл санааны хохирлыг Иргэний хуулийн 230.2-т заасан зохицуулалттай уялдуулан тайлбарлаж, хуульд тухайлан сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах тухай зохицуулаагүй гэж үндэслэж, сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах эрхийг ноцтой зөрчсөөр байна. Зүй нь Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд заасан хамгаалагдах эрхийн объектыг өргөтгөн хуульд тусгах шаардлагатай юм.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд ХБНГУ болон Япон Улсын хувьд сэтгэл санааны хохирлыг бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, бэлгийн эрх чөлөө зэрэг эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд гаргуулж байна. Гэхдээ ХБНГУ-ын хувьд хуульд тухайлан заасан нөхцөлд сэтгэл санааны хохирлыг гаргуулна гэж сэтгэл санааны хохирол шаардах

боломжийг Иргэний төрөлжсөн хуулиар хязгаарласан байна. Учир нь сэтгэл санааны хохирол нь сэтгэл санааны хямрал буюу айх, ичих, уур уцаартай болох, баяр баясалгүй болох, зовох, шаналах зэрэг байдлаар илэрдэг тул сэтгэл санааны ямар хямралыг сэтгэл санааны хохирол гэж үзэх гэдэгт хязгаар тогтоох нь зүйтэй байсан гэж хэлж болно. Судлаачдын зүгээс мөн адил сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахад тодорхой хязгаар, урьдчилсан нөхцөл шаардлагатай гэж үзсэн.

Манай улсын шүүхийн практик, түүнчлэн ХБНГУ болон Япон Улсын шүүхийн практикийг судалж үзэхэд тодорхой хэд хэдэн урьдач нөхцөлийг сэтгэл санааны хохирол нөхөн гаргуулахад авч үзсэн байна. Үүнд, (i) учирсан сэтгэл санааны хохирол нь хохирогч этгээдэд хамааралтай байх эсхүл өв залгамжлагчид хамааралтай байх; (ii) тухайн учирсан сэтгэл санааны хохирлыг дахин засварлах, сэргээх боломжгүй байх; (iii) санаатай болон болгоомжгүй гэм буруутай байх; (iv) үйлдэл нь жигшим, зэвүүцмээр, хэнд ч мэдэгдэхүйц сэтгэл санааны хохирол учруулах үйлдлээр илэрсэн байх; (v) дээрх үйлдэл нь нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирол учрах шалтгаан болсон байх; (vi) хохирогчид сэтгэл санааны хохирол буюу сэтгэл санааны хямралын хэв шинж илэрсэн байх; (vii) иргэний хууль болон бусад хууль тогтоомжид сэтгэл санааны хохирлоо нөхөн гаргуулах шаардах эрхийг тухайлан заасан байх зэрэг юм.

Сэтгэл санааны хохирол нь шууд хохирлоос үргэлжилсэн байдлаар учирдаг хохирол тул анх үүсгэж буй гэм хор буюу эрх зүйн үр дагавар нь ноцтой, зэвүүцмээр, жигшим байхыг шаарддаг. Ингэснээр сэтгэл санааны хохирлыг ялимгүй зөрчил үйлдсэний үр дүнд гаргуулах боломжгүй болох бөгөөд тодорхой хязгаарыг тогтоож өгөх юм. Монгол Улсын шүүх сэтгэл санааны хохирлыг гаргуулж буй шийдвэрүүдийг судлан үзэхэд хэргийн хөнгөн, хүнд нөхцөл байдлаас хамааран хохирлыг гаргуулах эсэх нь ихээхэн хамаарч байна. Учир нь хэргийн

хөнгөн, хүндээс хамаарч хохирогчийн сэтгэл санааны хямралын түвшин тодорхойлогддог гэж хэлж болно. Мөн иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд хэдийгээр сэтгэл санааны хохирол учирсан эсэх нь нотлогдоогүй гэж үзсэн боловч илтэд ноцтой, зэвүүцмээр, жигшим үйлдэл гаргасан хэргүүдэд хохирогчийн эдийн хохиролд сэтгэл санааны хохирлын дүн, үнэлгээг багтааж нэхэмжлэлийг хангах байдал ажиглагдаж байна. Энэ нь манай улсад сэтгэл санааны хохирлыг гаргуулж, эрхийг сэргээх суурь нөхцөл бүрдсэнийг харуулж байна. Гагцхүү Иргэний хуулийн 230.2 дахь хэсгийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, Иргэний хуулийн 511 дэх хэсгийн зохицуулалтаар сэтгэл санааны хохирол шаардах эрхийн хүрээг хязгаарласан зэрэгтэй холбоотойгоор сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах боломж хязгаарлагдсаар байгааг дахин дурдах нь зүйтэй юм.

Сэтгэл санааны хохирлыг үнэлэхэд ихээхэн төвөгтэй байдаг. Учир нь сэтгэл санааны хохирлыг мөнгөөр яв цав үнэлэн тогтоох боломжгүй. Гэхдээ зөрчигдсөн эрхийг анхны байдалд оруулж болохгүй тул мөнгөн хэлбэрээр хохирлыг гаргуулж, хохирогчийн эрхийг орлуулан сэргээхэд чиглэдэг. Манай улсын хувьд хохирлыг үнэлэх эрх зүйн ерөнхий зохицуулалт бий боловч шүүхийн практикт хэрэглэж хэвшээгүй. Учир нь Иргэний хуулиар сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах шаардах эрхийг хязгаарласантай холбоотой. Шүүх сэтгэл санааны хохирлыг шаардах эрхгүй байна гэж дүгнэж ирснээс бус хохирлыг үнэлэх асуудлыг тэр бүр шийдвэрлэж ирсэнгүй. Үүнтэй уялдан сэтгэл санааны хохирлыг үнэлэн тогтоох шүүхийн практик өргөн хүрээнд тогтоогүй юм.

Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт заасан “Гагцхүү хуульд тусгайлан заасан” тохиолдол гэсэн үг, өгүүлбэрийг зөвхөн Иргэний хуулиар хязгаарлахгүйгээр бусад хууль тогтоомжтой

уялдуулан хэрэглэж хэвших нь сэтгэл санааны хохирлыг гаргуулахад ихээхэн ач холбогдолтой байна. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр шаардах боломжийг тусгасан боловч шүүх “Иргэний хуульд тусгайлан заагаагүй” гэсэн үндэслэлээр сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр гаргуулахаас татгалзаж байна.

ЗУРГАА. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТТЭЙ УЯЛДУУЛАН ГАРГАСАН САНАЛ

Нэг. Иргэний хуулийн 230.2 дахь хэсгийн зохицуулалтыг хэвээр үлдээж, мөн хуулийн 511 дүгээр зүйлд эдийн хохирлоос гадна учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулах зохицуулалтыг өргөтгөн тусгах замаар уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Ингэхдээ ХБНГУ-ын адил амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэгт учирсан эдийн бус хохирлыг эдийн хохирлоос тусад нь мөнгөөр үнэлэн төлүүлж болно гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Хоёр. Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт заасан “Тагцхүү хуульд тусгайлан заасан” тохиолдол гэсэн үг, өгүүлбэрийг зөвхөн Иргэний хуулиар хязгаарлахгүйгээр бусад хууль тогтоомжтой уялдуулан хэрэглэж хэвших нь сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг гаргуулахад ихээхэн ач холбогдолтой. Учир нь Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр шаардах боломжийг тусгасан боловч шүүх “Иргэний хуульд тусгайлан заагаагүй” гэсэн үндэслэлээр сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр гаргуулахаас татгалзаж байна.

Гурав. Сэтгэл санааны хохирлыг үнэлэхдээ хохирогчид учирсан шууд хохирлын үр дагавар, хохирлын үнэ цэн, гэм хор учруулагчийн гэм буруу, түүний хэлбэр, үйлдэл, хохирлын

шалтгаант холбоо, хохирогчийн сэтгэл санааны хямралын түвшин зэргээс хамааруулан шүүх хуулийг тайлбарлах замаар хэргийн материалд тулгуурлан тогтоох нь зүйтэй.

Дөрөв. Шүүх сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг ханган шийдвэрлэхдээ дараах урьдчилсан нөхцөл байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй ба тэдгээр нь хэргийн үйл баримтад хэрхэн тусгагдсан талаар шийдвэрийн үндэслэлдээ тэмдэглэх нь энэ төрлийн эрх зүйн харилцааны зохицуулалт илүү боловсронгуй болоход дөхөм болно. Үүнд, (i) учирсан сэтгэл санааны хохирол нь хохирогч этгээдэд эсхүл өв залгамжлагчид хамааралтай эсэх; (ii) тухайн учирсан сэтгэл санааны хохирлыг дахин засварлах, сэргээх боломж байгаа эсэх; (iii) санаатай болон болгоомжгүй гэм буруутай эсэх; (iv) үйлдэл нь жигшим, зэвүүцмээр, хэнд ч мэдэгдэхүйц сэтгэл санааны хохирол учруулах үйлдлээр илэрсэн эсэх; (v) дээрх үйлдэл нь нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирол учрах шалтгаан болсон эсэх; (vi) хохирогчид сэтгэл санааны хохирол буюу сэтгэл санааны хямралын хэв шинж илэрсэн эсэх; (vii) иргэний хууль болон бусад хууль тогтоомжид сэтгэл санааны хохирлоо нөхөн гаргуулах шаардах эрхийг тухайлан заасан эсэх зэрэг юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

А. Монгол хэлээр:

1. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага, УБ., 2017.
2. Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV, УБ., 2016.
3. Ё.Каюг, Э.Шпанглер нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, УБ., 2010.
4. Ц.Одмаа, Нийтийн эрх зүйн бүлийн зарим улс дах эдийн бус гэм хорыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2009, №1.
5. Швейцарын хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Стрессийг үүсгэх шалтгаан ба оношилгоо, тусламж: Мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ., 2010.
6. Б.Батсайхан, М.Дэлгэржав, Ерөнхий сэтгэл судлал (Анхны хэвлэл) УБ., 2013.
7. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011.
8. Б.Буянхишиг, Үүргийн эрх зүй (Ерөнхий анги), УБ., 2013.
9. Б.Улаанбаатар, Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2006.
10. С.Должин, Харьцуулсан хувийн эрх зүй судлал, УБ., 2018.

11. Ж.Оюунтунгалаг, Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019, №1 (71).
12. Э.Золзаяа, Монгол Улсын болон гадаад улсын иргэний эрх зүй дэх сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлын эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа, “Эрх зүй” сэтгүүл, 2014, №1 (27).
13. Хүний эрхийн Үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ, УБ., 2013.
14. Гүнтэр Кристиан Шварц, Манфрэд Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй (3 дахь хэвлэл), УБ., 2017.
15. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2007.
16. Б.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь, Бакалаврын дипломын ажил, 2011.

Б. Гадаад хэлээр:

1. Black’s law dictionary (7th ed. 1999).
2. Betsy J. Grey, The Future of Emotional Harm, 83 Fordham L. Rev. 2605 (2015).
3. Finja Marten, The Mediating Effect of Eustress and Distress on the Relation between the Mindset Towards Stress and Health.
4. Amir Mohammad Shamsavarani, Esfandiar Azad Marz Abadi, Maryam Hakimi Kalkhoran, Stress: Facts and Theories through Literature Rev. International Journal of Medical Reviews, Vol.2, Issue 2, 2015.

5. Aline Drapeau, Alain Marchand and Dominic Beaulieu-Prévost, *Epidemiology of Psychological Distress* (2012).
6. M.Lee Huffaker, *Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama*, *Alabama Law Review* Vol. 52:3:1003 (2000).
7. Francis X. Clinch and Jodie L. Johnson, *Compensation of Emotional Distress in Montana: Distinctions between Bystanders and Direct Victims*, 47 *Mont. L. Rev.* (1986).
8. Ulrich Magnus, *The Reform of German Tort Law*, *Universidad de Hamburgo* (2003).
9. Madeleine Tolani, *U.S. Punitive damages before German courts: A comparative analysis with respect to the ordre public*, *Annual Survey of International & Comparative Law*, Vol. 17, Iss. 1, Article 9 (2011).
10. Volker Behr, *Punitive Damages in America and German Law - Tendencies towards Approximation of Apparently Irreconcilable Concepts*, *Chi.-Kent. L. Rev.* (2003).
11. Ruben Enrique Rodriguez Samudio, *Non-economic losses under Japanese law from a comparative law perspective*, *Hokkaido University, Doctoral thesis* (2017).

В. Япон хэлээр:

1. 最判昭和33年8月5日民集12・12・1901 (Япон Улсын Дээд шүүхийн тогтоол, 1958 оны 8 дугаар сарын 5-ны өдөр).
2. 我妻榮, 有泉亨著『コンメンタル事務管理・不当利得・不法行為』日本評論社, 1998
3. 加藤一郎編集『不法行為・注釈民法債権10第709~724条』有斐閣、2013
4. 能見善久, 加藤新太郎編『判例民法8・不法行為〔第3版〕』第一法規、2019
5. 齋藤修編『慰謝料算定の理論』ぎょうせい、2010

6. 前田陽一『債権各論Ⅱ〔不法行為法〕〔第3版〕』弘文堂、2017
7. 升田純判例にみる慰謝料算定の実務』民事法研究会、2018

Г. Хууль тогтоомж, Дээд шүүхийн тайлбар, зөвлөмж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1992, №1.
2. Иргэний хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2002, №7.
3. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2016, №7.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017, №23.
5. Гэр бүлийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1999, №30.
6. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай, Дугаар №15.
7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 2018-09-21, Дугаар №11.

Д. Шүүхийн шийдвэр:

1. УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 592 тогтоол.
2. УДШ-ийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Дугаар 238 тогтоол.
3. УДШ-ийн 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн Дугаар 169 тогтоол.
4. УДШ-ийн 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Дугаар 001/ХТ2018/01759 тогтоол.

5. УДШ-ийн 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Дугаар 692 тогтоол.
6. УДШ-ийн 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Дугаар 001/ХТ2019/00036 тогтоол.
7. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 1087 дугаартай шүүхийн шийтгэх тогтоол.

2

ЭДИЙН БУС ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ОНОЛЫН АСУУДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ШҮҮХЭЭР ЭДИЙН БУС ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



БАТЖАРГАЛЫН АРИУНЗАЯА

АКР хуулийн фирмийн гүйцэтгэх захирал, хууль зүйн магистр тэрбээр 2012 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн, 2014 онд Япон Улсын Нагояагийн их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Одоогоор “Монгол Улсын эдийн бус хохирлын асуудалтай холбоотой харьцуулсан судалгаа” сэдвээр Япон Улсын Каназавагийн их сургуульд докторын зэрэг хамгаалахаар судалгаа хийж байгаа болно. Тэрээр сэтгэл санааны хохирлын асуудлаар *Human and Socio-Environment Studies* сэтгүүлд өгүүлэл нийтлүүлж байснаас гадна шүүхийн талаарх хэд хэдэн судалгаа хийж нийтлүүлсэн.



ЛХАГВАСҮРЭНГИЙН АМГАЛАНБААТАР

2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2020 онд Япон Улсын Нагояагийн их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Үндсэн хууль, хүний эрх, шүүхийн жишиг зэрэг сэдвээр судалгааны ажилд оролцон өгүүлэл, нийтлэлээ “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл, “Шүүх эрх мэдэл” сэтгүүлд нийтлүүлсэн туршлагатай.

Судлаачид:

Б.Ариунзаяа (LL.D.
candidate)

Л.Амгаланбаатар
(LL.M.)

Х.Норовсүрэн (LL.B)



ХҮРЭЛИЙН НОРОВСҮРЭН

2021 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.

“Гэрээний стандарт нөхцөлийг өөрчлөхтэй холбогдох эрх зүйн асуудал”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын хараат бус байдлыг Үндсэн хуулиар бэхжүүлэх нь” зэрэг өгүүлээ монгол болон япон хэлээр нийтлүүлсэн туршлагатай.

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	97
1.1. Судалгааны хэрэгцээ, шаардлага	97
1.2. Судалгааны зорилго	100
1.3. Сэдвийн судлагдсан байдал	101
1.4. Судалгааны арга зүй	104
ХОЁР. ЭДИЙН БУС ХОХИРЛЫН ТУХАЙ ОНОЛЫН ЕРӨНХИЙ УРСГАЛ	106
2.1. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны зорилго, шинж чанар	106
2.2. Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх тогтолцооны олон талт чиг үүрэг	110
2.3. Сэтгэл санааны хохирлыг үнэлэх зарчим	114
2.4. Сэтгэл санааны хохирлын хүрээ хязгаар	115
ГУРАВ. ЭДИЙН БУС ХОХИРЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ЗАРИМ ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	120
3.1. Эр эмийн харилцаа дахь сэтгэл санааны хохирол	121
3.2. Өмчийн эрх зөрчигдсөний улмаас үүсэх сэтгэл санааны хохирол	133

3.3. Гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоор учирсан сэтгэл санааны хохирол	137
3.4. Хөдөлмөрийн харилцаа дахь сэтгэл санааны хохирол.....	157
3.5. Дүрсийн эрхийг зөрчсөнөөс үүсэх сэтгэл санааны хохирол	162
3.6. Хууль бусаар цагдан хорих, ял шийтгүүлсэн хэрэг	169
3.7. Бүлгийн дүгнэлт	180
ДӨРӨВ. ГАДААД УЛСУУДЫН ТУРШЛАГА	188
4.1. Улс орнуудын Иргэний хуульд эдийн бус хохирлын асуудал тусгагдсан байдал	188
4.2. Улс орнууд эдийн бус хохирлын шинж чанарыг авч үзсэн байдал	192
4.3. Эдийн бус хохирлыг ойр дотнын хүнд нь хүлээн зөвшөөрдөг эсэх	196
4.4. Хохирлыг үнэлэх суурь зарчим, аргыг тогтоосон эсэх	198
4.5. Дүгнэлт	202
ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ	203
5.1. Дүгнэлт	203
5.2. Санал	206
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	212

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИХ	Иргэний хууль
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОСНААУТ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх гэдэг нь сэтгэл санааны буюу эдийн бус хохиролд олгож буй мөнгөн хэлбэрийн нөхөн төлбөр бөгөөд уг хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь аливаа хууль бус үйлдэл үйлдсэн этгээдийн зүгээс эрх нь зөрчигдсэн этгээд буюу хохирогчид шударга ёсыг буцаан тогтоох, хохирогчийн эрхийн мэдрэмжийг сэргээх чиг үүрэг бүхий орчин үеийн нийгэмд нэн шаардлагатай, чухал тогтолцоо гэж үнэлэгдэж байна¹. Нөгөө талаар эдийн бус хохирол нь аливаа хувь хүний бие махбод болон сэтгэл санааны шаналлыг эрх зүйн хувьд үнэлж буй үнэлгээ юм. Өөрөөр хэлбэл, эдийн бус хохирол нь аль ч улс үндэстний зүгээс өөрийн иргэдийг хувь хүнийх нь хувьд хэрхэн үнэлж буйг хэмжигч барометр гэж хэлж болно². Иймд аливаа улсын хувьд иргэнд учирсан хохирлыг хэрхэн үнэлж байгаагаас нь тухайн улсын төр засаг иргэнээ хэрхэн үнэлж буй нь харагдана гэсэн үг юм.

Монгол Улсын хувьд “эдийн бус хохирол”, “сэтгэл санааны хохирол”-той холбоотой цөөн хэдэн зохицуулалт хууль тогтоомжид байдаг бөгөөд эдгээрийн утга, агуулга нь “эдийн бус хохирлыг” хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрсөн

¹ Saito Osamu (齋藤修), “Compensation Calculation Theory” [慰謝料算定の理論], Gyosei [行政] no. 5 (2010), p. 2.

² Saito Osamu (齋藤修), “Traffic Law Research” [交通法研究], no. 33 (2005), p.10.

шинжтэй байдаг. Тодруулбал, Иргэний хууль (ИХ)-ийн 230.1-д “Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй” гэснээс харахад эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрч байх боловч 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж зааснаар түүнийг хэрэглэх хүрээг хязгаарлажээ. Ингэснээр энэ нь зөвхөн аль нэг хуульд эдийн бус хохирлыг мөнгөн төлбөрөөр нөхөн олгох тухай заалт хуульчлагдсан тохиолдолд хүлээн зөвшөөрөх утгатай болсон байна. Одоогийн байдлаар ИХ-ийн 511 дүгээр зүйлд эдийн бус хохирлыг мөнгөн төлбөрөөр барагдуулахаар тусгайлан зохицуулсан байгаа бөгөөд үүнд зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсантай холбоотойгоор эдийн бус гэм хорыг арилгахаар заасан байна. Үүнээс өөр тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудал хүндрэлтэй байдаг.³ Нэгэнт ИХ-ийн 230-д ийм зохицуулалт байхад бид өөр тохиолдолд энэ заалтыг төсөөтэй хэрэглэх боломжгүй юм⁴.

Хэдийгээр ИХ-д эдийн бус хохирлыг хязгаарлагдмал хүрээнд хуульчилсан боловч шүүхийн практикт иргэд нэр төр, алдар хүндэд халдсанаас бусад олон тохиолдолд эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирол нэхэмжилсээр байгаа нь анхаарал татдаг. Тухайлбал, гэрлэгсдийн хэн нэг нь гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэсний улмаас нөгөө тал нь өөрт учирсан сэтгэл санааны хохирол шаардсан⁵, сүйт эмэгтэй нь сүйгээ цуцалсны улмаас санал тавьсан залуу нь сэтгэл санааны хохирлоо сүйт эмэгтэйдгээсээ шаардсан⁶, түрээсийн гэрээний

³ Б. Буянхишиг, Үүргийн эрх зүйн тусгай анги, 3 дахь хэвлэл, 2013, 518 дахь тал.

⁴ Б. Буянхишиг, Үүргийн эрх зүйн тусгай анги, 3 дахь хэвлэл, 2013, 518 дахь тал.

⁵ Н.Б-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 142/ШШ2016/01333 дугаартай шийдвэр (142/2016/00473/и).

⁶ К.Г-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 0229 дугаар шийдвэр (102/2016/07738/и).

үүргийн зөрчлөөс үүдэн түрээслэгч тал өөрт учирсан сэтгэл санааны хохирол шаардсан⁷, ажлаасаа хууль бусаар халагдсаны улмаас олон сар ажилгүй явсан ажилтан сэтгэл санааны хохирлоо ажил олгогчоос шаардсан хэрэг⁸ гэх мэт цөөнгүй хэрэг байна. Эдгээр хэргийн шүүхийн шийдвэрүүд нь ИХ-д тусгагдсан нэр төр, алдар хүндэд учирсан эдийн бус хохирол, мөн хүний хамгийн дээд үндсэн эрх болох амь нас, эрүүл мэндэд учирсан эдийн бус хохирлоос гадна өөр олон эрхийн зөрчилд эдийн бус хохирол үүсэх боломжтой гэдгийг харуулсан чухал ач холбогдолтой юм.

Гэвч эдгээр хэргийн ихэнхэд шүүх эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээс татгалзсан байдаг. Шүүхийн хувьд “эдгээр тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульд заагаагүй”, “эдийн бус хохирол үүссэн нь нотлогдохгүй байна”, “эдийн бус хохирлын хэмжээг үнэлэх боломжгүй байна” гэдэг үндсэн гурван шалтгаанаар эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрдөггүй.

Монголын криминологичдын холбооны 2021 онд хийсэн судалгаагаар “Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явцад хохирол нөхөн төлүүлэлт 2017 онд 37.6 хувь байсан бол 2018 онд хохирол 16.8 хувь буюу 20.8 хувиар буурсан”⁹ гэжээ. Эндээс үзэхэд Монгол Улсад хохирол нөхөн төлүүлэлтийн хувь хэмжээ туйлын бага байгааг харж болно. Эдийн бус хохирол байтугай эдийн хохирлын нөхөн төлүүлэлт хангалтгүй хэмжээнд байгаа нь манай улсад хүний эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг

⁷ “Э” ХХК-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 7 дугаар сарын 1-ний 5022 дугаартай шийдвэр (101/2016/04107/и).

⁸ Төв аймгийн ИТХ-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 151/ШШ2019/00159 дугаартай шийдвэр.

⁹ Монголын криминологичдын холбоо, Нээлттэй Нийгэм Форум, Хохирлын Үндэсний Тогтолцоо: Монголд гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлж буй нөхцөл байдал, 2020, 84 дэх тал.

сэргээх ажил туйлын хангалтгүй хэрэгжиж байгааг илэрхийлж байна.

Иймээс Монгол Улсын шүүхээр хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндээс бусад эрхийн зөрчилд учирсан эдийн бус хохирлыг хэрхэн нөхөн төлүүлж буй шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд шүүхэд тулгарч буй асуудал, байр суурь, үндэслэлийг тодорхой болгох, улмаар эдийн бус хохирлыг илүү өргөн хүрээнд ойлгож, хүлээн зөвшөөрөхийн ач холбогдол, хэрэгцээ шаардлага, арга замыг тодорхой болгох шаардлагатай юм.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгаагаар эдийн бус хохирлын талаарх шүүхийн байр суурийг онолын үндсэн дээр тодруулах, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд шүүхэд тулгарч буй асуудлыг шүүхийн шийдвэрт үндэслэн авч үзсэнээр эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны чиг үүрэг, ач холбогдлыг тодорхойлохыг зорилоо. Мөн манай улсад эдийн бус хохирлыг хэрхэн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх боломжтой талаар санал, зөвлөмж боловсруулах нь судалгааны ажлын зорилгод багтана. Энэхүү зорилгод хүрэхийн тулд бид дараах зорилтыг дэвшүүлж ажиллав. Үүнд:

- Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх зорилго, чиг үүргийг тогтоох. Үүний тулд Бодит хохирлын болон Шийтгэлийн шинжтэй хохирлын онол гэсэн эдийн бус хохирлын онолыг тус тусад нь тодорхойлох;
- Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг онол, хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрдөг

- онолыг судлан шинжилж, тус бүрийн давуу болон сул талыг тодорхойлох;
- Эдийн бус хохирол болон сэтгэл санааны хохирлын талаарх тодорхойлолт, эдгээр нэр томъёоны нийтлэг болон ялгаатай талыг тодорхойлох, эдийн бус хохирол нь зөвхөн хүний амь нас, эрүүл мэндийн эрхийн зөрчилд үүсдэг үү эсхүл үүнээс бусад эрхийн зөрчилд үүсэж болох уу гэдгийг тодорхойлж, түүний хүрээ хязгаарыг тодорхойлохыг оролдох;
 - Монгол Улсын шүүхийн практикт эдийн бус хохирлыг нэхэмжилж буй болон шийдвэрлэж буй байдал, ямар төрлийн эрхийн зөрчилд хязгаарлан шийдвэрлэж байгаа талаар шинжлэн, практикт ямар төрлийн эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг тогтоох;
 - ХБНГУ, Япон Улс, ОХУ, АНУ зэрэг дөрвөн улсын туршлагыг авч үзэн, эдийн бус хохирлын ямар онолуудыг авч хэрэгжүүлсэн, тэдгээрийн давуу болон сул талд дүн шинжилгээ хийх;
 - Монгол Улсын ИХ-д эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх боломж, арга замыг эрэлхийлэх.

1.3. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Эдийн бус хохирлын тухай судалгаа нь 1996 оноос эхэлж хийгдсэн бөгөөд сүүлийн жилүүдэд үүнтэй холбоотой судалгааны ажил харьцангуй эрчимжин, цөөнгүй өгүүлэл, нийтлэл гарсан байна. Холбогдох бүтээлүүдийг дурдвал Н.Туяа

“Сэтгэл санааны хохирлын асуудал” (1996)¹⁰, Ж.Оюунтунгалаг “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудал” (2002)¹¹, Ш.Үнэнтөгс “Сэтгэл санааны хохирол ба нэр төр, алдар хүндийн асуудал” (2007)¹², П.Баянбаатар “Иргэний хууль дахь сэтгэл санааны хохирлын хамрах хүрээ” (2008)¹³, А.Доржготов “Эдийн бус хохирлын эрх зүйн орчин: Гэм хор, иргэний эрх зүйн зохицуулалт” (2012)¹⁴, Б.Буянхишиг “Үүргийн эрх зүйн тусгай анги” (2013)¹⁵, Л.Дарьсүрэн “Эдийн бус хохирлын тухай” (2014)¹⁶, П.Золзаяа “Сэтгэл санааны хохирлын асуудал” (2016)¹⁷, З.Сүхбаатар “Ёс суртахууны гэм хор” (2018)¹⁸, Ш.Сүхбаатар “Бусдын нэр төр, алдар хүндэд учирсан эдийн бус гэм хорын асуудал” (2013)¹⁹, Д.Ганхүрэл “Монгол Улс дахь эмч, эмнэлгийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль хэрэглээний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль

¹⁰ Н.Туяа, Сэтгэл санааны хохирлын асуудал, “Монгол Улсын төр, эрх зүй” сэтгүүл, 1996, №2, 35 дахь тал.

¹¹ Ж.Оюунтунгалаг, Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудал, 2002, ИХ-ийн 230.2-ыг “Бусдын эдийн бус баялаг, эрхийг зөрчсөн тохиолдолд учирсан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр нөхөн төлнө” гэж өөрчлөн найруулах хэрэгтэй” гэж бичиж байв.

¹² Ш.Үнэнтөгс, Сэтгэл санааны хохирол ба нэр төр, алдар хүндийн асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2007, 46 дахь тал.

¹³ П.Баянбаатар, ИХ дахь сэтгэл санааны хохирлын хамрах хүрээ, Дээд шүүхийн мэдээлэл, 2008, 22 дахь тал.

¹⁴ А.Доржготов, Эдийн бус хохирлын эрх зүйн орчин: Гэм хор, иргэний эрх зүйн зохицуулалт, “Монгол Улсын төр, эрх зүй” сэтгүүл, 2012, №2, 102 дахь тал.

¹⁵ Б.Буянхишиг “ИХ-ын 230-ыг өөрчлөх, улмаар ХБНГУ-ын ИХ-ийн 253.2-тай адил төсөөтэй болгох... Ингэснээр иргэний эрх зүйн хохирол учрахаас өмнөх байдалд сэргээх үндсэн зарчим, Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол, тэгш ёс, шударга ёсыг хангах болно” гэж тус тус санал гаргасан байдаг.

¹⁶ Л.Дарьсүрэн, Эдийн бус хохирлын тухай, “Монгол улсын төр, эрх зүй” сэтгүүл, 2014, №2, 78 дахь тал.

¹⁷ П.Золзаяа, Сэтгэл санааны хохирлын асуудал, МУИС-ийн төв номын сан, мастерын судалгааны ажил, 2016.

¹⁸ З.Сүхбаатар, Ёс суртахууны гэм хор, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2018, №4, 73 дахь тал.

¹⁹ Ш.Сүхбаатар “Бие махбод, амь насанд хохирол учруулснаар үүдэх эдийн бус хохирлыг нөхөн төлүүлдэг болох нь зүйтэй” гэсэн.

хэрэглээний асуудал” (2017)²⁰, А.Түвшинтөгс “Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” (2020)²¹ зэрэг өгүүлэл болон магистр, докторын судалгааны ажил хийгджээ.

Эдгээр өгүүлэл, судалгаанд сэтгэл санааны хохирлыг бие махбодын гэмтэлд нөхөн төлүүлэх тухай, түүнийг үнэлэх аргачлалын талаар өгүүлжээ. Гэхдээ эдгээр судалгаа нь эдийн бус хохирлыг нөхөн төлөх тогтолцооны зорилго, чиг үүрэг, ач холбогдлын талаар болон амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндээс бусад эрхийн зөрчилд эдийн бус хохирол нөхөн төлүүлэх тухай дэлгэрэнгүй санал, дүгнэлт гаргаагүй байна.

Ер нь эдийн бус хохирлын талаар өгүүлэхэд түүнийг гагцхүү сэтгэл санааны хохирлоор хязгаарлаж ойлгох нь өрөөсгөл юм. Учир нь сэтгэл санааны хохирол нь хувь хүний мэдэрч буй сэтгэлийн шаналал, зүдүүр, өвдөлт, амьдралаас авах мэдрэмж, таашаал үгүй болох, өдөр тутмын амьдралын үйл явцад оролцох боломжгүй болох зэрэг ихэвчлэн хувь хүнд үүсдэг бол эдийн бус хохирол нь сэтгэл санааны шаналал, зүдүүрээс гадна хувь хүн болон хуулийн этгээдэд ч үүсэж болох эдийн бус бүхий л эрх, ашиг сонирхлыг хамруулж ойлгож болно гэлтэй. Энэ ч утгаараа бид цаашид эдийн бус хохирлыг хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд зэрэг цөөн тооны эрхийн зөрчлөөр хязгаарлаж ойлгох бус, олон тооны эрхийн зөрчлийн хүрээнд хүлээн зөвшөөрч, нөхөн төлүүлэх чиг хандлага, онол,

²⁰ Д.Ганхүрэл нь ИХ-ийн эдийн бус хохирлын нөхөн төлүүлэх тогтолцоог шүүмжлэн “Иргэний хуулийн 230.2 дахь заалт Үндсэн хуулийн 16.14 заалтын үндсэн эрхийг зөрчиж байгаа талаар мэдээлэл гаргаж, Үндсэн хуулийн цэцээр тус заалтыг хүчингүй болгуулах боломжтой” гэжээ. “Монгол Улс дахь эмч, эмнэлгийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль хэрэглээний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль хэрэглээний асуудал” 2017, 7 дахь тал.

²¹ А.Түвшинтөгс, Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал, 2020.
<https://legaldata.mn/b/660> (сүүлд орсон огноо: 2021 оны 8 дугаар сарын 13).

практикийн асуудлуудыг хөндөж гаргах нь чухал юм. Ийм ч учраас энэхүү судалгаагаар эдийн бус хохирлыг илүү өргөн хүрээнд авч үзэж, шаардлагатай шийдлийг санал болгож буй нь судалгааны шинэлэг тал гэж найдаж байна.

1.4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Уг судалгааг хийж гүйцэтгэхдээ онолын судалгааны болон тохиолдол судлах арга, эрх зүйн орчны болон гадаад улсын эрх зүйн харьцуулсан судалгаа, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг нийтлэг аргыг хэрэглэлээ.

Тохиолдол судлах хүрээнд хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндээс бусад нийтлэг бус эрхийн зөрчилд эдийн бус хохирлыг нэхэмжилсэн хэд хэдэн шийдвэрт төвлөрч, нэхэмжлэгчийн эдийн бус хохирлыг шаардсан үндэслэл, нотлох баримтын бүрдүүлэлт, мөн шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн эсхүл татгалзсан үндэслэлд дүн шинжилгээ хийв.

Харьцуулсан судалгааны аргын хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ), Оросын Холбооны Улс (ОХУ), Япон Улс, Америкийн Нэгдсэн Улс (АНУ) зэрэг гадаадын зарим улс оронд эдийн бус хохирлыг үнэлэн төлүүлж буй арга, зарчим, шалгуур үзүүлэлтүүдийг судалж, дүгнэлт, санал боловсрууллаа. ХБНГУ, ОХУ-ыг манай улсын Иргэний хуулийн эх хуулиуд гэсэн шалтгаанаар сонгон авсан бол Япон Улсыг эдийн бус гэм хорыг хамгийн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг орнуудын тод жишээ болох үүднээс сонгон авч судалсан болно. Харин АНУ нь эдийн бус хохирлын тэс өөр онол нэвтрүүлсэн Англо-Саксоны орнуудын төлөөлөл юм.

Онолын судалгааны аргын хүрээнд эдийн бус хохирлын онолын үндсэн хоёр ойлголт болох *Natural restitution*²² болон *Punitive damage*²³ зэргийг судлан шинжлэхээс гадна эдийн бус хохирлыг “өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх онол”, “хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх онол”-ыг шинж чанар, онцлог, зорилго, хэрэглэдэг улс орнуудынх нь хамт судаллаа.



²² Судлаачид “Бодит хохирлыг нөхөн төлүүлэх онол” гэж орчуулан хэрэглэв.

²³ Судлаачид “Шийтгэлийн шинжтэй хохирол нөхөн төлүүлэх онол” гэж орчуулан хэрэглэв.

ХОЁР. ЭДИЙН БУС ХОХИРЛЫН ТУХАЙ ОНОЛЫН ЕРӨНХИЙ УРСГАЛ

Монгол Улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх бие даасан эрх зүйн зохицуулалт 2002 оны Иргэний хуулиас эхтэй тул эдийн бус хохирлын талаарх ойлголт нь манай улсын эрх зүйд харьцангуй шинэлэг ойлголт юм. Гэхдээ энэ асуудлыг тойрсон дотоодын онолын судалгаа 2002 оноос эхлэн хийгдэж ирсэн онцлогтой бөгөөд цаашид нэмэгдэх хандлагатай байна. Иймээс тус бүлэгт эдийн бус хохирлын зорилго, чиг үүрэг, мөн чанар, үнэлэх зарчмын тухай Монгол Улсад болон олон улсад номлож буй онолын ерөнхий ойлголтыг авч үзэх болно.

Эдийн бус хохирлын тухай онолын чиг урсгалыг сөхөж харахад (i) Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь чухамдаа ямар зорилготой, эрх зүйн шинж чанартай вэ?; (ii) Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь ямар чиг үүрэг гүйцэтгэдэг вэ?; (iii) Эдийн бус хохирлыг хэрхэн үнэлэх вэ? гэдэг асуудлуудыг ихэвчлэн хөндсөн байдаг. Эдгээр онолын чиг урсгалуудын талаар доор авч үзье.

2.1. ЭДИЙН БУС ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ ЗОРИЛГО, ШИНЖ ЧАНАР

“Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь ямар зорилготой, эрх зүйн ямар шинж чанар агуулдаг вэ?” гэх

асуудлын хувьд хоёр үндсэн онол хариулт өгдөг бөгөөд энэ хоёр онол нь Монголын эрх зүйн онолд хэдийнээ танигдаж эхэлсэн. Тухайлбал “Эдийн бус хохирол гэдэгт хөрөнгийн хохирлоос бусад бие махбод болон сэтгэл санааны шинжтэй нөхцөл байдлыг ойлгох бол хуульд эрүүл мэндийн хохирол учирсантай холбоотой эдийн бус гэм хорыг арилгах тухай зохицуулалт байдаггүй. Харин энэ үзэгдэл нь англо-саксоны эрх зүйн тогтолцоонд *punitive damage* хэлбэрээр, ром-германы эрх зүйн тогтолцоонд амь бие, эрүүл мэнд, эрх чөлөөнд халдсаны улмаас үүдсэн эдийн бус хохирлыг бага боловч мөнгөн төлбөрөөр орлуулах зохицуулалтын хэлбэрээр нийтлэг хэрэглээнд орсон байдаг”²⁴ гэжээ. Өөрөөр хэлбэл, эдийн бус хохирлын талаарх эрх зүйн хоёр тогтолцоонд “мөнгөөр нөхөн төлөх чиг үүрэг бүхий эдийн бус хохирлын тогтолцоо” болон “шийтгэлийн буюу хариуцлага оногдуулах чиг үүрэг бүхий эдийн бус хохирлын тогтолцоо” гэж хоёр төрлийн онол хөгжсөнийг танилцуулжээ.

Энэ хоёр онол нь дараах үндсэн агуулгын хүрээнд ялгаатай байдаг. Үүнд:

- “Эдийн бус хохирлыг нөхөн төлөх тогтолцоо нь ямар зорилго, чиг үүрэгтэй байх ёстой вэ?”;
- “Эдийн бус хохирлыг ямар тохиолдолд олгох ёстой вэ?” буюу эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрөх эрхийн зөрчлийн хүрээ хязгаар;
- “Эдийн бус хохирлыг хэрхэн үнэлэх, тогтоох вэ?” гэсэн асуудлууд юм.²⁵

²⁴ Б.Буянхишиг, Үүргийн эрх зүйн тусгай анги, 3 дахь хэвлэл, 2013, 480 дахь тал.

²⁵ Saito Osamu (齋藤修), “Compensation Calculation Theory” [慰謝料算定の理論], Gyosei [行政] no. 5 (2010), p. 2.

1) Нөхөн төлбөрийн онол

Нөхөн төлбөрийн онолын хувьд эдийн бус хохирлыг нөхөн төлөх тогтолцоо нь шинж чанарын хувьд хохирогчид учирсан бодит хохирлыг л нөхөх үүрэгтэй гэж үздэг.

Мөн эдийн бус хохирлыг мөнгөөр үнэлэх боломжгүй тул хохирогч өөрт учирсан эдийн бус хохирлоо гарцаагүй байдлаар нотлохыг шаардаагүй буюу шүүгч тухайн хэргийн олон талын нөхцөл байдлыг харгалзан үзээд өөрийн “үзэмжээр” тогтоох эрх хэмжээтэй байдаг ажээ. Улмаар шүүгч эдийн бус хохирлыг үнэлэхдээ харгалзан үзсэн нөхцөл байдал нь ямар учраас тийм үнэлгээтэй эдийн бус хохиролд хүргэж байгаа тухайгаа шүүхийн шийдвэртээ нарийвчлан тайлбарлах албагүй, зөвшөөрсөн эдийн бус хохирлын хэмжээг нотлох шаардлага байхгүй буюу “шударга”, “зүй зохистой” гэж үзсэн хэмжээгээр тогтооход хангалттай байдаг²⁶.

Эндээс үзэхэд уг онол нь зөвхөн “бодит хохирол” төлүүлэхийг чухалчилдаг боловч “бодит хохирол” гэдэгт зөвхөн эдийн хохирол буюу нотлох баримтаар тогтоож болдог хохирлыг ойлгоогүй байна. Тодруулбал, эдийн бус хохирлын хувьд ч бодит хохирол гэж хүлээн зөвшөөрч, нөхөн төлүүлэхийг хүлээн зөвшөөрдөг.

Энэ онол нь ХБНГУ, Япон зэрэг эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад нийтлэг байдаг бөгөөд манай улс ч энэ онолыг хэрэгжүүлдэг улсад хамаардаг гэж хэлж болно.

2) Шийтгэлийн онол

Харин хоёр дахь буюу “Шийтгэлийн онол”-ын хувьд эдийн бус хохирлыг нөхөн төлөх тогтолцоо нь аливаа хууль

²⁶ Yoshinobu Tai (田井義信), “On damages of emotional distress” [非財産的損害の賠償について], Shihou [私法] no. 43 (1981), p. 149.

бус үйлдэл, эс үйлдэхүйг их хэмжээний гэм хортойгоор учруулсан этгээд болох хариуцагчийг шийтгэх, дахин ийм гэм хорыг бусдад учруулахаас урьдчилан сэргийлэх нь чухал гэж үзэж, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх нь хувийн эрх зүйн шийтгэл, хариуцлагын нэгэн төрөл гэж үздэг²⁷. Энэ онолын дагуу хариуцагчийн гэм буруугийн хэмжээ их байгаа тохиолдолд шүүгчийн зүгээс нэхэмжлэгчийн шаардсан эдийн бус хохирлын хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлэн тогтоож, хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгон шийдвэрлэхийг хэвийн зүйл гэж үздэг.

Гэхдээ энэ онолыг эсэргүүцэх судлаачид цөөнгүй бий. Тэд үгүйсгэлийн байр сууриа дараах байдлаар тайлбарладаг. Үүнд:

Нэгд, хохирогчид учирсан хохирлын хэмжээг нэмэгдүүлэх, гэм буруутай этгээдийг шийтгэн хариуцлага хүлээлгэх нь иргэний эрх зүйн мөн чанартай харшилна. Шийтгэлийн онол нь нөхөн төлбөр болон шийтгэл гэсэн хоёр өөр ойлголтыг нэг доор зэрэгцэн орших ёстой гэж номлох нь зөрчилдөөн бий болгоно гэж тайлбарладаг²⁸.

Хоёрт, хэрэв хариуцагчийг шийтгэж байгаа бол илүү төлсөн хохирлын мөнгө нь нэхэмжлэгчийн халаасанд бус, улсын төсөвт орох ёстой хэмээн шүүмжилдэг²⁹.

Харин зарим судлаач “Гэм хорын эрх зүйн үндсэн зорилго нь хариуцагчид шийтгэл, хариуцлага хүлээлгэх явдал биш боловч эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх замаар хариуцагчийг шийтгэж буй нь шүүхээр шийдэгдэж буй

²⁷ Goto Takanori (後藤孝典), “Modern Theories of Compensation” [現代損害賠償論] (Nihon hyoronsha), 1982, p. 187.

²⁸ Shokurin Ko (植林弘), “Compensation Calculation Theory” [慰謝料算定論] (Yuhikaku), 1962, 132-138.

²⁹ Katou Ichirou (加藤一郎), “Comparative Research on Compensation” [慰謝料の比較的研究], Hikakuhou Kenkyu [比較法研究] (Yuhikaku, 1982) no. 44, p. 123.

хэргүүдээс харагдаж байна”³⁰ гэсэн байна. Тухайлбал, эдийн бус хохирлын хэмжээг шүүх тогтоохдоо хариуцагчийн гэм буруугийн хэмжээ, гэм буруугийн шинж чанар, нийгэмд учруулах аюул, хариуцагчийн хувийн байдал, нэр хүнд, эд баялаг зэргийг харгалзан үздэг. Иймд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны шийтгэлийн буюу хариуцлагын шинж чанарыг бүрэн няцаах боломжгүй³¹ гэжээ.

Энэхүү онолыг Англи-Саксоны орнууд буюу АНУ, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-д нэвтрүүлсэн байдаг.

Нөгөө талаар дээрх хоёр онолыг зэрэгцэн оршиж болно гэсэн зарим судлаачийн байр суурь бий. Тухайлбал, Японы эрдэмтэн Като Ичиро нь “Энэ хоёр онол нь бие биеэ үгүйсгэсэн шинж байхгүй. Учир нь шийтгэлийн онол нь хохирогч болон хариуцагчийн аль алиных нь нөхцөл байдлыг харгалзан, хэн хэнд нь шударга санагдахуйц хохирлыг тогтоож өгдөг бол нөхөн төлбөрийн онол нь дан ганц хохирогчид төвлөрөлгүй, хариуцагчийн нөхцөл байдлыг ч харгалзан үзэж, хохирлын хэмжээг тогтоодог”³² гэжээ.

2.2. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ ОЛОН ТАЛТ ЧИГ ҮҮРЭГ

Сэтгэл санааны хохирол буюу эдийн бус хохирлын агуулга нь тодорхой бус, мөн хэмжээг нь шүүгч үнэлж тогтоодог

³⁰ Kubota Atsumi (窪田充見), “Moral Damages and Punitive Damages in Tort” [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究] Vol. 2, no. 4 (Tou Aija, Hen 4, 2018), p. 50.

³¹ Saito Osamu (齋藤修), “Compensation Calculation Theory” [慰謝料算定の理論], Gyosei [行政] no. 5 (2010), p. 13.

³² Katou Ichirou (加藤一郎), “Comparative Research on Compensation” [慰謝料の比較法的研究], Comparative Law Research [比較法研究] (Yuhikaku, 1982), no. 44, p. 119.

тул өдгөө шүүхийн практикт сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо нь олон талт чиг үүрэг гүйцэтгэж байна³³. Тодруулбал, сэтгэл санааны хохирлын тогтолцоо нь хатуу хуульчлагдсан хуулийн зүйл, заалтуудыг уян хатан байдлаар хэрэглэж тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэдэг³⁴.

Иймд сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх тогтолцооны зорилго, чиг үүрэг нь зөвхөн хохирол нөхөн төлүүлэхээр хязгаарлагдахгүй бөгөөд дараах олон янзын чиг үүрэг гүйцэтгэж байна. Үүнд:

1) Хохирол нөхөн төлүүлэх

Сэтгэл санааны хохирол нь гэм хорын эрх зүйн нэгэн институт тул гэм хорын эрх зүйтэй адил хохирол нөхөн төлүүлэх үндсэн чиг үүрэг гүйцэтгэнэ³⁵.

2) Хариуцагчийг шийтгэх

Шүүгч нь сэтгэл санааны хохирлыг үнэлж тогтоохдоо зөвхөн хохирогчийн нөхцөл байдлыг бус хариуцагчийн үйлдлийн шинж чанар, хор хөнөөлийн болон хувийн байдал, зан авир, нас, эд хөрөнгө, гэм буруугийн хэмжээ зэргийг тодорхой хэмжээгээр харж судлан тогтоож байгаа тул сэтгэл санааны хохирол нь хариуцагчийг зохих ёсоор шийтгэх хариуцлагын үүргийг гүйцэтгэж байна гэж үзэх боломжтой³⁶.

³³ Kubota Atsumi (窪田充見), "Moral Damages and Punitive Damages in Tort" [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究] Vol.2 no. 4 (Tou Aja, Hen 4, 2018), p. 45.

³⁴ Saito Osamu (齋藤修), edited by Yamada Takao (山田卓生編集) "Issues on Compensation" [慰謝料に関する諸問題], "Lectures on New, Modern Damages Law (Damages & Insurance)" [新・現代損害賠償法講座] Vol.6 (Yuhikaku, 1987, p. 222.

³⁵ Kubota Atsumi (窪田充見), "Civil Code Commentary New Edition" [新版注釈民法], Vol.15 (Yuhikaku, 2017), p. 876.

³⁶ Kubota Atsumi (窪田充見), "Moral Damages and Punitive Damages in Tort" [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究] Vol.2 no. 4 (Tou Aja, Hen 4, 2018), p. 48.

3) Хохирогчид сэтгэл ханамж өгөх чиг үүрэг

Энэ чиг үүрэг нь сэтгэл ханамжийн онолоос гаралтай. Хохирогчийн зовлон, шаналал, зүдгүүрийн оронд хангалттай хэмжээний мөнгөн төлбөр төлөх замаар хохирогчид сайн сайхан, аз жаргалтай мэдрэмж төрүүлэх, шударга бус явдалд сэтгэл дундуур байгаа хохирогчийн мэдрэмжийг хөнгөлөн, сэтгэл ханамжид хүргэх нь чухал гэж үздэг³⁷.

4) Хүний сэтгэл мэдрэмжийн үнэ цэнийг илэрхийлэх чиг үүрэг

Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тогтолцоо нь хүний сэтгэл мэдрэмжийн үнэ цэнийг илэрхийлэх үүрэгтэй. Энэ чиг үүргийг эрдэмтэд тодорхойлохдоо “Хүний сэтгэл болон бие махбодод учирсан зовлон шаналалд нөхөн төлбөр олгох нь ардчилсан нийгмийн зүгээс өөрийн гишүүд болох иргэдийнхээ сэтгэл мэдрэмжийг үнэ цэнээр илэрхийлж буй явдал”³⁸ гэж үздэг. Түүнчлэн “Тухайн нийгмийн зүгээс гишүүдийнхээ сэтгэл мэдрэмжид өгдөг үнэ цэнийг тухайн нийгмийн хууль ёсны төлөөлөгч болох шүүгч дотоод итгэл үнэмшлийнхээ дагуу үнэлж, мөнгөн хэлбэрт оруулах явдал юм”³⁹ гэж тодорхойлсон байна.

5) Зовлон бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг

Энэ чиг үүрэг нь хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохиролд мөнгөөр нөхөн олговор олгох нь хохирогчид

³⁷ Saito Osamu (齋藤修), edited by Yamada Takao (山田卓生編集) “Issues on Compensation” [慰謝料に関する諸問題], “Lectures on New, Modern Damages Law (Damages & Insurance)” [新・現代損害賠償法講座] Vol.6 (Yuhikaku, 1987, p. 218.

³⁸ Saito Osamu (齋藤修), edited by Yamada Takao (山田卓生編集) “Issues on Compensation” [慰謝料に関する諸問題], “Lectures on New, Modern Damages Law (Damages & Insurance)” [新・現代損害賠償法講座] Vol.6 (Yuhikaku, 1987), p. 218.

³⁹ Shinomiya Kazuo (四宮和夫), “Complete Series of Modern Law Study 10 Tort Law (Administrative Management, Unjust Enrichment, Tort)” [現代法律学全集10 不法行為(事務管理・不当利得・不法行為)], Vol.2&3 (Oomori Shoin, 1990), p. 595.

санхүүгийн эрх чөлөө олгох замаар зовлон бэрхшээлээ даван туулахад нь туслах зорилготой гэж үздэг юм⁴⁰.

6) Эдийн буюу материаллаг хохирлыг нөхөх чиг үүрэг

Энэ нь хохирогчийн эдийн буюу материаллаг хохирлыг нотлоход бэрхшээлтэйн улмаас эдийн хохирлыг нь бүрэн дүүрэн тогтоох боломжгүй үед эдийн бус хохирол олгох замаар хохирогчийн эдийн хохирлыг нөхөх чиг үүргийн тухай юм.

Ганцхан эдийн хохирлыг нотлоход хүндрэлтэй байхаас бус олон тооны хохирогчтой эсхүл эдийн хохирол нь нотлогдож байгаа ч хангалттай бус байгаа үед эдийн хохирлын оронд сэтгэл санааны хохирлыг нөхөн олгосноор хохирогчийн эрхийг сэргээж болох юм. Жишээлбэл, олон тооны хохирогчтой хэрэг дээр хохирогчдын нас адилхан байхад эрэгтэй, эмэгтэй гэж хүйсийн ялгаатай цалин, хөлснөөс үүдэн өөр өөр хэмжээний эдийн хохирол оноох нь шударга биш гэж үзвэл шүүх тэдгээрийг эдийн бус хохирлоор тооцож нөхөн олгож болох юм⁴¹.

Энэ мэт эдийн бус хохирлын нөхөх чиг үүргийг цалингийн тэгш бус байдал, насан туршдаа эмчилгээ, асаргаа сувилгаа шаардсан өвчтэй болох, цаашид амжилт гарган цалин орлого нэмэгдэх нь тодорхой байсан тохиолдол, инфляц, хохирогч амиа хорлосон гэх мэт тохиолдолд үр нөлөөтэй хэрэглэдэг байна.

⁴⁰ Saito Osamu (齋藤修), edited by Yamada Takao (山田卓生編集) "Issues on Compensation" [慰謝料に関する諸問題], "Lectures on New, Modern Damages Law (Damages & Insurance)" [新・現代損害賠償法講座] Vol.6 (Yuhikaku, 1987), p. 218.

⁴¹ Kubota Atsumi (窪田充見), "Civil Code Commentary New Edition" [新版注釈民法], Vol.15 (Yuhikaku, 2017), p. 880.

Kubota Atsumi (窪田充見), "Moral Damages and Punitive Damages in Tort" [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究] Vol. 2 no. 4 (Tou Aja, Hen 4, 2018), p. 44.

2.3. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ҮНЭЛЭХ ЗАРЧИМ

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, тооцоолох аргачлал, томьёо гэж байдаггүй. Сэтгэл санааны хохирлыг хохирогч, хариуцагч, гэм буруугийн хэмжээ, хууль бус үйлдлийн шинж чанар гэх мэт олон нөхцөл байдлыг харгалзан шүүгч өөрийн “шударга”, “зүй зохистой” гэж үзсэн үнэлэмжээр тогтооно.

Зарим оронд шүүгч үнэлж тогтоосон сэтгэл санааны хохирлын хэмжээгээ нотлох, үндэслэлээ тайлбарлах шаардлагагүй гэж үздэг⁴². Түүнчлэн хохирогч тал ч мөн адил хохирлын хэмжээгээ нотлох шаардлагагүй⁴³. Учир нь өмнө нь дурдсанчлан сэтгэл санааны хохирол өөрөө эдээр буюу мөнгөөр үнэлэгдэхгүй хохирол учир эдийн хохирлын адил гарцаагүй нотлох баримт үүсэх боломжгүй гэдэг онцлог шинж чанартай юм.

Энэ тухай “хохирлын хэмжээг тогтоохдоо мөнгөн төлбөрийг шударга ёсны зарчимд нийцэх байдлаар тогтоох ба энэ нь эргээд нэр төр, алдар хүнд зэрэг үнэт зүйлстэй холбоотой эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний нэр төр гутаасан нөхцөлд хохирлын хэмжээ нь хувь хүн хоорондын зөрчлөөс илүү их байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хэвлэлтийн тоогоо олшруулан ашиг хонжоо олох зорилгоор бусдын нэр төр, алдар хүндэд халдсан бол энэ нөхцөл байдал нь хохирлын хэмжээг тогтооход томоохон нөлөө үзүүлнэ”⁴⁴ гэжээ.

⁴² Shokurin Ko (植林弘), “Compensation Calculation Theory” [慰謝料算定論] (Yuhikaku, 1962), p. 120.

Yoshimura Ryoichi (吉村良一), edited by Hoshino Eichi (星野英一編) “Right to claim damages” [慰謝料請求権], “Civil Law Lectures, Administrative management, Unjust Enrichment, Tort”, [民法講座 『事務管理・不当利得・不法行為』] (Yuhikaku, 1985), p. 431.

⁴³ Sawano Kazuhiro (澤野和博), “Damages from the view of life/ survival” [慰謝料—生存・生命を考えながら], “Waseta Current Studies of Civil Law” [早稲田民法学の現在], p. 509.

⁴⁴ Б.Буянхишиг, Үүргийн эрх зүйн тусгай анги, 3 дахь хэвлэл, 482 дахь тал.

Тодруулбал, эдийн бус хохирлын хэмжээг тогтооход эд мөрийн баримтад тулгуурлахаасаа илүү шударга ёсонд нийцүүлэн, гэм хорын нөхцөл байдлыг харгалзан уян хатан байдлаар тогтоох ёстой болохыг дурджээ.

2.4. СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫН ХҮРЭЭ ХЯЗГААР

Сэтгэл санааны хохирлыг өргөн хүрээнд болон хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрдөг хоёр хандлага байдаг бөгөөд уг хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх чиг хандлага нь гэм хор үүссэн ямар ч тохиолдолд эдийн болон эдийн бус хохирлын аль алиныг нь нөхөн төлөх ёстой гэж үздэг. Тодруулбал, эдийн бус хохирлыг эрхийн зөрчлөөр хязгаарлалгүйгээр бүхий л эрхийн зөрчилд зөвшөөрдөг гэсэн үг. Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, Иргэний хуульдаа тусгасан улсууд нь юуны өмнө хүний амь нас, эрүүл мэнд, бие махбодын гэмтлийг хамгийн тэргүүн эрх, эрх ашиг гэж үздэг тул заавал нөхөн төлж байх ёстой гэж үздэг. Иймд эдгээр орны шүүхийн шийдвэрийг харахад амь нас, эрүүл мэнд, бие махбодын гэмтэлд төлсөн эдийн бус хохирлоос гадна өөр олон төрлийн хамгаалагдсан эрх, эрх ашгийн зөрчилд эдийн бус хохирлыг зөвшөөрдөг байна.

Тухайлбал, хүний амь нас, эрүүл мэнд, бие махбодын гэмтэлтэй холбоогүй эдийн бус хохирол бий болгодог эрхийн зөрчлийг гурван том бүлэгт хуваан авч үзэж болох ба эдгээр нь (i) хүний хувийн эрхийн зөрчилтэй хамаатай тохиолдол; (ii) хувь хүн, хуулийн этгээдийн эдийн засгийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдол; (iii) эд хөрөнгийн эрхийн зөрчилтэй холбоотой тохиолдол юм⁴⁵. Эдгээр гурван ангилал тус бүрд ямар

⁴⁵ Кубота Ацүми нар, Япон Улсын Иргэний хуулийн тайлбар, 2017.

эрхийн зөрчлүүд практикт үүсэж болох тухай жишээг доор тайлбарлая⁴⁶.

1) Хүний хувийн эрхийн зөрчил

Эдгээрт оюуны өмч, зохиогчийн эрх, гэрлэгчдийн эрх, үүрэг (бие биеэ халамжлах үүрэг, асран тэтгэх үүрэг, үнэнч байх үүрэг зэрэг), хөдөлмөрлөх эрх, аливаа дарамтаас ангид байх эрх, хөршийн эрх, нууц, дүрс, нэрээ хамгаалах эрх гэх мэт хувийн эрхийн зөрчил багтана.

- *Зохиогчийн эрх.* Зохиогчийн эрхийн тухай болон Оюуны өмчийн тухай хууль зөрчиж бусдын бүтээл, санааг хууль бусаар ашиглах нь хууль бус үйлдэл тул үүний улмаас учирсан эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг мөн нөхөн төлүүлэх боломжтой. ХБНГУ-д Зохиогчийн эрхийн тухай хуулиар хувь хүн, хуулийн этгээдийн зохиогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд эдийн хохирлоос гадна эдийн бус хохирол нөхөн төлүүлэх зохицуулалттай байна⁴⁷.
- *Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаа.* Гэрлэгсдийн аль нэг талын буруутай, хууль бус үйлдлийн улмаас цуцалж байгаа эсхүл гэрлэгсдийн нэг тал нөгөөдөө үнэнч байх үүргээ зөрчин гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон тохиолдолд, хамтран амьдрагчид хамтын амьдралаа дуусгасан эсхүл сүй тавьсан боловч сүйг нэг тал цуцалсан зэрэг тохиолдолд хохирогч тал нь нөгөө талаас эдийн хохирол гаргуулсан эсэхээс үл хамааран эдийн бус хохирол шаардах боломжтой.

⁴⁶ Япон Улсын Чива мужийн Өмгөөлөгчдийн холбоо, Эдийн бус хохирлыг үнэлэх нь, Гоёсэй, 2013.

⁴⁷ Gesetz ber Urheberrecht und verwandte Schutzrechte (Urheberrechtsgesetz), 1965, Art. 97.

- *Хөдөлмөрлөх эрхийн зөрчил.* Ажлаас хууль бусаар халах, хууль бусаар өөр ажилд томилох, хууль бусаар сахилгын шийтгэл ногдуулах, үйлдвэрлэлийн осолд орох зэрэг тохиолдолд хохирогч нь эдийн хохирлоос гадна эдийн бус хохирол нөхөн төлүүлэх боломжтой.
- *Дарамт буюу Харассмент.* Бэлгийн, эрх мэдлийн, академик дарамт⁴⁸ үүссэн тохиолдолд хохирогч нь эдийн хохирол үүсээгүй ч эдийн бус хохирол шаардах эрхтэй.
- *Хөршийн эрхийн зөрчил.* Нарны илч авах эрх, чимээгүй орчинд амьдрах зэрэг эрх зөрчигдсөний улмаас эдийн бус хохирол нөхөн төлүүлэх боломжтой.
- *Нууц, дүрс, нэрээ хамгаалах эрх.* Манай улсад хувь хүн, албан байгууллагын нууцад халдсан тохиолдолд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэдэг боловч эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрдөггүй. Хэдий тийм боловч хувь хүн, хуулийн этгээдийн нууцад халдах, тэдний нууцыг задруулснаар хэр хэмжээний эдийн хохирол учирснаас үл хамааран тухайн этгээдэд эдийн бус хохирол учруулж байгаа юм. Тиймээс дээрх хэрэг нь эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрөх гарцаагүй тохиолдлын нэг мөн.

2) Эдийн засгийн эрх ашгийн зөрчил

Хэрэглэгчийн эрх, гэрээний үүргийн зөрчлүүд, бүтээгдэхүүний хариуцлага, хувьцаат компанийн дотоод мэдээлэл алдагдсаны улмаас хувьцааны арилжаанд хохирол амсах тохиолдол мөн банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компаниудын мэдээлэл өгөх, тайлбарлах үүргээ

⁴⁸ Академик дарамт гэдэг нь боловсролын хүчирхийлэл буюу илүү өндөр зэрэгтэй эсхүл албан тушаалтай профессор нь өөрийн эрх мэдлийг ашиглан бусад бага зэрэгтэй багш, профессор эсхүл оюутнуудыг дарамтлах үйлдлийг хэлнэ.

биелүүлээгүй зэрэг нь хууль бус үйлдэл тул үүний улмаас эдийн хохирол учраагүй ч эдийн бус хохирлоо шаардах эрхтэй.

- *Гэрээний үүргийн зөрчил.* Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээний нөгөө талд хохирол учирсан бол хохирлоо шаардах эрх ИХ-ийн 219.1-д заасны дагуу олгогдсон. Гэвч шүүхээс үүнийг зөвхөн эдийн хохирлын хүрээнд хязгаарладаг. Гэтэл гэрээний үүргийн зөрчил нь санаатай эсхүл урт хугацаанд үргэлжилсэн, үүрэг зөрчигч талын дэндүү хайхрамжгүй байдал зэргээс үүдэлтэй бол хохирогч талд сэтгэл санааны буюу эдийн бус хохирол үүсэж байдаг. Иймд гэрээний үүргийн ямар ч зөрчилд эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай байдаг.
- *Түрээсийн гэрээний хувьд* түрээслэгч түрээсийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй үед түрээслүүлэгч нь түүнийг өөртөө туслах замаар буюу хүч хэрэглэн хөөж гаргах нь хууль бус үйлдэл юм. Энэ тохиолдолд түрээслэгчид эдийн бус хохирол үүсэх боломжтой.
- *Зээлийн гэрээний хувьд* тухайлбал, зээлээ хугацаанд нь төлж чадаагүй зээлдэгчийг дарамтлах, айлган сүрдүүлэх замаар зээлээ төлөхийг шаардах, эд хөрөнгийг нь хураах, зээлдэгчийг хууль бусаар “чанаргүй зээлдэгч”, “анхаарах шаардлагатай зээлдэгч” зэрэг ангилалд бүртгэх тохиолдол орно.
- *Бүтээгдэхүүний хариуцлага.* Бүх төрлийн бүтээгдэхүүний хариуцлага үүнд орох ба тухайн бүтээгдэхүүнээс болж бие махбодод гэмтэл учирсан бол тэдгээрт харгалзах эдийн бус хохирлоо шаардах боловч бие махбодод гэмтэл учраагүй тохиолдолд ч мөн адил эдийн бус хохирлоо шаардах эрхтэй. Тухайлбал,

эмнэлгийн багаж хэрэгсэл, эм, тариа, автомашин, зуух, гар утас зэрэг өдөр тутмын бараа, бүтээгдэхүүн нь доголдолтой байх тохиолдолд бие махбод гэмтээгүй ч эдийн бус хохирлыг шаардаж болно.

3) Хөрөнгийн эрхийн зөрчил

Үнэ цэнтэй эд зүйлс⁴⁹, гэрийн тэжээвэр амьтад алга болох, устгах, гэмтэх зэрэг нь эд хөрөнгийн эрхийн зөрчлийн онцгой тохиолдол юм. Зарчмын хувьд эд хөрөнгийн хохирол учирсан бол тухайн эд хөрөнгийг засварлах эсхүл шинээр авахад шаардлагатай зардлыг нөхөн төлснөөр хохирлыг бүрэн барагдуулсанд тооцдог. Гэвч дээрх онцгой тохиолдолд тухайн эд хөрөнгө нь энгийн эд хөрөнгө биш онцгой эд хөрөнгө байдаг. Тухайлбал, гэрийн тэжээвэр амьтны эзний хувьд тухайн амьтантайгаа субъектив холбоо үүссэн байдаг учир гэр бүлийн нэг гишүүнээс өөрцгүй болсон байдаг. Иймд эдийн хохирол дээр нэмээд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой юм.

Харин хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх хандлага нь тодорхой нэг эрхийн зөрчилд үүссэн гэм хор дээр л эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрнө гэж үздэг. Тухайлбал, манай улс шиг зөвхөн “нэр төр, алдар хүнд”-д халдсан тохиолдолд л эдийн бус хохирол төлүүлэх эрх зүйн зохицуулалттай байж болно.

⁴⁹ Үнэ цэнтэй эд юмс гэдэг нь ихэвчлэн эртнээс өвлөгдөж ирсэн эд, урлагийн хосгүй бүтээл зэрэг юм.

ГУРАВ. ЭДИЙН БУС ХОХИРЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ЗАРИМ ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Удиртгал хэсэгт дурдсанчлан энэхүү судалгааны объект нь хүний амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндээс бусад эрх, ашиг сонирхлын зөрчилтэй холбогдуулан эдийн бус хохирлоо шүүхээс шаардсан хэргүүд билээ. Учир нь хүний амь нас, эрүүл мэнд нь хүний тэргүүн дээд эрх тул эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх нь гарцаагүй. Харин нэр төр, алдар хүндийн хувьд манай улсын ИХ-д эдийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийн зөрчил гэж хуульчлагдсан байдаг.

Иймд манай судалгааны баг 2010-2020 он хүртэлх⁵⁰ 10 жилийн хугацаанд иргэний хэргийн шүүхээр нэхэмжилсэн амь

⁵⁰ Шүүхийн шийдвэрийн хамрах хүрээг 2010-2020 он гэж тодорхойлсон үндэслэл нь: 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.30 дахь хэсэгт “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” гэх тусгай сангийн төрлийг 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуульд шинээр оруулж, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотой. Улмаар гэмт хэргийн улмаас өөрт учирсан эдийн хохирлыг төрөөс нэхэмжлэхээс гадна сэтгэл санаанд үүссэн хохирлыг нэхэмжлэх үндэс суурь бүрдсэн. Тус хуулийн 213 дугаар зүйлд **“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” гэсэн заалт нэмэгдэж, энэхүү зохицуулалтаар тодорхой төрлийн гэмт хэргийн** улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээ, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нөхөн төлөхөд зарцуулахаар нарийвчлан зохицуулсан юм. Үүнтэй холбоотойгоор иргэд ч сэтгэл санааны хохирлоо шаардах болсон тул шүүхийн шийдвэрийн цар хүрээг 2010-аас 2020 оныг хүртэлх байдлаар сонгож авсан болно.

нас, эрүүл мэнд хохирсноос бусад төрлийн шийдвэрүүдийг судалгааны объект болгож хамрууллаа. Ийнхүү судлахдаа шүүхийн шийдвэрийн албан ёсны цахим сан болох shuukh.mn, old.shuukh.mn, new.shuukh.mn, shine.shuukh.mn сайтуудыг эх сурвалж болголоо.

Энэхүү судалгаанд шүүхийн 100 орчим шийдвэрээс түүвэрлэн ач холбогдол бүхий 90 шийдвэрийг судалсан бөгөөд нийт хэргийн 64 нь хууль бусаар гэмт хэрэгт холбогдож хоригдсон, шалгагдсантай холбоотой хэргүүд, үлдсэн хувийг бусад шалтгаанаар сэтгэл санааны хохирлоо нэхэмжилсэн хэргүүд эзэлж байна.

Судалгааны явцад сонирхол татсан, цаашид шүүхийн практикт жишиг болохуйц хэргүүд байсан бөгөөд тэдгээрийг энэхүү судалгааны дараагийн дэд бүлэгт агуулгаар нь ангилан дэлгэрүүлж үзэх болно.

3.1. ЭР, ЭМИЙН ХАРИЛЦАА ДАХЬ СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

1. Гэр бүлээс гадуурх харилцаанаас үүдэлтэй сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁵¹

⁵¹ Б.Б-д холбогдох гэр бүлээс гадуурх харилцаанаас үүдэлтэй сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2012 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 93 дугаартай шийдвэр.

Нэг. Үйл баримт

Нэхэмжлэгч А болон хариуцагч Б1 нар нь 2010 оны 7 дугаар сараас эхлэн хамтран амьдарч байгаад 2011 оны 3 дугаар сарын 25-нд гэрлэлтээ батлуулсан. 2011 оны 2 дугаар сарын 25-нд хүүгээ төрүүлсэн бөгөөд түүнээс нэг хоногийн дараа хариуцагч Б2 (Б1-ийн хамтын амьдралтай байсан эмэгтэй) утсаар “Би Б1-ийн анхны хүүхдийг төрүүлсэн эхнэр нь байна, чи хэн бэ?” гэж дарамталж эхэлсэн. Үүнээс хойш Б2 нь А-г байнга дарамталж, заналхийлсэн мессеж илгээн, утсаар байнга занаж байсан. Улмаар 2011 оны 8 дугаар сарын 30-нд А-гийн гэрт ирж амь насанд нь заналхийлэн, биед нь гэмтэл учруулсан бөгөөд А цагдаа дуудаж, Б2-т торгуулийн арга хэмжээ авсан байна.

Эдгээр дарамтын улмаас А-д зүрх өвдөх, нойргүйдэх, уур бухимдал төрөх, салганах, зүрхээр нь хатгах зовуурь илрэх болж, эмчийн байнгын хяналтад байдаг болсон. Түүгээр ч зогсохгүй 2011 оны 11 дүгээр сараас Б1, Б2 нь хамт амьдрах болсон байна. Иймд А нь сэтгэл санааны хохиролд 1,000,000 төгрөгийг хариуцагч Б1, Б2 нараас нэхэмжилжээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“Монгол Улсын Гэр бүлийн тухайн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т зааснаар “Гэрлэгсэд нь бие биедээ цнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, ...хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх үүрэгтэй” бөгөөд хариуцагч Б1-ийн хувьд дээрх үүрэгээ зохио ёсоор биелүүлээгүйн улмаас зохигчдын хооронд маргаан үүсжээ.

“Хариуцагч Б1 нь хариуцагч Б2-той эр, эмийн харьцаатай байсан бөгөөд Б2 нь Б1-ийн хүүхдийг 2010 оны 9 дүгээр сард төрүүлсэн, улмаар Б1 нь 2011 оны 11 дүгээр сард эхнэр А болон хүүхдээ орхиж Б2-той хамтран амьдрах болсон нь зохигчдын тайлбараар тогтоогдож байна. Түүнчлэн Б1-ийн дээрх үйлдэл болон Б2-ын утсаар заналхийлсэн, сэтгэл санаагаар дарамталсан, доромжилсон үйлдлийн

улмаас нэхэмжлэгчийн эрцүл мэнд болон сэтгэл санаанд хохирол учирсан байна” гэж шүүх дүгнэжээ. Нэхэмжлэгч А нь “Сэтгэл санааны хохиролд 1,000,000 төгрөг” нэхэмжилсэн бөгөөд нэхэмжлэгчийн биеийн эрцүл мэнд, түүний сэтгэл санаанд учруулсан хариуцагчдын үйлдлийн үр дагавар зэргийг харгалзан хохирлын хэмжээг шүүх тодорхойлж “нэхэмжлэлийн шаардлагаас 300,000 төгрөгийг хангаж” шийдвэрлэжээ.

Хариуцагчид “Нэхэмжлэгч нь төрөлхийн зүрхний цооролттой байсан, тэр нь эрцүл мэндэд нь нөлөөлсөн” гэж маргаж байгаа боловч энэ талаарх нотлох баримтаа гаргаж өгөөгүй, татгалзлаа нотлох үүргээ биелүлээгүй гэж шүүх үзлээ. “Иймд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 511 дүгээр зүйлийн 511.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаас 300,000 төгрөгийг хангаж, үлдэх 700,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь үндэслэлтэй байна” гэжээ.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Энэхүү шийдвэр нь Гэр бүлийн тухай хуулийн дагуу “гэрлэгсэд бие биедээ үнэнч байх, халамжлах үүргээ” биелүүлэхгүй байх нь Иргэний хуулийн 497.1 дэх хэсгээр хамгаалагдсан “бусад эрх”-ийн зөрчил мөн бөгөөд энэ тохиолдолд хариуцагч нь хохирогчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх ёстой гэж тогтоосон.

Мөн шүүх хохирогчоос сэтгэл санаагаар хохирсон эсэхийг гарцаагүй байдлаар нотлохыг шаардаагүй. Өөрөөр хэлбэл, хохирогчийн эрх зөрчигдсэн явдлыг хариуцагчид хангалттай няцааж чадаагүй учир гэм хорын үүрэг үүссэн хэмээн

хохирогчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэснээрээ ач холбогдолтой юм.

2. Маргааны зүйл

Уг хэргийн хувьд гэрлэгсдийн хэн нэг нь гэр бүлээс гадуур буюу гуравдагч этгээдтэй дотно харилцаа үүсгэсний улмаас гэрлэгсдийн нөгөө тал хууран мэхэлсэн тал болон гуравдагч этгээдээс сэтгэл санааны хохирлоо шаардах эрхтэй юү гэдэг асуудал нь маргааны зүйл болжээ.

Уг хэргийн онцлог нь гэрлэгсэд аль нэгнээ хууран мэхэлсэн үйлдлээс гадна гуравдагч этгээдийн зүгээс дарамталсан, сүрдүүлсэн, биед нь гэмтэл учруулсан гэх үйлдлүүд мөн адил сэтгэл санааны хохирол нэхэмжлэх нэг үндэслэл болж байгаа. Гэхдээ бид энэ хэсгээс илүү гэрлэгсдийн бие биеэ хууран мэхэлсэн үйлдэл болон сэтгэл санааны хохирлын хоорондох асуудлыг чухалчлан үзэх болно.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Иргэний хуулийн 52 дугаар бүлэгт “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг”-ийн талаар зохицуулсан. Тус бүлэгт гэм хорын эрх зүйн ерөнхий зохицуулалт болон тусгай зохицуулалтыг тусгасан бөгөөд үүнд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тухай ерөнхий зохицуулалт багтаагүй байдаг.

Гэм хорын эрх зүйн ерөнхий зохицуулалт болох Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж заасан. Уг зохицуулалтыг үгчлэн тайлбарлах аргын үүднээс авч үзвэл “бусдын эрх” гэдэгт эдийн болон эдийн бус бүхий л эрх хамаарч болно. Энэ талаар Улсын Дээд шүүх (УДШ) “бусад” гэдэгт өөр бусад

этгээд гэж ойлгох ба “эрх” гэдгийг тухайн зүйлд нэрлэн заасан байгаа хувь этгээдийн амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгийн эрхтэй адил хэмжээний боловч энэ зүйлд нэрлэн заагаагүй өөр бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан эрх, ашиг сонирхол гэж тайлбарлажээ.⁵²

Нөгөө талаас нь авч үзэхэд иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байдаг. Бусдын эрхийг зөрчиж бие махбодын болон сэтгэл санааны гэм хор учруулсан этгээдээр тодорхой хэмжээний мөнгөн төлбөр төлүүлэх болон бусад үүрэг хүлээлгэхийг эдийн бус гэм хорыг арилгах иргэний эрх зүйн хамгаалалтын арга гэж үздэг. Энэ талаар ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтад “эдийн бус гэм хорыг арилгуулах” гэж заасан. Эдийн бус гэм хор гэж бусдын нэр төр, алдар хүнд, хувийн халдашгүй байдал, эрүүл мэндэд халдаж эд хөрөнгийн бус амины эрхийг нь зөрчсөний улмаас хохирогчийн бие махбод болон сэтгэл санаанд учирсан зовлон зүдгүүрийг ойлгоно⁵³.

Уг хэргийн хувьд гэрээний үүргийн зөрчил үүсээгүй. Харин хариуцагч нэхэмжлэгчийн хуулиар олгогдсон эрхийг зөрчин түүнд гэм хор учруулсан хэрэг байна. Гэр бүлийн тухай хуульд “Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, ...хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх үүрэгтэй” гэж заасан. Аливаа этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг нь нөгөө талын хувьд тухайн үүргийг биелүүлэхийг шаардах эрх болдог.

⁵² Монгол Улсын Дээд шүүх Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг), IV, УБ., 2016, 54 дэх тал.

⁵³ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар), УБ., 2015, 20 дахь тал.

Шүүхийн зүгээс Гэр бүлийн тухай хуульд заасан гэрлэгсэд нэг нэгнээсээ “...үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, бие биеэ халамжлах, хүндэтгэх”-ийг шаардах энэхүү эрхийг ИХ-ийн 497 дугаар зүйлд заасан “бусад эрх”-ийн хүрээнд хамгаалалтад авч буй нь цаашид шүүхийн практикт жижиг ч гэсэн жишиг болохуйц жишээ болсон байна. Шүүх хуулийн хатуу зохицуулалтыг дэлгэрүүлэн тайлбарлаж, бусад эрхийн зөрчилд үйлчлэх эрх зүйн хамгаалалтыг хөгжүүлж буй нь сайшаалтай юм.

4. Эдийн бус хохирлыг барагдуулах эсэх

ИХ-ийн 230.1, 230.2, 511.1-д заасны дагуу хүний нэр төр, алдар хүндэд халдсанаас бусад тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр шаардах боломжгүй нөхцөл байдалд хүргэж байгаа тухай өмнө нь дурдсан билээ.

Ийм ч учраас уг шүүхийн шийдвэрт хөндөгдөж буй гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэсэн нөхрийнхөө эсрэг сэтгэл санааны хохирол болон нөхрийнхөө хамтран амьдрагч эмэгтэйн дарамт, заналхийллийн улмаас өөрт учирсан сэтгэл санааны хохирлыг шаардах эрх нь ИХ-д байхгүй байна. Гэхдээ шүүгч дээрх хууль зүйн үндэслэл, нотлох хатуу шаардлагад хязгаарлагдалгүйгээр хуулийг хэрэглэж сэтгэл санааны хохиролд 300,000 төгрөг төлүүлэхээр нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэжээ. Шүүгч сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гаргахдаа ИХ-ийн 497, 511 дүгээр зүйлийг үндэслэсэн байх боловч эдгээр нь төдий л хамааралтай заалт биш юм.

Иймээс хуулиар тусгайлан заасан тохиолдол биш байхад шүүгч сэтгэл санааны хохирлыг зөвшөөрсөн нь уг шүүхийн шийдвэрт ИХ-ийн зүйл, заалтыг буруу хэрэглэсэн мэт харагдаж байна. Гэвч үүнээс үл хамааран, шүүгч нэхэмжлэгчид тодорхой хэмжээний сэтгэл санааны хохирлыг хүлээн

зөвшөөрсөн нь хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг бүрэн барагдуулах ИХ-ийн болон Үндсэн хуулийн зарчимд нийцсэн, шударга шийдвэр болжээ гэж дүгнэж байна.

5. Дүгнэлт

Шүүхийн энэ шийдвэрээс үзэхэд хэдийгээр гэр бүлээс гадуурх харилцаа тогтоож, эхнэр эсхүл нөхөр, хүүхдээ хаяж явсан, мөн үгээр байнгын дарамт, заналхийлэлд байлгасан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх тухай заалт манай улсын хууль тогтоомжид байхгүй байгаа боловч хариуцагчийн гэм буруугийн хэмжээ, хохирогчийн хохирсон нөхцөл байдал зэрэгт үндэслэн эдгээр тохиолдолд ч сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх нь зүйтэй. Хэдийгээр эдгээр тохиолдолд эдийн хохирлоо нэхэмжилж болох ч манай одоогийн шүүхийн практикт энэ нь бас л хүндрэлтэй байна.

Учир нь нэхэмжлэгчийн хувьд “эхнэр эсхүл нөхөр нь гэр бүлээс гадуур гуравдагч этгээдтэй нууцаар дотносох, улмаар эхнэр эсхүл нөхрөө хаяж явах зэргээс учирсан эдийн хохирол”, “хүүхдээ өсгөн хүмүүжүүлээгүйн улмаас үүссэн эдийн хохирол” зэргийг нотлох баримтаар нотлох, бүрдүүлэх нь хүндрэлтэй юм. Ийм ч учраас эцсийн дүндээ дээрх хууль бус, гэм буруутай үйлдэл хийсэн хариуцагч ямар нэгэн эдийн болон эдийн бус хохирол төлөхгүй, хариуцлага хүлээхгүй үлдэхээр байна.



2. Сүйт бүсгүй нь гэрлэхээс татгалзсантай холбоотой сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁵⁴

Нэг. Үйл баримт

Нэхэмжлэгч А болон хариуцагч Б нар нь 2016 оны 4 дүгээр сард танилцаж, тухайн жилийнхээ 7 дугаар сарын 29-ний өдөр Баян-Өлгий аймагт А нь бэр гуйх ёслол үйлдэн, Б нь зөвшөөрсөн. Ийнхүү бэр гуйх ёслолд А нь өөрийн хамаатан садны хамтаар бэлэг сэлт бэлдэж, Б ч бас ирсэн зочдыг хүлээн авч бэлэг сэлт өгсөн. Гэвч мөн оны 7 дугаар сарын 30-ны өдөр А, Б нар нь Улаанбаатар хотод буцаж ирмэгцээ Б нь А-тай гэрлэх бодолгүй гэдгээ илэрхийлсэн. Иймд А нь эхнэр авч байгаа гэж бэр гуйх ёслол үйлдэж, хамаатан садандаа хэлсэн байтал Б түүнтэй гэрлэхгүй гэсэн нь түүнд сэтгэл санааны хохирол учруулсан тул сэтгэл санааны хохиролд 2,000,000 төгрөг мөн бусад эдийн хохиролд 8,000,000 төгрөг нийт 10,000,000 төгрөгийг хариуцагч Б-гээс нэхэмжилжээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“Нэхэмжлэгчийн гэрлэх саналыг хариуцагч хүлээн зөвшөөрч бэр гуйх ёслолын ажиллагаа хийж байгаа үйл баримтыг авч үзвэл талуудын хооронд ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.3-т зааснаар “хэлцэл” хийгдсэн байна. Нөгөө талаар ИХ-ийн 196 дугаар зүйлийн 196.1.5-д зааснаар А-гийн гэрлэх саналд Б нь зөвшөөрсөн хариу өгч бэр гуйх ёслолын ажиллагаа хийсэн байх тул талуудын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ. Зохигчид Баян-Өлгий аймгаас ирсний дараа хэсэг хугацаанд хамт амьдарч байгаад 2016 оны 8 дугаар сараас Б надтай амьдрахгүй гээд явсан гэж А тайлбарлаж байх бөгөөд үүнийг гэрээнээс татгалзсанаас өөрт учирсан хохирлоо шаардаж байна гэж үзэхээр байна.

⁵⁴ Г-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 0229 дүгээр шийдвэр.

Мөн А нь сэтгэл санааны хохиролд 2,000,000 төгрөг шаардаж байгаа боловч юунаас болж нэхэмжлэгчийн сэтгэл санаа нь хохирсон талаар тодорхой тайлбарлаагүй бөгөөд хариуцагч Б нь нэхэмжлэгчийн эрх, амь нас, эрцүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар гэм хор учруулсан гэх нөхцөл байдал тогтоогдохгүй байна. Иймд эдийн бус хохирлыг хэрэгсэхгүй болгож, бусад эдийн хохирлын талаар холбогдох баримтуудыг гаргаж өгөөгүй байгаа тул ИХ-ийн 281 дүгээр зүйлийн 281.1-д зааснаар хариуцагч Б-гийн хүлээн зөвшөөрсөн хүрээнд буюу 160,000 төгрөгийг нэхэмжлэгчид олгож үлдсэн хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв”.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Энэхүү кэйс нь иргэд хоорондын гэрлэх зорилгоор үйлдэж буй сүй тавих үйлдэл иргэний эрх зүйн харилцааг үүсгэх “хэлцэл”-ийн нэг төрөл мөн, түүнчлэн сүйг нэг талын санаачилгаар цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалсан тал нь гэрээнээс татгалзсаны улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй болохыг харуулсан ач холбогдолтой шийдвэр юм.

2. Маргааны зүйл

Уг хэргийн маргааны зүйл нь сүйг цуцалсны улмаас үүсэх сэтгэл санааны хохирлыг шаардах эрхтэй юү гэдэг асуудал байна.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Аливаа этгээд бусдад учруулсан хохирлыг барагдуулах үндэслэл нь ИХ-ийн 497.1 дэх хэсэгт заасны дагуу гэм хор

үүссэн эсхүл гэрээний үүрэг зөрчигдсэн тохиолдолд бий болдог.

Уг хэргийн хувьд зохигчдын нэг нь сүй тавих ёслолоор дамжуулан нэгэндээ гэрлэх санал тавьж, нөгөөх нь түүнийг хүлээн авчээ. Хэдийгээр Б нь үнэн сэтгэлээсээ гэрлэх хүсэлгүй байсан байж болох ч сүй тавих ёслол дээр гэрлэхийг зөвшөөрсөн. Үүний улмаас А нь Б-тэй гэрлэнэ гэж итгэн, Б-д эдийн засгийн болон бусад тусламж үзүүлэх гэх мэтээр сүйт залуугийн үүргийг биелүүлж ирсэн байна. Б нь А-гаас эд материалын болон бусад тусламж авч байхдаа “жинхэнээсээ гэрлэх бодолгүй” тухайгаа дурдаж, илэрхийлж байгаагүй. Ийм учраас энэхүү сүй тавих ёслолыг гэрлэхээр харилцан тохиролцсон тохиролцоо буюу хэлцэл гэж үзэх үндэслэлтэй юм.

Энэ талаар шүүх “Нэхэмжлэгчийн гэрлэх саналыг хариуцагч хүлээн зөвшөөрч бэр гуйх ёслолын ажиллагаа хийж байгаа үйл баримт нь талуудын хооронд ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.3-т зааснаар хэлцэл хийгдсэн байна. Нөгөө талаар ИХ-ийн 196 дугаар зүйлийн 196.1.5-д зааснаар А-гийн гэрлэх тухай саналд Б зөвшөөрсөн хариу өгч бэр гуйх ёслолын ажиллагаа хийсэн байх тул талуудын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ” гэж дүгнэсэнтэй санал нэг байна.

А нь Б-гээс гэм хор учруулснаас үүсэх үүрэг буюу ИХ-ийн 497.1-д заасны дагуу хохирлоо шаардаж болох юм. Тодруулбал, нэхэмжлэгчийн хувьд хариуцагч Б-тэй гэрлэхээр бэр гуйсан бөгөөд ийнхүү түүнтэй гэрлэнэ гэж итгэж үнэмшсэн учраас түүнд санхүүгийн болон бусад тусламж үзүүлж ирсэн, өөрийн ээж, хамаатан саданд энэ талаараа мэдэгдэж, сүй тавих үйлдэл хийсэн тул түүний итгэл үнэмшил нь хүчтэй байсан гэж үзэх үндэслэлтэй. Ийнхүү нөгөө талдаа итгэл үнэмшил төрүүлсний дараа түүнтэй гэрлэхгүй гэсэн нь түүнийг энэхүү үйлдэлдээ санаатай юм уу болгоомжгүй хэлбэрээр гэм буруутай болохыг харуулж байна. Ийм учраас Б нь сүй тавьсны дараа сүйгээ

цуцалж буй нь А-гийн “итгэж найдах эрх”⁵⁵-ийг зөрчиж буй гэм буруутай үйлдлийн төлөө ИХ-ийн 497.1-д заасны дагуу А-гийн хохирлыг төлөх үүрэгтэй байж болох юм.

4. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Энэ тохиолдолд А нь гэрээний үүргийн зөрчил эсхүл гэм хорын улмаас Б-гээр эдийн хохирлоо нөхөн төлүүлэх бүрэн эрхтэй. Харин сэтгэл санааны хохирлын хувьд ИХ-ийн 230.2-т заасны дагуу “гэрээний үүргийн зөрчил” болон “итгэх эрхийн зөрчил”-д сэтгэл санааны хохирлыг мөнгөөр арилгах тухай тусгайлсан заалт байхгүй тул сэтгэл санааны хохирол шаардах эрх үүсэхээргүй байна.

Шүүх “нэхэмжлэгч А-г юунаас болж нэхэмжлэгчийн сэтгэл санаа хохирсон талаар тодорхой тайлбарлаагүй, хариуцагч Б нь А-д эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар гэм хор учруулсан гэх нөхцөл байдал тогтоогдохгүй байна” гэжээ. Өөрөөр хэлбэл, шүүх нэхэмжлэгчийг юунаас болж сэтгэл санаа хохирсон талаар тодорхой тайлбарлаагүй гэсэн байна.

Хэрэв нэхэмжлэгч өөрт нь сэтгэл санааны хохирол үүссэн тухай амаар дэлгэрэнгүй тайлбарлаж мэтгэлцсэн бол шүүгч сэтгэл санааны хохирлыг хүлээн зөвшөөрөх байсан болов уу? Эсхүл заавал гарцаагүй нотлох баримт гаргаж өгөхийг шаардах байсан уу гэдэг нь шүүхийн энэ шийдвэрээс тодорхой харагдахгүй байна. Ямар боловч нэхэмжлэгчийн хувьд өөрийн нэхэмжлэлд хариуцагчийн үйлдлийн улмаас “сэтгэл санааны

⁵⁵ “Сүй тавьсан ч талууд гэрлээгүй эсхүл үндэслэл бүхий шалтгаанаар сүйг цуцлаагүй тохиолдолд үүнийг үүргийн зөрчил гэж үзэж нөгөө талд учруулсан хохирлоо арилгах үүрэг хүлээнэ. Учир нь энэ нь 期待権 буюу нөгөө талдаа итгэл төрүүлсэн ч түүний эсрэг үйлдэл хийж итгэх, найдах эрхэд халдаж байгаа хэрэг”. Япон Улсын Чива мужийн Өмгөөлөгчдийн холбооноос хэвлэн гаргасан “Сэтгэл санааны хохирлын тооцооллын хэрэгжилт” ном, 2002, 25-26 дахь тал.

хохирол тодорхой хэмжээгээр үүссэн бөгөөд үүнийгээ 2,000,000 төгрөгөөр үнэлсэн” тухай тодорхой бичсэн байна.

Тиймээс сэтгэл санааны хохирол ямар байдлаар үүссэн тухай тайлбарлаж нотолбол зохилтой талаар тодорхой болгох шаардлага үүсэж байгаа юм.

5. Дүгнэлт

Шүүхийн шийдвэрээс дүгнэхэд сүй тавих нь хэлцлийн нэг хэлбэр мөн бөгөөд сүйгээ хүндэтгэн үзэх шалтгаангүй цуцлах нь гэрээний үүргийн зөрчлийн нэг хэлбэр болж байна. Хамгийн гол нь сүйн харилцааны нэг тал сүй тавьсан явдал нь гэрлэх үр дагаварт хүргэнэ гэдэгт итгэж, үнэн сэтгэлээсээ хэлцэл байгуулсан, түүнээс улбаатай үйлдэл, эс үйлдлүүдийг хийсэн байх нь чухал юм.

Иймээс сүйг үндэслэлгүйгээр цуцалсан нь нөгөө талдаа хохирол учруулсан бол хохирогч тал нь хохирлоо шаардах эрхтэй. Гэрээний үүргийн зөрчил биш юм гэхэд хохирогч нь өөрийн “итгэх эрх”-ийг зөрчсөн гэдэг үндэслэлээр гэм хорын шаардах эрхийг ашиглан шаардах давхар боломж байж болох юм.

Гэрээний үүрэг зөрчсөн тохиолдолд эдийн болон эдийн бус хохирол төлөх үүрэг үүсэх боловч манай одоогийн ИХ-ийн 230.2-т заасны дагуу сүйг цуцалсан тохиолдолд сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх тусгайлсан зохицуулалт байхгүй тул боломжгүй юм.

3.2. ӨМЧИЙН ЭРХ ЗӨРЧИГДСӨНИЙ УЛМААС ҮҮСЭХ СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

1. Орон байрнаас нь хүчээр хөөж гаргасантай холбоотойгоор үүссэн сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁵⁶

Нэг. Үйл баримт

Хариуцагч “Б” үйлдвэрээс нэхэмжлэгч А-д холбогдуулан орон сууцнаас нүүлгэн нөхөн төлбөр гаргуулах нэхэмжлэл гаргасныг 2001 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 171 дүгээр шийдвэрээр “Б” үйлдвэрийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэгч А-г шударга эзэмшигч болохыг тогтоосон. Гэвч “Б” үйлдвэр нь 2001 оны 8 дугаар сарын 9-ний өдөр цагдаагийн хүчээр нэхэмжлэгч А-гийн орон байранд дайрч орон, гэр бүлийг нь гудамжинд хөөж гаргасан. Нэхэмжлэгч А нь “Б” үйлдвэрт хандаж орон сууц авах өргөдөл өгсөөр байсан ч “Б” үйлдвэрийн зүгээс “Дарга нар байр өгнө, хүлээж бай” гэсээр байв. Иймд “Б” үйлдвэрт холбогдуулан эд хөрөнгийн хохирол болох хоёр өрөө орон сууц эсхүл түүнтэй дүйцэхүйц 18,000,000 төгрөг, мөн 10 жилийн хугацаанд гэр бүлээрээ амгалан тайван, ая тухтай амьдрах нөхцөл боломжийг нь алдагдуулсны сэтгэл санааны хохирол болох 10,000,000 төгрөг, нийт 28,000,000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргажээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

Нэхэмжлэгч А нь 45-р байрны 38 тоот хоёр өрөө орон сууцыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр эзэмшиж байхад нь “Б” нь орон сууцыг В-д эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн болох нь “Б”-гийн Орон сууцны тухай 2001 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн өргөтгөсөн хурлын протокол, “Б”-гээс 2001 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Бор-Өндөр хотын Цагдаагийн тасгийн даргад гаргасан тодорхойлолт зэргээр нотлогдож

⁵⁶ “Б”-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн 2 дугаар шүүхийн 2012 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 66 дугаар шийдвэр.

байна. Иймд нэхэмжлэгч А нь ИХ-ийн 497-р зүйлийн 497.1, 498-р зүйлийн 498.2-т зааснаар гэм хорын хохиролд хоёр өрөө орон сууцтай дүйцэхүйц 18,000,000 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлага гаргах эрхтэй байна.

Ийнхүү А нь 45-р байрны 38 тоот хоёр өрөө орон сууц эзэмших эрхийг шийдвэрлэлгүй хугацаа алдсанаас өмчлөх эрхэд нь гэм хор учирсан байх тул Хэнтий аймгийн Дархан сумын үнэлгээний комиссоос тогтоосон үнэлгээгээр хоёр өрөө орон сууцны үнийг 18,000,000 төгрөгөөр тооцож хариуцагчаас нөхөн төлүүлэх хууль зүйн үндэслэлтэй байна гэж шүүх үзлээ.

Харин нэхэмжлэгч нь сэтгэл санааны хохирол болох 10,000,000 төгрөгийн талаарх нэхэмжлэлийн шаардлагаа шүүхэд нотолж чадаагүй, энэ талаарх нотлох баримтыг мөн шүүхэд ирүүлээгүй байх тул уг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй” гэж шүүх шийдвэрлэв.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Энэхүү шийдвэрээр эд хөрөнгө эзэмших, өмчлөх эрх зөрчигдсөн тохиолдолд сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой эсэхийг тодорхой болгосон бөгөөд шүүх ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.1 дэх хэсэгт заасныг баримтлан энэ тохиолдолд зөвхөн эд хөрөнгийн хохирол нөхөн төлүүлэх боломжтой боловч сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй гэж үзсэн.

2. Маргааны зүйл

Энэ тохиолдлын хувьд маргааны гол зүйл нь аливаа этгээдийн эд хөрөнгийн эрхийг зөрчих нь сэтгэл санааны

хохирол нөхөн төлүүлэх үндэслэл болох эсэх тухай асуудал байна.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Энэ хэргийн хувьд нэхэмжлэгч А нь маргаан бүхий орон сууцыг 1983 оноос хойш эзэмшин ашиглаж ирсэн бөгөөд 2001 онд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр шударга эзэмшигч хэмээн тогтоогдсон. Ийнхүү орон сууцыг шударгаар эзэмшиж байхад нь 2001 оны 8 дугаар сард “Б” үйлдвэр тус орон сууцыг өөр этгээдэд эзэмшүүлэхээр шийдвэрлэж, нэхэмжлэгчдийг орон сууцнаас хөөж гаргасан. Шүүх “Б” үйлдвэрийн тушаал хүчингүй болохыг тогтоож, ИХ-ийн 497-р зүйлийн 497.1, 498-р зүйлийн 498.2-т зааснаар нэхэмжлэгчийг хариуцагчаас гэм хорын хохирол нөхөн төлүүлэх эрхтэй болохыг тогтоосон. Судлаачдын хувьд шүүхийн энэ дүгнэлттэй санал нэг байна.

4. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Харин шүүхээс нэхэмжлэгчид олгох ёстой хохирлыг тооцоолохдоо хоёр өрөө орон сууцтай дүйцэхүйц 18,000,000 төгрөгийг хариуцагчаас нэхэмжлэгчид гаргуулахаар шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчид эдийн хохирол нөхөн төлөхийг хариуцагчид даалгасан. Харин нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэхдээ “нэхэмжлэгч сэтгэл санааны хохирол 10,000,000 төгрөгийн талаарх нэхэмжлэлийн шаардлагаа шүүхэд нотолж чадаагүй, энэ талаарх нотлох баримтыг мөн шүүхэд ирүүлээгүй байх тул уг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй” гэж шийдвэрлэсэн.

Гэвч сэтгэл санааны хохирол нь үндсэн шинжээрээ гарцаагүй нотлох баримтаар нотлогдох боломжгүй хохирлын төрөл болохыг бид өмнө нь дурдсан. Хэрэв сэтгэл санааны хохирлыг ямар нэг нотлох баримтаар нотлохыг шаардах аваас энэ нь эдийн хохиролтой агаар нэгэн болно.

ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.2 дахь хэсэгт “Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө” гэж заасан. Нотолгооны үүргийн хувьд сэтгэл санааны хохирлыг аливаа баримтаар нотлох нь бодит байдалд биелэгдэх боломж хязгаарлагдмал тул үндэслэл болж байгаа бусад эрхийн зөрчил, түүний нотолгооны асуудалтай холбож авч үзэх нь зүйтэй.

Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орон сууц эзэмших эрх зөрчигдсөн гэдэг нь баримтаар нотлогдсон бол түүний улмаас сэтгэл санааны хохирол мөн адил учирсан гэж нотлогдоход хүргэнэ. Өөрөөр хэлбэл, хэргийн нэхэмжлэгчийн орон сууц эзэмших эрх зөрчигдсэн болох нь холбогдох нотлох баримтуудаар тогтоогдсон байх тул ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийн объектив шинж хангагдаж байна. Улмаар нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирол нь түүний орон сууцны эзэмших эрх зөрчигдсэн гэх үйл баримттай салшгүй холбоотой тул нэхэмжлэгч өөрөө “энэ зөрчлийн улмаас сэтгэл санааны хохирол учирсан” гэдгээ үнэмшилтэй толилуулснаар сэтгэл санааны хохирол нь нотлогдсон гэж үзвэл зохилтой юм.

Нөгөө талаас сэтгэл санааны хохирлын нотолгооны үүргийг хариуцагч талд оногдуулах нь ИХ-ийн 497.2 дахь хэсгийн агуулгад нийцнэ. Энэ тохиолдолд гэм хор учруулагч этгээд бусдад учруулсан сэтгэл санааны хохирлыг түүний буруугаас болоогүй гэдгийг нотлох үүрэгтэй байх бөгөөд хэрэв нотолж чадахгүй бол сэтгэл санааны хохирлыг зохих хэмжээнд нэхэмжлэгчид төлөх учиртай.

Гэвч өмнөх шүүхийн шийдвэрүүдийн дүн шинжилгээд дурдсанчлан ИХ-ийн 230.2 дахь хэсгийн агуулга нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхэд саад болж байна. Тус

зүйлийн дагуу бусдын өмчлөх эрхийг зөрчсөн тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тухай тусгайлан заасан зохицуулалт байхыг шаардаж байгаа тул энэ хэргийн нэхэмжлэгчийн хувьд өмчлөх эрхээ зөрчүүлсний улмаас сэтгэл санааны хохирлоо эцсийн дүндээ шаардах боломжгүй болж байна.

5. Дүгнэлт

Ийнхүү нэхэмжлэгчийн өмчлөх эрх нь ноцтой зөрчигдсэн бөгөөд нэхэмжлэгч нь эдийн хохирлоо хариуцагчаар гаргуулан авахаар болсон. Гэвч нэхэмжлэгчийн эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг ИХ-ийн 230.2-т заасны дагуу нөхөн төлүүлэх боломжгүй байна. Харин шүүх нь сэтгэл санааны хохирол төлүүлэхээс татгалзахдаа буруу үндэслэл баримталж тайлбарласан. Тэрбээр нэхэмжлэгчийг сэтгэл санааны хохирлоо нотолж чадаагүй, нотлох баримт гаргаж өгөөгүй хэмээн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон нь ИХ-ийн гэм хорын эрх зүйн нотолгооны үүргийн зарчмыг зөрчиж байхын сацуу сэтгэл санааны хохирлын хатуу баримтаар үл нотлогддог үндсэн шинж чанартай зөрчилдөж байна.

3.3. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙГООР УЧИРСАН СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

Энэ хэсэгт бид аливаа гэрээний харилцаанд орсон этгээдүүдийн нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь өөрт учирсан эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлоо шаардсан хэргийг шинжлэн үзнэ.

1. Авиа компани болон зорчигчдын хооронд үүссэн Тээвэрлэлтийн гэрээний үүргийн зөрчил ба сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁵⁷

Нэг. Үйл баримт

Нэхэмжлэгч А1, А2 болон түүний насанд хүрээгүй хүүхдүүд болох В, Г нар нь 2014 оны 7 дугаар сарын 10-ны өдөр авиа нислэгийн “Б” ХХК-д 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Увс аймгийн Улаангом хотоос Улаанбаатар хот руу зорчих нислэгийн тийз тус тус захиалсан. Онгоц нисэх цаг нь 16:50 байсан бөгөөд нэхэмжлэгчид тэр өдөр 16:07 минутад онгоцны буудал дээр ирсэн. Ингээд онгоцны гэйт дээр бүртгүүлэхээр очсон боловч хариуцагч компанийн бүртгэлийн ажилтан “Манай компанийн дотоод журмын дагуу 50 минутын өмнө бүртгэл хаагддаг бөгөөд та бүхэн 16:00 цагаас өмнө ирэх ёстой байсан тул бүртгэлээс хоцорсон” гэдэг шалтгаанаар тэднийг онгоцонд оруулаагүй. Гэвч тийзийн санамж бичиг болон дагалдах бичиг баримт дээр нислэгээс 50 минутын өмнө бүртгэл хаах тухай огт бичээгүй байсан болно.

Мөн 16:30 минут болоход хоцорч гэйт дээр ирсэн өөр нэгэн этгээд нь “Б” ХХК-д ажилладаг танилтайгаа утсаар холбогдон, онгоцонд оруулахыг гуйсан бөгөөд тэр ажилтан түүнийг онгоцонд оруулсан байна. Энэ үед нэхэмжлэгчид мөн л хамт оруулаач хэмээн дахин гуйхад бүртгэлийн ажилтан эрс татгалзжээ. Сүүлд шүүх дээр хариуцагчийн төлөөлөгч нь тухайн этгээдийг “өмнө нь бүртгүүлчхээд гарчхаад ирсэн тул оруулсан” гэдэг шалтгаан дурдсан байдаг. Ингээд нэхэмжлэгчид дараагийн өдрийн онгоцонд нэмэлт торгуулийн мөнгө болох 97,000 төгрөг төлж суусан байна. Нэхэмжлэгчид дараа нь Баянзүрх дүүргийн анхан шатны шүүхэд “Б” ХХК-ийн эсрэг гэм хорын нэхэмжлэл гарган, өөрсдөө болон түүний хүүхдүүдийг онгоцонд багтаахыг маш их хүсэж, уйлж гуйхад оруулаагүй атлаа хоцорч ирсэн өөр этгээдийг оруулсан нь нэхэмжлэгчид болон түүний хүүхдүүдэд маш их сэтгэлийн хохирол учруулсан тул 1,000,000 төгрөг, ямар ч үндэслэлгүйгээр онгоцонд оруулаагүй тул хууль бус торгуулийн 97,000 төгрөг, мөн хоёр өдөр Улаангом хотод өнжиж, ажлаа алдсан тул олох ёстой байсан орлого 40,000, таксины мөнгө 10,000 төгрөг тус тус, нийт 1,147,000 төгрөгийг “Б” ХХК-иас нэхэмжилжээ.

⁵⁷ АМ ХХК-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 11 дүгээр сарын 17-ны 5672 дугаар шийдвэр.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“Хариуцагч “Б” ХХК нь зорчигчийн нислэгийн тийзэд нислэгийн өмнөх зорчигч бүртгэлийн дуусах хугацааг заагаагүй, орон нутгийн нислэгийн хувьд зорчигч нислэг эхлэхээс 50 минутын өмнө онгоцны буудалд ирж бүртгүүлэх үүрэгтэй талаар тийзэд бичигдээгүй, зорчигчид энэ талаар тайлбарлаж өгсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул хариуцагч нь зорчигчийг бүртгэхээс үндэслэлгүйгээр татгалзсан гэм буруутай гэж үзэхээр байна. Нэхэмжлэгчид нь нислэгээс хоцорсонтой холбоотойгоор өөрт учирсан хохирлоо хариуцагчаас шаардах эрхтэй байх боловч шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаа баримтаар нотлоогүй байна.

ИХ-ийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж, мөн хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд ...эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд нэхэмжлэгчид онгоцноос хоцорсноос шалтгаалж энэ үндэслэлээр сэтгэл санааны хохирол учирсан гэж хариуцагчаас 1,000,000 төгрөг нэхэмжилсэн боловч энэ талаар шүүхэд нотлоогүй, хууль зүйн үндэслэл бий болсон эсэх нь тодорхойгүй байх тул нэхэмжлэгчдийн сэтгэл санааны хохирол 1,000,000 төгрөг шаардсаныг хангах үндэслэлгүй. Иймд нэхэмжлэгчийн 94,350 төгрөгийг хүлээн зөвшөөрч, үлдэх 1,050,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.”

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Анхан шатны шүүхийн энэ шийдвэр нь тээвэрлэлтийн гэрээний үүргийг тээвэрлэгч тал зөрчсөний улмаас зорчигч тал нь өөрт учирсан эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг шаардах эрхтэй эсэхийг тодорхой болгожээ.

2. Маргааны зүйл

Уг шүүхийн шийдвэрт гэрээний үүргийг зөрчсөний улмаас эдийн хохирлоос гадна эдийн бус хохирол шаардах боломжтой юу гэдэг асуудал маргааны зүйл болжээ.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Нэхэмжлэгч, хариуцагч нарын хооронд “Тээвэрлэлтийн гэрээ”-ний харилцаа үүссэн гэж шүүх тодорхойлсонтой санал нэг байна. Онгоцны билет дээр “онгоц нисэх цагаас 50 минутын өмнө ирсэн байх” тухай тайлбар бичигдээгүй байсан. Иймд нэхэмжлэгчид онгоцны буудал дээр 16:07 минутад ирснийг “хоцорсон” гэх шалтгаанаар онгоцонд оруулаагүй нь хариуцагч гэрээний үүргээ үндэслэлгүй зөрчсөн үйлдэл байна. Шүүх энэ талаар “Хариуцагч нь зорчигчийг бүртгэхээс үндэслэлгүйгээр татгалзсан гэм буруутай” гэж дүгнэсэнтэй санал нэг байна.

Иймээс нэхэмжлэгчийн хувьд учирсан хохирлоо гэрээний эрх зүйн хүрээнд шаардах эрхтэй. Мөн үүнээс гадна нэхэмжлэгч хохирлоо гэм хорын эрх зүйн хүрээнд ч шаардах боломжтой. Учир нь хохирол шаардах эрхийн хүрээнд гэрээний эрх зүй болон гэм хорын эрх зүй нь өрсөлдөх хэм хэмжээнүүд болдог⁵⁸.

⁵⁸ Б.Буянхишиг, Үүргийн эрх зүйн тусгай анги, 3 дахь хэвлэл, 2013, 484 дэх тал.

Мөн энэ хэргийн хувьд хариуцагч нь зөвхөн гэрээний үүргээ зөрчөөд зогсохгүй нэхэмжлэгчийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг давхар зөрчжээ. Нэхэмжлэгчид 16:07 цагт ирэхэд онгоцонд оруулаагүй атал 16:30 цагт ирсэн өөр зорчигчийг онгоцонд оруулсан нь талуудын мэдүүлгээр нотлогдсон байна. Нэхэмжлэгчид бага насны хүүхдүүдтэй ба онгоцонд суулгахыг удаа дараа гуйсныг хариуцагч эрс татгалзсан байдаг хэр нь 16:30 цагт ирсэн зорчигчийг шууд оруулсан үйлдэл нь нэхэмжлэгчдийг илтэд ялгаварлан гадуурхсан үйлдэл мөн. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасныг илт зөрчсөн үйлдэл юм.

Эндээс үзвэл хариуцагч нь хуулиар хориглосон хоёр зөрчил гаргажээ: (i) тээвэрлэлтийн гэрээний үүргийг зөрчсөн тул гэрээний хариуцлага хүлээх; (ii) бусдыг ялгаварлан гадуурхсан гэм буруутай үйлдэлдээ гэм хорын хариуцлага хүлээх үндэслэлтэй байна.

4. Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Тус шийдвэрийн хувьд эдийн бус хохирлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн үндэслэл нь “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж, мөн хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд ...эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд нэхэмжлэгчид онгоцноос хоцорсноос шалтгаалж энэ үндэслэлээр сэтгэл санааны хохирол учирсан гэж хариуцагчаас 1,000,000 төгрөг нэхэмжилсэн боловч

энэ талаар шүүхэд нотлоогүй, хууль зүйн үндэслэл бий болсон эсэх нь тодорхойгүй байх тул нэхэмжлэгчдийн сэтгэл санааны хохиролд 1,000,000 төгрөг шаардсаныг хангах үндэслэлгүй” гэжээ.

Эндээс үзэхэд шүүгч (i) ийм тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх хууль зүйн үндэслэл байхгүй; (ii) сэтгэл санааны хохирол учирсан гэдгээ нотлоогүй гэдэг үндэслэл тавьжээ.

Нэгдүгээр үндэслэлийн хувьд өмнөх шүүхийн шийдвэрүүдэд дурдсантай адил ИХ-ийн 230.2-т зааснаар “хуульд тухайн эрхийн зөрчлийг тусгайлан заасан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлнө” гэснийг баримталбал гэрээний үүргийн зөрчлийн тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө гэсэн тусгайлсан заалт байхгүй тул уг үндэслэлийг хуульд нийцсэн гэж үзэж болох юм.

Харин хоёрдугаар үндэслэлийн хувьд “сэтгэл санааны хохирол учирсан нь нотлогдохгүй байна” гэжээ. Өмнө нь дурдсанчлан сэтгэл санааны хохирол нь өөрөө эд хөрөнгөөр илэрхийлэгдэх боломжгүй учир эдийн бус хохирол гэж нэрлэгдээд буй. Ийм учраас эдийн бус хохирол нь эдийн хохиролтой адил хэмжээнд нотлогдох боломжгүй юм. Иймд эдийн бус хохирол нотлогдохгүй байна гэдэг үндэслэлээр эрс татгалзах нь учир дутагдалтай буюу сэтгэл санааны хохирлын өөрийнх нь үндсэн шинж чанартай зөрчилдөх магадлалтай.

Гэрээний үүргийн зөрчлийн үр дагаварт эдийн болон эдийн бус хохирлын аль аль нь үүсэх боломжтой. Гэхдээ гэрээний үүрэг зөрчигдсөн бүхий л тохиолдолд сэтгэл санааны хохирол үүснэ гэсэн үг биш. Хариуцагчийн гэм буруу хэр ноцтой, хариуцагчийн гэм буруутай үйлдэл нийгэмд хэр хор уршигтай, хариуцагч тухайн зөрчлийг хэрхэн үйлдсэн, ямар хугацаанд хохирогч уг зөрчлийн хор уршигийг амссан бэ гэх

мэт олон нөхцөл байдлыг тэнцвэртэй шинжилснээр сэтгэл санааны хохирол үүссэн эсэх, үүссэн бол хэр хэмжээнд байгаа нь тогтоогдоно. Энэ хэргийн хувьд хариуцагч гэрээний үүргээ зөрчихдөө санаатайгаар үйлдсэн, нэхэмжлэгчдийн зүй ёсны шаардлагыг удаа дараа биелүүлээгүй, тэдний дараа хоцорч ирсэн зорчигчийг онгоцонд оруулсан гэх мэт үйлдэл нь ноцтой байх тул нэхэмжлэгчдийн сэтгэл санааны хохирлыг хүлээн зөвшөөрөх нь хохирлыг бүрэн барагдуулах, хохирогчийн эрхийг бүрэн сэргээх шударга ёс, тэгш эрхийн зарчимд нийцнэ.

Түүнчлэн аливаа хүнийг ялгаварлан гадуурхсан цагаас эхэлж сэтгэл санааны шаналал, зүдгүүр үүсдэг бөгөөд ялгаварлан гадуурхсан үйлдэлд ямар нэгэн нотлох баримт үлдэх нь хүндрэлтэй. Ялгаварлан гадуурхах зөрчил, гэмт хэргийн үндсэн шинж болон үр дагавар нь өөрөө хохирогчид сэтгэл санааны хохирол үүсгэх явдал юм. Иймээс хариуцагч нэхэмжлэгчдийг ялгаварлан гадуурхсан үйлдэл нь тэдэнд тодорхой хэмжээний сэтгэл санааны хохирол үүсгэсэн нь гарцаагүй тул үүнд гарцаагүй нотлох баримт шаардалгүйгээр ялгаварлан гадуурхсан үйл баримт нотлогдсон.

5. Дүгнэлт

Шүүхийн энэ шийдвэрээс харахад хариуцагч нь нэхэмжлэгчдийн “гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрх” болон хэний ч өмнө “ялгаварлан гадуурхагдахгүй байх” эрхүүдэд халдсан боловч нэхэмжлэгчид төлөх ёстой хохирлыг шүүхээс зөвхөн онгоцны зөрүү мөнгө болох 94,350 төгрөг буюу эдийн хохирлоор хязгаарлаж өгсөн нь дутагдалтай байна. Сэтгэл санааны хохирлын асуудлыг шийдвэрлэхдээ хэдийгээр шүүх хуулиа баримталсан боловч хохирогчид учирсан хохирол бүрэн төлөгдөж чадсан уу, зөрчигдсэн эрх нь эргэн сэргэсэн үү? гэдэг нь эргэлзээтэй байна.

2. Түрээсийн гэрээний үүргийн зөрчил ба сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁵⁹

Нэг. Үйл баримт

“А” ХХК болон “Б” ХХК-ийн хооронд 2013 оны 5 дугаар сарын 28-ны өдөр “Түрээсийн гэрээ” байгуулагдаж, 2013 оны 6 дугаар сарын 3-наас 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаагаар К байрыг сувиллын зориулалтаар түрээслэхээр талууд тохиролцжээ. Уг гэрээний 5.2-т “Байрыг дулаан, цахилгаан, усаар хангах асуудлыг түрээслүүлэгч тал хариуцаж, хэрэглээгээр хангагч байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллана. Гэнэтийн эвдрэл, гэмтлийг түрээслэгчийн дуудлага, захиалгын дагуу шуурхай засварлах ...” гэж заасан байна. Гэвч 2014 оны 9 дүгээр сарын 15-наас эхлэн халаалт ирэх ёстой байтал ирээгүй, ирсэн ч өвчтөн сувилуулагч хэвтэж эмчлүүлж болохоор хэмжээнд ирээгүй бөгөөд энэ талаар түрээслүүлэгч тал болох “Б” ХХК нь ч хүлээн зөвшөөрч, холбогдох “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Цаашид “ОНӨААТҮГ” гэх)-ын Зүүн түгээх төв зэрэг холбогдох байгууллагуудад халаалт сайжруулах талаарх хүсэлт, албан бичиг хүргүүлж байсан. Гэсэн хэдий ч халаалт сайжрахгүй байсаар “Б” ХХК нь санаачилгаараа 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдөр түрээсийн гэрээг цуцалж, “А” ХХК нь түрээсийн байрнаас гарсан байна. Ингээд “А” ХХК түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчсөн түрээслүүлэгч тал болох “Б” ХХК-ийн буруугаас үйл ажиллагаагаа явуулж чадаагүй хохирчхоод байхад нэмж түрээсийн төлбөр нэхэн хууль, шүүхийн байгууллагаар явуулан, олон сарын хугацаанд сэтгэл зүйн дарамтад оруулсан тул сэтгэл санааны хохирол болох 3,400,000 төгрөгийг “Б” ХХК болон дулаанаар хангах үүрэгтэй байсан “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар” (цаашид “ОСНААУГ” гэх), ОНӨААТҮГ-аас тус тус гаргуулахаар шаарджээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

Түрээсийн гэрээний үүрэг шаардсан дээрх нэхэмжлэлийг шүүхэд гаргасан гэх боловч хэрэгт авагдсан бичгийн

⁵⁹ А-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 05022 дугаартай шийдвэр.

баримтаар тогтоогдохгүй байх бөгөөд “А” ХХК-ийн захирал “Б”-гээс түрээсийн төлбөрийг хууль зүйн үндэслэлгүйгээр нэмж нэхэн хууль, шүүхийн байгууллагаар явуулж, олон сарын хугацаанд сэтгэл зүйн дарамтад оруулан, сэтгэл санааны хохирол учруулсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Түүнчлэн сэтгэл санааны хохиролд 3,400,000 төгрөг нэхэмжилсэн бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагаа нотлох үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Иймд дээрх үндэслэлүүдээр хариуцагч байгууллагуудын буруутай үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирол учруулсан гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Анхан шатны шүүхийн энэ шийдвэр нь түрээсийн гэрээний үүргийг түрээслүүлэгч тал зөрчсөний улмаас түрээслэгч тал нь эдийн бус хохирол нэхэмжлэх эрхтэй эсэхийг тодорхой болгосноороо ач холбогдолтой байна.

2. Маргааны зүйл

Уг хэргийн маргааны зүйл нь түрээсийн гэрээний үүргийн зөрчлийн улмаас хохирогч тал нь сэтгэл санааны хохирол шаардаж болох уу гэдэг асуудал байна.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Хэргийн агуулга, үйл баримтаас харахад түрээсийн гэрээг хариуцагч тал ноцтой зөрчсөн нь илэрхий байна. Түрээсийн гэрээний 2.1-д заасан “халаалтаар хангах үүрэг” нь түрээслүүлэгч буюу хариуцагчийн үүрэг байсан бөгөөд энэ нь тухайн түрээсийн байрыг зориулалтын дагуу эзэмшиж ашиглах гол нөхцөл болж байна. Түрээсийн байрыг халаалтаар хангахгүй бол тухайн түрээсийн байрыг зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох бөгөөд ингэснээр түрээсийн гэрээний үндсэн зорилт хангагдахгүй болно гэсэн үг. Түрээслүүлэгч талын энэхүү үүрэг нь түрээсийн гэрээний гол зүйлийн нэг бөгөөд түрээслүүлэгч байрыг халаалтаар хангах үүргээ биелүүлээгүй нь гэрээний үүргийн ноцтой зөрчил гэж үзэх үндэслэлтэй. Тиймээс түрээслүүлэгч тал гэрээний хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ түрээслүүлэгч нь халаалт ирүүлэхийг шаардан ОСНААУГ руу олон удаа хүсэлт, шаардлага, албан бичиг явуулж, өөрөөс хамаарах шаардлагатай бүхий л арга хэмжээ авсан байгааг харгалзан түүний хариуцлагын хэмжээг бууруулж болох юм.

Харин ОСНААУГ-ын хувьд түрээсийн барилгын халаалтыг хариуцаж буй байгууллага бөгөөд түрээслүүлэгч талтай холбогдох гэрээ байгуулсан. Хэдийгээр ОСНААУГ нь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн буруутай үйл ажиллагаанаас болоод халаалт өгч чадаагүй гэх боловч аливаа орон сууц, барилга эзэмшигч, өмчлөгчтэй дулаанаар хангах гэрээ байгуулах этгээд нь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК биш, ОСНААУГ байх тул уг байгууллага түрээслүүлэгчийн хүлээх хариуцлагыг хамтран хариуцаж болох юм.

Иймээс түрээсийн гэрээний үүрэг зөрчигдсөн, түрээсийн гэрээний үүргийн зөрчлөөс үүдэн нэхэмжлэгч гэрээнээс

татгалзсан, нэхэмжлэгч өөр байр руу нүүж орох, үйл ажиллагаа нь тасалдах гэх мэт тодорхой хохирол амссан байна. Нэхэмжлэгч эдийн хохирол шаардаж болох байсан боловч зөвхөн сэтгэл санааны хохирол шаардсан байна.

4. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Шүүх сэтгэл санааны хохирлыг “Хариуцагч нэхэмжлэгчийг хууль, шүүхийн байгууллагаар явуулан, олон сарын хугацаанд сэтгэл зүйн дарамтад оруулж, сэтгэл санааны хохирол учруулсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Түүнчлэн сэтгэл санааны хохиролд 3,400,000 төгрөг нэхэмжилсэн бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагаа нотлох үүргээ хэрэгжүүлээгүй байна” гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна.

Нэхэмжлэгч сэтгэл санааны хохирлоо шаардахдаа “түрээсийн мөнгө нэмж шаардан, шүүхийн байгууллагаар олон удаа явуулсан нь” сэтгэл санааны хохирол үүсгэсэн хэмээн шаардсан. Гэвч нэхэмжлэлийн шаардлага үүсэх болсон үндэслэл, үйл баримтаас харахад сэтгэл санааны хохирол нь түрээслүүлэгч талаас халаалтын асуудлыг шийдвэрлээгүйгээс улбаатай буюу гэрээний үүргийн зөрчилтэй шууд холбоотой байна. Иймд түрээслүүлэгч тал болон ОСНААУГ нь нэхэмжлэгчид учирсан эдийн болон эдийн бус хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй. Эдийн хохирлын хувьд түрээсийн байрнаас нүүх зардал, сувилуулагчид хүйтэн өрөөнөөс болж сувиллын гэрээгээ цуцлах, дахин үйлчлүүлэгчид ирэхгүй байх зэрэг олох ёстой байсан ашиг, орлого зэрэг эдийн хохирол учирсан байх боломжтой.

Ийм учраас өмнө дурдсанчлан нэхэмжлэгч нь өөрт учирсан эдийн бус хохирлыг хатуу “нотлох баримт”-аар нотлох

боломжгүй учир хариуцагчийн гэрээний үүргийн зөрчил нотлогдож, мөн нэхэмжлэгч өөрт нь сэтгэл санааны хохирол учирсан гэдгийг үнэмшилтэй толилуулснаар түүний сэтгэл санааны хохирол нотлогдсон гэж үзвэл зохилтой. Мөн ИХ-ийн 497.2-т заасны дагуу сэтгэл санааны хохирлыг нотлох үүргийг хариуцагч талд оногдуулах нь зүйтэй. Иймд хариуцагч нь нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирол учруулаагүй гэдгийг нотлох үүрэгтэй байх бөгөөд хэрэв нотолж чадахгүй бол сэтгэл санааны хохирлыг зохих хэмжээнд нэхэмжлэгчид төлөх учиртай.

5. Дүгнэлт

Ийнхүү түрээсийн гэрээний үүргийг түрээслүүлэгч тал ноцтой зөрчсөн, гэрээг цуцалсан хэр нь хохирлыг барагдуулалгүйгээр нэмж түрээсийн төлбөр шаардсан, нэхэмжлэгчийг түрээсийн төлбөр төлсөнгүй хэмээн шүүхэд өгснөөс харахад нэхэмжлэгчид эдийн болон эдийн бус хохирол учирсан гэж үзэхээр байх боловч шүүгч нотолгооны шаардлага хангагдаагүй гэж хэрэгсэхгүй болгосон байна. Хэдийгээр манай улсын ИХ-ийн зохицуулалтын дагуу энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх боломжгүй байгаа ч шүүгч үүнийг өөрийн шийдвэрийн үндэслэл болголгүйгээр нотолгооны шаардлагыг үндэслэлээ болгосон байгаа нь анхаарал татаж байна.

3. Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх гэрээний үүргийн зөрчил ба сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁶⁰

Нэг. Үйл баримт

2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд хариуцагч Б нь өөрийн автомашиныг жолоодож явахдаа осол аваар гаргасны улмаас иргэн В-гийн амь насыг хохироосон бөгөөд энэ хэргийг холбогдох эрүүгийн шүүхээр шийдвэрлэсэн. Энэ үед В-гийн хүү нэхэмжлэгч А нь оршуулгын зан үйл, бусад зардалд нийт 4,800,000 төгрөгийг хариуцагч Б-гээс авсан байна. Харин 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Б нь А-д сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр болгож 3,000,000 төгрөг төлөх, хэрэв хугацаандаа төлөхгүй бол 0.5 хувийн алданги төлөхөөр “хохирол төлөх баталгаа” үйлдэж, талууд гарын үсэг зуран, нотариатаар баталгаажуулжээ. Гэвч Б нь энэхүү төлбөрийг өгөхгүй байсаар А нь Б-гээс тохиролцсон 3,000,000 төгрөг, хугацаандаа төлөөгүйн алданги 2,010,000 төгрөг, нийт 5,010,000 төгрөг нэхэмжилсэн байна.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“ИХ-ийн 230 дугаар зүйлийн 230.2-т “...гагцхүц хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө...” гэж заасан хэдий ч ИХ болон бусад хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй тул мөнгөөр нөхөн төлүүлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, ИХ-д эрүүл мэнд, эд хөрөнгө, алдар хүндэд учирсан гэм хорыг арилгуулахаар заасан ч сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэл нь хуульчлагдаагүй байна.

Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нотариатчийн чиг үүргийг зохицуулсан байх бөгөөд

⁶⁰ Д.Ч-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 436 дугаартай шийдвэр.

нотариатч нь төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэхээс гадна ...үйлчлүүлэгч хүсвэл нотариатчаар гэрчлүүлэхээр хуульд зааснаас бусад үйлдэл, баримт бичгийг үл маргах шинжтэй болгох зорилгоор гэрчлэх, гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэхээр байна. Тухайн гэрчилсэн баримт бичиг хуульд нийцсэн эсэхийг шүүх тогтоохоор хуульчилсан. Нэхэмжлэгч А-гийн нэхэмжлэлийн шаардлагаа нотлохоор гаргаж өгсөн нотариатчаар гэрчлүүлсэн баримт бичгийн агуулга нь хуульд нийцээгүй байх тул шүүх үнэлэх боломжгүй байна.

Иймд Б-д холбогдуулан гаргасан гэм хорын хохирлоос үүдэлтэй сэтгэл санааны хохиролд 3,000,000 төгрөг, түүнийг хугацаанд нь төлөөгүйн алданги 2,010,000 төгрөг нийт 5,010,000 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэгч А-гийн нэхэмжлэлийг шүүх бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв”.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Анхан шатны шүүхийн 2015 оны энэ шийдвэр нь талууд сайн дураараа “Сэтгэл санааны хохирол нөхөн олгох гэрээ” байгуулсан ч ИХ-д “сэтгэл санааны хохирол”-ыг мөнгөөр нөхөн төлүүлэх тухай хуульчлаагүй учир энэ төрлийн гэрээг хууль бус гэж дүгнэсэн. Улмаар энэ гэрээний талууд сэтгэл санааны хохирол шаардах эрхгүй гэдгийг тодорхой болгожээ.

2. Маргааны зүйл

Энэ хэргийн хувьд иргэд хоорондоо сайн дурын үндсэн дээр сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээ байгуулсан бол тэрхүү гэрээний дагуу уг хохирлыг гаргуулахаар шаардах эрхтэй эсэх нь гол маргааны зүйл юм.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Гэрээ гэдэг нь хоёр ба түүнээс дээш тооны этгээдийн хооронд байгуулагдсан эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн хэлцэл бөгөөд гэрээний чөлөөт байдлын зарчмын дагуу талууд гэрээг хэнтэй байгуулах, ямар агуулгатай байгуулахыг өөрсдөө шийдвэрлэдэг. Гэхдээ хэдийгээр талууд гэрээний агуулгаа өөрсдөө шийдвэрлэх боловч тухайн гэрээ нь ИХ-ийн 56.1-д заасныг зөрчсөн тохиолдолд хүчин төгөлдөр бус болох магадлалтай. Мөн зарим гэрээний хувьд бичгээр байгуулах эсхүл нотариатаар гэрчлүүлэх гэх мэт хэлбэрийн шаардлага тавигддаг бөгөөд эдгээрийг биелүүлснээр хүчин төгөлдөр болдог.

Харин энэ хэргийн хувьд А болон Б нарын хооронд байгуулсан “Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх гэрээ” нь өөрөө хүчин төгөлдөр эсэх асуудал үүсгэсэн байна. А нь Б-гээс гэрээний үүргийн гүйцэтгэлийг шаардахын тулд түүний үндэслэл болсон гэрээ хүчин төгөлдөр байх ёстой.

Шүүх “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “...гагцхүц хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө...” гэж заасан хэдий ч Иргэний хууль болон бусад хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй тул мөнгөөр нөхөн төлцлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, Иргэний хуульд эрцл мэнд, эд хөрөнгө, алдар хүндэд учирсан гэм хорыг арилгуулахаар заасан ч сэтгэл санааны хохирол нөхөн төлцлэх эрх зүйн үндэслэл нь хуульчлагдаагүй байна” гэж дүгнэн уг гэрээг хууль бус гэж үзсэн.

Гэвч шүүгчийн энэ үндэслэл нь гэрээний чөлөөт байдлын зарчмыг гажуудуулсан буруу тайлбар болсон байна. Хэрэв хүмүүс хоорондоо “Хүн алах тухай гэрээ”-г харилцан тохиролцож байгуулсан бол энэ нь хүчин төгөлдөр бус гэрээ юм. Өөрөөр хэлбэл, энэ гэрээний үүргийг гэрээний талууд заавал

хэрэгжүүлэх хуулийн үүрэг, хариуцлага үүсэхгүй. Учир нь хүн алахыг Эрүүгийн хуулиар хориглосон. Харин “сэтгэл санааны хохирол нөхөн төлөх”-ийг хууль, тогтоомжоор хориглосон зохицуулалт байхгүй. ИХ-ийн 230.2 болон 511.1 нь диспозитив хэм хэмжээ бөгөөд эдгээр нь сэтгэл санааны хохирол нөхөн төлөхийг хориглосон заалт биш. Иргэний эрх зүйн зарчим нь диспозитив зарчим буюу “хориглосноос бусдыг зөвшөөрнө”⁶¹ гэдэг зарчим билээ.

Энэ үүднээс авч үзвэл А, Б нарын хоорондох Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээ нь хүчин төгөлдөр гэрээ мөн бөгөөд А нь Б-гээс гэрээний үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй байна.

4. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Шүүх нэг ёсондоо өмнөх шүүхийн шийдвэрүүдийн адил тусгайлсан зохицуулалт байхгүй тохиолдолд ямар ч нөхцөл байдал байсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхийг зөвшөөрөхгүй гэсэн хатуу байр суурь баримталжээ.

Энэ хэргийн хувьд нэгэнт талуудын хооронд хийсэн гэрээ нь ИХ-ийн нэрлэгдээгүй гэрээний нэг төрөл бөгөөд хүчин төгөлдөр гэрээ байна. Иймээс А нь Б-гээс гэрээний үүргийн гүйцэтгэл болгож 3,400,000 төгрөгийн хохирол шаардах эрхтэй. Энэ тохиолдолд “Хуульд тусгайлан заасан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр төлнө” гэсэн ИХ-ийн 230.2 дахь хэсэг үйлчлэхгүй. Учир нь энэ заалт нь иргэд хоорондоо сайн дураараа сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөхийг хориглосон заалт биш юм. Түүнчлэн “сэтгэл санааны хохирлыг төлөх” асуудал нь гэрээний үндсэн үүрэг болж байгаа болохоос ИХ-ийн 230.2 болох үүргийн зөрчлөөс үүсэх үр дагавар биш юм.

⁶¹ “Эрх зүйн боловсрол” академи, Ханнс-Зайделийн сан, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2018, 242 дахь тал.

5. Дүгнэлт

Эндээс үзэхэд хэргийн талууд сайн дурын үндсэн дээр гэрээний агуулгаа өөрсдөө шийдвэрлэх эрхтэй бөгөөд гэрээний чөлөөт байдлын зарчим үүнийг хамгаалдаг. Тэд энэхүү гэрээний чөлөөт байдлын зарчмын дагуу харилцан тохиролцож, сэтгэл санааны хохирол төлөхөөр гэрээ байгуулах болсон байхад шүүх тэрхүү гэрээг хүчин төгөлдөр бус гэрээ хэмээн үзэж, сэтгэл санааны хохирлыг няцаасан нь үндэслэлгүй байна. Хувийн эрх зүйд “хориглосноос бусдыг зөвшөөрнө” гэдэг зарчим үйлчлэх бөгөөд сэтгэл санааны хохирол нөхөн төлөхийг хориглосон заалт ИХ-д байхгүй учир А нь Б-гээс гэрээний үндсэн үүргийн биелэлт болгож сэтгэл санааны хохирол шаардах эрхтэй юм.

4. Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх гэрээний үүргийн зөрчил ба сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁶²

Нэг. Үйл баримт

Нэхэмжлэгч А-гийн нөхөр В нь 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр бусдад зодуулж тархиндаа хүнд гэмтэл авсан. Улмаар 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдөр ГССҮТөвд нас барсан. Харин уг гэмт хэрэгт хариуцагч Б-г яллагдагчаар татаж хуулийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явагдсан бөгөөд Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 498 дугаар шийтгэх тогтоолоор хариуцагч Б-г хүний эрүүл мэндэд санаатай хохирол учруулсны улмаас хохирогч нас барсан гэмт хэрэгт буруутайг тогтоож, зургаан жилийн хорих ял оноосон. Мөн Б-гийн үйлдсэн гэмт хэргийн улмаас нэхэмжлэгч А-гийн нөхрийн амь нас хохирч А, В нарын охин өнчирч үлдсэн. Хариуцагч Б нь 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр нэхэмжлэгч А-тай гэрээ байгуулан сэтгэл санааны хохиролд 4,000,000 төгрөг нөхөн төлөхөө илэрхийлсэн бөгөөд уг төлбөрөө төлж барагдуулаагүй байна. Иймд хариуцагч Б-гээс сэтгэл санааны хохиролд 4,000,000 төгрөг гаргуулж өгнө үү гэж шүүхэд ханджээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр

“Нэхэмжлэгч А нь хариуцагч Б-д холбогдуулж сэтгэл санааны хохиролд 4,000,000 төгрөг гаргуулахаар шүүхэд хандсан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тэрээр шаардлагынхаа үндэслэлийг “...сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээний үүрэгт 4,000,000 төгрөг гаргуулах” гэж өөрчилсөн (хх 1, 50 хуудас). Зохигчид 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр “Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээ” байгуулсан байна. Уг гэрээгээр хариуцагч Б болон түүний эхнэр В нар А-д 4,000,000 төгрөгийг 2018 оны 2 дугаар

⁶² Г.Д-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 дугаар сарын 13-ны 02559 дугаартай шийдвэр.

сараас эхлэн сард 100,000 төгрөгөөр, 40 сарын хугацаанд төлж барагдуулахаар тохирсон байна (хх 3 хуудас).

Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт заасны дагуу аливаа гэрээг байгуулж байгаа этгээдүүд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй бөгөөд талуудын хооронд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулагдсан “Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээ” нь Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх хэсэгт нийцсэн, хүчин төгөлдөр байна. Тодруулбал, дээр дурдсан гэрээний гол нөхцөлийг буюу “...сэтгэл санааны хохиролд 4,000,000 төгрөг төлөх”-ийг хариуцагч Б хүлээн зөвшөөрч гарын үсгээ зурсан нь дээр дурдсан хуулийн заалтуудтай харшлаагүй.

Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1 дэх хэсэгт зааснаар үүрэг гүйцэтгэгч нь хүлээсэн үүргээ тогтоосон газар, хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгэх ёстой. Хэрэгт цугларсан баримтууд болон зохигчийн тайлбаруудаас үзэхэд Б нь 4,000,000 төгрөгийг А-д төлсөн нь нотлогдохгүй байх тул нэхэмжлэгч мөн хуулийн 186 дугаар зүйлийн 186.1 дэх хэсэгт заасны дагуу гэрээний үүргийг хариуцагчаас шаардах эрхтэй байна. Иймд шүүхээс А-гийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэв. Иргэний хуулийн 186 дугаар зүйлийн 186.1, 206 дугаар зүйлийн 206.1 дэх хэсгүүдэд заасныг баримтлан хариуцагч Б-гээс 4,000,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч А-д олгосугай”.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

2018 онд гарсан анхан шатны шүүхийн энэхүү шийдвэр нь өмнөх шийдвэрээс эсрэг шийдвэр гаргасан. Талууд сайн дураараа “Сэтгэл санааны хохирлыг нөхөн олгох гэрээ”

байгуулсан бол гэрээний дагуу сэтгэл санааны хохирлыг шаардах эрхтэй гэдгийг тогтоосон. Шүүх энэ тохиолдолд гэрээний чөлөөт байдлын зарчим баримтлан, сэтгэл санааны хохирол төлөх гэрээ нь хүчин төгөлдөр учир хариуцагч ИХ-ийн 186.1, 206.1-д заасны дагуу сэтгэл санааны хохирол төлөх гэрээний үүргийг биелүүлэх ёстой гэж үзсэн.

2. Маргааны зүйл

Энэ хэргийн хувьд иргэд хоорондоо сайн дурын үндсэн дээр сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээ байгуулсан бол тэрхүү гэрээний дагуу уг хохирлыг гаргуулахаар шаардах эрхтэй эсэх нь гол маргааны зүйл юм.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Энэ хэргийн хувьд маргааны гол зүйл нь өмнөх шүүхийн шийдвэртэй адилхан боловч дүгнэлт нь эсрэгээрээ байна. Шүүгч “Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт заасны дагуу аливаа гэрээ байгуулж байгаа этгээдүүд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй бөгөөд талуудын хооронд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулагдсан “Сэтгэл санааны хохирол нөхөн төлөх тухай гэрээ” нь ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх хэсэгт нийцсэн, хүчин төгөлдөр байна” гэж тайлбарласан нь гэрээний чөлөөт байдлын зарчмыг зөв тайлбарласан үндэслэл болжээ.

4. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Гэрээ хүчин төгөлдөр тул гэрээний үүргийг биелүүлэх шаардлага үүснэ. Шүүгч үүнийг “Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1 дэх хэсэгт зааснаар үүрэг гүйцэтгэгч нь хүлээсэн үүргээ тогтоосон газар, хугацаанд нь зохих ёсоор

гүйцэтгэх ёстой. Хэрэгт цугларсан баримтууд болон зохигчийн тайлбаруудаас үзэхэд Б нь 4,000,000 төгрөг Б-д төлсөн нь нотлогдохгүй байх тул нэхэмжлэгч мөн хуулийн 186 дугаар зүйлийн 186.1 дэх хэсэгт заасны дагуу гэрээний үүргийг хариуцагчаас шаардах эрхтэй байна” гэж дүгнэсэн нь зөв болжээ.

5. Дүгнэлт

2018 оны шүүхийн энэхүү шийдвэр нь өмнөх 2015 оны шүүхийн шийдвэртэй яг ижил маргааныг өөрөөр шийдвэрлэсэн байна. Энэ шийдвэрээр шүүгч гэрээний чөлөөт байдлын зарчмыг зөв тайлбарлан, гэрээний үүргийг заавал биелүүлэх зарчмыг баталгаажуулж, хохирогчийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн нь цаашид жишиг болохуйц сайн шийдвэр болжээ.

3.4. ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААН ДАХЬ СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

Энэ хэсэгт хөдөлмөрийн харилцаа үндэслэлгүйгээр цуцлагдсан буюу ажилтан үндэслэлгүйгээр халагдсантай холбоотойгоор үүссэн сэтгэл санааны хохирол шаардсан шүүхийн шийдвэрийг шинжлэн судална.

1. Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас үүсэх сэтгэл санааны хохирлыг шийдсэн хэрэг⁶³

⁶³ Төв аймгийн ИТХ-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 151 дүгээр шийдвэр.

Нэг. Үйл баримт

Хариуцагч Б нь Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд ажиллаж буй нэхэмжлэгч А-г үндэслэлгүйгээр ажлаас халсан болохыг тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр нь 2017 оны 11 дүгээр сарын 20-нд гарснаас хойш Б нь шүүхийн шийдвэрийг эс биелүүлж, А-г ажилд эгүүлэн томилоогүй байна. Үүнээс хойш 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдөр буюу ажлын нийт 122 хоногийн дараа А-г урьд эрхэлж байсан албан тушаал болох Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд эгүүлэн томилсон боловч 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Б нь А-гийн албан тушаалыг бууруулж, ИТХ-ын Ажлын албаны шашин, соёл, эрүүл мэндийн бодлого хариуцсан ажилтнаар томилсон байна. А-гийн албан тушаалыг бууруулсан Б-гийн энэхүү шийдвэрийг шүүхээс илт хууль бус буюу үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн байна.

Тиймээс А нь шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш олгогдох ёстой байсан цалин хөлс болох 8,667,533, эрх зүйн өмгөөллийн үйлчилгээний хөлс 1,500,000, сэтгэл санааны хохирол 20,000,000 төгрөг тус тус, нийт 30,167,533 төгрөгийг Б-гээс гаргуулахаар нэхэмжилжээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх нь нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шүүх нь “Ажилгүй байсан хугацааны цалин хөлс нөхөн төлүүлэх тухайд А-гийн хөдөлмөрлөх болон түүнд тохирсон цалин хөлс авах эрхийг зөрчсөн байх учир нийт ажилгүй байсан өдөрт нь тооцож, Б-гээс ойролцоогоор 10,400,000 төгрөг гаргуулах”-аар шийдвэрлэсэн байна.

Шүүх “Өмгөөлөгчийн хөлс нөхөн төлүүлэх тухайд А нь өмгөөллийн төлбөрийг хэнээс хэнд, хэрхэн төлсөн талаарх нотлох баримтыг шүүхэд ирүүлээгүй, шаардлагаа нотлох үүргээ хэрэгжүүлээгүй байх тул өмгөөлөгчийн хөлсийг Б-гээс нөхөн төлүүлэх үндэслэлгүй” гэж шийдвэрлэсэн байна.

Шүүх “сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх тухайд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1 дэх хэсэгт хохирогч нь эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардлага гаргах эрхтэй бөгөөд 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан байгаа нь А-гийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр шаардсан нь энэ үндэслэлд хамаарахгүй буюу хуульд тусгайлан заасан гэж үзэхгүй. Харин Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхгүй)-ээр гэм хор учруулсан этгээдээс уг гэм хорыг шаардах эрхтэй” гэж зааснаар шаардлага гаргах эрхтэй” гэж дүгнэсэн байна.

“А нь ажилгүй 2 жил 4 сарын хугацаанд даралт ихэсдэг болсон, ажлаас халагдсан өдөр олгойн хагалгаанд орсон, турсан зэргээр сэтгэл санааны хувьд хохирсон гэж уг хохиролд 20,000,000 төгрөг нэхэмжилсэн боловч Б-гийн хууль бус шийдвэрийн улмаас өөрт учирсан гэм хорын хэмжээ, шалтгаант холбоо, түүнийг нотлох баримтыг шүүхэд гаргах, шүүх хуралдааны цээр мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэн нотлох үүрэгтэй хэдий ч өөрийн сэтгэл санаанд учирсан хохирлыг хэрхэн, ямар аргачлалаар тогтоосон, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад хандсан эсэх, ямар өвчин, зовуурь бий болсон зэргээр тайлбараа нотлох баримтыг шүүхэд ирүүлээгүй байна. Харин сэтгэл санааны хохирлыг үнэлүүлэхээр хөрөнгийн үнэлгээний “Хан үнэлэмж” ХХК-ийг шинжээчээр томилуулахаар гаргасан хүсэлтдээ хэнд (бие, эрүүл мэнд, сэтгэл зүй), юунд (эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад хандаж үзүүлсэн, үйлчлүүлсэн бичиг баримт болон бусад) шинжилгээ хийлгэх шаардлагатай байгаа, шинжээч нь сэтгэл санаанд учирсан хохирлыг үнэлэх

тусгай мэдлэг ур чадвар, аргачлал эзэмшсэн эсэх, тусгай зөвшөөрөлтэй эсэхийг тодорхойлоогүй, нотлоогүй учир шүүх хэцээлтэйг хангахгүй орхисон байна.

Иймд А-гийн сэтгэл санааны хохиролд 20,000,000 төгрөг нөхөн төлүүлэх шаардлагаа нотлох үүргээ хэрэгжүүлээгүй тул энэ шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй” гэж шүүх дүгнэсэн байна.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Анхан шатны шүүхийн энэхүү шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтан ажил олгогчоос сэтгэл санааны хохирол нэхэмжлэх эрхтэй эсэхийг шийдвэрлэсэн бөгөөд шүүх энэ тохиолдолд нэхэмжлэгчийг сэтгэл санааны хохирлоо шаардах эрхгүй гэж үзсэн.

2. Хохирол нөхөн төлүүлэх үндэслэл бий болсон эсэх

Энэ хэргийн хувьд хоёр удаагийн шүүх хурлаар хариуцагч байгууллага нь нэхэмжлэгч А-г хууль бусаар ажлаас халсан болох нь тогтоогдсон байна. Ажилтныг ажлаас хууль бусаар халах нь ажилтны хөдөлмөрлөх эрх, цалин хөлс авах эрх, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хууль ёсоор ажлаас чөлөөлөгдөх эрхийг зөрчдөг. Эдгээр эрх нь ИХ-ийн 497.1-д заасан “бусад эрх”-д хамаарах учир хариуцагч нь нэхэмжлэгчид учирсан хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй юм.

3. Эдийн бус хохирол төлүүлэх үндэслэлтэй эсэх

Шүүх нь нэхэмжлэгчид учирсан хохирлыг тооцохдоо ажилгүй байсан үеийн цалин хөлсөөр хязгаарлажээ. Бусад

эдийн хохирлыг нотлох баримт байхгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон бол сэтгэл санааны хохирлын хувьд “хуульд тусгайлан заагаагүй” гэж хэрэгсэхгүй болгосон.

Энэ нь мөн л ажлаас үндэслэлгүй халагдсан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлнө гэсэн тусгайлсан хуулийн зүйл, заалт байх ёстойг дахин сануулж байна.

4. Дүгнэлт

Эндээс үзэхэд ИХ-ийн 230.2-т заасны дагуу сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх нь тусгайлсан зохицуулалт шаардаж байгаа гэдгийг шүүгч тайлбараараа дахин батлан харуулжээ. Гэсэн хэдий ч энэ нь ажилтныг ажлаас үндэслэлгүй халснаар ажилтанд сэтгэл санааны хохирол үүсдэггүй гэсэн үг биш. Аливаа хууль бус үйлдлийн улмаас их, бага хэмжээгээр сэтгэл санааны хохирол үүсдэг бөгөөд ажил олгогч ажилтныг хууль бусаар халсан тохиолдлын хувьд ажил олгогчийн гэм буруугийн хэлбэр, хэмжээ, хууль бусаар халсан үйлдлийн шалтгаан, сэдэл зэрэг олон нөхцөлийг харгалзан үзэхэд ноцтой гэм буруугийн шинжтэй, нийгэмд хор уршигтай, ажилтны санхүүгийн болон хувийн нөхцөл байдалд ноцтой хохирол учруулсан шинжтэй бол сэтгэл санааны хохирлыг зохих ёсоор барагдуулах нь зөв бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.4-т заасан хүний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх, түүнд тохирсон цалин хөлс авах, хохирлыг барагдуулах үндсэн зарчимд нийцнэ.

Мөн ажил олгогч ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халсан энэ хэргийн хувьд ажил олгогч нь илт хууль зөрчиж ажилтныг хууль бусаар халсан, хууль бусаар албан тушаал бууруулсан, түүнчлэн ажилтныг урьд эрхэлж байсан ажилд нь эгүүлэн тогтоохыг даалгасан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байхад түүнийг биелүүлэлгүй 122 хоног буюу дөрвөн сарын дараа ажилд нь эгүүлэн томилсон, ажилд нь эгүүлэн

томилсноос хойш 22 хоногийн дараа албан тушаал бууруулан өөр ажилд шилжүүлсэн бөгөөд шүүх ажил олгогчийн энэ үйлдлийг хууль бус болохыг дахин тогтоосон шийдвэр гаргасан байдаг. Ингэж ажил олгогчийн санаатай гэм буруутай удаа дараагийн үйлдэл, шүүхийн шийдвэрийг үл ойшоосон байдал нь хохирогчид төдийгүй нийтийн эрх ашигт хор уршигтай, гэм буруугийн ноцтой хэлбэр мөн.

Иймд энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн олгохгүй байх нь ажил олгогчдын ажилтныг хууль бусаар халдаг хууль зөрчсөн үйлдэл болон шүүхийн шийдвэрийг эс биелүүлдэг хууль бус үйлдлийг өөгшүүлсэн, хохирогчийн эрхийг бүрэн сэргээж чадахгүй байх муу үр нөлөөтэй гэж үзэж болно.

3.5. ДҮРСИЙН ЭРХИЙГ ЗӨРЧСӨНӨӨС ҮҮСЭХ СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛ

1. Дүрсийн эрхийн зөрчилтэй холбоотойгоор үүссэн сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэсэн хэрэг⁶⁴

Нэг. Үйл баримт

2014 оны 11 дүгээр сард нэхэмжлэгч А-гийн охин В-г найз залуу нь гэртээ дуудаж ирүүлэн бэлгийн харилцаанд орсон бөгөөд В-гийн найз залуу болон түүний найз нь уг үйлдлийг гар утсаараа бичлэг хийхээр урьдаас төлөвлөж, гар утсаа юмны ард нуун бэлдсэн байсан бөгөөд 2015 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн тэр бичлэг тараагдаж эхэлсэн.

⁶⁴ А-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 00002 дугаар шийдвэр.

Улмаар нэхэмжлэгч А-гийн охин В амиа хорлох оролдлого хийж, шуун дээрээ зүссэн байсан ба “Сургуулийн коридороор явуулахаа болилоо, намайг жирэмсэн болсон гэх зэргээр сургуулийн хүүхдүүд болон Facebook-ээр доромжлоод байна” гэх болсон. Улмаар В хичээлдээ явахаа больсон боловч сургуулиас нь өөр газарт хүртэл түүнийг “порно од явж байна” гэдэг байсан. Ингээд В гэрээсээ гарах, найзуудтайгаа уулзахаа больж, сүүлдээ орондоо шээдэг болсон. Аймгийн цагдаагийн газарт гомдол гаргаж, мөн аймгийн хүүхдийн эрхийг хамгаалах төвд хандахад хамгийн түрүүнд хүүхдийнхээ орчныг соль гэж зөвлөсөн. Улаанбаатар хотод хоёр удаа сэтгэлзүйн эмчид үзүүлсэн. Цаашид аймагтаа сурах ямар ч боломж байгаагүй учраас В-г Улаанбаатар хот руу шилжүүлсэн.

Иймд нэхэмжлэгч А-гийн охины нэр хүндэд учирсан гэм хорын хохиролд 20,000,000, сэтгэл санаанд учирсан гэм хорын хохиролд 20,000,000, сургалтын төлбөрт 20,680,000, бусад зардалд 5,500,000, замын зардал болон бусад зардалд 4,000,000, өмгөөлөгчийн хөлсөнд 900,000, бясалгалын дээд курсийн төлбөрт 300,000, энергийн засалд 100,000, рейки бясалгалын төлбөрт 200,000 төгрөг тус тус, нийт 5,500,000 төгрөгөөс татгалзаж, эмчилгээний зардал болох 88,500 төгрөг, нийт 165,680,000 төгрөг нэхэмжилж байна гэжээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“Дээрх нөхцөл байдлаас дүгнэлт хийхэд Монгол Улсын Үндсэн хууль болон Хувь хүний нууцын тухай хуульд заасан эрхийг зөрчиж, В-гийн найз залуутайгаа бэлгийн харилцаанд орсон бичлэгийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр олон нийтэд үзүүлснээр түүний нэр төр, алдар хүндийг гутааж, тэрээр аймгийнхаа сургуульд суралцах боломжгүй болж, өөр орон нутагт шилжсэн, мөн байнгын айдас түүшүүртэй, сэтгэл гутралтай, өөрийгөө хянах чадвар суларсан болох нь дээрх шинжээчийн дүгнэлт болон шилжиж очсон сургуулийнх нь тодорхойлолтоор нотлогдож байна.

Иргэний хуулийн 6 дугаар зүйлд зөвхөн мөнгөөр үнэлж болох эдийн бус баялаг Иргэний эрх зүйн харилцааны объект болохыг тодорхойлсон байх бөгөөд иргэн хүний хуулиар

тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ, дүрс, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрцүл мэндэд гэм хор учруулсан тохиолдолд хохирлыг мөнгөөр нөхөн төлж болохыг Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 511 дүгээр зүйлийн 511.1, 511.2-т тусгайлан заасан байх тул бичлэг хийж тараасан арга хэрэгсэл, тархсан хүрээ, В-гийн нэр төр, алдар хүндэд учирсан үр дагавар зэргийг харгалзан хариуцагчдаас 9,000,000 төгрөг, мөн эрцүл мэндэд учирсан гэм хор буюу эм хангамжийн компаниас авсан эм, тарианы зардал 88,500 төгрөг, нийт 9,088,500 төгрөгийг хариуцагчдаас хувь тэнцүүлэн нөхөн төлүүлэх үндэслэлтэй байна.

Сэтгэл санаанд учирсан гэм хорын хохиролд 20,000,000 төгрөг нөхөн төлүүлэх шаардлагын тухайд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-д “эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй” боловч мөн хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүц хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан байна. Гэтэл Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд “сэтгэл санааны хохирол”-ыг арилгах асуудлыг зохицуулаагүй тул энэ талаар гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй. Нэхэмжлэлийн шаардлагын үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна”.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Энэхүү шийдвэр нь бусдын хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр тараах, хүний дүрсийн эрхийг зөрчсөн тохиолдолд сэтгэл санааны хохирол нөхөн төлөх үү гэдэг асуудлыг хөндсөн бөгөөд шүүх энэ тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн арилгах

үүрэгтэй боловч сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөхгүй гэж шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, эдийн бус хохирол болон сэтгэл санааны хохирлыг ялгаатай байдлаар тайлбарлан дүгнэсэн нь онцлог байв.

Мөн хүний “дүрсийн эрх”-ийн зөрчил гэдэг талаас бус, хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан гэдэг үндэслэлээр эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

2. Маргааны зүйл

Уг хэргийн хувьд хүний “дүрсийн эрх”-ийг зөрчих нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болох эсэх нь маргааны зүйл болжээ.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар “Хувь хүний нууц гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ”. Иймд хариуцагчид нь нэхэмжлэгчийн охины дүрсийн эрх болон хувь хүний нууцын эрхийг зөрчсөн. Хувь хүний дүрс нь түүнийг хэн болохынх нь хувьд хэлбэр талаас нь тодорхойлж байдаг бөгөөд гутаах зорилго агуулаагүй байсан ч иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр дүрслэн нийтэд тараасны улмаас түүнд гэм хор учрахаас иргэний эрх зүй хамгаалж байдаг⁶⁵.

Харин ИХ-ийн 21.5-д “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд

⁶⁵ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2015, 96 дахь тал.

үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй” гэж хуульчилсан.

Иймээс хариуцагч нь нэхэмжлэгчийн охиныг найз залуутайгаа бэлгийн харилцаанд орсон бичлэгийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр олон нийтэд үзүүлснээр нэхэмжлэгчийн охины дүрсийн эрхийг зөрчсөн байна.

Харин шүүх энэ тохиолдолд нэхэмжлэгчийн дээр дурдсан дүрсийн эрх зөрчигдсэн гэж зөв дүгнэсэн боловч ИХ-ийн 511 дүгээр зүйлийн дагуух нэхэмжлэгчийн нэр төр, алдар хүнд гутаагдсан гэж дүгнэсэн нь эргэлзээ төрүүлж байна.

Учир нь ИХ-ийн 511 нь зөвхөн иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдлыг зохицуулсан байдаг⁶⁶. Өөрөөр хэлбэл, худал мэдээ тараасан этгээд түүнийгээ нотолж чадахгүй бол хохирогчид эдийн бус хохирлыг нь 511-р зүйлийн дагуу төлөх үүрэгтэй. Гэвч уг хэргийн хувьд охины бичлэгийг нууцаар хийсэн, бичлэгийг нь тараасан үйлдэл нь худал мэдээ, мэдээлэл тараасан гэх үйлдэлтэй нийцэхгүй. Нэг ёсондоо ИХ-ийн 511-р зүйлд үндэслэн хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй байна.

Харин нэхэмжлэгчийн охины дүрсийн эрх болон нууцын эрх нь ИХ-ийн 497.1 дэх “бусад эрх”-д хамаарах тул эдгээр эрхийг зөрчсөн гэдэг үндэслэлээр хариуцагчаас хохирлоо шаардах үндэслэлтэй юм.

4. Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Уг хэргийн хувьд шүүхээс нэхэмжлэгчийн нэр төр, алдар хүндэд учирсан хохирол гэж ИХ-ийн 511.1-д заасныг

⁶⁶ Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 дүгээр тогтоолд “нэр төр” гэж тухайн хүний хувийн болон ёс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшний талаар бусдаас өгч буй үнэлэмжийг, “алдар хүнд” гэдэгт бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмжийг ойлгоно гэжээ.

баримтлан 9,000,000 төгрөг гаргуулахаар болсон. Харин “сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага”-ыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ “Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд “сэтгэл санааны хохирол”-ыг арилгах асуудлыг зохицуулаагүй тул энэ талаар гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй байна” гэсэн.

Эндээс үзэхэд нэгдүгээрт, шүүх нь эдийн бус хохирол болон сэтгэл санааны хохирлыг ялгаатай ойлголтууд буюу өөр өөр хохирлын төрөл гэж ойлгож байна. Манай улсад сэтгэл санааны хохирлыг сэтгэл санааны шаналал, зүдгүүр хэмээн тодорхойлдог. Энэ нь сэтгэл санааны хохирлыг явцуу байдлаар тайлбарлаж байгаа хэрэг юм. Харин сэтгэл санааны хохирлыг өргөн хүрээнд тайлбарлан авч үзвэл энэ нь эдийн хохирлоос бусад бүх төрлийн эдийн бус хохирлын тухай ойлголт юм. Тиймээс энэ шийдвэр дэх “эдийн бус хохирлыг шаардах эрхтэй боловч сэтгэл санааны хохирлыг шаардах эрхгүй байна” гэдэг тайлбар нь эдийн бус хохирлын үндсэн агуулга, шинж чанарт үл нийцсэн тайлбар болжээ. Бид сэтгэл санааны хохирол гэдэг нэр томъёог зөвхөн сэтгэл санааны шаналал, зүдгүүрээр хязгаарлахгүйгээр, эдийн бус хохирол гэдэг өргөн утгаар хэрэглэж хэвших нь зүйтэй.

Хоёрдугаарт, уг хэргийн хувьд хохирогчийн дүрсийн эрх болон хувийн нууцын эрх зөрчигдсөн тул хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээж, түүнд учирсан хохирлыг бүрэн барагдуулах нь зүйд нийцнэ. Гэвч ИХ-ийн 230.2-т заасны дагуу эдгээр тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тусгайлсан заалт байхгүй тул дүрсийн эрх, нууцын эрхийн зөрчилд сэтгэл санааны хохирол гаргах боломжгүй.

Шүүх хэдийгээр ИХ-ийн 511.1-ийн дагуу нэр төр, алдар хүндэд халдсаны эдийн бус хохирол гэж 9,000,000 төгрөг гаргуулсан боловч үүнийг хохирогчийн дүрсийн эрх, хувь хүний нууцын эрхийн зөрчилд олгосон хохирол гэж хэлэхэд хэцүү

байна. Хэдийгээр дүрсийн эрх, хувийн нууцын эрхийн зөрчилд 511.1-д заасныг төсөөтэй хэрэглэсэн байхыг үгүйсгэхгүй ч анхнаасаа “эдийн бус хохирол” болон “сэтгэл санааны хохирол” хоёрыг хохирлын ялгаатай төрөл гэсэн ухагдахуунаар энэ хохирлыг зөвшөөрсөн шүүгч шийдвэрээ гаргасан. Тиймээс шүүхийн зүгээс дүрсийн эрх болон хувь хүний нууцын эрхийн зөрчилд эдийн бус хохирол гаргуулахгүй гэсэн байр суурьтай байна гэж хэлж болно.

5. Дүгнэлт

Ийнхүү шүүхээс ИХ-ийн 230.2-т заасны дагуу дүрсийн эрх, хувь хүний нууцын эрх зөрчсөн тохиолдолд сэтгэл санааны буюу эдийн бус хохирлыг шаардах боломжгүй гэж үзсэн нь хуульд нийцсэн тул буруутгах боломжгүй.

Гэвч ингэж шийдвэрлэх нь шударга бус байдлыг бий болгож байна. Өмнө нь дурдсанчлан зөвхөн эдийн бус хохирлыг бий болгодог хэргүүд гэж байдаг бөгөөд дүрсийн эрх, нууцын эрхийн зөрчлүүд нь эдийн хохирлоос илүү эдийн бус хохирол үүсгэн бий болгодог зөрчлүүд юм. Ийм ч учраас энэ тохиолдолд хохирогчийн эдийн бус хохирол буюу сэтгэл санаанд учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал нь зүй ёсонд нийцнэ. Иймд гэм хор учруулагч этгээд эдийн хохирлыг нөхөн төлсөн эсэхээс үл хамааран хохирогчийн сэтгэл санаанд учирсан гэм хорыг давхар арилгах үүрэг хүлээнэ. Энэ нь цаашид эдийн бус хохирол болон сэтгэл санааны хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх эрх зүйн шинэчлэл шаардлагатай болсныг харуулж байна.

3.6. ХУУЛЬ БУСААР ЦАГДАН ХОРИХ, ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХЭРЭГ

1. Сэтгэл санааны хохирлыг үнэлсэн үнэлгээний компанийн үнэлгээг нотлох баримт гэж үзэх боломжгүй гэж үзэн, хохирол нэхэмжилснийг хэрэгсэхгүй болгосон хэрэг.⁶⁷

Нэг. Үйл баримт

Нэхэмжлэгч А нь Хөтөлийн “Цемент-Шохой” ХК-д 1987 онд анх ажилд орж, 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга буюу Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан бөгөөд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсээс түүнийг 2013 оны 8 дугаар сард Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэг, 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэг, 166¹ зүйлийн 166¹ 3 дахь хэсэг, 265 дугаар зүйлийн 265.2 дахь хэсэг, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт тус тус сэжигтнээр тооцон эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн.

Улмаар Сум дундын 20 дугаар шүүхийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 106 дугаар шийтгэх тогтоолоор аж ахуйн нэгжийн албан тушаалтан хувьдаа болон бусдад давуу байдал тогтоон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас Хөтөлийн “Цемент-Шохой” ХК-д онц их хэмжээний буюу 60 сая төгрөгийн хохирол учруулсан гэм буруутайд тооцож, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хоёр жилийн хугацаагаар хасаж, 3 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэж, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн тогтоолоор дээрх шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан. Улмаар Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 93-А дугаартай тогтоолоор эцэслэн шийдвэрлэж хэргийг хэрэгсэхгүй болгосон.

⁶⁷ “ИЭ” ХХК-д холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 0228 дугаартай шийдвэр.

Энэ хугацаанд А-г Хөтөлийн “Цемент-Шохой” ТӨХК-ийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалаас түдгэлзүүлж, 138 хоног цагдан хорьсон. Мөн А-г гэмт хэрэгт шалгагдаж байх хугацаанд түүний төрсөн эцэг нас барсан байдаг.

Иймд сэтгэл санааны хохирлынхоо нөхөн төлбөрийн үнэлгээг А нь мэргэжлийн үнэлгээний байгууллага болох “ИЭ” ХХК-иар гаргуулсан бөгөөд уг хохирлын үнэлгээг 16,082,800 төгрөг хэмээн тодорхойлжээ. Мөн хууль бусаар хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцон нийт 138 хоног хоригдсоны хохирол 26,496,000 төгрөг, албан тушаалаас түдгэлзүүлсэн өдрөөс эхлэн Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 93-А дугаартай тогтоолоор цагаатгах хүртэлх 2 жил, 2 сар, 22 хоног ажилгүй байсан хугацаанд авах байсан цалин (нэг сарын үндсэн цалин 2,891,000 төгрөг)-д нийтдээ 77,286,066, өмгөөлөгчид төлсөн хөлс 30,000,000 төгрөг тус тус, иймд өмнө нь нэхэмжилсэн эд хөрөнгийн хохирол 133,782,066 төгрөг дээр сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрт 16,082,800 төгрөгийг нэмэн нийт 149,864,866 төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар нэхэмжилж байна гэжээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“Нэхэмжлэгч А-д холбогдох эрцүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан шийтгэх тогтоол гарч хүчин төгөлдөр болсон байх тул Эрцүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.2.2-т “Тухайн иргэнийг цагаатгасан шүцхийн тогтоол гарсан тохиолдолд хохирол нөхөн төлүцлэх эрх үцснэ” гэж зааснаар учирсан хохирлоо нөхөн төлүцлэх эрх үцссэн гэж үзэж, өөрт учирсан эдийн болон эдийн бус хохирлыг арилгуулахаар шаардсан нь үндэслэлтэй.

Гэвч нэхэмжлэгч А нь эд хөрөнгийн бус хохиролд хууль бусаар цагдан хоригдсон 138 хоногийг тухайн үед мөрдөгдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 192,000 төгрөгөөр тооцон 26,496,000 төгрөг, сэтгэл санааны хохирол 16,083,800 төгрөгийг тус тус нэхэмжилснийг хангах

үндэслэлгүй гэж үзлээ. Учир нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-д “Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө”, Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан боловч цагдан хоригдсон хоног тутамд нөхөн төлбөр төлөх, сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх зохицуулалтыг Иргэний хуульд тусгайлан заагаагүй тул Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос тогтоосон хүний амь насны суурь үнийг үндэслэл болгож гаргасан “ИЭ” ХХК-ийн сэтгэл санааны хохирлын үнэлгээний тайланг нотлох баримтаар үнэлэх боломжгүй юм.

Нэхэмжлэгчийн хүсэлтээр түүний гаргаж өгсөн баримтуудад тулгуурлан түүний сэтгэл санааны хохирлыг тогтоосон шинжээчийн дүгнэлтийг хуульд тусгайлан заасан журмын дагуу тогтоосон үнэн зөв, эргэлзээгүй нотлох баримт гэж үзэх үндэслэлгүй. Дээрх “ИЭ” ХХК-ийн сэтгэл санааны хохирлыг үнэлсэн үнэлгээний тайланд нэхэмжлэгч А сэтгэл санааны хүнд дарамтад орсон, холбогдсон гэмт хэргийн талаар сонин сэтгүүл, цахим ертөнцөөр мэдээлэгдсэнээс харилцагчид, найз нөхдийн хүрээнд өөрчлөлт, хөдөлгөөн гарч алдар хүндэд ихээхэн хохирол учруулсан, 830 хоногийн турш хилсээр буруутан болж явж, эрүүл мэндээрээ хохирсон сэтгэл санааны сөрөг үр дагаврууд учирсан гэж дүгнэсэн боловч нэхэмжлэгч А нь сэтгэл санаа, биеийн эрүүл мэндийн өөрчлөлтийн улмаас эмнэлгийн байгууллагад хандаж эмчлүүлсэн эсэх, холбогдсон гэмт хэргийн талаар сонин сэтгүүл, цахим ертөнцөд хэдэн удаагийн давтамжтай мэдээлэл түүгээж, хэчнээн хүнд тарсан эсэх зэрэг байдлыг тогтоосон нь тодорхойгүй байх бөгөөд бусад нотлох баримтыг үнэлж үзэхэд нэхэмжлэгч А-д эдийн бус хохирол буюу сэтгэл санааны үр дагаврын улмаас хэчнээн хэмжээний хохирол учирсан нь тогтоогдохгүй байна.

Иймд дээр дурдсан үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагаас хууль бус ажиллагааны улмаас Иргэний аваагүй дундаж цалин хөлсний хохиролд 42,073,720 төгрөг, хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсөнд 22,500,000 төгрөг, нийт 64,573,720 төгрөгийн шаардлагыг хангаж нэхэмжлэгч А-д олгон, үлдсэн 85,291,146 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв”.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн ихэнх шүүхийн шийдвэрт “Нэхэмжлэгч нь өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо гэж үнэлж нэхэмжилж байгаа боловч нэхэмжлэгчид түүний нэхэмжилж буй хэмжээгээр сэтгэл санааны хохирол учирсан гэж нотлох баримт байхгүй байна. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй” гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгодог. Харин энэхүү шүүхийн шийдвэр нь нэхэмжлэгч өөрийн сэтгэл санааны хохирлыг өөрөө үнэлж нэхэмжилсэн биш, мэргэжлийн үнэлгээний компаниар сэтгэл санааны хохирлоо үнэлүүлж, нэхэмжилсэн гэдгээрээ онцлогтой. Өөрөөр хэлбэл, ихэнх шүүхийн шийдвэрт дурдагдсан, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох гол үндэслэлийг няцаах баримт бүрдүүлсэн бөгөөд шүүх энэ хэрэгт хэрхэн дүгнэлт хийсэн нь цаашдын шүүхийн практикт өндөр ач холбогдолтой.

2. Маргааны зүйл

Эдийн бус гэм хор учирсан болохыг хэрхэн нотлох, энэ талаарх үнэлгээний компанийн дүгнэлтийг нотлох баримтаар тооцох эсэх нь уг хэргийн гол маргааны зүйл болжээ.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Энэ тохиолдолд нэхэмжлэгч А нь 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн аж ахуйн нэгжийн албан тушаалтан хувьдаа болон бусдад давуу байдал тогтоон, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан хэрэгт шалгагдаж эхэлсэн бөгөөд улмаар шүүхээс нэхэмжлэгчийг гэм буруутайд тооцож, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг нь хоёр жилийн хугацаагаар хасаж, 3 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгүүлж байжээ. 2015 оны 12 дугаар сарын 8-ны өдөр шүүх тус хэргийг дахин шийдвэрлэж, хэргийг хэрэгсэхгүй болгон, нэхэмжлэгчийг цагаатгасан. Мөн А-г гэмт хэрэгт шалгагдаж байх хугацаанд түүний төрсөн эцэг нас барсан байдаг. Энэ хугацаанд нэхэмжлэгч А-г 138 хоног цагдан хорьсон.

Тухайн үед хэрэгжиж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.2.2-т “Тухайн иргэнийг цагаатгасан шүүхийн тогтоол гарсан тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх эрх үүснэ” гэж зааснаар нэхэмжлэгч нь өөрт учирсан эдийн болон эдийн бус хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй бөгөөд шүүх энэ талаар үндэслэлтэй дүгнэжээ.

4. Эдийн бус хохирол нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Шүүх “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391.1, Иргэний хуулийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан боловч цагдан хоригдсон хоног тутамд нөхөн төлбөр төлөх, сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх зохицуулалтыг Иргэний хуульд тусгайлан заагаагүй тул Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос тогтоосон хүний амь насны суурь үнийг үндэслэл болгож гаргасан “Итгэлт-эстимэйт” ХХК-ийн сэтгэл санааны хохирлын үнэлгээний тайланг нотлох баримтаар үнэлэх боломжгүй юм” гэж дурджээ. Өөрөөр хэлбэл, хэдийгээр Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд эдийн бус хохирол

гаргуулах талаар зохицуулсан боловч түүнийг хэрхэн үнэлж, тогтоох тухай журам нь ИХ-иар зохицуулагдах ёстой атал тийн нарийвчлан заагаагүй учир “Итгэлт-эстимэйт” ХХК-ийн сэтгэл санааны хохирлын үнэлгээний тайланг нотлох баримтаар үнэлэх боломжгүй гэж үзсэн байна. Шүүхийн хувьд хууль бусаар цагдан хоригдсон тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр хэрхэн нөхөн төлөх тухай зохицуулалт ИХ-д байх шаардлагатай гэж үзэж байна.

Нөгөөтээгүүр шүүх “сэтгэл санааны үр дагаврын улмаас хэчнээн хэмжээний хохирол учирсан нь тодорхойгүй” гэдэг үндэслэл гаргажээ. Гэвч энэ нь сэтгэл санааны хохирлын мөн чанар, агуулгатай нийцэхгүй тайлбар байна. Сэтгэл санааны хохирол нь өөрөө үр дагавар юм. Хууль бусаар цагдан хоригдсон, ял шийтгүүлсний улмаас сэтгэл санааны шаналал зүдгүүр амсах нь өөрөө сэтгэл санааны хохирлыг бий болгож байх бөгөөд шүүх гагцхүү тэр үүсчихсэн сэтгэл санааны хохирлыг мөнгөөр үнэлэн илэрхийлж, нөхөн төлүүлэх л үүрэгтэй билээ.

Үүнээс гадна шүүх “Сэтгэл санаа, биеийн эрүүл мэндийн өөрчлөлтийн улмаас эмнэлгийн байгууллагад хандаж эмчлүүлсэн эсэх ...нь тодорхойгүй байх” гэж тайлбарласнаас харахад сэтгэл санааны хохирол учирсан болохыг нотлохын тулд эмнэлгийн байгууллагад хандаж эмчлүүлсэн байхыг шаарджээ. Гэвч сэтгэл санааны хохирол нь мөн чанартаа заавал сэтгэл санаа, биеийн эрүүл мэндэд ноцтой өөрчлөлт үүсгэж, түүндээ эмнэлгийн тусламж авсан байхыг шаардахгүй юм. Хэрэв эмнэлгийн тусламж авсан байхыг шаардах аваас энэ нь сэтгэл санааны хохирол бус, эрүүл мэндийн хохирол болох билээ. Эрүүл мэндийн хохирол учирсан тохиолдолд гардаг эмчилгээний зардал болон бусад зардал нь эдийн хохирол болдог. Тиймээс шүүхийн “сэтгэл санаа, биеийн эрүүл мэндийн өөрчлөлтийн улмаас эмнэлгийн байгууллагад хандаж

эмчлүүлсэн нь тодорхойгүй, сэтгэл санааны үр дагаврын улмаас хэчнээн хэмжээний хохирол учирсан нь тогтоогдохгүй байна” гэж буй дүгнэлт нь өрөөсгөл байна.

5. Дүгнэлт

Уг шийдвэрийн хувьд ИХ-ийн 230.2 дахь хэсгийн агуулгад нийцүүлэн ИХ болон бусад хуульд тусгайлан зохицуулагдаагүй, эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөхгүй гэдэг шүүхийн өмнөх шийдвэрүүдийн байр суурийг дахин баталгаажуулжээ. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 391.1 дэх хэсгийг хэрэглэхийн тулд эдийн бус хохирлын талаар илүү нарийвчилсан зохицуулалт ИХ-д байх ёстой гэж үзсэн байна.

2) Хамгийн өндөр хэмжээгээр сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлсэн хэрэг⁶⁸

Нэг. Үйл баримт

Талийгаач В нь компанийн нягтлан бодогчоор ажиллаж байсан нэхэмжлэгч А-г (В-гийн эхнэрийн төрсөн эгч) хутгалж амь насанд нь аюултай хүнд гэмтэл учруулан, дараа нь өөрийнхөө хоолойг хэрчин амь насаа хохироосон байна. Улмаар Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтсээс 2015 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр нэхэмжлэгч А-г В-гийн амь насыг хөнөөсөн байж болзошгүй гэж эрүүгийн хэрэг үүсгэж, Монгол Улсын хилээр нэвтрэх эрхийг нь хязгаарласан байдаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 1 жил 11 сарын турш үргэлжилж, улсын Ерөнхий прокурорын газрын прокурорын 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 1/21 тогтоолоор хэрэгсэхгүй болгож, эцэслэн шийдвэрлэсэн.

⁶⁸ Монгол Улсын төрд холбогдох сэтгэл санааны хохирол шаардсан хэргийн тухай Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 02057 дугаартай шийдвэр.

Нэхэмжлэгч А нь Засгийн газрын нөөц сангаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд 75,320, эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлсэн өмгөөлөгчдийн ажлын хөлсөнд нийт 16,000,000, сэтгэл заслын эмчилгээний зардалд 4,850,000, сэтгэл санааны хохиролд 70,000,000, материал бүрдүүлэхэд гарсан зардалд 63,100, өмгөөллийн хөлсөнд 5,000,000 төгрөгийг тус тус, бүгд 95,988,420 төгрөгийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргажээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр ба үндэслэл

“Нэхэмжлэгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар шаардах эрхтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгч А-д холбогдуулан эрцүгийн хэрэг үүсгэж, хуульд заасан ажиллагаа явуулсан боловч нэхэмжлэгч нь гэм буруутай болох нь тогтоогдоогүй байх тул уг ажиллагаатай холбогдон үүссэн үр дагаврыг төр хариуцан арилгах үүрэгтэй.

Нэхэмжлэгчид амь биед аюултай хүнд зэргийн гэмтэл учирсан цед онц хүнд хэрэгт сэжигтнээр татан баривчилж, таслан сэргийлэх арга хэмжээ авч, 1 жил 11 сар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байх ба нэхэмжлэгчид учирсан сэтгэл санааны үр дагавар буюу сэтгэл санааны хохиролд 70,000,000 төгрөгийг олгох үндэслэлтэй байна.

Нэхэмжлэгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд 75,320 төгрөгийг, материал бүрдүүлэхэд гарсан зардалд нийт 63,100 төгрөгийг, өмгөөллийн хөлсөнд 5,000,000 төгрөгийг, бүгд 5,138,420 төгрөгийг гаргуулахаар нэхэмжилж байх боловч тус зардлууд нь мөрдөн байцаалтын ажиллагаатай буюу мөрдөгч, прокурорын ажиллагаатай холбоогүй байх тул учирсан хохиролд тооцоггүй болно.

Төрийг төлөөлж буй Сүхбаатар дүцүргийн прокурорын газар нь нэхэмжлэгчийг яллагдагчаар татааггүй тул нэхэмжлэгч нь хохирол нэхэмжлэх эрхгүй гэж маргаж байх боловч 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан сэжигтний эрх зүйн байдал, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр бүлэгт заасан яллагдагчийн эрх зүйн байдалтай ижил байх тул нэхэмжлэгч нь хохирол нэхэмжлэх эрхтэй байна.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.3.5 дахь заалтад зааснаар Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас учирсан хохиролд бүгд 89,850,000 төгрөгийг ($15,000,000 + 4,850,000 + 70,000,000 = 89,850,000$) гаргуулан нэхэмжлэгчид олгон, нэхэмжлэлийн шаардлагаас үлдсэн 6,138,420 төгрөгийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй байна”.

Гурав. Дүн шинжилгээ

1. Шийдвэрийн ач холбогдол

Энэхүү шийдвэр нь хууль бусаар гэмт хэрэгт шалгагдсан этгээдэд сэтгэл санааны хохирлыг аливаа нотлох баримт шаардалгүйгээр олгосон гэдгээрээ ач холбогдолтой байна. Өмнөх шүүхийн шийдвэрт энэ шийдвэртэй ижил төсөөтэй хэрэг дээр үнэлгээний компаниар сэтгэл санааны хохирлоо үнэлүүлсэн боловч нотлох баримтын шаардлага хангахгүй хэмээн шүүх няцаасан байдаг. Харин энэ шийдвэрт огт нотлох баримт шаардалгүйгээр 70 сая төгрөгийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлсэн гэдгээс үзэхэд шүүхийн шийдвэрүүд хоорондоо ямар их зөрүүтэй байгааг харж болно.

2. Маргааны зүйл

Ямар нөхцөл байдал үүссэн тохиолдолд сэтгэл санааны хохирол үүссэн гэж үзэх болон тухайн хохирлыг хэрхэн үнэлэх нь уг хэргийн хувьд маргааны гол зүйл болжээ.

3. Хохирол барагдуулах үндэслэл бий болсон эсэх

Нэхэмжлэгч А нь өөрөө гэмт хэргийн хохирогч болсон байхад түүнийг В-гийн амь насанд буруутган хилсээр 1 жил 11 сарын хугацаанд гэмт хэрэгт шалгасан боловч гэм буруутай гэдэг нь тогтоогдоогүй.

ИХ-ийн 498.4-ийн дагуу хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан иргэнийг цагаатгасан тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй байгаа.

Иймд нэхэмжлэгч А нь ИХ-ийн 498.4-т заасны дагуу гэм хорын хохирлоо шаардах эрхтэй талаар шүүхийн дүгнэлт зөв байна.

4. Эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй эсэх

Шүүх ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсгийг үндэслэн нэхэмжлэгчийн сэтгэл санааны хохирлыг Засгийн газрын тусгай сан болох Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сангаас олгохоор болжээ.

Шүүх энэ тохиолдолд ИХ-ийн 230.2 дахь хэсгийг хэрэглэсэнгүй. Энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай тусгайлсан зохицуулалт шаардахгүйгээр 498.1 болон 497.1 дүгээр заалт нь өөрөө эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болно гэж үзсэн байна.

Хэрэв ИХ-ийн 230.2-ыг гэм хорын зохицуулалтаас тусгай зохицуулалт буюу хоорондоо харилцан хамаарал байхгүй гэж үзвэл шүүхийн энэ шийдвэртэй адил 497.1-д зааснаас хойших заалт нь дангаараа сэтгэл санааны хохирол барагдуулах үндэслэл болох боломжтой. Ингэснээр ИХ-ийн 230.2-т заасныг зөвхөн гэрээний үүргийн зөрчилтэй хамааралтай гэж тайлбарлаж болох юм.

Гэвч ИХ-ийн бүтэц, зохион байгуулалтаас харахад 230 дугаар зүйлийг багтаасан “Гэм хорыг арилгах” 18 дугаар бүлэг нь үүргийн ерөнхий ангийн нэгэн бүлэг бөгөөд хохирол төлөх ерөнхий нөхцөлүүдийг зааж өгсөн байна. Гэм хорын бүлэг нь өөрөө хуулиар үүсэх үүрэг буюу үүргийн эрх зүйн нэгэн том бүлэг болж буйн хувьд үүргийн ерөнхий ангийн заалтуудаас ангид байх боломжгүй билээ. Ийм учраас ИХ-ийн 230.2 заалт нь яалт ч үгүй гэрээний үүргийн зөрчилд ч, гэм хорын зөрчилд ч хэрэглэгдэх ерөнхий зохицуулалт болж байна. Шүүхийн олон шийдвэр энэ үндэслэлээр сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээс татгалзаж байна.

Уг шийдвэрийн хувьд хэдийгээр ИХ-ийн 230.2 дахь хэсгийг огт хэрэглэлгүйгээр нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирлыг 70,000,000 төгрөгөөр үнэлж олгосон нь хохирогчийн нөхцөл байдалд тохирсон шударга шийдвэр болсон байж болох ч шүүх яагаад ИХ-ийн 230.2-ыг энэ тохиолдолд хэрэглээгүй талаараа тайлбарласан бол шүүхийн шийдвэрийн үндэслэл илүү ойлгомжтой байх байлаа.

5. Дүгнэлт

Шүүхийн энэхүү шийдвэр нь хууль бусаар сэжигтнээр татагдсан, цагдан хоригдсон, ял шийтгэгдсэн тохиолдолд сэтгэл санааны хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх ёстой, мөн сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтооход “нэхэмжлэгч заавал гарцаагүй нотлох ямар нэг баримт гаргаж өгөх ёстой” гэдэг

шүүхийн өмнөх шийдвэрүүдээс эсрэг байр суурь гаргаснаараа онцлогтой байна.

Ингэснээр нэхэмжлэгч өөрөө эрүүл мэнд, бие махбодын хувьд гэмтэл авч хохирогч болсон байхад нэг жил гаруйн турш сэжигтнээр татагдан, шалгагдсанаас харахад нэхэмжлэгчид дан ганц эдийн хохирол бус эдийн бус хохирлыг нөхөн олгох нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах Үндсэн хуулийн зарчим болоод иргэний эрх зүйн хамгаалалтын зорилгод нийцнэ.

3.7. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлэгт шүүхийн нийт 11 шийдвэрийг судлав. Эдгээр шийдвэр нь 2010 оноос 2019 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн сэтгэл санааны хохирол буюу эдийн бус хохирол шаардсан хэргүүд юм. Эдгээр хэргийн хувьд хүний амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд хохирол учраагүй бөгөөд ангиллаар нь ялгавал эр, эмийн харилцаан дахь зөрчлөөс үүдэлтэй сэтгэл санааны хохирол, өмчийн эрхийн зөрчлөөс үүдэлтэй сэтгэл санааны хохирол, дүрсийн эрх зөрчсөний улмаас үүсэх сэтгэл санааны хохирол, хөдөлмөрийн харилцаан дахь сэтгэл санааны хохирол, гэрээний үүргийн зөрчлөөс үүдэлтэй сэтгэл санааны хохирол, хилсээр сэжигтнээр татагдсан, цагдан хоригдсоноос үүдэлтэй сэтгэл санааны хохирол гэж хуваагдана.

Эдгээр хэргээс хилсээр гэмт хэрэгт холбогдож, шалгагдсан хэрэг хамгийн олон нь байна. Энэ нь тухайн төрлийн хэргийн хохирогч сэтгэл санааны хохирлоо шаардах эрхтэй талаар тусгайлсан зохицуулалт (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйл) байгаатай холбоотой байж

болох юм. Түүнчлэн энэ төрлийн нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгддөг тул сэтгэл санааны хохирлоо шаардахад хялбар байсан байж магадгүй юм.

Бусад төрлийн хэргийн хувьд тус бүр 1-4 шийдвэр байна. Энэ нь манай улсын шүүхийн практикт “Иргэний хуулийн 230.2 болон 511 дүгээр зүйлийн дагуу нэр төр, алдар хүндэд халдсанаас бусад тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх хууль зүйн үндэслэл байхгүй” гэдэг шүүхийн практик болон онолын нийтлэг ойлголт, мөн их хэмжээний сэтгэл санааны хохирол нэхэмжлэхийн тулд тэр хэмжээний тэмдэгтийн хураамж төлөх ёстой болдогтой холбоотой байхыг үгүйсгэхгүй.

Гэсэн хэдий ч маш олон төрлийн хэрэг дээр хохирогчид болон тэдний өмгөөлөгчид сэтгэл санааны хохирлыг нэхэмжилсээр иржээ. Энэ нь дээрх шүүхийн шийдвэрүүдээс харсанчлан хэргийн нөхцөл байдал болон шүүх, шүүгчээс шалтгаалан сэтгэл санааны хохирлыг зарим тохиолдолд хүлээн зөвшөөрч, зарим тохиолдолд татгалзаж байгаатай холбоотой юм. Ихэнх тохиолдолд ИХ-ийн 230.2-т заасныг баримтлан энэ төрлийн нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь илт байна.

Ингээд дээрх шүүхийн шийдвэрүүдээс дараах байр суурь, чиг хандлага, дүр зураг ажиглагдаж байна. Үүнд:

1. Сэтгэл санааны хохирлыг шаардсан хэргүүдийн онцлог

- a. Эдийн бус хохирлыг шаардсан бүх шийдвэрт хариуцагч этгээдийн гэм буруу тогтоогдсон, гэм хорын зөрчил эсхүл гэрээний үүргийн зөрчил үүссэн, хохирогчийн аливаа нэг эрх, эрх ашиг зөрчигдсөн болох нь тогтоогдсон хэрэг байгаа бөгөөд хохирогчид эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлоо давхар шаардсан байдаг.

- б. Зарим хэргийн хувьд эдийн хохирол үүсэх боломжгүй, зөвхөн эдийн бус хохирол үүсгэх боломжтой хэрэг байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, дүрсийн эрхийг зөрчих нь хохирогчид эдийн хохирол үүсгэхээс илүү эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирол үүсгэдэг. Энэ төрлийн хэргүүдийн гол шинж чанар нь сэтгэлзүйн дарамт, шаналал байдаг.

2. Шүүхийн олонхын байр суурь

Ихэнх хэрэгт шүүхээс эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг хэрэгсэхгүй болгож байгаа бөгөөд үүний цаана үндсэн болон дагалдах гэсэн хоёр шалтгаан байна.

1. *Үндсэн шалтгаан:* ИХ-ийн 230.2-т заасныг баримтлан сэтгэл санааны хохирлын шаардлагыг хэрэгсэхгүй болгож байна. Тус заалтын дагуу эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг заасан хуулийн зүйл, заалт байх ёстой гэж шүүх үзэж байгаа юм. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг шаардахын тулд ИХ эсхүл бусад хуульд “гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэсэн утга бүхий заалт байсан тохиолдолд тухайн хэргийн хохирогчид сэтгэл санааны хохирлыг олгох эрх үүснэ гэсэн үг юм.
2. *Дагалдах шалтгаан:* “Сэтгэл санааны хохирлоо нотлоогүй эсхүл нотлох баримт гаргаж өгөөгүй эсхүл сэтгэл санааны хохирол учирсан гэдэг нь нотлогдохгүй байна” гэсэн нотолгооны үүргийг хохирогчид тохохоос гадна хохирогчоос нотлох баримт гаргаж өгөхийг шаардаж байна. Хохирогч өөрөө нотлох баримт гаргаж

өгөөгүй бол сэтгэл санааны хохирлыг хэрэгсэхгүй болгож байна.

Ялангуяа Улсын Дээд шүүх нь эдийн бус хохирол шаардах эрхийн хувьд хатуу байр суурь баримталж байна. Анхан болон давж заалдах шатны шүүхүүд зарим тохиолдолд ИХ-ийн 230.2 дахь хэсгийг хэрэглэхгүйгээр эсхүл 511.1-д заасныг төсөөтэй хэрэглэн, энэ төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг хангадаг боловч хяналтын шатны шүүхийн шатанд бүгд хэрэгсэхгүй болж байна. Улсын Дээд шүүх нь эдийн бус хохирлыг барагдуулах гэж байгаа бол ИХ-ийн 230.2-т заасныг гарцаагүй хэрэглэх ёстой гэж үзэн нэр төр, алдар хүндэд халдсан эсхүл хүн амины онц ноцтой хэрэг биш бол сэтгэл санааны хохирлыг барагтай нөхөн төлүүлээгүй байна.

3. Шүүхийн цөөнхийн байр суурь

- а. Цөөн тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхээс ИХ-ийн 230.2-т заасныг үл ойшоон, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлсэн тохиолдол бий. Тухайлбал, гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэсэн нөхөр болон үг хэлээр байнга дарамталж буй нөхрийнхөө хамтран амьдрагчийн эсрэг сэтгэл санааны хохирол шаардсан хэрэг болон гэмт хэргийн хохирогч болсон этгээд өөрөө гэмт хэрэгт шалгагдсан хэргүүд дээр шүүх ИХ-ийн 230.2-т заасныг огт баримтлалгүйгээр сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлсэн нь бий. Гэр бүлийн хэрэг дээр 300,000 төгрөг гаргуулсан бол хууль бусаар цагдан хорьсон хэрэг дээр 70,000,000 төгрөг гаргуулсан байдаг. Эндээс үзэхэд зарим тохиолдолд анхан шатны шүүхээс сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлж байна.

- б. Мөн эдгээр шүүхийн шийдвэрт хохирогчоос нотлох баримт шаардаагүй, сэтгэл санааны хохиролд шаардсан мөнгийг нотлохыг үүрэг болгоогүй байсан онцлогтой. Энэ бол сэтгэл санааны хохирол мөн чанар нь нотлох баримтаар илэрдэггүй гэсэн онолын суурь ойлголтыг шүүхийн практикт нэвтрүүлсэн зөв алхам мөн.

4. Шүүхийн шийдвэрүүдийн зөрүүтэй байдал

Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар шүүхүүд яг адил маргаан дээр өөр өөрөөр шийдвэрлэх тохиолдол байна. Тухайлбал:

- а. Өмнө нь танилцуулсан нэгэн шийдвэр дээр (2015 оны) аливаа этгээдүүд сэтгэл санааны хохирол нөхөн төлөхөөр харилцан тохиролцож гэрээ байгуулсан тохиолдолд “Сэтгэл санааны хохирлыг зөвхөн хуульд заасан тохиолдолд нөхөн төлөх тул энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөхөөр гэрээ байгуулсан нь хууль зөрчиж байна” хэмээн хэрэгсэхгүй болгосон бол дараагийн шийдвэр дээр нэгэн (2018 оны) шүүхийн шийдвэрт “Гэрээний чөлөөт байдлын зарчмын дагуу талууд гэрээний агуулгыг өөрсдөө шийдвэрлэх эрхтэй” хэмээн сэтгэл санааны хохирол шаардах эрхийг хангаж шийдвэрлэсэн байдаг.
- б. Мөн 2016 оны шүүхийн шийдвэрээр хууль бусаар цагдан хоригдож ял шийтгүүлсэн этгээдэд “...сэтгэл санааны хохирлыг төлөх хууль зүйн үндэслэл байхгүй, сэтгэл санааны хохирлын хэмжээгээ нотолж чадахгүй байна” гэж хэрэгсэхгүй болгосон байдаг бол 2018 онд өөр нэгэн анхан шатны шүүх нь хууль зүйн үндэслэл, нотлох баримт огт шаардалгүйгээр сэтгэл санааны хохирлыг хангаж шийдвэрлэсэн байна.

Энэ мэт ижил хэрэг дээр өөр өөрөөр шийдвэрлэж байгаа нь нэхэмжлэгчид, хохирогчдод ялгавартай хандаж, тэгш эрхийн зарчмыг зөрчсөн гэж ажиглагдаж байна.

5. Сэтгэл санааны хохирлын талаарх шүүгчдийн онолын ойлголтын дутмаг байдал

Шүүхийн шийдвэрүүдээс харахад сэтгэл санааны хохирлын талаар шүүгчид онолын үндсэн агуулга дээр зөрүүтэй мэдлэг, ойлголттой байгаа нь ажиглагдлаа.

- а. Юуны өмнө сэтгэл санааны хохирол болон эдийн бус хохирлыг тэс өөр хохирлын төрөл мэтээр авч үзэж байна. Сэтгэл санааны хохирлыг сэтгэл санааны шаналал, зовлонтой дүйцүүлэн, эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүндэд халдсанаар үүсдэг хохирол мэтээр бичих нь нийтлэг байна. Нэр томьёоны хувьд сэтгэл санааны хохирол болон эдийн бус хохирлыг адилтган авч үзэж болно. Өөрөөр хэлбэл, эдийн хохирлоос бусад бүх хохирол бол эдийн бус хохирол билээ. Ихэвчлэн сэтгэл санааны шаналал, зүдгүүрээр илэрдэг тул сэтгэл санааны хохирол гэж түгээмэл хэрэглэгддэг боловч угтаа энэ нь эдийн бус хохиролтой ижил дүйцэхүйц ойлголт юм. ИХ болон иргэний эрх зүйд сэтгэл санааны хохирол биш, эдийн бус хохирол гэж томъёолдог тул цаашид энэ нэр томъёог хэрэглэж хэвших нь зүйтэй болов уу. Учир нь эдийн бус хохирол нь зөвхөн хувь хүнд үүсдэг бус, хуулийн этгээдэд ч бас үүсдэг учиртай юм.
- б. Сэтгэл санааны хохирол хэзээ үүсдэг талаар шүүгчид өрөөсгөл ойлголттой байгаа нь тэд гэм хор үүссэнийг тогтоосон хэр нь сэтгэл санааны хохирол үүссэн гэдэг нь тогтоогдохгүй байна эсхүл нотлогдохгүй байна гэж

тайлбарласнаас харагдана. Гэм хорын зөрчил эсхүл гэрээний үүрэг зөрчигдсөнөөр хохирогчид эдийн болон эдийн бус байдлаар хохирол үүсдэг бөгөөд эдийн хохирлыг гарцаагүй нотлох баримтаар нотолж болох ч эдийн бус хохирлыг тийн нотлох боломжгүй. Тиймээс нэхэмжлэгчээс эдийн бус хохирол үүссэнээ гарцаагүй нотлох баримтаар нотлохыг шаардаж болохгүй. Энэ тохиолдолд нотолгооны шаардлагыг хөнгөлж, зөвхөн “үнэмшилтэй толилуулснаар” эдийн бус хохирол үүссэнийг хүлээн зөвшөөрдөг байхад хангалттай. Өөрөөр хэлбэл, гэм хорын зөрчил эсхүл гэрээний үүргийн зөрчлийн улмаас өөрт нь эдийн бус хохирол үүссэн талаар нэхэмжлэгч нь гарцаагүй нотлох баримтаар нотлох шаардлага байхгүй.

- в. Шүүх нь сэтгэл санааны хохирлыг үнэлэх талаар өрөөсгөл ойлголттой байна. Тухайлбал, шүүхээс “Сэтгэл санааны хохирлын хэмжээгээ нэхэмжлэгч өөрөө нотолж чадахгүй байна, нотлох баримт байхгүй байна” гэж няцааж байгаа. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хохирлын хэмжээг үнэлэх үүргийг нэхэмжлэгчид оноож, мөн түүнийгээ хатуу баримтаар нотлохыг нэхэмжлэгчид даалгаж байгаа. Гэтэл эдийн бус хохирол нь өөрөө яагаад эдийн бус хохирол билээ? Эд хөрөнгөөр үнэлэгдэх боломжгүй учраас эдийн бус хохирол гэдэг. Гэвч эдийн бус хохирол нь хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас хохирогчдод бий болдог бодит хохирол мөн. Гагцхүү эмчилгээний төлбөр, цалин хөлс гэх мэт нотлох баримтаар нотлох боломжгүй байдаг нь түүний үндсэн шинж чанар юм. Ийм ч учраас сэтгэл санааны хохирлын хэмжээгээ нэхэмжлэгч өөрөө үнэлээд шүүхэд толилуулсан бол түүнийг ихэсгэж, багасгаж тогтоох үүрэг нь шүүхэд байна. Нэхэмжлэгч болон шүүгчийн

хэн хэн нь өөрсдийн тогтоосон хэмжээгээ заавал эд мөрийн хатуу баримтаар нотлох шаардлагагүй. Энэ нь ч боломжгүй юм.

Шүүхийн шийдвэрүүдээс ажиглагдсан зүйлийг нэгтгэн хөрвүүлэхэд ийм байна. Энэ бүхнийг нэгтгэн дүгнэхэд шүүхийн практикт хэдийгээр гэм хор, гэрээний үүргийн зөрчил нь нотлогдсон ч хариуцагчийн гэм буруугийн хэмжээ их байсан ч хохирогчийн хохирол шаардах эрхийг зөвхөн эдийн хохирлоор хязгаарлан, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудал тун хангалтгүй байна. Тэр ч байтугай эдийн хохирлыг ч нотлох баримтын шаардлагын улмаас бүрэн дүүрэн зөвшөөрөхгүй байх хандлага харагдаж байна.

Жишээлбэл, зөвхөн эдийн бус хохирол үүсгэдэг хэргийн хувьд хохирогч ямар ч нөхөн төлбөр авч чадалгүй үлдэх, хариуцагч нь ямар ч хариуцлага хүлээхгүйгээр үлдэх гэх мэт нийгэмд хор уршигтай, сөрөг үр дагавруудыг авчирч байна. Иймээс эдийн бус хохирлын асуудлыг нэн яаралтай шинэчлэн шийдвэрлэх шаардлагатай.

ДӨРӨВ. ГАДААД УЛСУУДЫН ТУРШЛАГА

Өмнөх гурван бүлэгт эдийн бус хохирлын талаарх онолын ерөнхий ойлголт, Монгол Улсын шүүхийн практикт эдийн бус хохирлыг хэрхэн авч үзэж байгаа талаар өгүүлсэн бол энэ бүлэгт гадаад улсуудын эдийн бус хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо, эдийн бус хохирлыг ямар шинж чанартай гэж үздэг зэргийг авч үзэх юм. Ингэхдээ уламжлалт байдлаар аль нэг улс энэ асуудлыг хэрхэн зохицуулсан байдгаар нь биш харин асуудал тус бүрийн хүрээнд тухайн улсууд хэрхэн зохицуулсан талаар нь авч үзлээ.

4.1. УЛС ОРНУУДЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД ЭДИЙН БУС ХОХИРЛЫН АСУУДАЛ ТУСГАГДСАН БАЙДАЛ

Эдийн бус хохирлын тогтолцооны талаар зарим улс орон ИХ-даа анхнаас нь өргөн хүрээнд хуульчилсан байдаг бол зарим нь явцын дунд нэмэлт, өөрчлөлт шинэчлэл хийх замаар тусгасан нь бий.

1. ОХУ

“*Моральный вред (moral harm)*” буюу сэтгэл санааны хохирол гэсэн нэр томъёог “зан суртахууны болоод бие

махбодын зовуурь, шаналал” гэж тодорхойлсон байна⁶⁹. Уг нэр томъёо нь Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын 1990 оны 6 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан “Хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хууль”-д анх тусгагдсан байдаг. Тус хуулийн 39 дүгээр зүйлд “Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бодит байдалд үл нийцсэн, нэр төр, алдар хүндийг гутаасан эсхүл бусад эдийн бус хохирол бий болгохуйц мэдээлэл тараасны үр дүнд учирсан сэтгэл санааны хохирлыг шүүх гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж заасан. Гэвч тус хуульд “*moral harm*” гэх нэр томъёо нь ямар агуулгатай болохыг тодорхойлоогүй байна.

Харин түүнээс хойш 1991 оны ЗХУ-ын Иргэний суурь хуулийн шинэтгэлийн хүрээнд “Компенсация морального вреда” буюу сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны суурийг тавьсан гэж үздэг. Тухайлбал, ЗХУ-ын Иргэний суурь хуулийн 131 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирол гэдгийг “физические или нравственные страдания” буюу “бие махбодын болон зан суртахууны зовуурь, шаналал” гэж тодорхойлсон бөгөөд мөн энэ агуулгыг 1994 оны ОХУ-ын ИХ-ийн 151 дүгээр зүйлд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

ОХУ-ын Иргэний хуулийн цэргийн ерөнхий ангийн 151 дүгээр зүйл. Ёс суртахууны хохирлыг нөхөн төлөх

- “Хүний эдийн бус эрх, бусад материаллаг бус үнэт зүйлсийг зөрчиж сэтгэл санааны хохирол (бие махбод болон зан суртахууны зовуурь, шаналал) учруулсан болон хуульд заасан бусад тохиолдолд шүүх гэм буруутай этгээдээр хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхээр үүрэг оногдуулна”.

⁶⁹ Б.Утевский, Возмещение неимущественного вреда как мера социальной защиты, Еженедельник советской юстиции, 1927, №35, с. 1083.

- “Шүүх ёс суртахууны хохирлын хэмжээг тогтоохдоо гэм буруутай этгээдийн гэм буруугийн хэр хэмжээ болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Мөн хохирогчийн өөрийн хувийн онцлог шинжтэй холбоотой бие махбодын болон зан суртахууны зовуурийн байдлыг харгалзан үзнэ”.

Мөн ОХУ-ын Иргэний хуулийн гэм хорын бүлгийн 1100 дугаар зүйл. Ёс суртахууны хохирлыг нөхөн төлөх үндэслэл

- “Ёс суртахууны хохирлыг дараах тохиолдолд хариуцагчийн гэм буруугаас үл хамааран нөхөн төлнө.
- *Хүний амь нас, эрцүл мэндэд хохирол учруулах;*
- *Хууль бусаар ял шийтгүүлсэн, эрцүгийн нэмэлт хариуцлага хүлээлгэсэн, цагдан хорих, үйлдсэн ялын шийтгэлээс учирсан хохирол;*
- *Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан мэдээлэл тарааснаас үүссэн хохирол;*
- *Хуульд заасан бусад тохиолдолд”.*

Эндээс үзэхэд ОХУ-ын ИХ нь эдийн бус хохирлыг харьцангуй өргөн хүрээнд хуульчилсан байна.

2. ХБНГУ

Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөхийн тулд ИХ-даа нэмэлт өөрчлөлт оруулсан улсын өөр нэгэн жишээ бол ХБНГУ юм. Тус улсын ИХ 1900 оноос хойш өдийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа⁷⁰ бөгөөд 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Үүргийн эрх зүйг шинэчлэх тухай хууль⁷¹ баталснаар маш өргөн хүрээний өөрчлөлт, реформ

⁷⁰ <https://www.gesetze-im-internet.de/bgb/BJNR001950896.html>, сүүлд үзсэн огноо 2021.08.13.

⁷¹ Zweites Gesetz zur Änderung schadensersatzrechtlicher Vorschriften, 19 Jul 2002, Artikel 2.

хийсэн гэж үздэг байна⁷². Ийнхүү үүргийн эрх зүйг шинэчлэх реформын хүрээнд эдийн бус гэм хорын зохицуулалтыг ч мөн шинэчилжээ.

ХБНГУ-ын ИХ-ийн 253.1-д “Эдийн бус хохирлыг хуульд заасан тохиолдолд шаардаж болно” гэж, 253.2-т “Хүний бие, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдлын эрхийг зөрчсөн тохиолдолд эдийн хохирлыг гаргуулснаас үл хамааран эдийн бус хохирлыг шаардаж болно” гэж зохицуулсан байна.

Харин 2017 оны ИХ-ийн нэмэлт өөрчлөлтөөр 844 дүгээр зүйлд 844.3 гэсэн шинэ заалт нэмж “Гэм хорын хариуцлага хүлээгч нь гэм хорын улмаас нас барсан хүнтэй нэн ойр дотно харилцаатай байсан гэр бүлийн этгээдэд учирсан сэтгэл санааны хохирлыг хариуцан төлөх үүрэгтэй. Хохирогчтой нэн ойр дотнын харилцаатай хүн гэдэгт нас барсан хүний эхнэр, нөхөр, тэдний эцэг эх, үр хүүхдүүдийг ойлгоно” гэж тусгажээ. Энэ нь хохирогчид учирсан хохирлоос гадна хохирогчийн гэр бүлийн хүний өөрийнх нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөхөд чухал заалт болсон байна.

3. Япон Улс

Япон Улсын хувьд дээрхээс эсрэгээр эдийн бус хохирлын тухай анхнаасаа өргөн хүрээтэй зохицуулалт гаргаж, хүлээн зөвшөөрсөн байна. Тодруулбал, Япон Улсын ИХ 1896 онд анх батлагдсан бөгөөд энэ үеэс эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хуульчлан зохицуулсан байдаг⁷³. Энэ нь тус хуулийг боловсруулахад Францын ИХ-ийг эш үндэс болгон ашигласантай холбоотой. Япон Улсын ИХ-ийн 710 дугаар зүйлд “Аливаа этгээдийн бие махбод, эрх чөлөө, нэр төр эсхүл бусдын эд хөрөнгийн эрхийн алиныг нь зөрчсөн эсэхээс үл хамааран

⁷² Ulrich Magnus et al, InDret, The Reform of German Tort Law, working paper 127, Barcelona, April 2003, p. 3.

⁷³ Hirai Yoshio (平井宜雄), “Right to Claim II, Tort” [債權各論Ⅱ 不法行為], (Kobundo, 1993) p. 13.

өмнөх заалтын дагуу бодит хохирлыг барагдуулах үүрэг хүлээсэн этгээд нь эдийн бус хохирлыг барагдуулах үүрэг мөн хүлээнэ” гэж заасан байдаг.

Энэ нь аливаа хууль бус үйлдэл хийсэн бол тухайн этгээд нь хохирогчийн ямар эрх, эрх ашгийг зөрчсөнөөс үл хамааран сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлнэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг нэгэн адил төлөх үүрэгтэй болохыг хуульчлан тогтоожээ.

Ийм ч учраас Япон Улсад хүний амь нас, эрүүл мэндийг салшгүй эрхийн нэн тэргүүнд авч үздэг бөгөөд түүнтэй холбоотой эдийн бус хохирлыг ч мөн чухалчлан авч үзэж, эхний ээлжид нөхөн төлүүлэхийг урьтал болгодог. Харин хүний амь нас, эрүүл мэндийн хохиролтой холбоогүй эдийн бус хохирол нь маш олон төрлийн эрхийн зөрчилд хамаарч болно гэж үздэг. Нэг ёсондоо гэм хорын зөрчил гаргасан ямар ч тохиолдолд эдийн бус хохирлын нөхөн төлбөр шаардах боломж нээлттэй байдаг байна. Эдгээрийг гурван том бүлэгт хуваан авч үзэж болно: (i) хүний хувийн эрхийн зөрчилтэй хамаатай тохиолдол; (ii) хувь хүн, хуулийн этгээдийн эдийн засгийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдол; (iii) эд хөрөнгийн эрхийн зөрчилтэй холбоотой тохиолдол гэж хуваана⁷⁴.

4.2. УЛС ОРНУУД ЭДИЙН БУС ХОХИРЛЫН ШИНЖ ЧАНАРЫГ АВЧ ҮЗСЭН БАЙДАЛ

Судалгааны эхэн хэсэгт эдийн бус хохирлыг бодит хохирлоор тооцож нөхөн төлөх үүргийн тухай “бодит хохирлын онол” болон хариуцагчийг шийтгэх үүргийн тухай “шийтгэлийн онол”-уудыг тус тус танилцуулсан. Тэгвэл энэ хэсэгт сонгон авч

⁷⁴ Кубота Ацүми нар, Япон Улсын Иргэний хуулийн тайлбар, 2017.

судалсан улсууд нь эдгээр онолоос алийг нь нэвтрүүлсэн талаар авч үзье.

1. ОХУ

ОХУ-д эдийн бус хохирлыг бодитоор учирсан хохирлын хэмжээнд нөхөн төлөх үүрэгтэй гэж үздэг. Өмнө дурдсанчлан бодит хохирол гэдэгт зөвхөн эдийн хохирол гэлтгүй эдийн болон эдийн бус хохирлын аль алиныг агуулж байгааг сануулах нь зүйтэй.

ОХУ-ын хувьд хохирогчид учирсан эдийн болон эдийн бус хохирол нь хоорондоо хамааралгүй гэж үздэг⁷⁵. Өөрөөр хэлбэл, хохирогчид эдийн хохирол учраагүй байсан ч эдийн бус хохирол дангаар үүсэх боломжтой гэж үздэг. Уг асуудлыг шийдвэрлэсэн “L.A. Nazhmutdinov et al v. PO Mayak” хэрэгт нэхэмжлэгч нь анх төрөхдөө нэг хөлгүй, хоёр гарын хуруу нь дутуу зэрэг хүнд хэлбэрийн эмгэгтэй төрсөн бөгөөд цөмийн байгууламжийн үйл ажиллагаа явуулдаг “PO Mayak” гэх улсын үйлдвэрийн эсрэг сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргажээ⁷⁶. Тухайн үеийн Оросын шинжлэх ухааны академи, ЗХУ-Америкийн харилцааны хүрээлэнгээс нэхэмжлэгч нь цацраг туяанд өртсөний улмаас генетикийн өөрчлөлттэй төрсөн гэсэн дүгнэлт гаргасан байна. Энэ хэрэгт нэхэмжлэгч хариуцагчаас эдийн хохирол шаардаагүй, харин зөвхөн сэтгэл санааны хохиролд 500,000 рубль шаардсан бөгөөд ОХУ-ын Дээд шүүх уг нэхэмжлэлийн шаардлагаас 50,000 рублийг хангаж шийдвэрлэсэн⁷⁷.

⁷⁵ Elizabeth Barrett Ristroph, Ilya Fedyaev, *Obstacles to Environmental litigation in Russia and the potential for private actions*, *Environmental Litigation in Russia*, 2006, p. 230.

⁷⁶ “Маяк” нь 1946 онд байгуулагдсан ЗХУ-ын химийн нууц үйлдвэр байсан бөгөөд 1957 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн Кыштымын цөмийн осолд өртсөн. Тухайн үеийн “Маяк” нь одоогоор “Маяк Росатом” гэх нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

⁷⁷ Определение судебной коллегии по гражданским делам Верховного Суда Российской Федерации, 24.07.1997.

2. ХБНГУ

ХБНГУ-ын хувьд эдийн бус хохирол нь бодит хохирол учруулсан байхыг шаарддаггүй боловч хохирлын улмаас тухайн хохирогчийн мэдрэмжид гэм хор учруулсан байхыг шаарддаг⁷⁸. Мөн хүн бүрийн өвчин, шаналлыг мэдрэх мэдрэмж харилцан адилгүй байдаг тул нэг хохирлын улмаас хохирогч бүрд адил хэмжээний хохирол учирсан гэж тооцож, тийнхүү адил хэмжээний хохирол нөхөн төлүүлэх боломжгүй гэж үздэг байна⁷⁹.

3. Япон Улс

Япон Улсын шүүхийн практик болон эрх зүйн онолыг судалж үзэхэд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь бодит хохирлыг нөхөн төлөх шинжтэй буюу нөхөн төлбөрийн онолыг нэвтрүүлсэн байдаг⁸⁰. Зарчмын хувьд Япон Улс нь шийтгэлийн онолыг сөрөг үр нөлөөтэй гэж үздэг байсан ч сүүлийн үед энэхүү онолыг ч бас хүлээн зөвшөөрөх хандлага гарч ирж байна⁸¹.

Үүний нэг жишээ нь профессор Ацүми Кубота “Хариуцагчийг шийтгэх шинж чанар нь зөвхөн эдийн бус

⁷⁸ Ulrich Magnus, Damages for Non-Pecuniary Loss in German Contract and Tort Law, [12 August 2015], Oxford, The Chinese Journal of Comparative Law, p. 290.

⁷⁹ Мөн тэнд.

⁸⁰ Saito Osamu (齋藤修), Compensation Calculation Theory [慰謝料算定の理論], Gyosei [行政] no. 5 (2010), p. 5.

⁸¹ Жишээлбэл, энэ онолыг Сантаро Окамацу, Мичитака Кайноу, Хикороку Окуно, профессор Танака/Такэучи, Мунехико Мишима нар дэмжиж байв. Жишээлбэл, Мичитака Кайноу “Энэ бол иргэний хариуцлага ба эрүүгийн хариуцлагын сэтгэцийн хохирол нь хорих арга хэмжээ биш харин цэвэр хохирол, түүнчлэн их хэмжээний хохирол гэж бодож байснаас тодорхой ялгаж салгасан эрин үе байсан. Энэ бол санаа бодлын тусгал байсан. Хэрэв хэн нэгэн нь хол бодсон бол энэ эрин үеийн чиг хандлагаас харахад мөн чанарыг нь “хохирлын өнгөөр шийтгэх” гэж үзэх боломжтой юм. Шагналыг сэтгэцийн болон сэтгэлзүйн хямралын нөхөн төлбөр гэхээсээ илүү иргэний эрх зүйн хариуцлага гэж ойлгох ёстой” гэж тэр хэлжээ. Нэмж дурдахад Мунехико Мишима мөн “Биет бус хохирлыг нөхөн төлөхөд хориг арга хэмжээ нэмснээр иргэний хариуцлагын зорилгод хамгийн сайн нийцэж байна гэж бодож байна” гэжээ.

хохирлын тохиолдолд биш гэм хорын эрх зүйн өөрийнх нь шинж чанарт байна... Хэдийгээр онолын хувьд шийтгэлийн онолыг бүрэн хүлээн зөвшөөрөх боломжгүй боловч бодит байдалд шүүхийн шийдвэрүүд нь эдийн бус хохирлыг үнэлж барагдуулах замаар хариуцагчид хариуцлага тооцох, шийтгэх үүрэг гүйцэтгэж байна”⁸² гэж хэлснээс харагдаж байна.

Эдийн бус хохирлын агуулга тэр бүр тодорхойгүй байдаг бөгөөд түүний хэмжээг шүүгчийн үзэмжээр тогтоодог тул эдийн бус хохирол нь өдгөө янз бүрийн чиг үүрэг гүйцэтгэж байна⁸³. Нөгөө талаар эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх нь нэлээд хатуу хуульчлагдсан хууль эрх зүйн зүйл заалтуудыг уян хатан байдлаар хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг⁸⁴.

Япон Улсын хувьд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцооны чиг үүрэг нь зөвхөн бодит хохирлыг нөхөн төлүүлэхээр хязгаарлагдахгүй хариуцагчийг шийтгэх, хохирогчид сэтгэл ханамж бий болгох, хүний сэтгэл хөдлөлийн үнэ цэнийг илэрхийлэх, зовлон бэрхшээлийг даван туулахад туслах, эдийн буюу материаллаг хохирлыг нөхөн гүйцээх зэрэг чиг үүргүүдийг гүйцэтгэж байна. Эдийн хохирлыг нөхөн гүйцээх чиг үүрэг нь Японы эрх зүйн тогтолцооны өвөрмөц үүрэг бөгөөд улам өргөжин хөгжиж байна. Тухайлбал, эмч буруутай үйлдэл хийсэн ч тухайн өвчтөн нас барах нь тодорхой байсан хэрэгт өвчтөний амь нас бус харин түүний илүү урт хугацаанд амьдрах байсан боломжийг нь үгүй хийснийг хохирол гэж үзэн

⁸² Kubota Atsumi (窪田充見), Moral damages and punitive damages in tort [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究], Vol. 2, no. 4 (Tou Aja, Hen 4, 2018), p. 50.

⁸³ Kubota Atsumi (窪田充見), Moral damages and punitive damages in tort [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究] Vol. 2, no. 4 (Tou Aja, Hen 4, 2018), p. 45.

⁸⁴ Saito Osamu (齋藤修) edited by Yamada Takao (山田卓生編集), Issues on Compensation [慰謝料に関する諸問題], Lectures on New, Modern Damages Law (Damages & Insurance) [新・現代損害賠償法講座] Vol. 6 (Yuhikaku, 1987), p. 222.

шалтгаант холбоог энэ дагуу тогтоож, эмчийн буруутай үйлдэлд хариуцлага ногдуулсан Дээд шүүхийн шийдвэр⁸⁵ бий.

Япон Улсын эдгээр зохицуулалтын хувьд мөн чанартаа хүний эрхийг хамгийн боломжит байдлаар “зөөлөн нөхцөлтэй”-гөөр хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой гэж үзэхээр байна.

4.3. ЭДИЙН БУС ХОХИРЛЫГ ОЙР ДОТНЫН ХҮНД НЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРДӨГ ЭСЭХ

1. ОХУ

ОХУ-ын Дээд шүүхээс сэтгэл санааны хохиролд хамаарах тохиолдлыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: (i) Ойрын садан, төрлийн хүнээ алдсанаас учирсан шаналал; (ii) Нийгмийн идэвхтэй амьдралаа цааш үргэлжлүүлэх боломжгүй болсонтой холбоотой шаналал; (iii) Ажил албаа алдсанаас учирсан шаналал; (iv) Гэр бүлийн болоод эрүүл мэндийн нууцыг нь задруулсантай холбоотой шаналал; (v) Тухайн хүний талаар худал мэдээлэл тараасан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг нь гутаасантай холбоотой шаналал; (vi) Тухайн хүний аливаа эрхийг түр хугацаагаар хязгаарласан эсхүл зөрчсөнтэй холбоотой шаналал; (vii) Бие махбодын өвчин зовлон болон эрүүл мэндийн бусад хохиролтой холбоотой шаналлыг тус тус сэтгэл санааны хохиролд хамаарна гэж тайлбарлажээ⁸⁶. Өөрөөр хэлбэл, ОХУ-ын дээд шүүхийн тайлбарын дагуу

⁸⁵ Японы Улсын Дээд шүүхийн 2001 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэр, Иргэний хэргийн шийдвэрийн эмхэтгэл, 54 дүгээр боть, №7, 2574 дахь тал.

⁸⁶ Decree of the Plenum of the Supreme Court of Russian Federation, Some issues on implementation of legislation on compensation for moral damage, *Biull. Verkh. Suda. RF.*, 1995, no. 3, pp. 9-11.

“Ойрын садан, төрлийн хүнээ алдсанаас учирсан шаналлыг сэтгэл санааны хохиролд хамаарна” гэж үзсэн байна.

2. ХБНГУ

ХБНГУ-д 2017 онд ИХ-ийн шинэчлэл явагдаж, сэтгэл санааны хохирлыг ойр дотнын хүнд нь нөхөн олгуулахыг зөвшөөрсөн шинэ зохицуулалт нэмэгдсэн. Тодруулбал, ИХ-ийн 823 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө болон бусад эрхийг санаатай болон болгоомжгүй байдлаар зөрчсөн этгээд үүгээр учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй” гэж заажээ. Ингэснээр шүүхээр ойр дотнын хүн нь амиа алдсаны улмаас хохирогчдод сэтгэл санааны хохирол учирсан нь ИХ-ийн 823 дугаар зүйлд хамаарна гэж үзэж тэдний сэтгэл санааны хохирлыг хангаж шийдвэрлээг болсон байна. Тодруулбал, гэр бүл болон ойрын хамаатны хүний бие махбодод учруулсан хохирлын улмаас хэн нэгэн нас барж байгааг харах, сонсох зэргийн улмаас сэтгэл, сэтгэл зүйн хувьд өөрчлөлт гарсан, үүнтэй холбоотой үүссэн эдийн бус хохирлыг тус хүний байдал хэвийн байдалд эргэн орох хүртэлх хугацааны хохирлыг ИХ-ийн 823-т заасны дагуу нөхөн төлүүлдэг байна⁸⁷.

3. Япон Улс

Япон Улсын ИХ-ийн 711-р зүйлд “Бусдын амь насыг хохироосон этгээд хохирогчийн эцэг, эх, эхнэр/нөхөр, үр хүүхдүүдэд эд хөрөнгийн эрх нь зөрчигдөөгүй байсан ч хохирлыг нөхөн төлөх ёстой” гэж заасан байдаг. Тиймээс зөвхөн амь насаа алдсан хохирогчийн төдийгүй эрүүл мэндийн хувьд хохирсон хохирогчийн ойрын хамаатан садан нь өөрийн эдийн бус хохирлыг шаардах эрхтэй.

⁸⁷ BGHZ 56, 163; BGH NJW 1989, 2317; BGH VersR, 2012, p. 634.

ИХ-ийн 711 дүгээр зүйлийн ойр дотнын хүний эдийн бус хохирол шаардах эрх нь мөн л Япон Улсын ИХ-д анхнаасаа хуульчлагдсан заалт юм. Харин шүүх энэхүү зүйлийн үйлчлэх хүрээг өргөжүүлэн, зөвхөн хохирогч амь насаа алдсан тохиолдолд бус, эрүүл мэнд, бие махбод нь гэмтсэн тохиолдолд ч хохирогчийн ойр дотнын хүнд сэтгэлзүйн хувьд асар их хохирол учирдаг гэж тайлбарлаж, 711 дүгээр зүйл нь эрүүл мэндийн хохирол амссан хүний ойр дотнын хүнд ч бас үйлчилнэ гэжээ.

Жишээлбэл, Япон Улсын Дээд шүүхийн 1958 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн шийдвэрт замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочийн буруугаас болж өсвөр насны охин хүнд гэмтэл авч, нүүрэндээ маш том сорвитой үлдсэн. Хохирогч охины ээж охиндоо учирсан хохирлыг шаардахаас гадна энэ хэргээс болж сэтгэл санааны хохирол амссан гэж өөрийн сэтгэл санааны хохирлыг давхар шаардсан. Хохирогчийн эхэд ИХ-ийн 711 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэн, өөрийн сэтгэл санааны хохирлыг давхар гаргуулахыг хүлээн зөвшөөрсөн⁸⁸ байна.

4.4. ХОХИРЛЫГ ҮНЭЛЭХ СУУРЬ ЗАРЧИМ, АРГЫГ ТОГТООСОН ЭСЭХ

1. ОХУ

ОХУ-ын шүүхэд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхдээ ИХ болон Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг тайлбарлаж хэрэглэхээс гадна доор дурдсан А.М.Эрделевскийн аргачлалыг албан бус байдлаар хэрэглэдэг⁸⁹. Энэхүү аргачлалыг анагаах ухаан, статистик болон бусад тоон

⁸⁸ Япон Улсын Дээд шүүхийн Шёвагийн 33 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн шийдвэр, Иргэний хуулийн 12-р боть, №12, 1901 дэх тал.

⁸⁹ Б.Д.Завидов, Моральный вред, 2001, с. 21-24.

мэдээлэлд тулгуурлан боловсруулсан бөгөөд гэмт хэргийн төрөл бүрд хамаарах сэтгэл санааны хохирлын тодорхой хэмжээг тусгасан байдаг. А.М.Эрделевскийн аргачлал нь:

$$D=d*f(v)*i*c*(1-f(s))^{90}$$

томъёололтой байх бөгөөд дараах агуулгатай. Үүнд:

D - сэтгэл санааны хохирлын дүн

d - сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ

f(v) - хохирол учруулагч этгээдийн гэм хорын хэмжээ. Гэм хор нь $0 < f(v) < 1$ байх ба

f(v) = 0.25 энгийн болгоомжгүй

f(v) = 0.5 хэтэрхий болгоомжгүй

f(v) = 0.75 шууд бус санаатай

f(v) = 1 шууд санаатай

i - хохирогчийн хувийн онцлог, $0 < i < 2$

c - анхаарвал зохих нөхцөл байдал, $0 < c < 2$

f(s) - хохирогчийн гэм буруутай байдал, $0 < f(s) < 1$.

2. ХБНГУ

Харин ХБНГУ-д эдийн бус хохирлыг тооцох нэгдсэн арга, схем байдаггүй. Энэ нь хэргийн нөхцөл байдал бүр харилцан адилгүй, мөн эдийн бус хохирол нь субъектив нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг гэдэгтэй холбоотой. Хохирлыг тооцохдоо тухайн хохирлын хохирогчийн амьдралд нөлөөлж буй хэмжээ, хүрээнээс “*die Hohe und das Maß der Lebensbeeinträchtigung*” (англ. *the height and measure of the life-impairment*) хамааран тооцдог байна⁹¹. Үүнд, тус хохирлын нөлөө, үргэлжлэх хугацаа, хэний буруугаас үүдсэн, гэм буруугийн хэлбэр, мөн бусад нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр тооцдог. Мөн гэм хор учруулагчийн санхүүгийн байдал ч чухал нөлөөтэй байдаг⁹². Ийнхүү эдийн бус хохирлыг тооцоход бүхий л

⁹⁰ А.М.Эрделевский, Компенсация морального вреда, 2007, М., с. 241-242.

⁹¹ BGHZ 18, р. 149.

⁹² BGHZ 18, р. 149.

нөхцөл байдал өөр өөр байдаг тул шүүгчийн дотоод үзэмжээс хамаараад хохирлын хэмжээг тогтоодог байна⁹³.

ХБНГУ-ын ИХ-ийн хувьд хохирлыг *restitutio in integrum* буюу хохирол учруулсан этгээд нь тус хохирол учруулахаас өмнөх байдалд сэргээх зарчмыг баримталдаг⁹⁴. Хохирол учруулагч нь тус хохирлыг буцаан сэргээх, засварлах ёстой ба хэрэв боломжгүй бол учруулсан хохирлыг мөнгөөр нөхөн төлж болно⁹⁵. Тухайлбал, тус улсын шүүхээс 1958 онд нэгэн иргэний зургийг бэлгийн дур хүсэл өдөөгч эмийн бүтээгдэхүүний сурталчилгаанд зөвшөөрөлгүйгээр нийтэлснийг тухайн хүний амины эрхийг зөрчсөн байна гэж үзэж 10,000 герман маркийн хохирол гаргуулахаар шийдвэрлэж байсан байна⁹⁶.

Мөн 2004 онд ХБНГУ-ын дээд шүүхээр нэгэн сонирхолтой хэрэг шийдэгдсэн. Нэгэн сэтгүүлийн газар Монакогийн Гүнт Улсын нэгэн гүнж ярилцлага өгөөгүй байхад өгсөн мэтээр зохиож, ярилцлага бэлтгэн нэгэн сэтгүүлд хэвлүүлсэн байна. Үүнийг тус сонины газар нь хохирогчийн хувийн эрхийг зөвхөн ашиг олох үүднээс ноцтойгоор зөрчсөн гэж холбооны шүүхээс үзэж хохирогчийн зураг, ярилцлагыг нийтэлсэнтэй холбоотойгоор олсон бүхий л орлогыг гаргуулж хохирогчид олгуулах нь зүйтэй гэж тогтоон Монакогийн гүнжид 150,000 герман марк гаргуулж шийдвэрлэжээ.⁹⁷ Эдгээрээс харахад ХБНГУ нь хохирлыг зөвхөн эдийн бус хохирол нөхөн төлүүлэх зохицуулалтаар хязгаарлаж биш, тухайн хүний эрхэд халдсан тохиолдолд хүртэл эдийн бус хохирлыг олгож буюу өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч байгаа болохыг харуулж байна.

⁹³ Ulrich Magnus, Damages for Non-Pecuniary Loss in German Contract and Tort Law [12 August 2015], Oxford, The Chinese Journal of Comparative Law, p. 290.

⁹⁴ BGB 249(1), Wer zum Schadensersatz verpflichtet ist, hat den Zustand herzustellen, der bestehen würde, wenn der zum Ersatz verpflichtende Umstand nicht eingetreten wäre.

⁹⁵ BGB 251 (1), Soweit die Herstellung nicht möglich oder zur Entschädigung des Gläubigers nicht genügend ist, hat der Ersatzpflichtige den Gläubiger in Geld zu entschädigen.

⁹⁶ Herrenreiter, Bundesgerichtshofs (BGH), vom 14. Februar 1958 (BGHZ 26, 349).

⁹⁷ BGH NJW 2005, p. 215.

3. Япон Улс

Япон Улсад ч эдийн бус хохирлыг үнэлэх томьёо, аргачлал байдаггүй бөгөөд эдийн бус хохирлыг шүүгч үзэмжээрээ үнэлдэг. Ийнхүү үнэлэхдээ гэмт этгээд болон хохирогчийн аль алиных нь хувийн байдал, эд хөрөнгө, хохирлын зэрэг, нас, боловсрол, ажил мэргэжил, орлого, амьдралын нөхцөл, нийгмийн байдал, гэмт үйлдлийн сэдэл, шалтгаан зэрэг олон нөхцөл байдлыг харгалзан үзэж тогтооно гэдэг дээр шүүх болон судлаачид нэгдсэн байр суурьтай байдаг.⁹⁸

Гэхдээ 1960-аад оны үеэс зам тээврийн ослын тоо үлэмж нэмэгдэж хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл ихсэн шүүхийн ачааллыг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан Өмгөөлөгчдийн холбооноос зам тээврийн осолд холбогдолтой хохирол тогтоосон шүүхийн шийдвэрүүдийг судлан шинжилж, ерөнхий чиг баримжаа, хохирлын дундаж хэмжээ зэргийг тооцоолсон ном гаргасан. Зарим тохиолдолд амь нас, эрүүл мэндээрээ хохирсон бусад хэргийн хохирогчдын хохирлыг үнэлэхэд ч бас энэхүү номыг баримтлах нь бий.

⁹⁸ Kato Ichiro (加藤一郎), Japanese Tort Law Restatements [日本不法行為法リステイトメント], Method of Compensation for Damages [損害賠償の方法] (Yuhikaku, 1988), p. 92.
Shokurin Ko (植林弘), Compensation Calculation Theory [慰謝料算定論] (Yuhikaku, 1962), p. 120.
Yoshimura Ryoichi (吉村良一) edited by Hoshino Eichi (星野英一編), Right to claim damages [慰謝料請求権], Civil Law Lectures, Administrative management, Unjust Enrichment, Tort, [民法講座 『事務管理・不当利得・不法行為』] (Yuhikaku, 1985), p. 431.
Hirai Yoshio (平井宜雄), Right to Claim II, Tort [債権各論II 不法行為], (Kobundo, 1993), p. 130.
Saito Osamu (齋藤修), Compensation Calculation Theory [慰謝料算定の理論], Gyosei [行政], no. 5 (2010), p. 25
Sawano Kazuhiro and others (澤野和博) edited by the Kouki, Memorial Papers Committee (古稀記念論文集委員会編) Damages from the view of life/ survival [慰謝料—生存・生命を考えながら], Waseda Current Studies of Civil Law [早稲田民法学の現在] (Seibundo, 2017), p. 508.
Kubota Atsumi (窪田充見), Moral damages and punitive damages in tort [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償] Minpou Kenkyu [民法研究], Vol. 2, no. 4 (Tou Aja, Hen 4, 2018), p. 45.

4.5. ДҮГНЭЛТ

ХБНГУ, ОХУ, Япон Улсын аль аль нь эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг бөгөөд ийнхүү хүлээн зөвшөөрснөөрөө нэг талаас сэтгэл санаагаар хохирсон тухайн хүний хохирлыг барагдуулах ба нөгөө талаараа тухайн хүний зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж байгаа гэдгээрээ ач холбогдолтой гэж үзэж байна.

Ялангуяа манай улсын иргэний эрх зүйд гол нөлөө үзүүлсэн гэгдэх ОХУ-д 1994 оноос, ХБНГУ-д 2002 оноос хойш эдийн бус хохиролтой холбоотой шинэ зохицуулалтыг ИХ-даа оруулах замаар илүү өргөн хүрээнд хуульчилсан байна. Харин манай улсын хувьд 2002 оноос хойш эдийн бус хохиролтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийг ИХ-даа оруулаагүй байгаа билээ. Эндээс дүгнэвэл манай улсын хувьд нийгмийн хөгжлийн хүрсэн түвшинд нийцүүлэн ИХ-ийн эдийн бус хохирлын зохицуулалтыг шинэчлэх цаг болсон гэж үзэж байна.

Түүнчлэн эдгээр улс орон ИХ-даа эдийн бус хохирлын талаар өргөн хүрээнд тусгасан боловч эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх хэрэг, эрхийн зөрчлийг ИХ-иар хязгаарлаагүй онцлогтой. Өөрөөр хэлбэл, шүүх аливаа маргааныг шийдвэрлэхдээ ИХ-ийн эдийн бус хохирлын тухай заалтыг хатуу тайлбарлахгүйгээр тухайн хохирогчийн аливаа эрх, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал түүнд учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж байна. Зарим тохиолдолд шүүх энэ мэтээр “шинэ” эрх, ашиг сонирхлыг үүсгэх тохиолдол ч гардаг бөгөөд эдийн бус хохирлыг өргөжүүлэх, дэлгэрүүлэх, амилуулахад шүүх голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Эндээс үзвэл манай улсын шүүгчид ч эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх одоогийн хууль тогтоомжийн хязгаарлагдмал зохицуулалтад баригдалгүйгээр хуулийг өргөжүүлэн тайлбарлаж хэрэглэх боломж, бололцоо байхыг үгүйсгэхгүй юм.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

5.1. ДҮГНЭЛТ

1. Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг болгох нийтлэг хэрэгцээ, шаардлага

Манай улсын ИХ-д эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тухай эрх зүйн зохицуулалт туйлын хязгаарлагдмал, шүүхийн практикт ихэвчлэн энэ төрлийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгодог ч иргэд төрөл бүрийн эрхийн зөрчил дээр эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлоо “нэхэмжлээд үзье” гэдэг байдлаар нэхэмжилсээр байна.

Нөгөө талаар анхан шатны шүүх зарим тохиолдолд хуулиар зохицуулагдаагүй харилцааны хүрээнд хуулийн хязгаарлагдмал зохицуулалт, Улсын Дээд шүүхийн тайлбарыг үл харгалзан эдийн бус хохирлыг хангаж шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй байна. Эндээс үзэхэд иргэд болон шүүхийн зүгээс эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрөхийг шаардаж буй нийтлэг хүсэл, шаардлага байгааг харж болно.

2. Эдийн бус хохирлын талаарх өнөөгийн тогтолцооны гажиг

Манай улсын шүүхээр эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөхөд “хуулийн хэт хязгаарлагдмал зохицуулалт” болон “эдийн бус хохирлын тухай онолын дутмаг байдал” гэсэн хоёр асуудал саад болж байна.

а. Хуулийн хэт хязгаарлагдмал зохицуулалт

Эхний асуудлын хувьд ИХ-ийн 230.2-т заасныг баримтлан сэтгэл санааны хохирлын шаардлагыг хэрэгсэхгүй болгож байна. Тус заалтын дагуу эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөхийг заасан хуулийн зүйл, заалт байх ёстой гэж шүүх үзэж байгаа юм. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг шаардахын тулд ИХ-д өөрт нь эсхүл бусад хуульд “гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэсэн утга бүхий заалт байсан тохиолдолд тухайн хэргийн хохирогчид сэтгэл санааны хохирлыг олгох эрх үүснэ гэсэн үг юм. Шүүхийн хувьд тухайн эрхийн зөрчилд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр заагаагүй бол шаардах эрхгүй гэсэн үг.

Ялангуяа Улсын Дээд шүүх эдийн бус хохирол шаардах эрхийн хувьд хатуу байр суурь баримталж иржээ. Тус шүүхээс эдийн бус хохирлыг төлүүлэх тохиолдолд ИХ-ийн 230.2-т заасныг гарцаагүй хэрэглэх ёстой гэж үзэн нэр төр, алдар хүндэд халдсан эсхүл хүн амины онц ноцтой хэрэг биш бол сэтгэл санааны хохирлыг тэр бүр нөхөн төлүүлэх шийдвэр гаргадаггүй байна.

б. Эдийн бус хохирлын талаарх онолын дутмаг байдал

Нөгөө талаас Монгол Улсын хувьд эдийн бус хохирлын тухай ойлголт, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн онол, үндэслэл, тайлбарын хөгжил төдий л сайн биш байна. Үүний улмаас эдийн бус хохирол болон сэтгэл санааны хохирлыг ялгаатай ойлголт хэмээн үзэх, мөн чанарынхаа хувьд эд хөрөнгөөр илрэн гарах боломжгүй, нотлох баримт үлдээх боломжгүй эдийн бус хохирлыг заавал нотлох баримтаар нотлохыг шаардах, эдийн бус хохирлын хэмжээгээ баримтаар нотлохыг нэхэмжлэгчээс шаардах зэрэг асуудал шүүхийн шатанд үүссэн байна.

Үр дүнд нь шүүхээс адил хэргийг өөрөөр шийдвэрлэх, хохирогчид учирсан бодит хохирлыг бүрэн нөхөн төлж чадахгүй байх, хохирогчийн зөрчигдсөн эрх хангалттай хэмжээнд сэргэхгүй байх зэрэг нөхцөл байдал үүсэж, Үндсэн хуулиар хамгаалагдсан “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх” хүний үндсэн эрх хангагдахгүй байна.

Ийнхүү манай өнөөгийн эдийн бус хохирлын тогтолцоо нь хариуцагчийн гэм буруутай үйлдлийг өөгшүүлсэн, хохирогчийн хохирол шаардах эрхийг хязгаарласан шинжтэй болсон байна. Үүний улмаас хохирол шаардах эрхийг зөвхөн эдийн хохирлоор хязгаарлан, эдийн бус хохирлыг огт нөхөн төлөхгүй нөхцөл байдалд хүрчээ. Үүний улмаас гэм буруутай этгээдүүд бусдад учруулсан хохирлоо бүрэн нөхөн төлөхгүй байх, хариуцлагаас мултрах үр дагавар үүсдэг. Энэ нь зөвхөн нэг удаагийн тохиолдлоор хязгаарлагдахгүй бөгөөд хариуцагч ямар нэг хариуцлага хүлээхгүй үлдэж байгаа нь буруутай үйлдэл дахин хийх боломж бүрдүүлж байгаатай адил юм.

3. Манай улсын эдийн бус хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо нь бусад улсынхтай харьцуулахад хэт хоцрогдмол түвшинд байна.

АНУ, Япон, Франц, ОХУ зэрэг хөгжингүй орнуудын Иргэний хууль тогтоомж, онолын урсгал, чиг хандлага, шүүхийн шийдвэрүүдийг судалж үзэхэд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг харьцангуй өргөн хүрээнд хуульчлан хүлээн зөвшөөрч байна⁹⁹. Мөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх

⁹⁹ Франц, Япон улсууд нь эдийн бус хохирлыг хамгийн өргөн хүрээнд зохицуулсан. Япон улсын Иргэний хуулийн 710-р зүйл нь хүний бүхий л эрхээс гадна “бусдын илүү урт наслах боломжийг нь үгүй хийх”, аливаа үйлдлийг хийх эсэхээ “чөлөөтэй шийдвэрлэх эрх”-ийг зөрчих, “найдах эрх”-ийг зөрчих зэрэг эрхийг шинээр үүсгэн бий болгож, сэтгэл санааны хохирлыг нь хүлээн зөвшөөрч байна. ХБНГУ-ын Иргэний хуулийн 253.1 нь “Эдийн бус хохирлыг гагцхүү хуульд заасан тохиолдолд шаардаж болно”, 253.2 “Бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, хүйсээ тодорхойлох эрхэд учруулсан хохирлыг нөхөн төлөхдөө эдийн бус хохирлыг мөн шаардаж болно” гэсэн. Мөн 2017 онд Иргэний хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулж, хохирогчийн эцэг,

ажиллагааны явцад шүүгчид нь эдийн бус хохирлыг өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэх, хөгжүүлэх чиг үүрэг гүйцэтгэж байна. Учир нь эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хүлээн зөвшөөрснөөр эцсийн дүндээ хүний эрхийг хамгаалах чухал хэрэгсэл болж буйг олон улсын туршлага нотолж байгаа юм.

Манай ИХ-ийн эш үндэс болсон ОХУ, ХБНГУ-ын ИХ-иудад 1994, 2002, 2017 онд томоохон нэмэлт өөрчлөлт орж, эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч эхэлсэн байх боловч манай ИХ-д 2002 оноос хойш буюу 19 жилийн хугацаанд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой дорвитой өөрчлөлт ороогүй. Цаашид энэ чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах цаг нь болсон болов уу гэж үзэж байна.

5.2. САНАЛ

1. Иргэний хуулийн шинэчлэл

Манай улсын өнөөгийн ИХ-д эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хуульчлахын тулд тодорхой шинэчлэл хэрэгтэй. Тухайлбал, ИХ-ийн 230, 497, 511 дүгээр зүйлд дараах нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой.

Юуны өмнө ИХ-ийн 230.2 дахь хэсгийг “Бусдын эрх болон хуулиар хамгаалагдсан эрх ашгийг хууль бусаар санаатай болон болон болгоомжгүй хэлбэрээр зөрчсөн этгээд нь эдийн хохирлыг арилгаснаас үл хамааран эдийн бус хохирлыг мөн арилгах үүрэгтэй” гэж өөрчлөн, эдийн бус хохирлыг хүлээн

эх, хүүхэд зэрэг ойр дотнын хүмүүсийн эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрсөн заалт оруулсан. ОХУ-ын Иргэний хуулийн 151, 1099-р зүйл нь эдийн бус хохирлыг өргөн хүлээн зөвшөөрч зохицуулжээ. Иймд цаашдаа ирээдүйд өөр ямар тохиолдолд эдийн бус хохирлыг хүлээн зөвшөөрөх вэ гэдэг асуудал нь нээлттэй сэдэв болоод байна.

зөвшөөрөх ерөнхий заалт болгох хэрэгтэй. Хамгаалагдах эрхийг “бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал болон бусад хуулиар хамгаалагдсан эрх, эрх ашгийг...” гэж тоочсон байдлаар оруулж болох боловч нийтлэг байдлаар оруулах нь хожмын иргэний эрх зүйн хөгжилд нэмэртэй гэж судлаачдын зүгээс үзэж байна. Ийм байдлаар ИХ-ийн 230.2 дахь хэсгийг өөрчлөх нь **гэм хор болон гэрээний үүргийн зөрчлийн аль алинд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж болдог болох** давуу талтай юм.

Үүний дараа ИХ-ийн 497 дугаар зүйлийн дотор “Бусдын эрхийг хууль бусаар санаатай болон болон болгоомжгүй хэлбэрээр зөрчсөн этгээд нь эдийн хохирлыг арилгаснаас үл хамааран эдийн бус хохирлыг мөн арилгах үүрэгтэй” гэсэн бичвэр бүхий шинэ заалт нэмж болох юм. Өмнөхтэй харьцуулбал энэ заалтыг заавал нэмэх шаардлагагүй бөгөөд зөвхөн ИХ-ийн 230.2 дахь хэсэг нь гэм хорын зохицуулалтад ч нэгэн адил хамаарна гэдгийг бататгах үүднээс ийнхүү нэмэгдэж болно.

Эцэст нь ИХ-ийн 511 дүгээр зүйлийн гарчгийг “Нэр төр, алдар хүндэд учирсан гэм хорын хохирлыг арилгах” гэж өөрчлөх хэрэгтэй. Учир нь нэр төр, алдар хүндэд халдсаны улмаас учирсан хохирлыг арилгуулах арга, хэлбэр нь бусад эрхийн зөрчилтэй харьцуулахад онцлогтой. Үүний дүнд эдийн бус хохирлын талаарх хуулийн зүйл, заалтууд уялдаа холбоотой, системтэй, эмх цэгцтэй болно хэмээн үзэж байна.

2. Эдийн бус хохирлын талаарх онолыг хөгжүүлэх нь

Хууль тогтоомжийг шинэчлэхээс гадна эрх зүйн мэдлэг, онолын суурь ойлголтыг хөгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, эдийн бус хохирлыг өргөн хүрээнд ойлгож, хүлээн зөвшөөрөх, энэ төрлийн хохирлын шинж чанар, зорилго, чиг үүрэг, үнэлэх зарчим зэрэг асуудал үүнд багтана.

а. Эдийн бус хохирол гэдэг ойлголтыг өргөн хүрээнд тайлбарлах

Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх нь амьд явах, эрх чөлөөтэй байх зэрэг амин чухал эрхээс эхлээд өмчлөх эрх, зохиогчийн эрх, оюуны өмчийн эрх, гэр бүлийн холбогдолтой эрх, хүүхдийн эрх, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрх гэх мэт бүхий л субьектив эрхийн зөрчилтэй холбоотойгоор эдийн бус хохирлоо шаардах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрөх агуулгыг илэрхийлнэ. Энэ нь ардчилсан нийгэмд хүний эрхийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, хүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чухал хөшүүрэг болно. Өөрөөр хэлбэл, эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүнд, хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулснаар хязгаарлалгүй олон тохиолдолд хүлээн зөвшөөрөх тухай асуудал юм. Тухайлбал, эдийн бус хохирлыг бие махбодын гэмтэлтэй холбогдон үүсэх эдийн бус хохирол, бие махбодын гэмтлээс үл хамаарах эдийн бус хохирол гэж хоёр хувааж үзэх боломжтой. Үүнээс бие махбодын гэмтэлтэй холбоотой эдийн бус хохирлыг “сэтгэл санааны хохирол” гэж бид хэлж заншсан. Тодруулбал, авто осол, эмчийн буруутай үйлдэл, бусдын биед гэмтэл учруулах, гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийлэл зэрэг хүний амь нас, эрүүл мэндийн эрхийн зөрчилд ихэвчлэн сэтгэл санааны хохирлыг хүлээн зөвшөөрөх магадлал их байдаг. Хүний амьд явах эрх нь хүний хамгийн тэргүүн дээд эрх, эрх ашиг мөн тул эдийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг заавал нөхөн олгуулах нь хүний эрхийн зарчим, үндсэн хуулийн зарчимтай нийцнэ.

Нөгөөх нь бие махбодын гэмтэлтэй үл хамаарах эдийн бус хохирол юм. Үүнд хохирогчийн амь нас, эрүүл мэнд хохироогүй ч гэсэн үүсдэг эдийн бус бусад хохирол хамааралтай. Тухайлбал, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалт, гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл,

гэрээний үүргийн зөрчил гэх мэт. Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх тухай ойлголт нь энэ мэтээр эдийн бус хохирлыг зөвхөн амь нас, эрүүл мэндийн хохиролтой холболгүйгээр өөр олон эрхийн зөрчилд хүлээн зөвшөөрөх тухай ойлголт юм. Гэхдээ гэрээний үүргийн зөрчилд эдийн бус хохирлыг зөвшөөрч үнэлэхдээ тухайн зөрчлийн шинж чанарыг сайтар харгалзан үзэх шаардлагатай.

Иймд эдийн бус хохирлын ойлголтыг зөвхөн сэтгэл санааны хохирол гэх явцуу утгаар бус өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх хандлагыг төлөвшүүлж, гадаадын улс оронд хөгжиж буй онол, практикийн ойлголтыг судлан өөрийн орны эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх нь чухал юм. Үүний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.14-т заасан хувь хүн, хуулийн этгээдийн хохирлоо бүрэн гүйцэд нөхөн төлүүлэх үндсэн эрх нь бодит утгаар хэрэгжих юм.

б. Эдийн бус хохирлын тогтолцооны олон талт чиг үүргийг таниулах

Эдийн бус хохирлыг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх нь бусдад учирсан хохирлыг нөхөн төлөх, хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээхээс гадна шүүхийн практикт эдийн хохирлыг нөхөх, хариуцагчийг хууль бус үйлдэл дахин хийхээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн сэтгэл санааг дээрдүүлэх, зовлон зүдгүүрийг давж гарахад туслах зэрэг олон талын чиг үүрэгтэй.

Ялангуяа манай улсын шүүхийн хувьд нотлох баримт байхгүй л бол эдийн хохирлыг хэрэгсэхгүй болгодог тул хохирогч нь эдийн бус хохирол байтугай эдийн хохирлоо ч бүрэн гаргуулахад хүндрэлтэй байдаг. Ийм тохиолдолд шүүх нь эдийн бус хохирлыг өндөр хэмжээгээр тогтоох зэргээр эдийн бус хохирлын уян хатан чанарыг ашиглан, хохирогчдын

хохирлыг барагдуулах ажиллагааг хийж болдог онцлогтой. Мөн байгаль орчныг бохирдуулсан зарим хэргийн хувьд олон тооны хохирогчтой байдаг тул хохирогч нэг бүрийн бодит хохирлыг тогтоохын тулд тэднээс ирүүлсэн нотлох баримт нэг бүрийг үнэлэх шаардлагатай болдог. Ийнхүү олон тооны нотлох баримтыг үнэлэх нь шүүхэд үлэмж ачаалал үүсгэдэг тул бүгдэд нь ижил хэмжээний эдийн бус хохирол тогтоох замаар эдийн бус хохирлын тогтолцооны ашиг тусыг ашиглаж болно.

Иймд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь бусдад учирсан бодит хохирлыг бүрэн гүйцэд арилгах ач холбогдолтойгоос гадна Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалахад нэн чухал хэрэглүүр болдгийг таниулснаар эдийн бус хохирлын тогтолцоог бид үр ашигтай ашиглаж чадна. Иймд эдийн бус хохирлын зорилт, чиг үүргийг дан ганц хувийн эрх зүйн хариуцлагын хүрээнд авч үзэх нь хангалтгүй юм. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо нь хувийн эрх зүйн төдийгүй нийтийн эрх зүй, Үндсэн хуулиар хамгаалсан хүний эрхийг хамгаалахад чухал үүрэгтэйг сурталчлан таниулах шаардлагатай.

в. Эдийн бус хохирол үүссэнийг нотлох тухай

Гэм хорын зөрчил эсхүл гэрээний үүрэг зөрчигдсөн нь тогтоогдсон тохиолдолд эдийн бус хохирол үүссэнийг нотлох шаардлага, нотолгооны үүргийг өөрчлөх шаардлагатай. Эдийн бус хохирол нь өөрөө эд хөрөнгөөр үнэлэгдэх эсхүл нотлогдох боломжгүй учраас эдийн бус хохирол болж байгаа. Тийм ч учраас нэхэмжлэгч эдийн бус хохирол үүссэн гэдгийг эдийн хохирлын адил эмчилгээний төлбөр, цалин хөлс гэх мэт хатуу баримтаар нотлох боломжгүй.

Иймд гэм хорын зөрчил эсхүл гэрээний зөрчил үүссэн нь нотлогдсон тохиолдолд нэхэмжлэгч гагцхүү өөрт эдийн бус хохирол үүссэн гэдгийг л үнэмшилтэй толилуулахад хангалттай. Ингэснээр нэхэмжлэгч сэтгэл санааны хохирол үүссэн талаар хатуу баримт шүүхэд гаргаж өгөх шаардлагагүй болно.

г. Эдийн бус хохирлыг үнэлэх зарчим

Эдийн бус хохирлыг үнэлэх нэгдсэн аргачлал гэж байхгүй. Иймд эдийн бус хохирлыг үнэлэх нь шүүгчийн бүрэн эрх, цэвэр үзэмжийн асуудал юм. Шүүгч талуудын тайлбар, үндэслэл, хохирогчийн нөхцөл байдлыг харгалзан хохирлын хэмжээг тогтоох ёстой. Жишээлбэл, осол аваарын улмаас айлын өрхийн тэргүүн нас барсан байвал тухайн гэр бүлд цаашдаа жижиг гэр бүлийн бизнес эрхлээд амьжиргаагаа аваад явчих хэмжээгээр хохирлыг тогтоож өгч болох юм. Үүнээс гадна зарим тохиолдолд эдийн хохирлыг нөхөн гүйцээх зорилгоор эдийн бус хохирлыг хэрэглэж болно. Тухайлбал, нотлох баримт дутуугийн улмаас эдийн хохирол нь бага хэмжээнд тогтоогдохоор байвал сэтгэл санааны хохирлыг нэмэлтээр тогтоож өгч болох юм. Шүүгч эдийн бус хохирлын хэмжээг өөрөө үнэлж тогтоохдоо олон талын нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой ч ийм үндэслэл, шалтгааныг заавал тайлбарлах, нотлох шаардлагагүй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

А. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019.
3. Иргэний хууль, 2002.
4. Эрүүл мэндийн тухай хууль, 2011.
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.

Б. Монгол хэлээрх эх сурвалж

1. П.Баянбаатар, Дээд шүүхийн мэдээлэл, Иргэний хууль дахь сэтгэл санааны хохирлын хамрах хүрээ, 2008.
2. Л.Дарьсүрэн, Эдийн бус хохирлын тухай, “Монгол Улсын төр, эрх зүй” сэтгүүл, 2014.
3. А.Доржготов, Эдийн бус хохирлын эрх зүйн орчин: Гэм хор, иргэний эрх зүйн зохицуулалт, “Монгол Улсын төр, эрх зүй” сэтгүүл, №2, 2012.
4. П.Золзаяа, Сэтгэл санааны хохирлын асуудал, МУИС-ийн төв номын сан, мастерын судалгааны ажил, 2016.
5. Ё.Кают, А.Шпанглер нар, Иргэний хуулийн тайлбар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2010.

6. Ш.Сүхбаатар, Бусдын нэр төр, алдар хүндэд учирсан эдийн бус гэм хорын асуудал, докторын судалгааны ажил, 2013.
7. Ж.Оюунтунгалаг, Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудал, МУИС-ийн төв номын сан, мастерын судалгааны ажил, 2002.
8. З.Сүхбаатар, Ёс суртахууны гэм хор, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, №4, 2018.
9. Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик - 2018.
10. Н.Туяа, Сэтгэл санааны хохирлын асуудал, “Монгол Улсын төр, эрх зүй” сэтгүүл, №2, 1996.
11. А.Түвшинтөгс, Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал, 2020.
12. Ш.Үнэнтөгс, Сэтгэл санааны хохирол ба нэр төр, алдар хүндийн асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2017.
13. “Эрх зүйн боловсрол” академи, Ханнс-Зайделийн сан, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2018 он.
14. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2015.
15. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2016.
16. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2017.
17. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2018.
18. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2019.

В. Шүүхийн шийдвэр

1. БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 0229 дүгээр шийдвэр.

ЭДИЙН БУС ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ
ОНОЛЫН АСУУДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ШҮҮХЭЭР ЭДИЙН БУС ХОХИРЛЫГ
НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

2. БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 өдрийн 05 дугаар сарын 29-ний өдрийн 01775 дугаартай шийдвэр.
3. БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 02559 дүгээр шийдвэр.
4. БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 05022 дугаартай шийдвэр.
5. Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 00002 дугаартай шийдвэр.
6. Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 436 дугаартай шийдвэр.
7. Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2012 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 93 дугаартай шийдвэр.
8. СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 5672 дугаартай шийдвэр.
9. СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 02057 дугаартай шийдвэр.
10. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 0228 дугаартай шийдвэр
11. Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 151 дүгээр шийдвэр.
12. Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр шийдвэр.
13. УДШ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 001/ХТ2019/00036 дугаартай тогтоол.

14. УДШ-ийн 2013 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 121 дүгээр тогтоол.
15. УДШ-ийн 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 238 дугаартай тогтоол.
16. Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн 2012 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 66 дугаартай шийдвэр.

Г. Гадаад хэлээрх эх сурвалж

1. Япон Улсын Чиба мужийн Өмгөөлөгчдийн холбооноос хэвлэн гаргасан “Сэтгэл санааны хохирлын тооцооллын хэрэгжилт” ном, 2002.
2. Kato Ichiro (加藤一郎), Japanese Tort Law Restatements [日本不法行為法リステイメント], Method of Compensation for Damages [損害賠償の方法], (Yuhikaku, 1988).
3. Katou Ichirou (加藤一郎), Comparative Research on Compensation [慰謝料の比較法的研究], Hikakuhou Kenkyu [比較法研究] (Yuhikaku, 1982), no. 44.
4. Yoshimura Ryoichi (吉村良一), edited by Hoshino Eichi (星野英一編), Right to claim damages [慰謝料請求権], Civil Law Lectures, Administrative management, Unjust Enrichment, Tort, [民法講座 『事務管理・不当利得・不法行為』] Yuhikaku, 1985).
5. Saito Osamu (齋藤修), edited by Yamada Takao (山田卓生編集), Issues on Compensation [慰謝料に関する諸問題], Lectures on New, Modern Damages Law (Damages & Insurance) [新・現代損害賠償法講座], Vol. 6 (Yuhikaku, 1987).
6. Hirai Yoshio (平井宜雄), Right to Claim II, Tort [債権各論Ⅱ 不法行為], (Kobundo, 1993).
7. Saito Osamu (齋藤修), Compensation Calculation Theory [慰謝料算定の理論], Gyosei [行政] no. 5 (2010).

8. Sawano Kazuhiro and others (澤野和博), edited by the Kouki, Memorial Papers Committee (古稀記念論文集委員会編) Damages from the view of life/ survival [慰謝料—生存・生命を考えながら], Waseda Current Studies of Civil Law [早稲田民法学の現在] (Seibundo, 2017).
9. Kubota Atsumi (窪田充見), Moral damages and punitive damages in tort [不法行為における精神的損害賠償と懲罰的損害賠償], Minpou Kenkyu [民法研究] Vol. 2, no. 4 (Tou Ajia, Hen 4, 2018).
10. Кубота Ацүми болон бусад, Япон Улсын Иргэний хуулийн тайлбар, 2017.
11. Чиба мужийн Өмгөөлөгчдийн холбоо, Эдийн бус хохирлыг үнэлэх нь, Гоёсэй, 2013.
12. Gesetz über Urheberrecht und verwandte Schutzrechte (Urheberrechtsgesetz), 1965.
13. Б.Утевский, Возмещение неимущественного вреда как мера социальной защиты, Еженедельник советской юстиции, 1927, №35.
14. Zweites Gesetz zur Dnderung schadensersatzrechtlicher Vorschriften, Artikel 2, 19 July 2002.
15. Ulrich Magnus et al, InDret, The Reform of German Tort Law, working paper 127, Barcelona, April 2003 .
16. Elizabeth Barrett Ristroph, Ilya Fedyaev, Obstacles to Environmental litigation in Russia and the potential for private actions, Environmental Litigation in Russia, 2006.
17. Определение Судебной коллегии по гражданским делам Верховного Суда, 24.07.1997.
18. Ulrich Magnus, Damages for Non-Pecuniary Loss in German Contract and Tort Law, Oxford, The Chinese Journal of Comparative Law, 12 August 2015.

19. Andrey Tikhonovich Tabunshikov, Vladimir A Anisimov, Institution of compensation for moral harm in civil law of the countries of the Commonwealth of Independent States Institution of compensation for moral harm in civil law of the countries of the Commonwealth of Independent States, *Revista Publicando*, 5 No. 16. (1), 2018.
20. BGB 249(1), Wer zum Schadensersatz verpflichtet ist, hat den Zustand herzustellen, der bestehen würde, wenn der zum Ersatz verpflichtende Umstand nicht eingetreten wäre.
21. BGB 251 (1), Soweit die Herstellung nicht möglich oder zur Entschädigung des Gläubigers nicht genügend ist, hat der Ersatzpflichtige den Gläubiger in Geld zu entschädigen.
22. Herrenreiter, Bundesgerichtshofs (BGH) vom 14. Februar 1958 (BGHZ 26, 349),
23. BGH NJW 2005.
24. Gesetz über Urheberrecht und verwandte Schutzrechte (Urheberrechtsgesetz), 1965.
25. Decree of the Plenum of the Supreme Court of Russian Federation “Some issues on implementation of legislation on compensation for moral damage” *Biull. Verkh. Suda. RF.*, No. 3, 1995.
26. BGHZ 56, 163; BGH NJW 1989, 2317; BGH VersR 2012.
27. Б.Д.Завидов, Моральный вред, 2001.
28. А.М.Эрделевский, Компенсация морального вреда, М., 2007.
29. Ulrich Magnus, Damages for Non-Pecuniary Loss in German Contract and Tort Law, Oxford, *The Chinese Journal of Comparative Law*, 12 August 2015.

З

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ

СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



ЛХАГВАСҮРЭНГИЙН БАНЗРАГЧ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2006 онд эрх зүйч мэргэжлээр төгссөн.

Иргэний эрх зүйн чиглэлээр мэргэшин сургалт, судалгаа, өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байна. Иргэний эрх зүй, хүний эрхийн чиглэлээр дангаар болон хамтран нийт 30 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, гарын авлага хэвлүүлснээс гадна 2017 онд “Гэрээний эрх зүйн онол, арга зүйн асуудал” ном хэвлүүлсэн. Иргэний эрх зүйн чиглэлээр докторын судалгааны ажил эрхэлж байна.

Судлаач:

Л.Банзрагч (LL.M)

ГАРЧИГ

УДИРТГАЛ	222
МАРГААНЫ ТОВЧ АГУУЛГА	225
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦЭГЦТЭЙ БАЙДАЛ БА БҮТЭЦ	226
ХОЁР. ТАЛУУДЫН ДЭВШҮҮЛСЭН ТАЙЛБАРЫГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	229
ГУРАВ. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	235
ДӨРӨВ. НОТЛОХ БАРИМТЫН ҮНЭЛГЭЭ	240
ТАВ. УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛЫН ИТГЭЛ ҮНЭМШИЛ ТӨРҮҮЛЭХҮЙЦ ҮНДЭСЛЭЛ	241
ДҮГНЭЛТ	243
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	244
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	245

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДШ	Улсын Дээд шүүх
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

УДИРТГАЛ

Иргэний эрх зүй дэх нэг тусгай төрөл нь тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалт юм. Уг эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсад 1994 оны Иргэний хуульд “орчин тойрондоо аюул учруулж болох зүйлээс гарах хариуцлага” гэх зүйлийн хүрээнд ерөнхий зохицуулагдаж ирсэн билээ. Ерөнхий гэж байгаа учир нь орчин тойрондоо аюултай зүйлд амьтны учруулсан гэм хор ч хамаардаг байсантай холбоотой. Харин 2002 оны Иргэний хуульд “Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас үүсэх гэм хорыг арилгах” гэж тусгайлан зохицуулах болсны зэрэгцээ хариуцлага хүлээх этгээдэд ялгамжтай зохицуулалт бий болсон. Ийнхүү илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан зохицуулалт агуулсан боловч иргэний эрх зүй дэх эрх зүйн зохицуулалтын хэрэглээ нь шүүхийн практикт нэг мөр болоогүйн зэрэгцээ судлаачдын хувьд ч тухайн эрх зүйн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэх онол, арга зүйн маргаантай хувилбарууд дэвшүүлэн, энэ байдал үргэлжилсээр байна. Мөн Улсын Дээд шүүх (УДШ)-ийн судалгааны тайланд “Энэ төрлийн маргааныг шүүх шийдвэрлэхдээ Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг нэг мөр ойлгоогүй тохиолдол байна”¹ гэж дурджээ.

¹ Улсын Дээд шүүхийн судалгааны тойм, 2014, “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг, хариуцлага хүлээх үндэслэл”.

Энэ нь нэг талаас Иргэний хуулийн 499 дүгээр зүйлд нэр томъёог оновчгүй хэрэглэж, эрх зүйн зохицуулалтыг ойлгомжгүй болгосонтой холбоотой бол нөгөө талаас гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчимд үндэслэсэн зохицуулалттай холбоотой байж болох юм. Тодруулбал, эрх зүйн сэтгэлгээний түүхэн талаас нь авч үзвэл өнөөдрийг хүртэл зөвхөн “гэм буруутай тохиолдолд хариуцлага хүлээнэ” гэх уламжлалт үзэл санаа эрх зүйн сэтгэлгээнд хүчтэй төлөвшсөн. Иймээс гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчмын үүднээс тухайн эрх зүйн зохицуулалтыг тайлбарлаж хэрэглэхэд хүндрэлтэй байдал үүссэн байж болох юм. Мөн тухайн эрх зүйн зохицуулалтад хэрэглэсэн нэр томъёоны хувьд авч үзвэл “эзэмшигч”-ийг тодорхойлох нь маргаантай байна. Өөрөөр хэлбэл, эдийн баялгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд тайлбарлавал тухайн нөхцөлд тээврийн хэрэгслийг бодит мэдэлдээ оруулсан этгээд болох жолооч хамаарах бол тухайн зохицуулалтын зорилго, зарчимд тулгуурлан, улмаар бусад зохицуулалтын уялдаа хамаарлыг анхааран системийн тайлбар хийвэл эзэмшигч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч байж болох гэх мэт ялгаатай тайлбар хийхэд хүргэж байна.

Ийнхүү манай улсад Иргэний хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш даруй 19 жил өнгөрч байхад тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын хэрэглээ төлөвшөөгүй байна. Гэтэл бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан нийт хэргийн дийлэнх хувийг тээврийн хэрэгсэл ашиглах явцдаа бусдад гэм хор учруулсан үйл баримтаас үүссэн эрх зүйн маргаан эзэлж байгаа юм.²

Иргэний хуулийн 499 дүгээр зүйл нь “дүрмийн бус” гэж хэлж болох гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчимд үндэслэхийн зэрэгцээ түүнд агуулагдсан нэр томъёо нь

² Мөн тэнд.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН
ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ

зохистой томъёологдоогүйн улмаас хууль хэрэглээний хувьд эргэлзээтэй нөхцөл бий болгож байгааг анхааран тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас үүсэх гэм хорын маргаантай холбоотой хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг³ тандан судалж, эрх зүйн дүгнэлт⁴ хийхийг зорилоо.

³ “Мтг” ХХК, Я.Б нарын нэхэмжлэлтэй О.Ц-д холбогдох Монгол Улсын Дээд шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 001/ХТ2019/00076 дугаар тогтоол.

⁴ Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээнд төсөлд тавигдах шаардлагын дагуу Улсын Дээд шүүхийн тогтоол сонгож, 2017 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай хамтран гаргасан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй”-г баримталсан болно.

МАРГААНЫ ТОВЧ АГУУЛГА

Хэргийн хариуцагч “О” нь “С” байгууллагын автомашины зогсоолд тээврийн хэрэгслээ байршуулсан. Бусдын тээврийн хэрэгсэл хааж тавьсан тул өөр тээврийн хэрэгсэл гарах тохиолдолд хөдөлгөх, зогсоолын байршлыг солиулах зорилгоор уг зогсоолыг хариуцаж буй “Б”-д тээврийн хэрэгслийнхээ түлхүүрийг үлдээсэн.

Авто зогсоол хариуцаж байсан “Б” нь түлхүүрийг “О”-гийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээд “Т”-д өгч замын хөдөлгөөнд оролцох боломж олгосон байдаг. Гуравдагч этгээд хариуцагчийн тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцож байх үедээ нэхэмжлэгч компанийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг мөргөж, эд хөрөнгөд нь гэм хор учруулсан. Улмаар нэхэмжлэгч компанийн автомашиныг түрээсийн гэрээгээр ашиглаж байсан этгээд “Я” унаж явсан бөгөөд түүний эрүүл мэндэд хохирол учирсан байна. Иймээс нэхэмжлэгч “Т” ХХК нь хариуцагч “О”-гоос эд хөрөнгөд учирсан хохирол, иргэн “Я” нь эрүүл мэндэд учирсан хохирлыг тус тус мөнгөн хэлбэрээр шаардсан байдаг. Хариуцагч “О” нь гэм хор учирсан эсэх асуудалд болон хохирлын хэмжээний асуудлаар маргадаггүй. Харин өөрийгөө уг гэм хорыг учруулаагүй тул гэм хорын хохирлыг арилгах үүрэггүй гэж маргадаг. Анхан болон давж заалдах шатны шүүх хариуцагч “О”-гоос нэхэмжлэгчдэд учирсан гэм хорын хохирлыг гаргуулахаар шийдвэрлэснийг хариуцагч эс зөвшөөрч хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан байна.

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦЭГЦТЭЙ БАЙДАЛ БА БҮТЭЦ

Формаль эрх зүйн шаардлага болох шүүхийн шийдвэрийн цэгцтэй байдал ба бүтцийг энэ хэсэгт авч үзье. Энэхүү эрх зүйн шаардлагыг шүүхийн тогтоол хуульд заасан бүтцээр бичигдсэн эсэх, тогтоолын бүтцийн харьцаа зохистой байгаа эсэх, шүүхийн тогтоолын бүтцийн агуулга гэсэн хүрээнд авч үзнэ.

Шүүхийн тогтоол хуульд заасан бүтцээр бичигдсэн эсэх

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгүүдээс бүрддэг. Бүх шатны шүүхээс гарч буй шийдвэр ийм бүтэцтэй байх бөгөөд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн бүрэн эрхийн дагуу хянан шийдвэрлэгдсэн асуудал тус бүр шийдвэрийн агуулгад тусгагдсан байна.⁵ Улсын Дээд шүүхийн 001/ХТ2019/00076 дугаартай тогтоолд удиртгал, тодорхойлох хэсгийг тухайлан нэрлэн тодорхойлоогүй боловч хуульд заасан бүтцийг хадгалжээ. Харин үндэслэх хэсгийг “хянавал” гэж томъёолон нэрлэсэн байна. Шүүхийн тогтоол хуульд заасан бүтцийг хадгалсан, хуульд заасан хэлбэрээр бичигдсэн байх боловч

⁵ Ц.Амарсайхан, Л.Бямбаа, А.Доржготов нар, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2014, 313 дахь тал (ISBN 978-99929-2-053-Х).

хянавал хэсэгт хуулийн тайлбар агуулаагүй, хэтэрхий товч болсон байх тул уг бүтцийг хэлбэрийн төдий агуулсан гэж дүгнэхээс өөр аргагүй байна.



Тогтоолын бүтцийн харьцаа зохистой байгаа эсэх

Улсын Дээд шүүхийн тогтоолын бүтцийн зохистой харьцааг авч үзвэл тус тогтоол нь зургаан нүүрт багтсан ба үүнд удиртгал хэсэг нэг, тодорхойлох хэсэг нь гурван нүүр тус тус, үндэслэх буюу хянавал хэсэг нэг нүүр хагас, тогтоох хэсэг нэг нүүрний гуравны нэг хэсгийг эзэлжээ. Эндээс үзвэл шүүхийн шийдвэрийн хянавал хэсэг тодорхойлох хэсгийн гуравны нэгтэй тэнцэж байгаа нь шүүхийн шийдвэрийн бүтцийн харьцаа илт алдагдсан байгааг харуулж байна.⁶ Улсын Дээд шүүхийн тогтоолын хянавал хэсэг нь тодорхойлох хэсгээс илт бага хувь эзэлж байгаа нь шүүх хэрэг шийдвэрлэхдээ хууль хэрэглэх, тайлбарлах үйл явцыг хангалтгүй хэрэглэж байгааг илтгэж байна.

Шүүхийн тогтоолын бүтцийн агуулга

Шүүхийн тогтоолын агуулгыг удиртгал хэсгийн хүрээнд авч үзвэл: Удиртгал хэсэгт тухайн шүүх хуралдаанд оролцогчдыг нэрлэн заадаг. Хэргийн оролцогчдын нэр ямар хэрэг шийдвэрлэж байгаа хэсэгт заагдсан хэдий ч эдгээр оролцогчийн хэн нь шүүх хуралдаанд оролцсон болохыг удиртгал хэсэгт заахаар хуульд журамласан байна. Нэхэмжлэгч, хариуцагч шүүх хуралдаанд оролцоогүй тохиолдолд эрх зүйн тодорхой үр дагавар үүсдэг тул шүүх

⁶ Б.Буянхишиг "...Эх газрын эрх зүйн практикт шийдвэрүүдийг тодорхойлох хэсэг таван нүүр байхад үндэслэх хэсэг дор хаяж 10-25 нүүр байх нь элбэг..." гэж тэмдэглэжээ. "Шүүх эрх мэдэл" сэтгүүл, 2015, №1, 60 дахь тал.

хуралдаанд тэрээр оролцсон эсэх нь шийдвэрийн удиртгал хэсэгт тодорхой тусгагдсан байх учиртай юм.⁷ Гэтэл удиртгал хэсэгт шүүх хуралдаанд “нэхэмжлэгчийн өмгөөлөгч Э оролцов” гэж тэмдэглэжээ. Тус иргэний хэргийн хувьд нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлага нь нэг бус, тус тусдаа шаардлага бүхий хоёр нэхэмжлэгчтэй хэрэг юм. Эдгээр нэхэмжлэгчийн хэнийх нь өмгөөлөгч оролцсон нь тодорхойгүй эсхүл хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон нэг өмгөөлөгч хоёр нэхэмжлэгчийн аль алиныг өмгөөлж байгаа бол нэхэмжлэгчдийн өмгөөлөгч гэж тэмдэглэх шаардлагатай байсан.

Шүүхийн тогтоолын агуулгыг хянавал хэсгийн хүрээнд авч үзвэл: Энэ хэсэгт “...хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон байна”, “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасныг зөрчөөгүй байна”, “Хариуцагчаас хэргийн оролцогчийн эрхийг хязгаарласан гэсэн үндэслэлээр гаргасан гомдолд давж заалдах шатны шүүхээс хийсэн дүгнэлт үндэслэл бүхий байна” гэх мэт байдлаар ямар ч тайлбаргүй, үндэслэлийг тодорхой заагаагүй, хэт товч дүгнэлт хийсэн байна. Хариуцагч давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч шүүхийн магадлалд заасан үндэслэлийг үгүйсгэн, хяналтын шатны шүүхэд хандсан байхад хяналтын шатны шүүх хянавал хэсэгтээ үндэслэлтэй тайлбар хийх үүрэгтэй байтал огт тайлбар хийхгүйгээр “давж заалдах шатны шүүхээс үндэслэл бүхий дүгнэлт хийсэн байна” гэж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн гэх гомдлыг үндэслэлгүй гэж дүгнэхдээ үндэслэлээ хэлбэрийн төдий тусгаж шийдвэрлэжээ.

⁷ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай” зөвлөмж, 2.7 дахь хэсэг.

ХОЁР. ТАЛУУДЫН ДЭВШҮҮЛСЭН ТАЙЛБАРЫГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын дэвшүүлсэн тайлбар (нэхэмжлэл, хариу тайлбар, шүүх хуралдаанд гаргасан тайлбар, давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол, түүний эсрэг гаргасан хариу тайлбар)-ыг хууль тогтоомж болон хэрэгт авагдсан нотлох баримттай харьцуулан дүгнэлт хийх замаар шүүх маргааныг шийдвэрлэдэг.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр нь талуудаас шүүхэд гаргаж буй тайлбар үндэслэлтэй эсэхийг шалган тогтоох ажиллагааны үр дүн байдаг. Иймд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудаас шүүхэд гаргаж буй тайлбарт шүүх үндэслэл бүхий дүгнэлт хийх нь зайлшгүй шинжтэй. Хэрэв талуудын тайлбарт агуулагдаж буй нөхцөл байдал, хууль зүйн үндэслэл бүрд дүгнэлт хийхгүйгээр хэргийг шийдвэрлэвэл тухайн шийдвэр “**хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх**” хуулийн шаардлага хангагдахгүй. Иймд талуудын дэвшүүлж буй тайлбарыг шүүх үндэслэл бүхий үнэлсэн байдалд дараах байдлаар дүн шинжилгээ хийж байна.

1. Дүн шинжилгээ хийж буй шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол учир хяналтын шатны журмаар гаргаж байгаа гомдолд дэвшүүлж буй үндэслэл, түүний эсрэг амаар (шүүх хуралдаанд гаргаж буй тайлбар) болон бичгээр гаргаж буй тайлбарын хүрээнд дүн

шинжилгээ хийх нь зохистой. Улсын Дээд шүүхийн тогтоолоос харвал нэхэмжлэгчийн хувьд шүүхэд амаар болон бичгээр тайлбар гаргаагүй байна. Хариуцагч нь шүүхэд хууль хэрэглээний асуудлаар дараах тайлбар гаргажээ. Үүнд:

а. Материаллаг эрх зүйн хүрээнд:

Шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн. Энэ зохицуулалтын дагуу гэм хорыг арилгуулах асуудлыг шийдвэрлэхдээ нэхэмжлэгч талд гэм хор учруулсан хариуцагчийн хууль бус үйлдэл, гэм буруу, гэм хор болон буруутай үйлдэл, эс үйлдэхүйн хоорондын шалтгаант холбоог нарийвчлан тогтоогоогүй, зөвхөн тээврийн хэрэгсэл эзэмшигч л хохирлыг бүрэн арилгах ёстой гэж үзсэнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд шүүх тухайн харилцаанаас үүссэн эрх зүйн маргааныг хууль зүйн үндэслэлтэй хянан шийдвэрлэсэн гэж үзэхгүй байна.

б. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хүрээнд:

Хариуцагч “Шүүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам ноцтой зөрчсөн. Миний өмгөөлөгч хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан боловч уг хүсэлтийг шүүх хүлээж аваагүй шүүх хуралдааныг үргэлжлүүлсэн нь өмгөөлүүлэх эрхийг ноцтой зөрчсөн байна” гэж өмгөөлүүлэх эрх хангагдаагүй талаар гомдол гаргасан байна.

2. Хариуцагчийн дэвшүүлсэн дээрх тайлбарт буюу гомдлын хариуд Улсын Дээд шүүх үндэслэл бүхий

дүгнэлт өгөөгүй төдийгүй иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хүрээнд гаргасан тайлбарт хууль зүйн үндэслэл бүхий ямар ч дүгнэлт хийгээгүй орхигдуулсан байгааг юуны өмнө дурдах нь зүйтэй.

а. Материаллаг эрх зүйн хүрээнд гаргасан хариуцагчийн дэвшүүлсэн тайлбарын агуулгын хүрээнд шүүх үндэслэл бүхий дүгнэлт өгөөгүй, нэн ялангуяа хариуцагчийн дэвшүүлсэн гол үндэслэлийг үндэслэлтэй эсхүл үндэслэлгүй болохыг дүгнээгүй байна. Тухайлбал:

- Хариуцагчийн хувьд жолоодож явсан этгээд эсхүл түүнд түлхүүр шилжүүлсэн этгээд гэм хорыг хариуцах ёстой гэдэг агуулгаар маргаж, гэм хор учруулсан үйлдэл болон хохирлын шалтгаант холбоог үндэслэн тайлбарласан. Өөрөөр хэлбэл, авто зогсоол хариуцаж буй хүнд түлхүүр үлдээсэн өөрийнхөө үйлдлийг нэхэмжлэгчдэд учирсан хохиролтой шалтгаант холбоогүй гэж тайлбарласан байхад шүүх хариуцагчийн үйлдэл нь учирсан хохиролтой “шалтгаант холбоо”-той эсэх асуудалд ямар ч дүгнэлт хийгээгүй байна.
- Улмаар хариуцагч нь анхан болон давж заалдах шатны шүүхэд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг хэрэглэх хууль зүйн үндэслэлгүй гэж гомдол гаргасан. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх хуулийн дээрх заалтыг хэрэглээгүй байдаг. Харин Улсын Дээд шүүх анхан болон давж заалдах шатны шүүх уг заалтыг хэрэглээгүй болохыг дурдаагүй.

Хэрэв Улсын Дээд шүүх хариуцагчийн гомдлыг анхаарч, түүний гомдолд дүгнэлт хийсэн бол хариуцагчийн үндэслээд байгаа Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг бүх шатны шүүх хэрэглээгүй болохыг дурдахаас гадна яагаад хэрэглэхгүй байгааг тайлбарлах байсан. УДШ хуулийн дээрх заалтыг Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3 дахь хэсэгтэй холбон тайлбарласан бол бүх шатны шүүх яагаад нэхэмжлэгчдэд учирсан хохирлыг хариуцагч арилгах үүрэгтэй гэж шийдвэрлээд байгаагийн хууль зүйн үндэслэл тодорхой болох байв.

- Гэм хорын эрх зүйд орчин тойрондоо аюултай зүйлийг өмчлөгч нь ямагт хянамгай байх үүрэгтэй гэж үздэг бөгөөд тээврийн хэрэгсэл нь орчин тойрондоо аюул учруулж болох аюултай зүйлд хамаардаг болохын хувьд тээврийн хэрэгслийн өмчлөгчид ч энэ үүрэг нэгэн адил хамаардаг. Энэ утгаараа гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх гэм буруугийн зарчмын дагуу өмчлөгч нь тухайн тээврийн хэрэгслийг өмчлөгч бус этгээд жолоодож явсан эсэхээс үл хамаарч хариуцлага хүлээх учиртай. Иргэний хуулийн 499 дүгээр зүйл нь 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгээс ялгаатай зохицуулагдсан бөгөөд дээрх тохиолдолд тээврийн хэрэгслийн өмчлөгч нь тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас нэхэмжлэгчдэд учирсан хохирлыг арилгах үүрэгтэй болж байгаа болно.

- Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1 дэх хэсэгт “...эзэмшигч хариуцна” гэж заасан бөгөөд эзэмшигч нь тухайн тохиолдолд өмчлөгч “О” мөн эсэхийг тайлбарлах шаардлагатай байсан. Хэрэв Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд зааснаар тайлбарлавал “О” нь эзэмшигч биш тул хариуцлага хүлээхгүй. Гэвч эдийн баялгийн эрх зүй дэх эзэмшлийн зохицуулалт гэхээс илүү тухайн зохицуулалтын зорилго, системчлэлд үндэслэн хөрөнгийн өмчлөгчийг эзэмшигч гэж тайлбарлах шаардлага үүснэ. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 499.3-т заасан “ашиглагч” гэх нэр томъёотой холбон тайлбарлавал ашиглагч нь тухайн нөхцөлд тээврийн хэрэгсэл жолоодож байсан этгээдийг ойлгох тул эзэмшигчийг 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэгт зааснаар тайлбарлах боломжгүй бөгөөд эзэмшигчийг тээврийн хэрэгслийн өмчлөгч гэж тайлбарлах нь зүйд нийцнэ. Иймд хариуцагч “О” нь эзэмшигч болохын хувьд тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас бусдад учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. Нөгөө талаас “О” нь орчин тойрондоо аюултай зүйлийг эзэмшигчийн хувьд түүний гэм буруутай эсэхээс үл хамаарч хариуцлага хүлээх гэм буруугүйн зарчим үйлчилж байгаа болно. Ийнхүү дээрх үндэслэлийг шүүх тайлбарласан бол шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх шаардлага хангагдах байжээ.
- б. УДШ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хүрээнд хариуцагчийн гаргасан гомдолд дүгнэлт өгөлгүй орхигдуулсан. Хариуцагч иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хүрээнд

дэвшүүлж буй гомдолдоо “Хууль зүйн туслалцаа авах эрхийг нь хязгаарласан” гэсэн үндэслэл дэвшүүлсэн. Гэтэл шүүх энэ гомдолд хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт өгөөгүй нь “шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” хуулийн шаардлага хангаагүй гэж үзэхээр байна. Хариуцагчийн гаргасан гомдол үндэслэлтэй байсан тохиолдолд хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах хууль зүйн үр дагавар үүсэх байсан. Учир нь анхан шатны шүүхийн гаргасан иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдааг дараагийн шатны шүүх засах боломжгүй буюу хууль зүйн туслалцаа авах, өөрөөр хэлбэл, өмгөөлүүлэх эрхийг нь хяналтын шатанд нөхөн эдлүүлэх боломжгүй тул хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх нь зүйтэй байсан. Үнэхээр өмгөөлөгчид нь хэргийн материалтай танилцах боломж олгоогүй бол энэ нь ялимгүй зөрчил бус Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн зөрчил болно.

ГУРАВ. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- а. *Шүүхийн шийдвэр хуулийн тайлбарт үндэслэл шаардлагатай тухайд*
- Шүүх хэргийг хуулийн зүйл, заалтыг үндэслэн шийдвэрлэдэг. Ийнхүү хэргийг шийдвэрлэсэн шүүх хуулийн тодорхой зүйл, заалтыг хэрэглэхдээ дур зоргын шинжтэй эсхүл таамгаар ханддаггүй. Харин тухайн зүйл, заалтыг тайлбарлах буюу яагаад энэ заалтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож байгааг хэргийн оролцогчдод ойлгомжтой тайлбарлаж хэрэглэх шаардлагатай. Гэвч шүүх оюун дүгнэлт хийж, хуулийн тодорхой заалтыг үндэслэдэг атлаа бичгээр буулгасан шүүхийн шийдвэрт ихэнх тохиолдолд хуулийн тодорхой заалтыг яагаад үндэслэсэн тухайгаа тусгаагүй байдаг. Ийнхүү хуулийг тайлбарлаж хэрэглэлгүй гарсан шүүхийн шийдвэрийн үндэслэл хэргийн оролцогчид ойлгомжгүй байдаг нь бодит үнэн.
 - Нэн ялангуяа хяналтын шатны шүүх хууль хэрэглээний маргааныг шийдвэрлэдгийн хувьд “яагаад?” гэх асуултад хариулах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, хуулийн тухайн заалтыг яагаад хэрэглэх болсон, өрсөлдөх хэм хэмжээ эсхүл нэхэмжлэгчийн хувьд шаардах эрхийн үндэслэл болгосон хуулийн

заалтыг, мөн нөгөө талаас хариуцагчийн хувьд шаардах эрхийн үндэслэлийг үгүйсгэсэн хуулийн заалт үндэслэж байгаа бол тэр бүгдийг яагаад хэрэглэх болсон эсхүл яагаад хэрэглээгүй болохыг тайлбарлах учиртай.

б. *УДШ-ийн тогтоолд үндэслэл болгож буй хуулийн заалтыг тайлбарлан хэрэглэсэн эсэх асуудалд*

- Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3 дахь хэсгийн эрх зүйн зохицуулалтын онцлог нь гэм хорын эрх зүй дэх гэм буруугийн зарчим бус харин гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчимд үндэслэсэн байдаг. Энэ утгаараа гэм хорын эрх зүйн шаардах эрхийн ерөнхий үндэслэл болсон гэм буруутай байхыг шаарддаг Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийн зохицуулалтаас зарчмын ялгаатай. Ийнхүү гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим үйлчилдэг тул зарим тохиолдолд хэргийн оролцогчид, нэн ялангуяа хариуцагч нь шүүхээс гэм хорын хохирлыг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд гэм буруугүй байхад яагаад гэм хорын хохирол хариуцахаар шийдвэр гарсан тал дээр эргэлзэх үндэслэл болдог.
- Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3 дахь хэсгийг нэхэмжлэгчийн шаардах эрхийн үндэслэл болгон шийдвэрлэж байгаа тохиолдолд заавал тайлбар хийх шаардлагатай. Учир нь энэ заалт нь гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчимд үндэслэсэн зохицуулалт юм.
- УДШ-ийн тогтоолын хувьд “хянавал” хэсэгт “тогтоох” хэсгийн тайлбар агуулагдах учиртай

боловч дүн шинжилгээ хийж буй шийдвэрийн хувьд Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3 дахь хэсгийг шийдвэрийн тогтоох хэсгийн үндэслэл болгохдоо тайлбарлалгүй хэрэглэсэн. Гэтэл маргааны хувьд авч үзвэл шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг хэрэглээгүй үндэслэл, мөн Иргэний хуулийн 499.3 дахь хэсгийг шаардах эрхийн үндэслэл болгосон үндэслэлээ тайлбарлах бодит шаардлага байсан. Учир нь хариуцагч шүүх хуулийг зөв хэрэглэн, хэргийг үнэн зөв шийдвэрлэж байгаа эсэх асуудалд эргэлзсээр, аль ч шатны шүүх эргэлзээг нь үл анхаарч, улам эргэлзүүлсэн шийдвэр гаргасаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан байгааг тэмдэглэх нь зүйтэй.

в. Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон материаллаг эрх зүйн хэм хэмжээнд хийсэн дүгнэлт

Материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн байдалд дүгнэлт хийхийн тулд зөвхөн иргэний хуулийн 499.3 дахь хэсгээр хязгаарлахгүй, илүү тодорхой, ойлгомжтой байх үүднээс холбогдох бусад зохицуулалт, өмнө дурдсан гэм буруутайгаар хариуцлага хүлээх зарчим болон гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчмыг тодорхой авч үзье.

- *Гэм буруутай байх болон гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим:* Гэм буруутай байх зарчмын хувьд XIX зууныг хүртэл асуудал бага байсан боловч үйлдвэрлэлийн хөгжил дагасан осол аваартай холбоотойгоор ажилтны учруулсан хохирлыг үйлдвэрийн эзэн хариуцах эсэх асуудал

хурцаар тавигдаж ирсэн.⁸ Гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчмын агуулга нь урьдчилсан нөхцөлийн хувьд “гэм буруу”-г авч үзэхгүй, харин зөвхөн шалтгаан болон үр дагаврыг чухалчилна. Гэм буруугүйгээр гэм хорыг нөхөн төлөх үүрэг үүсгэх зохицуулалтын тухайд эрх зүйн тогтолцооны хооронд ялгаатай. Гэм буруугүйгээр гэм хор учруулснаас үүрэг үүсэх асуудал Ромын эрх зүйд байсан боловч ийм үүрэг үүсэх үндэслэлийн талаар хангалттай тайлбар байдаггүй гэж үздэг.⁹ Ийнхүү иргэнлэг эрх зүйн системийн гол төлөөлөгч болсон орнуудын хувьд хуульд гэм буруугүйгээр хариуцлага хүлээх тухай зохицуулалтыг Иргэний хуульд шууд заасан байх нь ховор байдаг ч үүрэг огт үүсэхгүй гэж үздэггүй. Францад шүүхийн бүтээлч тайлбар гаргах замаар энэ асуудлыг шийдвэрлэж ирсэн бол Германд тусгайлсан хуулиар тодорхойлсон тохиолдолд үүрэг үүсэх үндэслэл болдог. Тухайлбал, амьтны учруулсан гэм хор, Замын хөдөлгөөний хуулиар машин эзэмшигчийн хариуцлага, Цөмийн энергийн тухай хууль гэх зэргээр тусгайлсан хуулиар заасан байдаг.¹⁰

- *Иргэний хуулийн 497.1 дэх хэсгийн тухайд:* Иргэний хуулийн 497 дугаар зүйл нь гэм хорын эрх зүйн суурь болсон ерөнхий зохицуулалт бөгөөд хохирогчид учруулсан гэм хорыг түүнийг учруулсан этгээдээр нөхөн төлүүлэхийн тулд уг

⁸ Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, 2013, 96 дахь тал (ISBN 978-99973-2-190-9).

⁹ R.Zimmermann, The Law of Obligations: The Roman Foundations of the Civilian Tradition (1996), p.366.

¹⁰ Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, 2013, 102 дахь тал (ISBN 978-99973-2-190-9).

этгээд нь гэм буруутай байх ерөнхий зарчим аль ч эрх зүйн тогтолцоонд тогтсон байна.¹¹ Энэхүү зарчим нь иргэнлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудын Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий зохицуулалтад ихэвчлэн тусгалаа олсон байдаг. Тухайлбал, Монгол Улсын хувьд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж заасан бол харин ХБНГУ-ын Иргэний хуулийн 823.1-д “Бусдын амь нас, бие, эрүүл мэнд, эрх чөлөө болон бусад төстэй эрхэд санаатай эсвэл болгоомжгүй, хууль бусаар хохирол учруулсан этгээд нь түүний улмаас учирсан бүх хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй” гэж заажээ.

¹¹ K.Zweigert&H.Koetz, Comparative law: Volume II, The Institutions of Private Law (1977), p. 266.

ДӨРӨВ. НОТЛОХ БАРИМТЫН ҮНЭЛГЭЭ

УДШ-д талууд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр буюу хуулийн хэрэглээ болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн асуудлаар гомдол гаргана.

Улсын Дээд шүүх энэ үндэслэлийн хүрээнд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хуульд заасан үндэслэлийн хүрээнд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд үйл баримтыг дүгнэхгүй, зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, хууль хэрэглээний асуудлыг хянах чиг үүрэгтэй. Тодруулбал, нотлох баримт үнэлсэн асуудалд дүгнэлт хийхгүй. Гэхдээ шүүх дүгнэлт хийх шаардлагатай гэж үзэн, нэгэнт үйл баримтад дүгнэлт өгч нотлох баримтыг үнэлж байгаа бол ямар үйл баримт нь хэрэгт авагдсан ямар нотлох баримтаар тогтоогдож байгааг тодорхой заах ёстой. Гэтэл тогтоолын хянавал хэсэгт “...үйл баримт хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон байна” гэж тодорхойгүй бичсэн нь туйлын ойлгомжгүй, учир дутагдалтай байгааг илтгэж байна.

ТАВ. УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛЫН ИТГЭЛ ҮНЭМШИЛ ТӨРҮҮЛЭХҮЙЦ ҮНДЭСЛЭЛ

Шүүхийн шийдвэрийн итгэл үнэмшил төрүүлэхүйц байх шаардлага нь талуудын дэвшүүлсэн тайлбарт үндэслэл бүхий хариулт өгснөөр хангагдана. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нэхэмжлэгч болон хариуцагчийн дэвшүүлсэн тайлбарт шүүх үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй. Нэн ялангуяа хариуцагчийн дэвшүүлсэн анхан шатны шүүх өмгөөлүүлэх эрхийг нь хязгаарлаж, үндсэн эрхийг зөрчсөн талаар гаргасан гомдолд дүгнэлт өгөөгүй нь шүүхийн шийдвэр итгэл үнэмшил төрүүлэхүйц байх шаардлагыг хангаагүй байна гэж үзэхээр байна.

а. Шүүх хуулийг нэг мөр хэрэглэх

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3 дахь хэсгийг үндэслэн нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэж буй нь практикт хууль хэрэглээний хүрээнд тогтсон асуудал болохын хувьд шийдвэрийн хүрээнд хуулийн хэрэглээ нэг мөр тогтсон. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд эргэлзээтэй байдал бий болгож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээг нэг мөр хангаж чадаагүй гэж үзэхээр байна.

б. Хуулийн үр нөлөө

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн хувьд хариуцлага хүлээх субъектийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч гэсэн нэр

томъёогоор илэрхийлсэн нь хуулийг хэрэглэхэд төвөгтэй байдал бий болгосон байна. “Эзэмшил”-ийг тодорхойлох тогтсон үзэл бодлын хүрээнд авч үзвэл тээврийн хэрэгслийг өөрийн бодит мэдэлдээ авсан этгээд эзэмшигч болно. Энэ агуулгаараа түлхүүрийг авч тухайн үед машин жолоодож байсан этгээд эзэмшигч болох боломжтой. Тэгвэл ашиглагч нь хэн байх вэ? гэдэг асуудал тулгарах болно. Энэ мэтчилэн “өмчлөгч” болон “эзэмшигч”, “ашиглагч”-ийг тодорхойлох үед тайлбар хийх шаардлага үүсэхээр байдаг. Гэвч шүүх хуулийг хэрэглэхдээ энэ асуудлаар тайлбар хийгээгүй байна.

Ийнхүү нэр томъёоны маргаантай байгаа асуудлыг УДШ хэрэг шийдвэрлэхдээ хариуцагчийг “өмчлөгч” эсхүл “эзэмшигч”-ийн аль нь болохыг тодорхойлохгүй шийдвэрлэсэн байна.

ДУГНЭЛТ

УДШ-ийн тогтоолын нийтлэг алдаа, хуулийн хэрэгжилтийн байдлыг нэгтгэн дараах ерөнхий дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. УДШ-ийн тогтоолын бүтэц нь хэлбэрийн хувьд хуульд заасан шаардлага хангаж байгаа хэдий ч агуулгын хувьд удиртгал болон “хянавал” хэсэг нь алдаатай байна. Тодруулбал, удиртгал хэсэгт шүүх хуралдаанд оролцогчдыг нэрлэн заахдаа алдаа гаргасан бол хянавал хэсэгт тухайн тогтоолын үндэслэл тусгагдаагүй байна.
2. УДШ хууль хэрэглээний маргааныг эцэслэн шийдвэрлэх үүрэгтэй болохын хувьд казуал тайлбар хийж, маргааныг шийдвэрлэсэн бол шүүхийн практикт төдийгүй сургалт, судалгаанд ач холбогдолтой шийдвэр болох байжээ.
3. Нэхэмжлэгч болон хариуцагч талын шүүхэд гаргаж буй тайлбар, гомдолд үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй буюу үндэслэлээ дэлгэрүүлж тайлбарлаагүй нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байна.
4. Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1 дэх хэсэгт “...эзэмшигч хариуцна” гэж заасан нь “эзэмшигч нь өмчлөгч үү?” эсхүл “өмчлөгчөөс бусад этгээд болох тээврийн хэрэгслийг тухайн мөчид мэдэлдээ оруулсан этгээд үү?” гэх мэт хууль хэрэглээний хувьд маргаантай байдал үүсэх нөхцөл бий болгож байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдэд:

- Нэхэмжлэгч болон хариуцагчийн шүүхэд гаргасан тайлбар, гомдлын үндэслэлийг яагаад үндэслэлтэй гэж дүгнэсэн эсхүл яагаад үндэслэлгүй гэж дүгнэсэн дүгнэлтээ дэлгэрэнгүй тайлбарлаж байх;
- Хэргийн оролцогчид иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн шийдвэр, тогтоолтой танилцаад хэргийн шийдвэрлэлтэд эргэлзэхгүй байх нөхцөл бүрдүүлэхэд анхаарах.

Хууль тогтоогчдод:

- Иргэний хуулийн Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх гэм хорын зохицуулалтын 499.1, 499.3, 499.4 дэх хэсгийн “өмчлөгч, эзэмшигч, ашиглагч” гэсэн нэр томъёог тодорхой болгон хуульчлах.

ЭХ СУРВАЛЖ

1. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2013.
2. Б.Буянхишиг, Үүргийн эрх зүйн ерөнхий анги, УБ., 2013.
3. Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, УБ., 2013.
4. Х.Сонинбаяр, Г.Алтанчимэг, Ц.Амарсайхан нар, Монгол Улсын иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), УБ., 2016.
5. УДШ-ийн 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай” зөвлөмж.
6. “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2015, №1.
7. “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2016, №1.
8. R.Zimmermann, The Law of Obligations: The Roman Foundations of the Civilian Tradition (1996).
9. K.Zweigert&H.Koetz, Comparative law: Vol. II, The Institutions of Private Law (1977).

4

ЭДИЙН БУС ГЭМ ХОРЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА



МӨНХБАЯРЫН ВАНЧИГМАА

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль зүйн доктор.

Хувийн, өв залгамжлалын, гэрээний болон гэм хорын эрх зүй, эрүүгийн процесс, иргэний процессын эрх зүйн чиглэлээр сургалт, судалгааны ажил эрхлэн явуулдаг.

Судалгааны чиглэлээр ном, гарын авлага 10, орчуулгын бүтээл нэг, хамтарсан бүтээл нэг, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 14, нийтлэл 10 орчмыг хэвлэн нийтлүүлж, зургаан судалгаа шинжилгээ, төсөл хөтөлбөрт оролцож, хоёр хуулийн төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгад санал дэвшүүлсэн.

Судлаач:

М.Ванчигмаа
Хууль зүйн доктор

ГАРЧИГ

УДИРТГАЛ	249
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА	252
Хэргийн агуулга	253
Шүүхийн шийдвэр	255
ХОЁР. ДҮН ШИНЖИЛГЭЭ	266
А. Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт хийсэн дүн шинжилгээ	266
Б. Материаллаг эрх зүйн үүднээс хийсэн дүн шинжилгээ	268
В. Процессын эрх зүйн үүднээс хийсэн дүн шинжилгээ	285
Г. Хэлбэрийн болон хууль зүйн техникийн шаардлага	286
ДҮГНЭЛТ	288
САНАЛ	293
ЭХ СУРВАЛЖ	296

УДИРТГАЛ

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь тодорхой шүүхийн шийдвэрийг хууль зүйн талаас нь задлан анализ хийж хууль хэрэглээ, онол-практикийн холбоо хамаарал, ач холбогдлын талаар тайлбарлан бичсэн эрдэм шинжилгээний ажлын нэг төрөл болно.¹ Нөгөөтгээгүүр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь эрх зүйн онол, үзэл санаа, шүүхийн практикийг судалж, улмаар онол, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, нэгдмэл аргачлал төлөвшүүлэх ач холбогдолтой.

Энэхүү судалгаагаар шүүгчийн хараат бус, бие даасан байдлыг хөндөхгүйгээр дүн шинжилгээ хийж, сонгож авсан кэйст үндэслэн судлаачийн зүгээс дүгнэлт, санал гаргахыг зорилоо. Дүн шинжилгээг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай хамтран боловсруулсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй”-д тулгуурлан гүйцэтгэв.²

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийн агуулгын талаар

¹ С.Должин, “Хувийн эрх зүй” эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017, 78 дахь тал.

² Шинжилгээний арга зүйг “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлийн 2017 оны №2-ын 113-122 дахь талаас харна уу.

<http://judinstitute.mn/main/209--.html>

Энэхүү дүн шинжилгээг хийх үед ННФ-аас боловсруулсан судалгааны тайланд мэдээллийн эх сурвалжийн эшлэл хийх заавар боловсруулагдаагүй байсан тул судалгааны ажлын эх сурвалж эшлэх ерөнхий загварын дагуу эшлэн тэмдэглэсэн болно.

“Шүүхийн шийдвэр удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох” хэсгээс бүрдэнэ гэж заасан байх бөгөөд мөн хуулийн 118 дугаар зүйлийн 118.4 дэх хэсэгт шүүхийн шийдвэрт “Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заана”³ гэжээ. Энэ нь “шүүх өөрийн гаргаж буй шийдвэрийг үндэслэхдээ Монгол Улсын дурын иргэнд ойлгомжтойгоор, логиктой тайлбарлах үүрэг хүлээнэ”⁴ гэснээр тайлбарлагдах, хууль ёсны зарчмын илэрхийлэл болдог. Учир нь нийгмийн харилцаа баялаг тул хуулийн ерөнхий заалт, зарчмыг шүүгч үндэслэлтэйгээр тайлбарлаж, эрх зүйн харилцааг зохицуулан шийдвэрлэж байх нь оновчтой юм.

Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд нь сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогчийн шаардах эрхийг хуульчлан уг хохиролд материаллаг бус бүх хохирлыг багтаадаг. Иргэний хуулийн тайлбарт дурдахдаа “Бие эрхтний болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна”⁵ гэх боловч шүүхийн практикт ялгамжтай байдлаар авч үзэх нь нийтлэг байгааг харгалзан хуулийн холбогдох заалтыг нэг мөр ойлгон хэрэглэх, иргэний эрх ашгийг хамгаалах иргэний эрх зүйн суурь зарчмыг баримтлах асуудлыг хөндөхийг эрмэлзэв.

³ Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.4 дэх хэсэгт, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2002, №8.

⁴ Б.Тэмүүлэн, Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, 2014, №2.

⁵ Ё.Кают, Э.Шпанглер нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2010. 458 дахь тал.

Аливаа шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд бүх шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тодорхой нэг маргааны шүүхийн шийдвэрийг сонгон авч үзэх нь тохиромжтой байдаг. Иймд судлаач уг дүн шинжилгээ хийж буй шүүхийн шийдвэрийг сонгохдоо Иргэний хуулийн 52 дугаар бүлгийн **Гэм хор учруулснаас үүсэх үүрэгт** хамаарах маргааныг шийдвэрлэсэн төсөөтэй маргаануудаас түүврийн аргаар шүүж, товлосон шийдвэрүүдээс дахин санамсаргүй түүвэрлэх замаар санамсаргүй болон зорилтот түүврийн аргыг хослуулан сонгосон болно.



НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдэд учирсан эдийн бус гэм хорын нэхэмжлэлтэй маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 001/ХТ2018/00169 дугаартай⁶ тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Уг тогтоолд Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 157 дугаар магадлал, Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2, 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас 15,689,500 төгрөг гаргуулан нэхэмжлэгч Б.Э, Д.И нарт олгож, нэхэмжлэлээс 11,812,800 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчлөн шийдвэр, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээж, прокурорын гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байдаг.

⁶ Шүүхийн шийдвэрийг дараах линкээр орж үзнэ үү.
<http://new.shuukh.mn/irgenhyanalt/3809/view>

Хэргийн агуулга

Д.И, Б.Э нар нь эхнэр, нөхөр бөгөөд “Э-О” ХХК-ийн нэр дээр зохих зөвшөөрөл, лицензийн дагуу хувийн хэвшлийн эмнэлэг ажиллуулж байгаад эмнэлгээ өргөтгөх, нөхцөлийг нь сайжруулах зорилгоор 2004 оны 10 дугаар сарын 4-нд “Ц.И” ХХК-ийн 1,026 м.кв байрыг худалдан авахаар урт хугацааны гэрээ хийн, эзэмших болжээ. “Ц.И” ХХК-ийн байрны өмчлөлийг хожим шилжүүлэн өгсөн байна. Д.И, Б.Э нар зах зээлийн хандлага, барилгын ашиглалт, орлого зэргийг дутуу тооцсоноос гэрээний үнийн төлөлт хангалтгүй байсан тул худалдагчийн саналаар 2007 оны 2 дугаар сарын 25-ны өдөр дахин гэрээ хийж, өмнөх гэрээний төлбөр хийгдэх хүртэл түрээс төлж байхаар тохиролцжээ. Ингэхдээ өмнөх гэрээг хүчинтэй хэвээр үлдээсэн байна. Түрээс зарим үед саатсан боловч төлөгдөж байсан. Гэвч “Ц.И” ХХК-ийн захирал Б.В агсан “барилга олигтой ашиглаж мөнгө төлж чадахгүй байна” хэмээн 2009 онд цагдаагийн байгууллагад хандсанаар 2009 оны 10 дугаар сарын 28-нд 20925363 тоот эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. Ингээд Д.И, Б.Э нарт 2009 оны 11 дүгээр сарын 16, 17-нд таслан сэргийлэх арга хэмжээ авч, мөн өдрөө Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.3-т заасны дагуу сэжигтнээр татсан байна. Улмаар 2010 оны 2 дугаар сарын 24-нд Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т заасан⁷ бусдыг бүлэглэн зохион байгуулалттай залилж, онц их хэмжээний хохирол учруулсан хэрэгт буюу онц хүнд гэмт хэрэгт яллагдагчаар татаж ял сонгосон байна. Энэ зүйл ангиар сонгосон ял Орхон аймаг дахь сум дундын шүүхийн 2014 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 14 тоот цагаатгах тогтоол гартал хэвээр үргэлжилсэн ба 2014 оны 5 дугаар сарын 30-ны

⁷ 148.4. Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

өдөр Улсын Дээд шүүхийн эцсийн шийдвэр гарснаар дээрх ял, хариуцлагаас бүрэн чөлөөлөгджээ. Энэ хугацаанд буюу анх сэжигтнээр тооцож, таслан сэргийлэх арга хэмжээ авсан 2009 оны 11 дүгээр сарын 16-наас сүүлчийн цагаатгах тогтоол гарч уг тогтоол нь давж заалдах шатны шүүхээр хэвээр үлдсэн 2014 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл 1,593 хоног таслан сэргийлэх арга хэмжээтэй, онц хүнд гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хэвээр байв. 2010 оны 2 дугаар сарын 24-нөөс цагаатгах тогтоол гарсан ч тэр нь давж заалдах шатны шүүхээр хэвээр үлдэж, 2014 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хүртэл 1,410 хоног яллагдагчийн эрх зүйн байдалтай, 73 хоног цагаатгагдсан этгээд гэсэн нэртэй явжээ. Д.И, Б.Э нар таван удаа яллах дүгнэлттэй шүүхэд шилжин, дөрвөн удаа шүүх хуралдаан дээр яллагдан Д.И нь энэ хэргийн учир цагдан хоригдох, хорих газарт ял эдлэх байдлаар 186 хоног хоригдсон, Б.Э торгох ялаар шийтгэгдэж байсан байна⁸.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэг (388-397 дугаар зүйл)-ийг баримтлан Монгол Улсын төрөөс гэм хорын хохирол нөхөн төлүүлэхээр дараах шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргажээ. Үүнд:

1. Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн 186 хоногт ногдох цалин хөлсийг 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл тооцон 1,235,000 төгрөг;
2. Нотлох баримт бүрдүүлэх зардалд 47,500 төгрөг;
3. Өмгөөлөгчид төлсөн нийт хөлс 5,200,000 төгрөг;
4. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөг;

⁸ Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийн хэсгээс.

5. Сэтгэл санааны хохиролд Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн нэг хоногт 50,000 төгрөгөөр тооцон 9,300,000, Д.И-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 3,627,000, Б.Э-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 5,580,000 төгрөг тус тус, бүгд 18,507,000, нийт 27,502,300 төгрөг гаргуулахаар нэхэмжлэлдээ тодорхойлсон байна.⁹

Шүцхийн шийдвэр

Анхан шатны шүцхийн шийдвэрийн агуулга ба үндэслэл: Шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг ханган, холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож дараах үйл баримт болон хуулийн үндэслэлийг баримтлан шийдвэрлэжээ.

“Нэхэмжлэгч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.8 дугаар зүйлийн 1-д “Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг хүн, хуулийн этгээд өөрөө, түүний хууль ёсны төлөөлөгч эсхүл тухайн хүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болно” гэж заасны дагуу мөн хуулийн 45.8 дугаар зүйлийн 3-т заасан “Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг цагаатгах тогтоол, яллахаас татгалзсан шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 жилийн дотор гаргана” гэсний дагуу, мөн зүйлийн 6-д зааснаар оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ шүүхэд хандан Монгол Улсын төрөөс гэм хорын хохиролд нийт 27,502,300 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

⁹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1, 391 дүгээр зүйлийг үндэслэн нэхэмжилсэн байна.

Шүүх бүрэлдэхүүн нэхэмжлэлийг онцгой ажиллагааны журмаар хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцуулсан болно. Нэхэмжлэгч Д.И, Б.Э нар нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “...Бидэнд холбогдуулан Орхон аймгийн Прокурорын газраас удаа дараа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.3, 148.4-т зааснаар яллаж, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэн, шүүх цагаатгах болон шийтгэх тогтоол гаргаж байсан. 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Улсын Дээд шүүхийн 199 тоот тогтоол гарч бидэнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан. Иймд бид Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388, 389 дүгээр зүйлд заасны дагуу гэм хорын хохирол болох нийт 27,502,300 төгрөгийг Монгол Улсын төрөөс нэхэмжилж байна” гэж тайлбарласан байна. Орхон аймгийн Прокурорын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч “...Д.И, Б.Э нарт эрүүгийн хэрэг үүсгэж шалгах шаардлага байсан. Д.И 186 хоног цагдан хоригдсон боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 62 дугаар зүйлд заасан үндэслэлээр түүнд таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь хууль зүйн үндэслэлтэй байна. Мөн энэ гэмт хэргийн тухайд удаа дараа шүүхээс гэм буруутай гэж шийдвэр, магадлал гарсан байдаг. Тийм учраас хэргийн хувьд илтэд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй шалгасан зүйл биш юм. ...Иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг арилгах тухай заалт байдаг боловч нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцож, ямар баримт үндэслэн нэхэмжилж байгаа нь тодорхойгүй байна. Нотлох баримт хуулбарласан 47,500 төгрөгийн зардлыг мөн гаргах боломжгүй. Иргэний хуульд нэхэмжлэгч өөрөө нотлох баримт бүрдүүлэх үүрэгтэй гэж заасан байдаг. ...Мөн эд хөрөнгө битүүмжилснээс үл хөдлөх хөрөнгийн татварт 2,512,800 төгрөгийг төлсөн гэж байна, өөрсдийнх нь нэр дээр байсан үл хөдлөх эд хөрөнгө учраас тэр татварыг нэхэмжлэх боломжгүй.

Тийм учраас нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй” гэсэн тайлбар гаргаж байна гэжээ. Орхон аймгийн Цагдаагийн газраас Д.И, Б.Э нарт холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.3-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.4-т зааснаар ял сонсгож яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн хэргийг ...Улсын Дээд шүүхийн 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор тус тус хэвээр үлдээж, Д.И, Б.Э нарт холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Д.И, Б.Э нарыг цагаатгаж шийдвэрлэсэн үйл баримт болсон нь хэрэгт авагдсан эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалт явуулах тогтоол, сэжигтэн яллагдагчаар татах тогтоол, яллах дүгнэлтүүд, шийтгэх болон цагаатгах тогтоолууд, Улсын Дээд шүүхийн тогтоолууд, нэхэмжлэгч нарын тайлбараар тогтоогдож байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар нэхэмжлэгч, нэхэмжлэлийн шаардлагаа нотолсон баримтыг өөрөө бүрдүүлж өгөх үүрэгтэй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д “...иргэнээр төлүүлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардлыг эд хөрөнгийн хохиролд тооцож нөхөн төлнө” гэсэн заалтыг үндэслэн нэхэмжлэгчдийн эрүүгийн хэргээс нотлох баримт бүрдүүлэхэд төлсөн зардал болох 46,500 төгрөгийг хангаж шийдвэрлэх үндэслэлтэй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсэгт зааснаар Д.И-г таван жил нэг сарын хугацаагаар хорих, Б.Э-г хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр буюу 12,000,000 төгрөгөөр торгох ял тус тус шийтгэсэн. Д.И-г 2011 оны 10 дугаар сарын 10-наас 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл 186 хоног

цагдан хорьсон, нэхэмжлэгчдийн холбогдсон хэргийн талаар олон нийтэд түгсэн мэдээллийн цар хүрээ зэргийг харгалзан Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, нэхэмжлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг нэхэмжилснийг ханган, нийт 24,988,500 төгрөгийг төрөөс гаргуулан нэхэмжлэгчдэд олгох нь зүйтэй.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа ...этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна” гэж заасан тул татварт төлсөн мөнгийг төрөөс нэхэмжилж байгааг хангаж шийдвэрлэх үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, “Э-О” ХХК үйл ажиллагаа явуулсан эсэхээс үл хамааран нэхэмжлэгчид үл хөдлөх эд хөрөнгийн татвар төлөх үүрэгтэй тул нэхэмжлэлийн шаардлагаас дээрх хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн болно.

Иймд Монгол Улсын төрөөс 27,502,300 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэгч Д.И, Б.Э нарын нэхэмжлэлийн шаардлагаас “Э-О” ХХК-ийн үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн 2,512,800 төгрөг, эрүүгийн хэргээс нотлох баримт авсан зардлын баримтаас илүү нэхэмжилсэн 1,000 төгрөг нийт 2,513,800 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв”¹⁰ гэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын агуулга ба үндэслэл: Давж заалдах шатны шүүх Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийг хэвээр үлдээж прокурорын давж заалдсан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн үндэслэлээ дараах байдлаар тайлбарлажээ.

¹⁰ Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийн хэсгээс.

“Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангасан байна. Нэхэмжлэгч Д.И, Б.Э нарын цалин хөлс болох 235,000, нотлох баримт хуулбар хийлгэн авч бүрдүүлсэн зардалд 47,500, өмгөөлөгчийн хөлс болох 5,200,000, үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн 2,512,800, сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг тус тус, нийт гэм хорын хохиролд 27,502,300 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага шүүхэд гаргажээ. Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд нэхэмжлэгч Д.И, Б.Э нар 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхэлж эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан, Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4-т заасан гэмт хэрэгт ял сонгож хэргийг шүүхэд шилжүүлж улмаар тэдэнд холбогдох эрүүгийн хэргийг гурван шатны шүүхээр удаа дараа хянан шийдвэрлэсэн ба 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн Улсын Дээд шүүхийн 199 дүгээр тогтоолоор эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож тэдгээрийг цагаатгаж шийдвэрлэсэн үйл баримт тогтоогдсон байна.

Эрүүгийн хэргийн улмаас нэхэмжлэгч Д.И хорих ялаар шийтгэгдэж 186 хоног хоригдсон, Б.Э торгох ялаар шийтгэгдэн, эрүүгийн хэргийг шалгаж шийдвэрлэх явцад оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байх ба Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн ...этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана” гэж заасны дагуу нэхэмжлэл гаргасан нь хуульд нийцжээ. Шүүх нэхэмжлэгч Д.И-гийн 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл 186 хоног хоригдсон хугацааны цалин хөлс болох 1,235,000, хууль зүйн туслалцаа авахад зарцуулсан 5,200,000, нотлох баримт бүрдүүлэхэд гаргасан зардал болох 46,500 төгрөг тус тус, нийт 6,481,500

төгрөгийг эд хөрөнгийн хохирол гэж үзсэн нь нэхэмжлэгчдийн хэрэгт авагдсан нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, хууль зүйн туслалцаа үзүүлсэн гэрээ зэрэг баримтаар тогтоогдсон байна. Түүнчлэн шүүх нэхэмжлэгчдэд сэтгэл санааны хохирол учирсан гэж үзэхдээ эрүүгийн хэргийн нөхцөл байдал, хэргийн ангилал, шалгагдсан болон хоригдсон хугацаа, шүүхээс оногдуулсан ялын хэмжээ зэргийг харгалзан үзэж Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн нэг хоногт 50,000, эрүүгийн хэргийн улмаас таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тус тус тооцон сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөгийг төрөөс гаргуулсан нь нэхэмжлэгчдэд холбогдох эрүүгийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн хугацааны тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцэхээр байна. Тухайлбал, эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж зохицуулсан ба нэхэмжлэгчдэд учирсан сэтгэл санааны хохирлыг иргэний болон эрүүгийн хэргийн тухайн нөхцөл байдал, хэргийн ангилал, сонгосон болон оногдуулсан ялын хэмжээ, хэрэгт шалгагдсан, хоригдсон хугацаа зэргийг харгалзан үзэж учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээг шүүх Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасны дагуу төрөөс гаргуулж шийдвэрлэснийг буруутгах үндэслэл байхгүй юм. Шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэл бүхий дүгнэлт хийж нэхэмжлэлийн шаардлагаас 24,988,500 төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар, үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн 2,512,800, илүү тооцсон 1,000 төгрөгийг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй байна. Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хууль буруу хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөрчсөн үндэслэл бүхий дүгнэлт хийн нэхэмжлэлийн шаардлагаас 24,988,500 төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар, үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн

2,512,800, илүү тооцсон 1,000 төгрөгийг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй байна. Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хууль буруу хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөрчсөн үндэслэл тогтоогдоогүй байх тул шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй”¹¹ гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэсэн байна.

Улсын Дээд шүүхийн тогтоолын агуулга ба үндэслэл: Анхан болон давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн хэрэглэвэл зохих зүйл, заалтыг хэрэглээгүй, зарим зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн, улмаар нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа эрх зүйн хувьд алдаатай дүгнэлт хийсэн байх тул шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, алдааг залруулах боломжтой гэж дүгнэжээ.

Үндэслэл нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1, мөн 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д “хууль зөрчсөн ажиллагаа”-ны эрх зүйн үр дагаврын талаар заасан ба энэхүү ажиллагаанд холбогдох албан тушаалтны хууль бус үйлдэл бүхий ажиллагаа хамаарахаас гадна яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан бол хуулийн дагуу явагдсан ажиллагаа ч мөн адил хамаарна. Учир нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрх зүйн презумпци нь иргэн бүрийг эрхийн үндэслэлгүй хязгаарлалтаас хамгаалах зарчим юм. Ийнхүү төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан, байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч ийнхүү зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй тохиолдолд

¹¹ Орхон аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 157 дугаартай магадлалын хэсгээс.

дээрх эрхийн хязгаарлалт хууль бусад тооцогддог болно. Улмаар үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульд “хууль бус ажиллагаа”-нд хамааруулдаг. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй. Энэ утгаар шүүх дээрх ажиллагаанаас учирсан гэм хорын асуудлыг эрх зүйн маргааны журмаар буюу нэхэмжлэлээр бус харин хүсэлтээр буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг болно. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон, цагаатгагдсан этгээдэд гэм хор учирсан явдал нь маргаангүй хүлээн зөвшөөрөгдөх үйл баримт юм.

Нөгөө талаар уг гэм хор эрх бүхий этгээдийн хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас учирсан байдаг тул Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан үндэслэлээр энэ хэрэгт хариуцагчаар уг үйл ажиллагааг явуулсан этгээд оролцох үндэслэлгүй болно. Харин хүсэлт гаргаж буй нэхэмжлэгч нь өөрт учирсан гэм хорын хэмжээг нотлох үүрэгтэй ба шүүх гэм хорыг хэдий хэмжээгээр хангах эсэхийг шийдвэрлэнэ. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 397 дугаар зүйлийн 397.1-д “Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан байжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуульд ийм зохицуулалт байхгүй байгаа нь тухайн асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй юм.

Шүүх нэхэмжлэгч Б.Э, Д.И нарын нэхэмжлэлийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй болжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3-т зааснаар онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь гуравдагч этгээдээр оролцож болдгоос гадна мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д зааснаар прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцдог байна. Дээрх зохицуулалтын дагуу прокурор нь тухайн төрлийн хэрэгт гуравдагч этгээдээр эсхүл төрийг төлөөлж эсхүл аль алианаар нь оролцох боломжтойг тэмдэглэх нь зүйтэй. Нэхэмжлэгчид нь өөрт эд хөрөнгийн болон эдийн бус гэм хор учирсан гэж нэхэмжлэлдээ нийт 27,502,300 төгрөг нэхэмжилжээ.

Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д заасан байна. Мөн хуулийн 45.4-т зааснаар эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар эдийн бус гэм хорыг хянан шийдвэрлэхэд шүүх Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг баримтална. Иргэний хуулийн 511

дүгээр зүйлийн 511.1-д заасан эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтад зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээдийн үүргийг тусгажээ. Харин Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2-т зааснаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй боловч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл санаанд учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхгүй нөхцөлд шүүх энэ талаарх шаардлагыг хангах боломжгүй юм.

Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан зохицуулалтыг тухайн маргаанд төсөөтэй хэрэглэсэн нь алдаатай болжээ. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх боловч мөн зүйлийн 4.3-т зааснаар тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. Сэтгэл санаанд учирсан гэм хор болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас учирсан гэм хор нь эдийн бус гэм төрөлд хамаарах боловч агуулга, хэлбэрийн хувьд ялгаатай тул эдгээр харилцаанд эрх зүйн нэг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзнэ.

Анхан болон давж заалдах шатны шүүх сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн нь дээрх үндэслэлээр хуульд нийцээгүй байна. Харин нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирлын хэмжээг нэхэмжлэлдээ 4,000 төгрөг (цагдан хоригдоогүй таслан сэргийлэх арга хэмжээтэй байх үед) гэж заахдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг өдөрт тооцох жишгээр тогтоосон гэж тайлбарласнаас үзвэл тухайн

гэм хорын агуулга нь эд хөрөнгийн шинжтэй гэж үзэхээр байна. Энэ утгаар нэхэмжлэгчдийн шаардлагыг дараах байдлаар хангах боломжтой гэж үзэв. Үүнд:

- Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн 186 хоногт ногдох цалин хөлсийг 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл тооцон 1,235,000 төгрөг;
- Нотлох баримт бүрдүүлэх зардалд 47,500 төгрөг;
- Өмгөөлөгчид төлсөн нийт хөлс 5,200,000 төгрөг;
- Д.И-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 3,627,000 төгрөг;
- Б.Э-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 5,580,000, нийт 15,689,500 төгрөг.
- Харин үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн төлбөрийг гэм хор гэж үзээгүй шүүхийн дүгнэлтийг үгүйсгэх үндэслэлгүй байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд хууль хэрэглээний болон тооцооллын өөрчлөлт оруулж, прокурорын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах боломжгүй¹² гэж дүгнэжээ.

¹² Шүүхийн шийдвэрийг эндээс дэлгэрүүлэн үзнэ үү.
<http://new.shuukh.mn/irgenhyanalt/3809/view>

ХОЁР. ДҮН ШИНЖИЛГЭЭ

А. Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт хийсэн дүн шинжилгээ

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчмын агуулгаар эрүүгийн гэмт хэрэгт шалгах эрх бүхий байгууллагын хууль ёсны ажиллагаа явагдсан ч эцэст нь тухайн этгээд гэм буруутай болох нь нотлогдоогүй тохиолдолд уг ажиллагааны эрх зүйн үр дагаврыг төр хариуцах үүрэг хүлээдэг. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1 дэх хэсэг болон 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хууль зөрчсөн ажиллагаа”-ны эрх зүйн үр дагаврын талаар заахдаа эрх бүхий албан тушаалтны хууль бус үйлдэл, үйл ажиллагаа хамаарахаас гадна яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан бол уг ажиллагаа нь хуулийн дагуу явагдсан ажиллагаа байсан ч адилтган ойлгоно. Учир нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрх зүйн презумпци нь иргэн бүрийг эрхийн үндэслэлгүй хязгаарлалтаас хамгаалах зарчимд хамаарна. Ийнхүү төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан,

байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй бол эрхийн хязгаарлалт тогтоосон үйл ажиллагаа нь хууль бус болох юм. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй гэж хуульчлагдсан байдгийг эрх зүйн үндэслэл бүхий оновчтой тайлбарласан байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.3 дахь хэсэгт зааснаар онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад иргэн, хуулийн этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь гуравдагч этгээдээр оролцож болдгоос гадна мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт зааснаар прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцдог байна. Дээрх зохицуулалтын дагуу прокурор нь тухайн төрлийн хэрэгт гуравдагч этгээдээр эсхүл төрийг төлөөлж эсхүл аль алианаар нь оролцох боломжтойг нэхэмжлэгч талд эрх зүйн үндэслэл бүхий, ойлгомжтой дурдсан байна.
3. Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 157

дугаар магадлал, Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх хэсгийг “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2, 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас 15,689,500 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч Б.Э, Д.И нарт олгож, нэхэмжлэлээс 11,812,800 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчлөн шийдвэр, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээж буйг тайлбарлахдаа сэтгэл санааны хохирлыг тооцох боломжгүй гэж үзсэн ба ингэхдээ эрх зүйн үндэслэлийг буруу ойлгон хэрэглэсэн, үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн төлбөрийг гэм хор гэж үзээгүй шүүхийн дүгнэлтийг үгүйсгэхгүй байгаа ч эрх зүйн үндэслэлийг дэлгэрүүлэн тайлбарлалгүй орхигдуулсан байна гэж үзэж байна.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл учир битүүлэг далд байх нь тухайн үндэслэлийн эсрэг гарч болох сөрөг шүүмжээс зайлсхийхэд тохиромжтой ч шүүгч шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлийг ил байхаар тайлбарлах үүрэгтэй.¹³ Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэл нь ил, тодорхой байх нь нэг талаас шүүгчийн хууль дээдэлсэн мэргэжлийн чадвар, ёс зүйн хэмжүүр, нөгөө талаас хэргийн зохигч тал шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөд чухал байдаг.

Б. Материаллаг эрх зүйн үндэс хийсэн дүн шинжилгээ

Уг хэргийг шийдвэрлэсэн гурван шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгчийн тавьсан шаардлагыг хэрхэн хөндөж үнэлэлт дүгнэлт өгснийг дараах хүснэгтээр харьцуулан үзүүлэв.

¹³ С.Должин, “Хувийн эрх зүй” эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017, 78 дахь тал.

№	Нэхэмжлэлийн шаардлага	Анхан шатны шүүхийн шийдвэр	Давж заалдах шатны шүүхийн магадлал	Хяналтын шатны шүүхийн тогтоол
1	Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн 186 хоногт ногдох цалин хөлсийг 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл тооцон 1,235,000 төгрөг.	Д.И-д дээрх хугацаанд аваагүй цалин болох 1,235,000 төгрөгийг түүний нийгмийн даатгалын дэвтэрт үндэслэн тооцон олгох	Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.	Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн 186 хоногт ногдох цалин хөлсийг 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл тооцон 1,235,000 төгрөг.
2	Сэтгэл санааны хохиролд: Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн нэг хоногт 50,000 төгрөгөөр тооцон 9,300,000 төгрөг, Д.И-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 3,627,000 төгрөг, Б.Э-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт	2009-2014 оны хооронд гадагш явж болохгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, таслан сэргийлэх арга хэмжээ авч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсэгт зааснаар Д.И-г 5 жил 1 сарын хугацаагаар хорих, Б.Э-г хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр буюу	Шүүх нэхэмжлэгчдэд сэтгэл санааны хохирол учирсан гэж үзэхдээ эрүүгийн хэргийн нөхцөл байдал, хэргийн ангилал, шалгагдсан болон хоригдсон хугацаа, шүүхээс оногдуулсан ялын хэмжээ зэргийг харгалзан үзэж Д.И-гийн цагдан хоригдсон,	Б.Э-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 5,580,000 төгрөг Д.И-гийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 3,627,000 төгрөг.



Хүснэгтийн үргэлжлэл

<p>4,000 төгрөгөөр тооцон 5,580,000 төгрөг, бүгд 18,507,000 төгрөг, нийт 27,502,300 төгрөг гэж нэхэмжлэлдээ тодорхойлсон байна.</p>	<p>12,000,000 төгрөгөөр торгох ял тус тус шийтгэсэн, Д.И-г 2011 оны 10 дугаар сарын 10-наас 2012 оны 4 дүгээр сарын 16- ны өдөр хүртэл 186 хоног цагдан хорьсон, нэхэмжлэгчдийн холбогдсон хэргийн талаар олон нийтэд түгсэн мэдээллийн цар хүрээ зэргийг харгалзан Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэн, нэхэмжлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг нэхэмжилснийг хангаж, нийт 24,988,500 төгрөгийг төрөөс гаргуулан нэхэмжлэгчдэд олгох нь зүйтэй.</p>	<p>хорих ял эдэлсэн нэг хоногт 50,000 төгрөг, эрүүгийн хэргийн улмаас таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тус тус тооцож сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөгийг төрөөс гаргуулсан нь нэхэмжлэгчдэд холбогдох эрүүгийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн хугацааны тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцэхээр байна.</p>
---	--	---

Хүснэгтийн үргэлжлэл

3	<p>Ноглох баримт бүрдүүлэх зардалд 47,500 төгрөг.</p>	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1-д зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа нотолсон баримтыг өөрөө бүрдүүлж өгөх үүрэгтэй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д "...иргэнээр төлүүлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардлыг эд хөрөнгийн хохиролд тооцож нөхөн төлнө" гэсэн заалтыг үндэслэн нэхэмжлэгчдийн эрүүгийн хэргээс ноглох баримт бүрдүүлэхэд төлсөн зардал болох 46,500 төгрөгийг хангаж шийдвэрлэх үндэслэлтэй байна.</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.</p>	<p>Ноглох баримт бүрдүүлэх зардалд 47,500 төгрөг.</p>
---	---	---	--	---



Хүснэгтийн үргэлжлэл

4	<p>Өмгөөлөгчид төлсөн нийт хөлс 5,200,000 төгрөг.</p>	<p>Хууль зүйн тусалцаа авахад нэхэмжлэгчдийн төлсөн хөлс 5,200,000 төгрөгийг (хэрэгт авагдсан баримтаар 5,500,000 төгрөг байх боловч нэхэмжлэлийн шаардлагын хэмжээнд) хангаж шийдвэрлэх үндэслэлтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.</p>	<p>Өмгөөлөгчид төлсөн нийт хөлс 5,200,000 төгрөг.</p>
5	<p>Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөг.</p>	<p>Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа ...этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна” гэж заасан тул татварт төлсөн мөнгийг төрөөс нэхэмжилж байгааг хангаж шийдвэрлэх үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, “Э-О” ХХК үйл ажиллагаа явуулсан</p>	<p>Шүүх хэрэгт авагдсан ноглох баримтад үндэслэл бүхий дүгнэлт хийж нэхэмжлэлийн шаардлагаас 24,988,500 төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар, үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн 2,512,800, илүү тооцсон 1,000 төгрөгийг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь</p>	<p>Үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн төлбөрийг гэм хор гэж үзээгүй шүүхийн дүгнэлтийг үгүйсгэх үндэслэлгүй байна (хэвээр).</p>

Хүснэгтийн үргэлжлэл

		<p>эсэхээс Үл хамааран нэхэмжлэгчид Үл хөдлөх эд хөрөнгийн татвар төлөх үүрэгтэй тул нэхэмжлэлийн шаардлагаас дээрх хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн болно.</p>	<p>хууль зүйн үндэслэлтэй байна.</p>	
Нийт	<p>Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4, 511 дүгээр зүйлийн 511.1, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1, 45.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 45.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 45.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.5, 1.6, 45.4 дүгээр зүйлийн 1-д заасныг тус тус баримтлан Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас 24,988,500 төгрөг</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас 15,689,500 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч Б.Э, Д.И нарт олгож, нэхэмжлэлээс 11,812,800 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай..</p>	



Хүснэгтийн үргэлжлэл

		гаруулан нэхэмжлэгч Д.И, Б.Э нарт олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 2,513,800 төгрөгийг хэрэгсэхгүй болгосугай.		
Шийдвэрлэгдэхгүй үлдэж буй маргаан бүхий асуудал	Нэхэмжлэлийн шаардлагаас үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон.	Нэхэмжлэлийн шаардлагаас үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон.	Нэхэмжлэлийн шаардлагаас үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон.	Нэхэмжлэлээс 11,812,800 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Үүнд: сэтгэл санааны хохирулд Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн нэг хоногт 50,000 төгрөгөөр тооцон 9,300,000 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөг.

Дээрх хүснэгтээс шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчийн шаардлагыг хэрхэн хангасан, түүний эрх зүйн үндэслэл болон зарим шаардлагыг хэрхэн хэрэгсэхгүй болгосон, түүний эрх зүйн үндэслэлийг тодорхой харах боломжтой.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаас хоёр асуудлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Ингэхдээ дараах үндэслэлийг баримталсан байна. Үүнд:

1. *Д.И-гийн сэтгэл санааны хохиролд цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн нэг хоногт 50,000 төгрөгөөр тооцон 9,300,000 төгрөг нэхэмжилснийг хэрэгсэхгүй болгосон.* “Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар эдийн бус гэм хорыг хянан шийдвэрлэхэд шүүх Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг баримтална. Гэтэл холбогдох зохицуулалт болох Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтад зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээдийн үүргийг тусгажээ. Харин Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2-г зааснаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй боловч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл санаанд учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхгүй нөхцөлд шүүх энэ талаарх шаардлага хангах боломжгүй байна. Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан зохицуулалтыг тухайн маргаанд төсөөтэй хэрэглэсэн нь алдаатай

болжээ. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх боловч мөн зүйлийн 4.3-т зааснаар тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. Сэтгэл санаанд учирсан гэм хор болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас учирсан гэм хор нь эдийн бус гэх төрөлд хамаарах боловч агуулга, хэлбэрийн хувьд ялгаатай тул эдгээр харилцаанд эрх зүйн нэг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзнэ. Хяналтын шатны шүүх анхан болон давж заалдах шатны шүүх сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн нь дээрх үндэслэлээр хуульд нийцээгүй байна” гэж үндэслэх хэсэгтээ тайлбарласан байна.

2. *Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан цед татварт төлсөн 2,512,800 төгрөг нэхэмжилснийг хэрэгсэхгүй болгосон.* “Үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн төлбөрийг гэм хор гэж үзээгүй шүүхийн дүгнэлтийг үгүйсгэх үндэслэлгүй байна” гэжээ.¹⁴

Судлаачийн хувьд дээрх хоёр асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлье:

¹⁴ Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтад зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээдийн үүргийг тусгажээ. Харин Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2-т зааснаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй боловч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл санаанд учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхгүй нөхцөлд шүүх энэ талаарх шаардлагыг хангах боломжгүй гэж шийдвэрлэсэн байдаг.

1. Д.И-гийн цагдан хоригдож, хорих ял эдэлсэнтэй холбоотой сэтгэл санааны хохирлын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болсонтой санал нийлэхгүй байна. Учир нь Иргэний хуулийн тайлбарт Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тайлбарлахдаа “Эрх зүйн шинжлэх ухаанд эрх зүйн зохицуулалтын хийдлийг арилгах үүднээс хуулийг төсөөтэй хэрэглэх, эрх зүйг төсөөтэй хэрэглэх тухай ойлголт байдаг. Нийгмийн амьдралын хүрээнд үүсдэг бүхий л харилцааг эрх зүйгээр зохицуулах боломжгүй. Түүнтэй адил иргэний эрх зүйн хүрээнд үүсдэг нийгмийн өргөн хүрээтэй харилцааны тодорхой хэсгийг, өөрөөр хэлбэл, хамгийн түгээмэл зүй тогтлыг л эрх зүйн хэм хэмжээгээр загварчлан зохицуулдаг. Иргэний хууль тогтоомжоор тухайн харилцааг тухайлан зохицуулсан, өөрөөр хэлбэл, зөвхөн тухайлсан нэг харилцааг зохицуулахаар тогтоосон хэм хэмжээг төсөөтэй бусад харилцаанд хэрэглэж болохгүй. Тухайлбал, Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2 дахь хэсэгт “Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээгээр нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй гэсэн байна. Энэхүү зохицуулалт нь гагцхүү банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн харилцааг тухайлан зохицуулсан бөгөөд үүнийг иргэд, хуулийн этгээдийн хоорондын зээлийн гэрээний харилцаанд төсөөтэй хэрэглэж болохгүй гэж ойлгоно¹⁵” гэснээр ойлгож болох боловч Иргэний хуулийн 230, 511 дүгээр зүйлд тусгайлсан харилцааг зохицуулсан хэм хэмжээ тусгагдаагүй байгааг зөв тайлбарлан ойлгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.

¹⁵ Ё.Кают, Э.Шпанглер нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2010, 13 дахь тал.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн **45.1 дүгээр зүйлд** “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж ямар төрлийн **хохирлыг арилгуулахаар шаардах эрхийн зохицуулалт хийсэн нь** тухайн хүнд учирсан хохирлыг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгахыг заасан. Мөн хуулийн **45.4 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах журмыг тодорхойлсон байх бөгөөд** эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан байна.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт заасан “...хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй” гэснийг мөн хуулийн 230 дугаар зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр төлүүлэх “тусгайлан заасан тохиолдол” гэж шууд дүгнэх боломжгүй юм. Монгол Улсын Дээд шүүхийн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай” 2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 3 тоот тогтоолд” “нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн” талаар хохирол хүлээсэн этгээдийн хохирлын хэмжээг ихэнхдээ мөнгөн илэрхийллээр тогтоох боломжгүй бөгөөд дээрх үндэслэлээр

хохирогчоор тогтоогдсон этгээд эд материалын хохирол хүлээснээ үндэслэл бүхий нотлох баримтаар нотолж хохирлын тухай тооцоогоо мөнгөн илэрхийллээр гаргаж ирсэн тохиолдолд шүүх түүнийг ердийн журмаар хянан шийдвэрлэх үүрэгтэй”¹⁶ гэж тайлбарласан байдаг нь хохирлоо нэхэмжлэх, түүнийг шүүх хянан шийдвэрлэх боломж олгосон байна.

Нөгөөтээгүүр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрхийг нэхэмжлэгчид олгосон байхад зөвхөн Иргэний хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй гэсэн үндэслэл зааж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан “...иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим”-д нийцэхгүй гэж үзэж болох юм. Иймээс хэрэгт авагдсан баримтаар Д.И-гийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн хоног тогтоогдож байх тул Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг гаргуулах нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт нийцнэ гэж үзэж байна. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй” гэж заасныг үндэслэн иргэний “шүүхэд гомдол гаргаж хохирлоо нөхөн төлүүлэх” эрх нь Үндсэн хуулийн дээрх зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах гол баталгаа болж байдаг¹⁷ гэж тайлбарласан байдаг. Харин хохирол гэдэгт

¹⁶ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл I, УБ., 2001, 205 дахь тал.

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, 2018.09.21, Дугаар 11.

аливаа этгээдийн үнэт зүйлс нь түүний хүсэл зоригийн эсрэг утсан, дордсон, муудсан явдлыг ойлгож болно¹⁸. Тус хохирлыг эдийн буюу материаллаг, эдийн бус буюу материаллаг бус хохирол гэж ангилан авч үздэг ба эдийн бус хохиролд сэтгэл санааны хохирол хамаарах юм. Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хангаснаар Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах үзэл баримтлал, иргэний эрх зүйн хохирол арилгахаас өмнөх байдалд эрхийг сэргээх¹⁹ үндсэн зарчимд тус тус нийцнэ. Хүний эрх, эрх чөлөө нь хууль зүйн олон эх сурвалжтай учир хүний салшгүй болон бусад эрх, эрх чөлөөг Үндсэн хуульд жагсааж бичээгүй, харин тэр бүхний үндсийг нь бэхжүүлсэн онцлог бий²⁰ гэж үзсэний дагуу ойлгож хэрэгжүүлэх нь оновчтой байна. Үүнийг дэлгэрүүлэн үзвэл сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн үзэл баримтлалыг Иргэний хуулийн 228-230, 497, 511 дүгээр зүйл, заалтад тодорхой тусгасан бөгөөд эдгээр зохицуулалт нь гэм хорын эрх зүйн үндсэн зорилго болох хохирлыг бүрэн нөхөн төлүүлэхэд оршино.

Хохирол олгоход чиглэсэн эрх зүйн зохицуулалтууд нь юуны түрүүнд эрхийг өмнөх байдалд нөхөн сэргээх, тэнцвэржүүлэхэд чиглэх ба хохирлыг нөхөн сэргээх боломжгүй бол хохирогчийн сэтгэлийг хангах замаар хохирлыг мөнгөөр барагдуулж болно. Учир нь хүнд бэрх сэтгэл санааны хохирлыг бага ч болов мөнгөн төлбөрөөр орлуулах нь аливаа зөрчил гаргасан этгээд бүхий л хохирлыг хариуцах үндсэн зарчимд нийцнэ.²¹ Дээрхээс гадна хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх явдал нь өмнөх зөрчигдсэн эрхийн үргэлжлэл болж өгдөг. Аль ч хохирлыг арилгах шаардах эрх нь холбогдох этгээдийн

¹⁸ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011, 110 дахь тал.

¹⁹ Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2006, 910-911 дэх тал.

²⁰ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага, УБ., 2017, 194 дэх тал.

²¹ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011, 112 дахь тал.

субъектив эрх, эрх зүйн үнэт зүйлсийг зөрчсөнөөр л үүсдэг. Тийм учраас аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тодорхой гэрээний үүрэг эсвэл хамгаалагдсан эрх, үнэт зүйлд халдсан байх явдал бол хохирол шаардах эрх үүсэх анхдагч нөхцөл юм. Энэхүү шаардах эрх нь эрхийг өмнөх байдалд нь сэргээхэд чиглэх тул эрх зүйн үүднээсээ хохирол арилгаж буй явдал бөгөөд энэ нь өөрөө тухайн эрхийн үргэлжлэл болох чиг үүрэгтэй.²² Уг үзэл баримтлалыг Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж зохицуулснаас харж болно.

Төсөөтэй шүүхийн шийдвэр:

Уг дүн шинжилгээнд хөндөгдөж буй сэтгэл санааны хохирлыг Иргэний хуулийн 511, 230 дугаар зүйлд заасныг баримтлан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд ч цөөнгүй байх бөгөөд ихэнх тохиолдолд шүүхийн энэ шийдвэрийн нэгэн адил байгааг дурдах нь зүйтэй.²³

Энэ тухай судлаач А.Түвшинтөгс²⁴ “Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” сэдэвт илтгэлдээ дээрх асуудлыг дараах байдлаар авч үзсэн байна. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт заасан сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн барагдуулах зохицуулалтын зорилго нь

²² Б.Буянхшиг, Үүргийн эрх зүй (Ерөнхий анги), УБ., 2013, 236 дахь тал.

²³ Улсын Дээд шүүхийн тогтоол, 2020 оны 5 дугаар сарын 14, дугаар 001/ХТ2020/00223.

²⁴ А.Түвшинтөгс, “Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” илтгэл, Б.Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн уралдаан, 2020.

тухайн хүнд учирсан гэм хорыг нөхөн сэргээх, дахин засварлах, урьдын хэвийн байдалд оруулах боломжгүй тохиолдолд л мөнгөн төлбөрөөр тооцох аргыг хэрэглэх юм. Өөрөөр хэлбэл, хохирогчийн хохирлыг өөр аргаар нөхөн төлөх боломжгүй болсон байх ёстой гэсэн үг.

Шүүхээс Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсгийг хэрэглэхдээ явцуу болон өргөн утгаар тайлбарлан хэрэглэж байна. Шүүхийн практикийг судлан үзэхэд илт сэргээх боломжгүй, мөнгөн төлбөрөөр төлөхөөс өөр аргагүй болсон хохирлыг эсхүл хэн ч харсан тухайн хохирогчид өөрт нь шууд байдлаар сэтгэл санааны хохирол учирсан байх тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Зарим тохиолдолд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт зааснаар гагцхүү хуульд тусгайлан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулахаар заагаагүй байгаа гэсэн үндэслэлээр эдийн бус хохирлыг сэргээхээс татгалзаж байна.²⁵

Судлаач А.Түвшинтөгс²⁶ дээрх заалтыг хэрэглэхдээ гурван зүйлийг анхаарах шаардлагатай гэж үзжээ. (i) тухайн хохирол нь хохирогч этгээдэд шууд хэлбэрээр илэрсэн байх, хохирогчид хамааралтай эсэхийг нягтлах; (ii) тухайн учирсан хохирлыг дахин засварлах, буцааж хэвийн байдалд нь оруулах боломжгүй байх; (iii) тус хохирол, гарзаас шалтгаалж хохирогч сэтгэлийн хувьд ихээр шаналсан байх юм. Дээрх гурван шаардлагыг хангаж байгаа тохиолдолд шүүх сэтгэл санааны хохирлыг хариуцагчийн гэм буруу, хохирлын хэмжээнээс

²⁵ Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 978 дугаартай шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 568 дугаартай магадлал, УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 592 тогтоолоор жишээ авч дүн шинжилгээ хийв.

²⁶ А.Түвшинтөгс, “Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” илтгэл, Б.Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн уралдаан, 2020.

шууд хамааруулан хангаж шийдвэрлэх нь оновчтой байж болох юм. Харин дээрх гурван шаардлагаас аль нэгийг нь хангаагүй тохиолдолд шүүх Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсгийн зохицуулалтын дагуу эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн барагдуулах талаар хуульд тусгайлан заасан эсэхийг анхаарах шаардлагатай. Учир нь шүүхийн болон хуулийн үндсэн зорилго нь хүний зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээхэд оршдог. Эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх тусгай заалт байхгүй гэсэн үндэслэлээр эдийн бус хохирлыг хангахгүй орхигдуулах нь төр, шүүхийн үндсэн зорилгод нийцэхгүй байхаас гадна Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах боломжийг хязгаарлах нөхцөл болж болзошгүй юм.

2. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татварт төлсөн 2,512,800 төгрөг нэхэмжилснийг нэг талаас үзвэл эрүүгийн гэмт хэрэгт иргэнийг холбогдуулан шалгах эрх бүхий байгууллага хуульд заасан ажиллагаа явуулсан хэдий ч эцэст нь тухайн иргэн гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны улмаас үүсэх үр дагаврыг төр хариуцах үүрэгтэй бөгөөд нэхэмжлэгчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг хязгаарласан гэж үзэж нэхэмжлэх боломжтойг үгүйсгэхгүй юм. Учир нь нэхэмжлэгчид шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ "Э-О" ХХК-ийн өмчийг битүүмжилж өмчлөгчийн захиран зарцуулах эрхийг хязгаарласан хугацаанд төлсөн үл хөдлөх эд хөрөнгийн татвар болох 2,512,800 төгрөгийг ЭБШХ-ийн 393.1-д зааснаар²⁷ гэж нэхэмжилжээ. Энд нэхэмжлэгчийн зөвхөн өмчийн захиран зарцуулах эрхийг хязгаарлаад зогсоогүй битүүмжилсэн гэснээс үзвэл²⁸ нэхэмжлэгч талын хувьд хөрөнгийг битүүмжлэх нь

²⁷ Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр, Дугаар 001/ХТ2018/00169.

²⁸ Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийн үндэслэх

захиран зарцуулах эрхийг хязгаарлах нэг төрлийн арга гэж үзэж болох ч тухайн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэн явуулж, ашиг орлого олох боломжийг хязгаарласан, Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогчийн шаардах эрхийг хуульчилсан бөгөөд энд эдийн бус хохиролд материаллаг бус бүх хохирлыг багтааж байдаг гэдгээр тайлбарлан ойлгож болох юм. Иймд Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй гэсэн үндэслэлээр нэхэмжлэх боломжтой гэж үзэж байна.

Анхан шатны шүүх уг асуудлыг шийдвэрлэхдээ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа ...этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна” гэж заасныг үндэслэсэн²⁹ нь зүйтэй. Хэдий тийм боловч шийдвэрийн үндэслэх хэсэгтэй Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1 дэх хэсэгт “Үл хөдлөх эд хөрөнгө

хэсэгт “...Өөрөөр хэлбэл, “Э-О” ХХК үйл ажиллагаа явуулсан эсэхээс үл хамааран нэхэмжлэгчид үл хөдлөх эд хөрөнгийн татвар төлөх үүрэгтэй тул нэхэмжлэлийн шаардлагаас дээрх хэсгийг хэрэгсэхгүй...” гэж тайлбарласан нь үйл ажиллагаа эрхлэх боломжгүй байсныг нотолж байна.

²⁹ Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэрийн үндэслэх хэсгээс.

өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно” гэж зааснаар нэхэмжлэгчид үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх нэгэнт үүссэн бөгөөд өмчлөх эрх дуусгавар болоогүй, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа өмчийн бүх төрөлд хамаарагдах компани нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад зааснаар үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байхаар, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварыг улирал бүр тэнцүү хэмжээгээр тооцож төлөх үүрэг хүлээж байгаа зэрэг эрх зүйн үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарлах нь зохигч талд шүүхийн шийдвэрийн уялдаа холбоог хоёрдмол утгагүй ойлгох боломжоор хангадаг.

Төсөөтэй шүүхийн шийдвэр:

Энэхүү дүн шинжилгээнд хөндөгдөж буй үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хязгаарлагдсан үед татвараас чөлөөлөх, төлсөн татварыг буцаан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг ихэвчлэн шүүхийн энэ шийдвэрийн нэгэн адил хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн практик түгээмэл байна.³⁰

В. Процессын эрх зүйн цүднээс хийсэн дүн шинжилгээ

1. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэгт зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны

³⁰ Улсын Дээд шүүхийн тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 13 өдөр, дугаар 519.

журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэйд үндэслэн гэм хорыг нэхэмжилсэн хэргийг нэхэмжлэлээр бус харин хүсэлтээр буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг болно. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 397 дугаар зүйлийн 397.1 дэх хэсэгт “хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан байсан ба 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ийм зохицуулалт байхгүй байгаа нь тухайн асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй бөгөөд шүүх нэхэмжлэгч Б.Э, Д.И нарын нэхэмжлэлийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн нь процессын эрх зүйн үүднээс зөв байна.

Г. Хэлбэрийн болон хууль зүйн техникийн шаардлага

Энэ хэргийг хянан хэлэлцэж гарсан шүүхийн шийдвэрүүд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд заасан бүтэц, хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Харин үйл баримтын болон зарим хуулийн асуултад хууль тайлбарлах зохистой аргыг хэрэглээгүйн улмаас шийдвэрийн зарим хэсэгт “үндэслэлтэй байх” агуулгын шаардлага хангагдаагүй үлджээ.

Шударга бус явдалтай тэмцэх, зөрчигдсөн эрхээ сэргээх иргэдийн эцсийн арга бол шүүхэд хандах явдал тул шүүх хуулийг эрх зүйн үндэслэл бүхий тайлбарлан хэрэглэх үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж байх нь чухал юм.

Шүүхийн энэхүү шийдвэрийн үндэслэх хэсэгт “...Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т, ...2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1-д, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д” гэх зэргээр бичсэн нийтлэг хэлбэр нь шүүхийн шийдвэрийн хууль зүйн бичиглэл, техник алдаа болох бөгөөд цаашид анхаарч байх нь шүүхийн үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцнэ гэж үзэж байна.

Аливаа шүүхийн шийдвэрт зохигчдын байр суурь, тэдгээрийг харьцуулан үнэлж буй шүүх бүрэлдэхүүний дүгнэлт тодорхой, ойлгомжтой, үндэслэлтэй тусгагдвал уг шийдвэр хүлээн зөвшөөрөгдөх, итгэл үнэмшил төрүүлэх суурь нөхцөл хангагдана.³¹ Үнэн худал, зөв бурууг ялгаж дүгнэхдээ үйл баримт болон хуулийн утга агуулгыг зөв ойлгон, үйл баримтыг нотлох үүргийг талуудад ногдуулж, тухайн нотлогдсон үйл баримтад нийцүүлэн хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн тохиолдолд шүүхийн шийдвэр үндэслэлтэй болдог. Уг шүүхийн шийдвэрт үл хөдлөх эд хөрөнгийн татварт төлсөн төлбөрийг гэм хор гэж үзээгүй учир шалтгааны талаар үндэслэл бүхий тайлбарлаагүй нь шийдвэрийн үндэслэх хэсэгт бичигдээгүй, бүрхэг үлджээ. Үйл баримтын талаарх талуудын маргааныг таслах, нотлогдсон нөхцөл байдалд хуулийг нийцүүлэн хэрэглэж, хуулийн заалтыг нэг мөр тайлбарлах зэрэг ажиллагааны үр дүнг шүүхийн шийдвэртээ дэлгэрэнгүй тусгах нь зохистой. Эндээс шүүх нэхэмжлэгчийн тайлбар, үндэслэлд ач холбогдол өгөхгүй, дэмжсэн, няцаасан зүйлээ тодорхой мэдэгдэхгүй, мэтгэлцээнийг үндэслэл болгоогүй мэт харагдаж байна.

³¹ Т.Мэндсайхан, “Орон сууцны талбайн маргаан бүхий иргэний хэрэг ба иргэний хуулийн 255 дугаар зүйлийн хэрэглээ” (Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ), “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, УБ., 2019, №1, 89 дэх тал.

ДҮГНЭЛТ

Иргэн Д.И, Б.Э нарын эдийн бус гэм хорын нэхэмжлэлтэй Монгол Улсын төрд холбогдох энэхүү хэрэг нь эдийн бус гэм хорын асуудлыг практикт шийдвэрлэж буй нийтлэг тохиолдол мөн.

Тус хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь Иргэний хуулийг механикаар хэрэглэдэг, шүүхийн практикт буруу жишиг тогтсоныг илтгэн харуулж буй оновчтой жишээ болохын зэрэгцээ нөгөө талаас нийгмийн харилцаа өргөжин хөгжих үйл явцтай зэрэгцэн бүх төрлийн эрх зүйн харилцааг боловсронгуй болгох шаардлага тулгарч байгаагийн илрэл юм. Иймд олон талт судалгаанд тулгуурлан хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтад, нэмэлт өөрчлөлт оруулах замаар иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах, сэргээн эдлүүлэх боломжийг өргөжүүлэх нь төрийн үндсэн үүрэгт нийцэх юм.

Анх Монгол Улсын Иргэний хуулийг боловсруулж байх үед ХБНГУ-ын Иргэний хуульд заасны нэгэн адил тодорхой нөхцөл өгөгдсөн, биелсэн тохиолдолд л аливаа этгээдэд учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилж болохоор хуулбарлан зохицуулсан³² гэж үздэг. Аливаа зөрчлийн улмаас хохирол амссан этгээдэд үүссэн алдагдал, нэмэлт зардал буюу хохирлыг тухайн зөрчлийг гаргасан хүнээр нөхөн төлүүлэх

³² Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011, 472 дах тал.

үндэслэлийг гэм хорын эрх зүйгээр зохицуулдаг.³³ Энэхүү эрх зүйн зохицуулалт юуны түрүүнд хохирол арилгахад чиглэсэн буюу нөхөн төлбөрийн зорилготой гэж үздэг бөгөөд холбогдох зохицуулалтууд нь хохирол арилгахад болон нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоо биелүүлж чадахгүй бол хохирол учирсан этгээдийн эрх зүйн байдал улам дордох эрсдэл өндөр болдог. Тухайлбал, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд хууль хэрэглээний хувьд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн гаргуулж байхаар хүрээ хязгаарыг³⁴ тогтоож өгсөн. Ийнхүү дурдсанаас бусад төрлийн эдийн бус эрх хөндөгдсөн, эрх чөлөөнд халдсан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гаргуулах боломжгүй болох юм. Учир нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт “зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн гаргуулна” гэж зааснаар хязгаарлан хуульчилсан байна.

Үүнийг тайлбарлахдаа манай улсад Иргэний хуулийг батлах үед Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь зохицуулалт нь англо-саксоны эрх зүйн “*Punitive damage*” буюу хохирлыг гэм буруутай үйлдлийн шийтгэл болгож өндрөөр тогтоон олгох практикийг хуульдаа тусгахгүй, харин эх газрын эрх зүйн бодит хохирлыг хэмжиж олгох гэсэн үзэл санааг дэмжиж байсантай холбоотой³⁵ гэж үздэгийг үгүйсгэхгүй. Сүүлийн үед ХБНГУ-ын Иргэний кодексын

³³ Ж.Оюунтунгалаг, Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019, №1 (71), 9 дэх тал.

³⁴ Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК), Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ, УБ., 2013, 2 дахь тал.

³⁵ А.Түвшинтөгс, “Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” илтгэл, Б.Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн уралдаан, 2020.

§253-т эдийн хохирлоос тусдаа амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэг эрх зөрчигдсөнөөс үүссэн сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлж болох тухай заалт тусгагдсан³⁶, түүнчлэн англо-саксоны эрх зүйд “*Punitive damage*” олгох асуудлыг хязгаарлаж эхэлсэн хандлага нь манай улсын Иргэний хуулийн 230 дугаар зүйлийг дээрх хоёр эрх зүйн бүлийн эдийн бус хохирол арилгах аргыг хослуулах замаар өөрчлөн найруулах нийгмийн хэрэгцээ шаардлага үүсэж байгааг энэхүү дүн шинжилгээ хийсэн шийдвэр баталж байна.

Манай улсын хувьд шүүхийн практик нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь заалтыг хэрэглэхдээ явцуу болон өргөн утгаар тайлбарлан хэрэглэж байгаа илт сэргээх боломжгүй, мөнгөн төлбөрөөр төлөхөөс өөр аргагүй болсон хохирлыг эсхүл хэн ч харсан тухайн хохирогчид өөрт нь шууд байдлаар сэтгэл санааны хохирол учирсан зэрэг тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах шаардлагыг ханган шийдвэрлэж байгаа бол зарим тохиолдолд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт зааснаар “...гагцхүү хуульд тусгайлан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулахаар заагаагүй” гэсэн үндэслэлээр

³⁶ Дам эшлэв. ХБНГУ-ын §249-254 дахь зохицуулалтууд нь зөрчигдсөн эрхийг сэргээх болон нөхөн төлөх үзэл санаанд үндэслэгдсэн. Бодит хохирлоос шалтгаалж бий болсон эдийн бус болон зовж, шаналсны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх зохицуулалтыг Герман Улсын иргэний кодекст тусгахад нэлээн маргаантай байсан. Учир нь дээрх байдлаар зохицуулах нь Англи-Америкийн эрх зүйд хэрэглэгддэг Punitive damage-тэй төстэй бөгөөд энэ нь шийтгэл юм. Шийтгэл нь эрүүгийн эрх зүйн үзэл санаа тул иргэний эрх зүйн үзэл санаанд үл хамаарна гэж эсэргүүцэж байсан байна. Улмаар ХБНГУ-д бодит хохирлоос шалтгаалж бий болсон эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх үзэл санаа нь хувийн эрх зүй дэх шийтгэл болно гэдгийг ойлгон Иргэний кодекст нэмж зохицуулжээ. ХБНГУ-ын Иргэний кодексын §253.1-д “Зөвхөн хуульд заасан тохиолдолд эдийн бус хохирлын нөхөн төлбөрт мөнгөн торгууль ногдуулж болно”, мөн кодексын §253.2-т “Амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэгт учирсан эдийн бус хохирлыг эдийн хохирлоос гадуур мөнгөөр үнэлэн төлүүлж болно” гэж зохицуулсан. Энэ зохицуулалтыг шүүхээс хэрэгжүүлэхдээ тэгш байдлыг буй болгох зорилгоор эдийн бус хохирлыг хэрхэн үнэлэх тухай нийтлэг жишиг гаргаж, хуулиа тайлбарладаг.

эдийн бус хохирлыг сэргээхээс татгалзах үндэслэл³⁷ болж байна. Судлаачийн хувьд уг хуулийн заалтыг (230 дугаар зүйлийн 230.2 дахь зохицуулалтын дагуу) тайлбарлан хэрэглэхдээ тухайн нөхцөл дэх эдийн бус хохирлыг хуульд мөнгөн хэлбэрээр нөхөн барагдуулах талаар тусгайлан заасан эсэх, эрх зүйн ерөнхий агуулга, онолын үүднээс эдийн бус хохирлыг хамааруулан ойлгох боломжтой эсэхийг анхаарах нь зүйтэй гэж үздэг. Ингэхдээ шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшилдээ тулгуурлан гаргаж буй шийдвэр, субъектив хандлага, хуулийг тайлбарлан хэрэглэх онол арга зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, шүүхийн байгууллагын үндсэн зорилго хүний зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээхэд оршдогийг удирдлага болгон ажиллах нь нэн чухал юм.

Олон улсын хандлагыг судалж үзвэл гэм хорын эрх зүйд хэрэглэгддэг зовлон, шаналал, өвдөлт³⁸ хэмээх ойлголтоос тусдаа сэтгэл санааны хямрал, зовлон, шаналал хэмээх ойлголт нь бие даасан судлагдахуун гэж үзэх болсон³⁹ бөгөөд сэтгэл санааны хямрал (*emotional distress*) хэмээх ойлголтыг бүр тодотгон сэтгэл санаа, оюуны гэмтэл (*mental or emotional injury*) гэж тодорхойлох болсон. Учир нь сэтгэл санааны хямрал нь энгийн стресстэй харьцуулшгүй бөгөөд сэтгэл санааны хямралд

³⁷ Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 978 дугаар шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 568 дугаартай магадлал, УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 592 тогтоолоор жишээ авч дүн шинжилгээ хийв.

³⁸ Гэм хорын эрх зүйд ихэнхдээ бусдын бие махбод, эрүүл мэндэд учруулсан зовлон шаналал, өвдөлт гэсэн утгаар ном сурах бичиг, судалгаанд дурдагддаг. Харин дээрх ойлголтоос тусдаа сэтгэл санааны хувьд зовох, шаналах, хямралд хүргэх өөр шинжүүд бий болж байгаа бөгөөд үүнээс үүдэн бусдад хохирол учирч байгааг судлаачийн зүгээс тодотгон дурдаж байгаа болно. АНУ-ын Дээд шүүхийн зүгээс сэтгэл санааны хохирол тус бүрийг тодотгож сэтгэл санаа болон оюуны гэмтэл (*injury*) гэж тодорхойлсон.

³⁹ M.Lee Huffaker, Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama, 2003, 1003 дахь тал; James V.Calvi, Susan Coleman, American Law and Legal systems, Fourth edition, 2008, 256 дахь тал.

ЭДИЙН БУС ГЭМ ХОРЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

өртсөн этгээд нойрны дутагдалд орох, хоол, унд идэж уух дуршилгүй болох, оюун санаа нь төвлөрөхгүй байх, байнгын уур уцаартай байх зэрэг шинжүүдээр илэрдэг байна. Үүнээс үүдэн мэдрэл, сэтгэцэд нөлөөлөх, цаашлаад сэтгэц, мэдрэлийн өвчин тусах магадлал ч нэмэгддэг болохыг мэргэжлийн шинжээчид хүлээн зөвшөөрч, энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажил нэлээд хийж байна.⁴⁰

⁴⁰ М.Ванчигмаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэний нэхэмжлэл, диссертацийн ажил, УБ., 2020, 99 дэх тал.

САНАЛ

Цаашид хууль хэрэглээний зохисгүй практикийг залруулах, Иргэний хуулийн холбогдох зүйл, хэсгийн хэрэглээг тодорхой болгох зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Иргэний хуулийн 498 дугаар зүйлд “...Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ. ...Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана” гэж зохицуулсан нь зөвхөн учирсан эдийн гэм хорыг материаллаг хэлбэрээр барагдуулах тухай зохицуулж өгсөн мэт ойлгогдохоор өрөөсгөл агуулгатай байх тул 498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч болон хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг эдийн болон эдийн бус хэлбэрээр бүрэн үнэлж, мөнгөн төлбөрөөр барагдуулах үүргийг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцах үүрэгтэй” гэж нарийвчлан тусгаж өгөх нь агуулгын

хүрээнд өргөн хэрэглэгдэж, хүний эрхийг бүрэн хангах практик боломжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

2. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэснийг “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан, сэтгэл санаа болон бусад эдийн бус баялагт хохирол учруулсан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж шаардах эрхийн заалтыг нэмж оруулах нь оновчтой байна.⁴¹
3. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд төрийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас битүүмжлэгдсэн, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж ашиг орлого олох боломжгүй байсан хугацааг тооцож, тодорхой хувь хэмжээгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрх зүйн зохицуулалт бий болгоход чиглэсэн судалгаа явуулах нь хууль ёсны зарчимд нийцэхээр байна.
4. Иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг арилгах тухай заалт байдаг боловч нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцож, ямар баримтыг үндэслэн нэхэмжилж байгаа нь тодорхойгүй байгааг шийдвэрлэх зорилгоор шинжилгээ хийх, шинжилгээний

⁴¹ М.Ванчигмаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэний нэхэмжлэл, диссертацийн ажил, УБ., 2020, 144 дэх тал.

байгууллагад мэргэшсэн шинжээчдийн нэгдсэн бүртгэлийн сан бий болгох, тэдэнд хууль хэрэглээг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, чиглэл өгөх, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа мэргэшсэн шинжээчдээс бүрдсэн орон тооны бус зөвлөл ажиллуулах зэргээр сэтгэл санааны хохирлыг нарийвчлан тогтоох эрх зүйн орчин, түүнийг тооцож нотлох баримт бүрдүүлэх нөхцөлийг төгөлдөржүүлэх зорилгоор ИХШХШТХ (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль)-ийн 47, 52 дугаар зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд нарийвчлан зохицуулах, нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.



ЭХ СУРВАЛЖ

А. Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Иргэний хууль, 2002.
2. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
3. Монгол Улсын Дээд шүүхийн “Шүүхийн шийдвэрийн тухай” 21 дүгээр тогтоол, 2006.
4. Монгол Улсын Дээд шүүхийн “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай” зөвлөмж, 2006.
5. Монгол Улсын Дээд шүүхийн “Шүүхийн шийтгэх ба цагаатгах тогтоол боловсруулах аргачлалын тухай” зөвлөмж, 2006.
6. Монгол Улсын Дээд шүүхийн “Давж заалдах шатны шүүхээс гаргах магадлалын тухай” 02 тоот зөвлөмж, 2009.
7. Монгол Улсын Дээд шүүхийн “Давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хэргийн талаар гаргах магадлалд тавигдах шаардлагын тухай” 01 тоот зөвлөмж, 2010.
8. Монгол Улсын Дээд шүүхийн “Шийтгэх/цагаатгах тогтоол үйлдэхэд анхаарах зарим асуудлын тухай” 01 тоот зөвлөмж, 2018.
9. Монгол Улсын Дээд шүүхийн “Магадлал үйлдэхэд анхаарах зарим асуудлын тухай” 02 тоот зөвлөмж, 2018.
10. Монгол Улсын дээд шүүхийн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон

Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” 15 дугаар тогтоол, 2009.

Б. Ном зохиол, өгүүлэл, илтгэл

1. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага, УБ., 2017.
2. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2011.
3. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 3 дахь хэвлэл, УБ., 2013.
4. С.Должин, “Хувийн эрх зүй” эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, УБ., 2017.
5. Б.Тэмүүлэн, “Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”, “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, №2, 2014.
6. Ё.Каюг, Э.Шпанглер нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2010.
7. Т.Мэндсайхан, Орон сууцны талбайн маргаан бүхий иргэний хэрэг ба иргэний хуулийн 255 дугаар зүйлийн хэрэглээ (Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ), “Шүүх эрх мэдэл” сэтгүүл, №1, УБ., 2019.
8. Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК), Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ, УБ., 2013.
9. Гүнтэр Кристиан Шварц, Манфрэд Вандт, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, 3 дахь хэвлэл, УБ., 2017.
10. Б.Отгонзул, “Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011.



11. Ж.Оюунтунгалаг, Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019, №1.
12. А.Түвшинтөгс, “Сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хууль зүйн асуудал” илтгэл, Б.Чимидийн нэрэмжит шилдэг илтгэлийн уралдаан, 2020.
13. Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК), Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ, УБ., 2013.

Гадаад эх сурвалж:

1. Betsy J. Grey, The Future of Emotional Harm, 83 Fordham L. Rev. 2605 (2015).
2. John J. Kircher, The Four Faces of Tort Law: Liability for Emotional Harm, 90 Marq. L. Rev., 789 (2007),
3. Handerson D.F, Law and legal process in Japan, Seattle, Washington, Tokyo., 2005.
4. Hart H.L, The concept of law, Oxford University Press, 1961.
5. International Encyclopedia of Comparative law, Criminal procedure, V. 1.
6. Klumer law International, The Hague-London, Boston, 1993-2004.
7. International Encyclopedia of laws, Criminal provedure law, V. 4, London, Boston, 1993-2004.
8. Гуценко К.Ф, Филимонов Б.А., “Уголовный процесс западных государств” М., 2002.
9. Калиновский К.Б., Смирнов А.В., Уголовный процесс, изд. “Питер”, М., 2015.
10. Карев Д.С., Сущность и задача уголовного процесса, учебник “Уголовный процесс”, М., 1998.

11. Конституции зарубежных государств: США, Великобритания, Франция, Германия, Италия, Греция, Канада, Япония, изд. “Бек”, М., 1997.

В. Шүүхийн шийдвэр (www.shuukh.mn)

1. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 001/ХТ2018/00169 дүгээр тогтоол.
2. Орхон аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 00157 дугаартай магадлал.
3. Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 142/ШШ2017/00847 дугаартай шийдвэр.
4. Монгол Улсын Дээд шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2020/00223 дугаартай тогтоол.
5. Монгол Улсын Дээд шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 001/ХТ2018/01759 дүгээр тогтоол.
6. Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 978 дугаартай шийдвэр.
7. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 568 дугаартай магадлал.
8. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 592 дугаартай тогтоол.



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M, MBA)

Өмгөөллийн DB>S ХХН-ийн гишүүн хуульч



Өмгөөллийн DB>S ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Билиг” дээд сургуульд хичээл зааж байсан туршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн турш өндрөөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл туурвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкманий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.) ШЕЗ-ийн Тамгын газрын дарга



ШЕЗ-ийн Тамгын газрын дарга тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кьюшюгийн их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ISBN 978-9919-9840-2-1



9 789919 984021